

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮРТГЭЛИЙН БАГЦ ЖУРАМ

Хавсралт 1. Үнэт цаасны бүртгэл

Хавсралт 2. Өрийн хэрэгслийн бүртгэл

Хавсралт 3. Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагаа

Хавсралт 4. Үнэт цаас барьцаалах

Хавсралт 5. Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам

Хавсралт 6. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасны бүртгэл

Хавсралт 7. Монгол Улсын хадгаламжийн бичгийг бүртгэх нийтэд санал болгон арилжих

Хавсралт 8. Ногдол ашиг тараах ажиллагаа

Хавсралт 9. Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих

Хавсралт 10. Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар

Хавсралт 11. Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх эрх шилжүүлэх үйл ажиллагаа

Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх

Хавсралт 12. Хаалттай хувьцаат компанийн тухай

Хавсралт 13. Санал хураах кумулятив арга

Хавсралт 14. Үнэт цаас гаргагч компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих

Хавсралт 15. Компанийн засаглалын кодекс

Хавсралт 16. Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих

Хавсралт 17. Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа

Хавсралт 18. Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих

Хавсралт 19. Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг бүртгэх, арилжих, тайлагнах

Хавсралт 20. Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн үйл ажиллагаа, түүний программ хангамжид тавих нөхцөл, шаардлага

Хавсралт 21. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх

Хавсралт 22. Хувьцаат компанийн дүрмийн үлгэрчилсэн загвар

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцаа, хувьцаанд хөрвөх опцион болон өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэл /цаашид “Хорооны бүртгэл” гэх/-д бүртгэх, өөрчлөлт оруулах, хасах, анхдагч зах зээлд байршуулах, захиалгыг бүрдүүлэх, худалдах, тайлагнах, үнэт цаас гаргагч, андеррайтер, арилжаа эрхлэх байгууллага, Хорооны эрх үүргийг тодорхойлох, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд хяналт тавих, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль, аудит, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэ журмаар хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өрийн хэрэгслээс бусад нийтэд санал болгон гаргах компанийн өрийн хэрэгслийг бүртгэх, үнэт цаасны хоёрдогч зах зээлд арилжигдажбуй хувьцааг худалдах, худалдан авахтай холбогдсон харилцааг зохицуулахгүй.

1.3. Хуульд өөрөөр заагаагүй бол Хороонд бүртгүүлээгүй аливаа хувьцааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ ашиглан нийтэд санал болгохгүй бөгөөд хувьцааг бүртгүүлэхээс өмнөх бэлтгэл үе шатанд үнэт цаас гаргагч болон андеррайтерийн стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдтэй хөрөнгө оруулалт татах талаар урьдчилан яриа, хэлэлцээр хийснийг хувьцааг нийтэд санал болгосонд тооцохгүй.

1.4. Нийтэд санал болгон гаргах хувьцааг арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн журмаар зохицуулна.

1.5. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон энэ журамд зааснаас бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг Хорооны бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг холбогдох хууль тогтоомж болон Хорооноостогтоосон журмаар тус тус зохицуулна.

ХОЁР. Үнэт цаас гаргах бэлтгэл үе шат

2.1. Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах тохиолдолд андеррайтер, Хороонд бүртгэлтэй хууль, аудитын үйлчилгээ үзүүлэгч болон шаардлагатай тохиолдолд хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч, хөндлөнгийн шинжээчтэйгэрээ байгуулна.

2.2. Үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулан ажиллах үндсэн андеррайтер нь түүний холбогдох этгээд байж болохгүй бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.5-д заасны дагуу түүнтэй хамтран ажиллах андеррайтер /цаашид “туслах андеррайтер” гэх/-ийн хувьд энэхүү шаардлага хамаарахгүй.

2.3. Андеррайтер нь нийтэд санал болгон хувьцааг бүртгүүлэхэд үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх, хууль, аудитын үйлчилгээ үзүүлэгчийн дүгнэлт, бусад шаардагдах баримтбичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллана.

2.4. Андеррайтер нь гэрээний дагуу үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах

хувьцааг Хорооны бүртгэл болон арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах ажиллагааг зохион байгуулна.

2.5. Андеррайтер нь үнэт цаас гаргагчтай тохиролцсоны үндсэн дээр нийтэд санал болгон гаргах хувьцааг үнэт цаасны анхдагч зах зээлд байршуулах, хувьцааны захиалгыг бүрдүүлэх аргачлалын талаар үнэт цаасны танилцуулгад дэлгэрэнгүй тусгасан байна.

2.6. Андеррайтер нь үнэт цаас гаргагч зөвшөөрсөн тохиолдолд нэг болон түүнээс дээш туслах андеррайтертай гэрээ байгуулж, хувьцааг нийтэд санал болгох ажиллагааг хамтран хэрэгжүүлж болно.

2.7. Андеррайтер нь энэ журмын 2.6-д заасан туслах андеррайтертай хамтран ажиллах гэрээнд үндсэн болон туслах андеррайтерийн хүлээх үүрэг, хариуцлага, анхдагч зах зээлд нийтэд санал болгон гаргах хувьцааны захиалгыг бүрдүүлэх аргачлал, хөрөнгө оруулагчдад хэрхэн сурталчлах, хувьцааг хуваарилах зарчим, андеррайтерийн үйлчилгээний төлбөр зэрэг мэдээллийг тусгасан байна.

2.8. Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран эрэмбэлсэн шилдэг 100 аж ахуйн нэгжээр шалгарсан үнэт цаас гаргагчийн хувьд хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч, хөндлөнгийн шинжээчтэй гэрээ байгуулахыг шаардахгүй бөгөөд хувьцаа бүртгүүлэх хүсэлтийг хялбаршуулсан горимоор хянаж, шийдвэрлэнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор нэмсэн/

ГУРАВ. Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргах, үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг хянах, бүртгэх

3.1. Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцаагаа бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана.

3.1.1. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл /энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу/;

3.1.2. үнэт цаасны танилцуулга;

3.1.3. хувьцаа гаргахтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

3.1.4. сүүлийн 6 сарын доторх хугацааны аудитын компаниар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон аудитын байгууллагын тодорхойлох захидал;

3.1.5. Хороонд бүртгэлтэй хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч хуулийн этгээдийн дүгнэлт;

3.1.6. андеррайтерийн компанитай байгуулсан гэрээ болон тодорхойлох захидал¹;

3.1.7. хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэн үнэлэлт, дүгнэлт гаргасан бол тэдгээрийн дүгнэлт;

3.1.8. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэгдсэн тухай шийдвэр;

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.1.9. компанийн шинэчилсэн дүрмийн төсөл;

3.1.10. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт.

3.2. Үнэт цаас гаргагч нь энэ журамд заасны дагуу хүсэлт, үнэт цаасны танилцуулга, баримт бичгийг зохих шаардлагын дагуу бүрдүүлж, Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлнэ.

3.3. Хороо үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцааг бүртгүүлэх шаардлага хангасан, бүрдэл бүрэн хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 өдөр, энэ журмын 2.8-д заасан үнэт цаас

гаргагчийн хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.4. Энэ журмын 3.1-д заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт тодруулга, мэдээлэл шаардлагатай тохиолдолд Хороо албан бичгээр үнэт цаас гаргагч болон андеррайтерт мэдэгдэх бөгөөд зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн нэмэлт баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

3.5. Энэ журмын 3.1.2-т заасан үнэт цаасны танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухайхуулийн 10.5-д зааснаас гадна дараах мэдээллийг тусгасан байна.

3.5.1. хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах нөхцөл;

3.5.2. нийтэд санал болгон гаргах хувьцааны үнийг тогтооход ашигласан аргачлал, ашигласан түүхэн болон таамаглал тоо баримтууд;

3.5.3. үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргах нийт хувьцаанаас андеррайтерийн худалдан авах хувь хэмжээ;

3.5.4. үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулахтай холбоотой хүлээх үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх хугацааны талаарх мэдээлэл;

3.5.5. үнэт цаас гаргагч болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдүүдийнхооронд үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар гаргасан мэдэгдэл;

3.5.6. үнэт цаас гаргахтай холбоотой гаргасан зардлыг нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс зарцуулах бол энэ тухай мэдээлэл.

3.6. Танилцуулгын эхний хуудсанд дараах анхааруулгыг тодоор бичсэн байна:

“Үнэт цаас гаргагчийн хувьцааг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг хувьцааныг эрсдэлийн талаар аливаа баталгаа гаргаагүй болохыг анхаарах нь зүйтэй. Энэ хувьцааг худалданавах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, үнэт цаасны танилцуулга, хувьцаа гаргах ажиллагааг сайтаранхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

3.7. Хувьцааг бүртгүүлэх тухай хүсэлт, үнэт цаасны танилцуулгад үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, андеррайтерийнгүйцэтгэх захирал нар гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

3.8. Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд нь гадаад улсад үнэт цаас гаргах, эхсүл гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад хувьцаагаа бүртгүүлэх тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.3-т заасны дагуу дараах баримт бичгийг Хороонд хүргүүлж, мэдэгдэнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.8.1. албан бичиг;

3.8.2. мэдэгдэл /энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу/;

3.8.3. холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.8.4. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

ДӨРӨВ. Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй үнэт цаасыг бүртгэх

4.1. Хороо, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь

компанийн нэмж гаргах энгийн хувьцаанд суурилсан опцион болон уг хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд Хороонд бүртгүүлнэ.

4.2. Үнэт цаас гаргагч нь компанийн ажилчдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх, эсхүл компанийн гүйцэтгэх удирдлага, түүний удирдлагын багийг урамшуулах зорилгоор энэ журмын 4.1-д заасан опционыг гаргана.

4.3. Үнэт цаас гаргагчийн нэмж гаргах энгийн хувьцаанд суурилсан опционы хэмжээ нь тухайн компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 15 хувиас хэтрэхгүй.

4.4. Үнэт цаас гаргагчийн опционд заасан энгийн хувьцааны үнэ нь Компанийн тухай хуулийн 40.3-т заасан арилжааны жигнэсэн дундаж үнээс доошгүй байна.

4.5. Үнэт цаас гаргагчаас гаргах опцион нь уг опционыг эзэмшигч энгийн хувьцааг тогтоосон үнээр, тогтсон хугацаанд компаниас худалдан авч болох эрхийг баталгаажуулсан төрлийн опцион байна.

4.6. Үнэт цаас гаргагч нь нэмж гаргах энгийн хувьцаанд суурилсан опционыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана.

4.6.1. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл /энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу/;

4.6.2. компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

4.6.3. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэсэн талаарх шийдвэр, дүгнэлт;

4.6.4. опцион гаргахтай холбоотой зохицуулалт тусгагдсан компанийн дүрмийн төсөл;

4.6.5. опционы үнэ, хугацаа, хэрэгжүүлэх хуваарь, худалдан авч болох хувьцааны тоозэрэг мэдээллийг агуулсан опционы талаарх дэлгэрэнгүй танилцуулга;

4.6.6. Компанийн ажилчдад хувьцаа эзэмшүүлэх, гүйцэтгэх удирдлага болон түүний удирдлагын багийг урамшуулахтай холбоотой опцион хуваарилах ажиллагааны журам;

4.6.7. хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах талаар хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл;

4.6.8. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

4.7. Үнэт цаас гаргагч нь холбогдох хүсэлт, опционы танилцуулга, баримт бичгийг зохих шаардлагын дагуу бүрдүүлж, Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлнэ.

4.8. Хороо үнэт цаас гаргагчийн энэ журмын 4.6-д заасан баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан өдрөөс хойш ажлын 20 өдөрт багтаан хянаж, шийдвэрлэнэ.

4.9 Энэ журмын 4.6-д заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт тодруулга, мэдээлэл шаардлагатай тохиолдолд Хороо албан бичгээр үнэт цаас гаргагчид мэдэгдэнэ.

4.10. Энэ журмын 4.8-д заасан Хорооны шийдвэрт үнэт цаас гаргагчийн нэмж гаргах энгийн хувьцаанд суурилсан опционы үнэ, төрөл, тоо хэмжээ, хэрэгжиж дуусах эцсийн хугацаа, опцион хэрэгжих үед нэмж бүртгэгдэх нийт энгийн хувьцааны тоо, опционы эрхийг хэрэгжүүлээгүй бол нэмж гаргах энгийн хувьцааг бүртгэхгүй байх заалтыг тус тус тусгасан байна.

4.11. Үнэт цаас гаргагчийн опционы хугацаа дуусгавар болох эсхүл опционы эрхийг хэрэгжүүлэх хүртэл тухайн компанийн нэмж бүртгэгдэх хувьцаа нь зарласан хувьцаа байна.

4.12. Үнэт цаас гаргагч нь опционыг хэрэгжүүлэх тохиолдолд энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг опцион хэрэгжүүлэх хүсэлтийн хамт ажлын 3 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

4.13. Хороо энэ журмын 4.12-т заасан хүсэлтийг ажлын 3 өдрийн дотор хянаж, хувьцаанд хөрвүүлэх опционы тоо хэмжээнд үндэслэн тухайн үнэт цаас гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны тоог нэмэгдүүлж, бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд энэ талаар арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад Хорооны

даргын албан бичгээр мэдэгдэнэ.

4.14. Арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэ журмын 4.13-т заасан Хорооны албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор үнэт цаас гаргагчийн бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.15. Үнэт цаас гаргагч нь энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй өрийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана.

4.15.1. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл /энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу/;

4.15.2. компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал болон төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;

4.15.3. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэсэн талаарх шийдвэр, дүгнэлт;

4.15.4. нийтэд санал болгон хувьцаанд хөрвөх өрийн хэрэгсэл гаргаж буй тохиолдолд

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5, 10.6-д заасан агуулгын хүрээнд боловсруулсан үнэтцаасны танилцуулга, дүгнэлт;

4.15.5. хаалттай хүрээнд санал болгон энгийн хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийг гаргах тохиолдолд өрийн хэрэгслийн талаарх товч танилцуулга;

4.15.6. энгийн хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийн нэрлэсэн үнэ, хугацаа, хүүгийн хувь, үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтийн хуваарь, өрийн хэрэгслийг хувьцаанд хөрвүүлэх хугацаа, хөрвүүлэх үнэ, хөрвүүлэх харьцаа, өрийн хэрэгсэл гаргагч компани болон худалдан авагчийн эрх, үүрэг, хариуцлага зэрэг мэдээллийг тусгасан өрийн хэрэгслийн гэрээ;

4.15.7. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

4.16. Үнэт цаас гаргагч нь энгийн хувьцаанд хөрвөх өрийн хэрэгсэл гаргах тохиолдолд хөрвөх хувьцааны тоо нь компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 30 хувиас хэтрэхгүй.

4.17. Үнэт цаас гаргагч нь холбогдох хүсэлт, хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийн танилцуулга, бусад баримт бичгийг зохих шаардлагын дагуу бүрдүүлж, Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлнэ.

4.18. Хороо үнэт цаас гаргагчийн энэ журмын 4.15-д заасан энгийн хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийн баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан өдрөөс хойш ажлын 20 өдөрт багтаан хянаж, шийдвэрлэнэ.

4.19. Энэ журмын 4.15-д заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт тодруулга, мэдээлэл шаардлагатай тохиолдолд Хороо албан бичгээр үнэт цаас гаргагч болон андеррайтерт мэдэгдэнэ.

4.20. Энэ журмын 4.18-д заасан Хорооны шийдвэрт үнэт цаас гаргагчийн энгийн хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийн үнэ, тоо хэмжээ, хугацаа, хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийн харьцаа, хөрвөх хувьцааны нийт тоо хэмжээг тус тус тусгасан байна.

4.21. Үнэт цаас гаргагчийн өрийн хэрэгслийн хугацаа дуусгавар болж, энгийн хувьцаанд хөрвүүлэх хүртэл тухайн компанийн нэмж бүртгэгдэх хувьцаа нь зарласан хувьцаа байна.

4.22. Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийг хувьцаанд хөрвүүлэх нөхцөл бүрдсэн тохиолдолд энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг өрийн хэрэгслийг хувьцаанд хөрвүүлэх хүсэлтийн хамт ажлын 3 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

4.23. Хороо энэ журмын 4.22-т заасан хүсэлтийг ажлын 3 өдрийн дотор хянаж, хувьцаанд хөрвөх өрийн хэрэгслийн тоо хэмжээнд үндэслэн тухайн үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны тоог нэмэгдүүлж, бүртгэлд өөрчлөлт оруулах бөгөөд энэ талаар арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад Хорооны даргын албан бичгээр мэдэгдэнэ.

4.24. Арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэ журмын 4.23-т заасан Хорооны албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн

дотор үнэт цаас гаргагчийн бүртгэлд өөрчлөлт оруулах ажиллагааг хэрэгжүүлнэ.

ТАВ. Хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах

5.1. Үнэт цаас гаргагч нь компанийн оноосон нэрийг өөрчлөх, компанийг нэгтгэх, хувьцаахуваах болон нэгтгэх, өрийг хувьцаагаар солих, компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт оруулах замаар Хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах тохиолдолд арилжааэрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлсэн байна.

5.2. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаас гаргагчийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулсан шийдвэрийг холбогдох дүгнэлт, үнэт цаас гаргагчийн ирүүлсэн баримт бичгийн хуулбарын хамт уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

5.3. Үнэт цаас гаргагчийн Хорооны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлтийг баримт бичгийнбүрдэл бүрэн хангагдсан тохиолдолд ажлын 20 өдөрт багтаан хянана.

5.4. Энэ журмын 5.3-т заасан баримт бичгийн бүрдэл дутуу, нэмэлт тодруулга, мэдээлэл шаардлагатай тохиолдолд үнэт цаас гаргагчид Хороо албан бичгээр мэдэгдэнэ.

5.5. Үнэт цаас гаргагч нь компанийг нэгтгэх бол дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

5.5.1. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

5.5.2. үнэт цаас гаргагч нь хуулийн этгээдийг нэгтгэх зорилго, нэгтгэснээр үүсэж болох давуу тал, эерэг нөлөөний талаарх судалгаа, нэгтгэсний дараах байдлаар хийгдсэн бизнес төлөвлөгөө;

5.5.3. үнэт цаас гаргагчтай нэгдэж буй хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;

5.5.4. үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийг нэгтгэх нөхцөл, дээрх ажиллагааг гүйцэтгэх журам;

5.5.5. нэгдэж буй компанийн хувьцааг үнэт цаас гаргагчийн хувьцаанд хөрвүүлэх харьцаа, холбогдох тооцоолол, арилжаа эрхлэх байгууллагын 6 сарын дундаж ханш, шаардлагатай тохиолдолд үнэлгээний тайлан;

5.5.6. нэгдэж буй болон нэгтгэж буй компани тус бүрийн сүүлийн 6 сарын доторх хугацааны аудитын компаниар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

5.5.7. нэгтгэсэн санхүүгийн тайлан, нэгтгэхэд ашигласан арга, аргачлал;

5.5.8. нэгтгэх үйл ажиллагаатай холбоотойгоор хийгдсэн хууль зүйн дүгнэлт;

5.5.9. үнэт цаас гаргагч өөрчлөн байгуулагдахтай холбоотой үүсэх хувьцаа эзэмшигчийн эрхийг хамгаалах ажиллагааны төлөвлөгөө, журам;

5.5.10. нэгтгэсний дараах байдлаар хийгдсэн компанийн дүрмийн төсөл;

5.5.11. арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолт;

5.5.12. хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн авах тохиолдолд хувьцааны бутархай үлдэгдлийг худалдан авах үнийг тогтоосон талаарх мэдээлэл;

5.5.13. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

5.6. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн журмаар тогтоосон хувьцааны бүртгэлийнII, III ангилалд багтдаг, нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшилд нийт хувьцааны 90-ээс дээш хувь нь төвлөрсөн, үйл ажиллагаа нь зогсонги байдалтай үнэт цаас гаргагчтай дор дурдсан хуулийн этгээд нэгтгэх ажиллагааг хэрэгжүүлж болно.

5.6.1. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч;

5.6.2. Тухайн жилийн компанийн нийт хөрөнгө нь 5.0 тэрбум төгрөгөөс дээшгүй, борлуулалтын орлого нь 1.0 тэрбум төгрөгөөс дээшгүй аж ахуйн нэгж.

5.7. Үнэт цаас гаргагч хувьцаа хуваах, эсхүл нэгтгэх тохиолдолд дараах баримт бичгийг

Хороонд ирүүлнэ.

5.7.1. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

5.7.2. арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолт, сүүлийн 6 сарын жигнэсэн дундажханшийн мэдээлэл;

5.7.3. компани хувьцаа хуваах, нэгтгэх нөхцөл, уг ажиллагааг гүйцэтгэх журам;

5.7.4. хувьцаа хуваах, нэгтгэх үйл ажиллагаатай холбоотойгоор хийгдсэн хууль зүйн дүгнэлт;

5.7.5. хувьцаа хуваах, нэгтгэх шаардлага, нөхцөл, хувьцааг хөрвүүлэх тооцоолол;

5.7.6. компанийн шинэчилсэн дүрмийн төсөл;

5.7.7. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

5.8. Үнэт цаас гаргагч өрийг хувьцаагаар солихоор шийдвэрлэж, нэмж хувьцаа гаргах тохиолдолд дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

5.8.1. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл /энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу/;

5.8.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

5.8.3. арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолт, сүүлийн 6 сарын жигнэсэн дундажханшийн мэдээлэл;

5.8.4. өр үүссэн шалтгаан, хувьцаанд хөрвөх нийт өрийн хэмжээ, хувьцааг өрөөр солиххарьцаа, нийт нэмж гаргах хувьцааны нэрлэсэн үнэ, тоо, ширхэг;

5.8.5. өр үүссэнийг нотлох санхүүгийн болон эрх зүйн баримт бичиг;

5.8.6. хувьцааг өрөөр солих ажиллагааг хэрэгжүүлэх журам;

5.8.7. хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаа эргүүлэн худалдан авах журам;

5.8.8. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

5.9. Үнэт цаас гаргагч нь компанийн оноосон нэрийг өөрчлөх, компанийн зарласан хувьцааны тоонд өөрчлөлт оруулах тохиолдолд дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5.9.1. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

5.9.2. компанийн шинэчилсэн дүрмийн төсөл;

5.9.3. компанийн оноосон нэрийн баталгаажуулалт;

5.9.4. арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолт.

5.10. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.3-т заасны дагуу хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцааг Хороонд хялбаршуулсан журмаар бүртгүүлэх ба дараах баримт бичгийг хавсаргана.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

5.10.1. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл /энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу/;

5.10.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

5.10.3. андеррайтерийн компанитай байгуулсан гэрээ болон тодорхойлох захидал;

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дугаар тогтоолоор нэмсэн/

5.11. Урьд нь нийтэд санал болгон үнэт цаас гаргасан үнэт цаас гаргагч өөр төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар гаргаж байгаа бол энэ талаар ажлын 3 өдрийн дотор Хороонд мэдэгдэж, олон нийтэд мэдээлнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дугаар тогтоолоор нэмсэн/

ЗУРГАА. Бүртгэлээс хасах

6.1. Үнэт цаас гаргагчийн хувьцааг дараах тохиолдолд Хорооны бүртгэлээс хасна.

6.1.1. үнэт цаас гаргагч өөрөө хүсэлт гаргасан;

6.1.2. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан;

6.1.3. шүүх болон эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрээр татан буулгах шийдвэр гаргасан.

6.2. Нийтэд санал болгон анх удаа болон нэмж хувьцаа гаргасан үнэт цаас гаргагч нь өөрийн хүсэлтээр Хороо болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасуулах хүсэлтийг гаргахад нэгдмэл сонирхолгүй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэсэн байна.

6.3. Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа бүртгэлээс хасуулахдаа дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

6.3.1. албан хүсэлт;

6.3.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

6.3.3. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хассан тухай шийдвэр;

6.3.4. компанийн хувьцаа эзэмшигчдийн тусгаарлагдсан хувьцааны талаарх мэдээлэл;

6.3.5. компани нь хувьцааг эргүүлэн худалдан авахаар бол хувьцаа эзэмшигчдэд ногдох мөнгөн хөрөнгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын дансанд байршуулсан талаарх “Хувьцааны төлбөр гүйцэтгэх гэрээ” болон мөнгөн хөрөнгө байршуулсан тухай тодорхойлолт, Хороонд бүртгэлтэй хөрөнгийн үнэлгээний компаниар сүүлийн 6 сарын хугацаанд хувьцаа эзэмшигчдэд ногдох нэгж хувьцааны үнэлгээг тогтоолгосон үнэлгээний тайлан;

6.3.6. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн төлбөрийн баримт.

6.4. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаас гаргагчийн хувьцааг өөрийн бүртгэлээс хассан нөхцөлд бүртгэлээс хассан талаарх шийдвэр, дүгнэлтийг Хороонд ажлын 3 өдөрт багтаан ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

6.5. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан үнэт цаас гаргагч нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, хувьцаагаа Хорооны бүртгэлээс хасуулах хүсэлтээ 1 сарын дотор гаргана.

6.6. Энэ журмын 6.5-д заасан хүсэлтийг үнэт цаас гаргагч гаргаагүй тохиолдолд Хороо хугацаатай үүрэг, даалгавар өгнө.

6.7. Хувьцаа эзэмшигч нь энэ журмын 6.3.5-д заасан ногдох мөнгөн хөрөнгийг 2 сарын хугацаанд өөрийн дансанд шилжүүлж авах хүсэлтээ гаргаагүй тохиолдолд бүртгэлээс хасагдсан компанийн хувьцаа эзэмшигчээр үлдсэнд тооцож, бүртгэлээс хасагдсан компанийн гүйцэтгэх удирдлага компанийн шинэчилсэн дүрмийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсний дараа шинэчилсэн дүрмийн хуулбар, хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг Хороонд ирүүлнэ.

6.8. Хороо нь хувьцааг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн

цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

6.9. Хороо үнэт цаас гаргагчийн хувьцааг бүртгэлээс хассан тохиолдолд шийдвэрийг ажлын 10 өдөрт багтаан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэнэ.

6.10. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь Хорооны бүртгэлээс хасагдсан үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг үнэт цаас гаргагч болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад тус тус ажлын 10 өдөрт багтаан хүргүүлнэ.

ДОЛОО. Хувьцааг анхдагч зах зээлд санал болгох, худалдах

7.1. Энэ журмын 3.3-т заасан Хорооны шийдвэрт үнэт цаас гаргагч үнэт цаасаа нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд анхдагч зах зээлд худалдах зөвшөөрөл болон холбогдох этгээдийн хувьцааг тусгаарлах, чөлөөлөх хугацааг тус тус заасан байна.

7.2. Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн Хороонд бүртгэгдсэн үнэт цаасны танилцуулгад заасан арга хэлбэрээр нийтэд санал болгон, эсхүл хаалттай хүрээнд үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдана.

7.3. Андеррайтер нь үнэт цаас гаргагч, түүний хувьцааны талаарх танилцуулгыг 50 ба түүнээс дээш тооны этгээдэд санал болгон худалдахаа цахим орчин дахь нийтийн сүлжээ, мэдээлэх хэрэгслээр мэдэгдэх ажиллагааг ажлын 10 өдрийн дотор, хувьцааны захиалгын бүртгэлийг ажлын 5 өдрийн дотор тус тус хийж гүйцэтгэнэ.

7.4. Андеррайтер нь энэ журмын 7.3-т заасан олон нийтэд танилцуулах ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнөх хугацаанд стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хувьцааны талаар танилцуулж болно.

7.5. Андеррайтер нь энэ журмын 7.3-т заасан олон нийтэд танилцуулах, сурталчлах болон хувьцааны захиалгыг эхлүүлэх хугацаа, хуваарийн талаар уг ажиллагааг эхлүүлэхээс ажлын 3- аас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэнэ.

7.6. Андеррайтер нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааны тодорхой хувийг худалдан авах бөгөөд энэ талаар үнэт цаасны танилцуулгад тусгасан байна.

7.7. Андеррайтер нь Хорооноос хоёрдогч зах зээлийн арилжаа эхлүүлэх зөвшөөрөл олгох хүртэл үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хувь хэмжээгээр татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагын дансанд байршуулна.

7.8. Энэ журмын 7.21, 7.22-т тус тус заасны дагуу үнэт цаас гаргагчийн өмчлөх эрхийн бүртгэл хийгдэж, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага нь татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаас гаргагчийн холбогдох банкны дансанд шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.9. Андеррайтер нь захиалгын бүртгэлийн аргаар хувьцааны захиалгыг бүрдүүлэх тохиолдолд үнэт цаасны танилцуулгад тусгасан үнийн дээд, доод хязгаарын хүрээнд хөрөнгө оруулагчдаас хувьцааны захиалгыг хүлээн авч, худалдах ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.10. Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн хувьцааг худалдан авах захиалгын бүртгэлийг хийж, хөрөнгө оруулагчдаас ирүүлсэн үнийн саналд үндэслэн нийтэд санал болгох эцсийн үнийг үнэт цаас гаргагчийн саналыг харгалзан тогтооно.

7.11. Андеррайтер нь нийтэд санал болгох хувьцааг тогтоосон үнээр санал болгож буй тохиолдолд энэ журмын 7.9, 7.10 дахь заалт хамаарахгүй.

7.12. Андеррайтер нь энэ журмын 7.3-т заасны дагуу анхдагч зах зээлд хувьцааны

захиалгыг бүрдүүлэхдээ өөрийн харилцагчдаас гадна бусад үнэт цаасны компанийн харилцагчдыг захиалга өгч, хувьцаа худалдан авах тэгш бололцоогоор хангасан байх ба хувьцааны хуваарилалтыг хийхдээ стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс бусад хөрөнгө оруулагчдад хувь тэнцүүлэн олгох зарчмаар хийж, байршуулна.

7.13. Андеррайтер нь үнэт цаасны танилцуулгад тусгасан хэмжээгээр санхүүжилтийг бүрэн татан төвлөрүүлэх, хувьцааг хуваарилах ажиллагааг хувьцааны захиалгын бүртгэлийг хийж дууссан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор гүйцэтгэнэ.

7.14. Андеррайтер нь үнэт цаас гаргагчтай тохиролцсоны үндсэн дээр нийтэд санал болгон гаргах хувьцааг анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд анхдагч зах зээлд нийтэд санал болгох хувьцааг тогтоосон үнээр санал болгоно.

7.15. Нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцааг анхдагч зах зээлд санал болгох, худалдах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан зохион байгуулахад энэ журмын 7.3, 7.5, 7.13, 7.17-д заасан хугацаа нэгэн адил хамаарна.

7.16. Андеррайтер нь хоёр удаа дараалан хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж чадаагүй нь тухайн этгээдийн андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

7.17. Андеррайтер нь энэ журмын 7.13-т заасны дагуу үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг хөрөнгө оруулагчдад худалдаж, санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны хоёрдогч зах зээл дээр арилжих бэлтгэл хангагдсан тухай тодорхойлолтын хамт энэ журмын 3 дугаар хавсралтын дагуу Хороонд ирүүлнэ.

7.18. Хороо нь тухайн үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагаа амжилттай явагдаагүй тохиолдолд нийтэд санал болгон гаргахыг зөвшөөрсөн хувьцааны бүртгэлийг хүчингүй болгож, энэ тухай нийтэд мэдээлнэ.

7.19. Хороо нь энэ журмын 7.17-д заасан тайланг ажлын 3 өдөрт багтаан хянах ба тухайн үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагаа амжилттай явагдсан гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийх, арилжаа эрхлэх байгууллагад хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг Хорооны даргын албан бичгээр хүргүүлнэ.

7.20. Анхдагч зах зээлд хувьцааны захиалгын эрэлтийн хэмжээ нь нийлүүлэлтийн хэмжээнээс давсан тохиолдолд андеррайтер, үнэт цаас гаргагч тохиролцсоны үндсэн дээр нийтэд гаргасан хувьцааны 15 хүртэлх хувийг нэмж гаргаж болох бөгөөд энэ талаар энэ журмын 3.3-т заасан Хорооны шийдвэрт тусгасан байна.

7.21. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэ журмын 7.19-т заасан Хорооны албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор үнэт цаас гаргагчийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлийг хийх ба энэ талаар Хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэнэ.

7.22. Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 7.21-т заасан үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлийг хийсэн тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 2 өдрийн дотор тухайн үнэт цаас гаргагчийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

7.23. Хороо нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргаж буй үнэт цаас гаргагчийн Хороонд бүртгүүлэхээс өмнөх үеийн компанийн нийт хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг дангаар болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байсан этгээдийн хувьцааг 6 сарын хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаар тусгаарлуулна.

7.24. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэ журмын 7.23-т заасан этгээдийн хувьцааг Хорооны шийдвэрийн дагуу тусгаарлаж, чөлөөлөх ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.25. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэ журмын 7.23-т заасан этгээдийн хувьцааг тусгаарлалтаас чөлөөлсөн талаарх мэдэгдлийг ажлын 3 өдрийн дотор өөрийнцахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

7.26. Банкны нийт гаргасан энгийн хувьцааны 20 хувиас дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж буй этгээдийн Банкны тухай хуулийн 36.1-д заасан шаардлагыг хангах зорилгоор бусдад худалдах, шилжүүлэх шаардлагатай хувьцаанд энэ журмын 7.23 дахь хэсэг хамаарахгүй.

НАЙМ. Хувьцааны үнэ тогтворжуулалт

8.1. Андеррайтер нь нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргаж байгаа үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш 1 сараас доошгүй хугацаанд гүйцэтгэнэ.

8.2. Андеррайтер нь энэ журмын 8.1-д заасан хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх тохиолдолд хүлээх үүрэг, хариуцлага, уг ажиллагааг гүйцэтгэх хугацааны талаар үнэт цаас гаргагчтай байгуулах гэрээ болон үнэт цаасны танилцуулгад тус тус тусгах бөгөөд дээрх ажиллагаанаас гарах зардлыг үнэт цаас гаргагчийн нийтээс татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөнөөс суутган тооцохгүй.

8.3. Андеррайтер нь хувьцааны үнийг тогтворжуулах арга хэмжээг туслах андеррайтер, эсхүл зах зээл үүсгэгчээр оролцох сонирхол бүхий бусад үнэт цаасны компанитай хамтран хэрэгжүүлж болно.

8.4. Андеррайтер нь энэ журмын 8.3-т заасан зах зээл үүсгэгчээр хувьцааны үнэ тогтворжуулах арга хэмжээг гүйцэтгүүлэх тохиолдолд уг зах зээл үүсгэгчийн талаар дараах мэдээллийг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

8.4.1. зах зээл үүсгэгчийн талаарх мэдээлэл;

8.4.2. бусад зах зээл үүсгэгчтэй хамтран хэрэгжүүлж байгаа бол түүний талаарх мэдээлэл;

8.4.3. хувьцааны үнийг тогтворжуулах хугацаа;

8.4.4. хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх журам

8.5. өсөлт, бууралтаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцаа худалдан авах, зарах ажиллагааг гүйцэтгэж, эрэлт нийлүүлэлтийн зарчмыг үйлажиллагаандаа мөрдөнө.

8.6. Андеррайтер, зах зээл үүсгэгчээс үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажиллагааг зах зээлийг урвуулан ашиглах хэлбэр гэж үзэхгүй бөгөөд хэрэв андеррайтер, зах зээл үүсгэгч нь хувьцааны үнийг тогтворжуулах нэрийн дор Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасан хэлбэрээр зах зээлийг урвуулан ашигласан нь тогтоогдсон тохиолдолд Хороо хуулийн хариуцлага хүлээлгэж, энэ талаар өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

8.7. Үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагааг хэрэгжүүлэх андеррайтер, зах зээл үүсгэгчийн чиг үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны онцлогтой холбоотой болон зах зээлийг урвуулан ашигласныг тогтоох, түүнээс хамгаалахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан журмыг арилжаа эрхлэх байгууллага тогтоож, уг журмыг Хороогоор батламжлуулна.

8.8. Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 8.7-д заасан журмын хүрээнд

андеррайтер, зах зээл үүсгэгчийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж, зах зээлийг урвуулан ашиглах замаар үнэ ханшийг зохиомлоор тогтоосныг илрүүлэх, зах зээлийг урвуулан ашиглахаас хамгаалах ажиллагааг хэрэгжүүлэх ба хувьцааны үнийг зохиомлоор өсгөсөн нь тогтоогдсон тохиолдолд холбогдох арга хэмжээг авч, хуулийн хариуцлага хүлээлгэх талаар холбогдох дүгнэлт, тайланг тухай бүр Хороонд ирүүлнэ.

8.9. Андеррайтер, зах зээл үүсгэгч нь үнэт цаас гаргагчийн хувьцааны үнийг тогтворжуулах ажиллагаа дууссан өдрөөс хойш тогтворжуулалтын чиглэлээр хийсэн гүйлгээний тайланг ажлын 3 өдрийн дотор Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

ЕС. Үнэт цаас гаргагч, арилжаа эрхлэх байгууллага, Хорооны эрх, үүрэг

9.1. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараах үүрэгтэй.

9.1.1. Хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалж, ногдол ашгийн бодлого, журмыг батлан мөрдөх;

9.1.2. Андеррайтер, хууль, аудит, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч этгээд болон хөндлөнгийн шинжээчдэд шаардлагатай үнэн зөв, бодитой мэдээллийг бүрэн гаргаж өгөх;

9.1.3. Энэ журмын 9.1.2-т заасан хууль, аудит, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч этгээд болон хөндлөнгийн шинжээчийн үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлөх, сонирхлын зөрчил үүсгэхгүй байх;

9.1.4. Нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах замаар компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болохыг Хороо зөвшөөрсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, компанийн шинэчилсэн дүрмийн төслийг батлан улсын бүртгэлд бүртгүүлнэ;

9.1.5. Хороонд бүртгүүлсэн үнэт цаасны танилцуулга, түүнд хавсаргасан холбогдох бүх баримт материалыг 10 жилийн хугацаанд компани дээрээ хадгалах.

9.2. Үнэт цаас гаргагч нь дараах эрхтэй.

9.2.1. Андеррайтераас гаргасан нарийвчилсан шинжилгээ, судалгаа, хийсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн нийтэд санал болгох хувьцааны анхны үнийг хамтран тогтоох;

9.2.2. Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигч, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь компанийн нийт гаргасан хувьцааны 5 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний өөрийн эзэмшлийн хувьцааг анхдагч зах зээлд худалдаж болно.

9.3. Арилжаа эрхлэх байгууллага нь дараах үүрэгтэй.

9.3.1. Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргасан хувьцааг бүртгэсэн тухай шийдвэр, хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулсан шийдвэрийг тус тус ~~хөжбөгдөж дүгнэлт~~, “Бүртгэв” тэмдэглэл бүхий үнэт цаас гаргагчийн ирүүлсэн үнэт цаасны танилцуулга, бусад баримт бичгийн хуулбарын хамт дээрх шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор Хороонд ирүүлэх;

9.3.2. Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг үр ашигтай, шударга, ил тод зарчмаар зохион байгуулан, хяналт тавьж ажиллах;

9.3.3. Үнэт цаасны хоёрдогч зах зээл дээр арилжих бэлтгэл хангагдсан тухай тодорхойлолтыг энэ журмын 7.17-д заасан хугацаанд андеррайтерт хүргүүлэх.

9.4. Арилжаа эрхлэх байгууллага нь дараах эрхтэй.

9.4.1. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн журмын нөхцөл шаардлагын дагуу үнэт цаас гаргагчийн хувьцааг өөрийн бүртгэлд бүртгэх, өөрчлөлт оруулах, хасах, бүртгэхээс татгалзах.

9.5. Хороо нь дараах эрхтэй.

9.5.1. Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргах хувьцааг Хорооны бүртгэлд бүртгэх, өөрчлөлт оруулах, хасах, бүртгэхээс татгалзах;

9.5.2. Энэ журмын 7.23-т заасан компанийн хувьцааг төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тусгаарлуулах;

9.5.3. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хувьцааг үнэт цаас гаргагчийн зүгээс тавьж буй ямар нэгэн нөхцөл болзолтойгоор Хороо бүртгэхгүй;

9.5.4. Нийтэд санал болгон гаргах хувьцааг бүртгэхтэй холбоотойгоор тодруулга, нэмэлт баримт бичгийг үнэт цаас гаргагчаас шаардах.

АРАВ. Үнэт цаас гаргагчийн тогтоосон хугацаанд болон тухай бүр ирүүлэх мэдээллийн төрөл, мэдээлэх хэлбэр

10.1. Үнэт цаас гаргагч нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон энэ журмаар тогтоосон мэдээлэл, тайлагналыг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, цаг хугацаанд нь Хороо, хөрөнгө оруулагч болон олон нийтэд хүргэх үүрэгтэй.

10.2. Үнэт цаас гаргагч нь энэ журмын 10.1-д заасан мэдээлэл, тайлагналыг Монгол хэлээр хүргэх ба шаардлагатай гэж үзвэл гадаад хэлээр хүргэж болно.

10.3. Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл нь мэдээлэл, тайлагналыг энэ журамд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн мэдээлж байгаа эсэхэд хяналт тавина.

10.4. Үнэт цаас гаргагч энэ журамд заасан мэдээллийг нийтэд хүргэх харилцааг зохицуулсан дотоод журам баталж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.

10.5. Үнэт цаас гаргагчийн мэдээлэл, тайлагнал нь хугацаат тайлагнал болон тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл гэсэн хоёр төрөлтэй байна.

10.6. Үнэт цаас гаргагч нь хугацаат тайлагнал болон тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллээ энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу цахим болон цаасан хэлбэрээр Хороонд ирүүлж, өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

10.7. Үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал нь жил, хагас жилийн үйл ажиллагааны тайлан хэлбэртэй байна. Үнэт цаас гаргагч жилийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

10.8. Үнэт цаас гаргагч нь хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргалтад нөлөө үзүүлэхүйц нөхцөл байдал үүссэн тохиолдолд тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийг нөхцөл байдал үүссэнээс хойш Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56.1-д заасан хугацаанд мэдээлнэ.

10.9. Хороо үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал болон тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийн нэгдсэн санг үүсгэн хөрөнгө оруулагчдад нээлттэй хэлбэрээр ажиллуулж, олон нийтэд мэдээлнэ.

10.10. Хорооны хянан шалгагч нь үнэт цаас гаргагчийн хугацаат тайлагнал болон тухай бүр нийтэд мэдээлэх мэдээллийн агуулга, бүрдэл, олон нийтэд түгээсэн хэлбэр, ирүүлсэн хугацаанд хяналт тавьж, хууль тогтоомжид заасан үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргээ хэрэгжүүлээгүй нь тогтоогдвол Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулна.

10.11. Үнэт цаас гаргагч нь энэ журмын 4 дүгээр хавсралтад тусгагдсан мэдээллээс гадна хөрөнгө оруулагчдад шаардлагатай гэж үзсэн компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдлын талаарх бусад мэдээллийг нийтэд мэдээлж болно.

10.12. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь энэ журамд заасан мэдээлэл тайлагналыг Монгол хэл дээр орчуулан нийтэд мэдээлнэ.

10.13. Үнэт цаас гаргагчийн мэдээлэх үүргийн хэрэгжилтэд арилжаа эрхлэх байгууллага хяналт тавьж ажиллах бөгөөд арилжаа эрхлэх байгууллагаас мэдээллийн ил тод байдлыг хангуулахтай холбоотой нарийвчилсан журмыг тогтоон, мөрдүүлнэ.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор нэмсэн/

АРВАН НЭГ. Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэх, бүртгэлээс хасах, тэдгээрийн үйл ажиллагаа

11.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.15, 24.1.16, 24.1.17-д заасан этгээдүүд нь энэ журмаар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж Хороонд бүртгүүлсний үндсэн дээр хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлнэ.

11.2. Хууль, аудит, хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгчийн гүйцэтгэх захирал, энэ журмаар тогтоосон мэргэжилтнүүд нь үнэт цаасны зах зээлийн чиглэлээр төрөлжсөн сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

11.3. Энэ журмын 11.2-т заасан сургалтыг мэргэжлийн холбоод зохион байгуулан ажиллаж, Хорооноос сургалтад хамрагдсан этгээдээс шалгалт авч эрхийн гэрчилгээг олгох, сургалтын зохион байгуулалтад хяналт тавьж ажиллана.

11.4. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэхийг хүссэн хуулийн байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

11.4.1. хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагааг 2-оос дээш жил эрхэлсэн байх;

11.4.2. хуулийн байгууллага нь 2 ба түүнээс дээш орон тооны хуульчтай байх бөгөөд хуульчид нь 1-ээс дээш жилийн хугацаанд ажиллаж, нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн үндсэн ажилтан байх;

11.4.3. хуульчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй байх.

11.5. Энэ журмын 11.4-т заасан шаардлагыг хангасан хуулийн этгээд нь энэ журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдлийг дор дурдсан баримт бичгийн хамт Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

11.5.1. улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм эсхүл нөхөрлөлийн үүсгэн байгуулагчдын гэрээ, батламжийн хуулбар;

11.5.2. орон тооны хуульчдын хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, үнэт цаасны зах зээлийн төрөлжсөн сургалтад хамрагдсан болон мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг нотлох баримт бичгийн хуулбар;

11.5.3. хуульчид нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай холбогдох мэргэжлийн холбооны тодорхойлолт;

11.5.4. үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагааны болон дотоод хяналтын журам;

11.5.5. хуулийн байгууллагын үйл ажиллагааны талаарх түүхчилсэн дэлгэрэнгүй танилцуулга, үнэт цаасны зах зээлд оролцогчдод хууль зүйн зөвлөгөөг тогтмол, үр дүнтэй, хариуцлагатай үзүүлэх чиглэлээр боловсруулсан хэрэгжихүйц дунд болон урт хугацааны бизнесийн төлөвлөгөө;

11.5.6. Хорооноос шаардсан бусад мэдээлэл.

11.6. Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэхийг хүссэн аудитын компани нь дараах шаардлагыг хангасан байна.

11.6.1. аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, аудитын үйл ажиллагааг 3-аас доошгүй жил эрхэлсэн байх;

11.6.2. аудитын компани нь 4 ба түүнээс дээш орон тооны аудитортой байх; 11.6.3. аудитын компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнууд нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

11.6.3.1. аудиторууд тухайн аудитын байгууллагад 2-оос доошгүй жилийн хугацаандажиллаж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн үндсэн ажилтан байх;

11.6.3.2. мэргэшсэн нягтлан бодогчийн хугацаагүй эрхтэй 4-өөс доошгүй аудитортой байна.

11.6.3.3. аудитын компанийн эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх.

/Энэ дэд заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор нэмсэн/

11.6.4. аудитын компани нь гүйцэтгэх удирдлагаас томилогдсон 2-оос доошгүй гишүүнтэй чанарын хяналтын нэгжтэй байх бөгөөд 1-ээс доошгүй нь мэргэжлийн байгууллагаасолгосон аудиторын батламжтай байх;

11.6.5. аудитын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 30,000,000.00 /гучинсая/ төгрөг байх;

11.6.6. аудиторууд нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй байх.

11.6.7. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18.4-т заасан жагсаалтад багтсан арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй үнэт цаас гаргагчид аудитын үйлчилгээ үзүүлж байсан компанийн хувьд энэ журмын 11.6.1, 11.6.3.1 дэх заалт хамаарахгүй бөгөөд тухайн компанидаа 2-оос доошгүй жил ажилласан туршлагатай үндсэн аудитортой байх.

11.7. Энэ журмын 11.2, 11.6-д заасан шаардлагыг хангасан аудитын компани нь энэ журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдлийг дор дурдсан баримт бичгийн хамт Хороонд хэвлэмэл болон цахим хэлбэрээр ирүүлнэ.

11.7.1. улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрэм, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;

11.7.2. орон тооны аудиторуудын аудитын үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, үнэт цаасны зах зээлийн төрөлжсөн сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар, мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээ²;

11.7.3. аудиторууд нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай холбогдох мэргэжлийн холбооны тодорхойлолт;

11.7.4. холбогдох эрх бүхий байгууллагаас зохион байгуулсан чанарын хяналтын шалгалтад хамрагдаж, хангалттай үнэлгээ авсан талаарх нотлох баримт;

11.7.5. аудитын дүгнэлттэй сүүлийн жилийн санхүүгийн тайлан;

11.7.6. аудитын компани нь үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх аудитын үйл ажиллагааны болон чанарын хяналтын журам;

11.7.7. аудитын компанийн үйл ажиллагааны талаарх түүхчилсэн дэлгэрэнгүй танилцуулга, бизнесийн төлөвлөгөө;

11.7.8. аудитын компани нь дараах журмуудыг боловсруулан гүйцэтгэх удирдлагаар батлуулсан байна. Үүнд:

- 11.7.8.1. Аудитын компанийн үйл ажиллагааны журам;
- 11.7.8.2. Аудитын чанарын стандартын журам;
- 11.7.8.3. Ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай журам;
- 11.7.8.4. Чанарын хяналтын журам;
- 11.7.8.5. Мэдээллийн ил тод байдлын тухай журам.

11.7.9. Хорооноос шаардсан бусад мэдээлэл.

11.8. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэхийг хүссэн хөрөнгийн үнэлгээний компани нь дараах шаардлагыг хангасан байна.

11.8.1. хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагааг 3-аас дээш жил тасралтгүй эрхэлсэн байх;

11.8.2. хөрөнгийн үнэлгээний компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 30,000,000.00 /гучин сая/ төгрөг байх;

11.8.3. хөрөнгийн үнэлгээний компани нь 2 ба түүнээс дээш орон тооны үнэлгээчинтэй байх бөгөөд үнэлгээчид нь 2-оос доошгүй жилийн хугацаанд ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн үндсэн ажилтан байх;

11.8.4. үнэлгээчид нь мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй байх.

11.9. Энэ журмын 11.2, 11.8-д заасан шаардлагыг хангасан хөрөнгийн үнэлгээний компани нь энэ журмын 5 дугаар хавсралтын дагуу гаргасан өргөдлийг дор дурдсан баримт бичгийн хамт Хороонд хэвлэмлээр эсхүл цахимаар ирүүлнэ.

11.9.1. улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн хуулбар;

11.9.2. орон тооны үнэлгээчдийн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, үнэт цаасны зах зээлийн төрөлжсөн сургалтад хамрагдсаныг гэрчлэх болон мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсаныг нотлох баримтын хуулбар;

² уг гэрээг байгуулахдаа ажлын гүйцэтгэлтэй уялдуулсан байдлаар нөхөн төлбөрийн үнэлгээний доод хязгаарыг тогтоосон байна.

11.9.3. аудитын дүгнэлттэй сүүлийн жилийн санхүүгийн тайлан;

11.9.4. үнэлгээчид нь мэргэжлийн болон ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй тухай холбогдох хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын тодорхойлолт;

11.9.5. хөрөнгийн үнэлгээний компани нь үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх үнэлгээний үйл ажиллагааны болон хараат бус байдлыг тогтоох, хянах горим, чанарын хяналтын журам;

11.9.6. үнэлгээний байгууллагын үйл ажиллагааны талаарх түүхчилсэн дэлгэрэнгүй танилцуулга, бизнесийн төлөвлөгөө;

11.9.7. Хорооноос шаардсан бусад мэдээлэл.

11.10. Энэ журам, холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаагүй нөхцөлд хуулийн этгээдийг Хороо бүртгэхээс татгалзаж болох бөгөөд уг хуулийн этгээдийн 1 жилийн дотор гаргасан хүсэлтийг хүлээж авахгүй.

11.11. Хороо бүртгэлийн нөхцөл, шаардлагын биелэлтийг хянах үүднээс хагас жил тутамүйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бүртгэлтэй этгээдээс шаардах бөгөөд жилд нэг удаагаар дээрх шалгалтыг хийнэ.

11.12. Үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэгчийг дараах шалтгаанаар Хорооны бүртгэлээс хасна.

11.12.1. үйлчилгээ үзүүлэгчээс бүртгэлээс хасуулах хүсэлт гаргасан;

11.12.2. энэ журмын 11.2, 11.4, 11.6, 11.8-д заасан шаардлагуудыг тус тус хангахгүй

болсон;

11.12.3. бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

11.12.4. бодит бус дүгнэлт гаргаж, дагаж мөрдвөл зохих хууль, журам, стандартыг зөрчсөн, мэргэжлийн ноцтой алдаа гаргасан, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүссэн;

11.12.5 Хороо ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

11.12.6. Хороонд бүртгүүлснээс хойш 3 жилийн хугацаанд үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлээгүй;

11.12.7. газар дээрх болон зайны хяналт, шалгалтаар хангалтгүй үнэлгээ авсан;

11.12.8. холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон.

11.13. Энэ журмын 11.12-д заасан үндэслэлээр бүртгэлээс хасагдсан үйлчилгээ үзүүлэгч нь бүртгэлээс хасагдсанаас хойш 2 жилийн хугацаанд Хороонд дахин бүртгүүлэхээр хандах эрхгүй.

11.14. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч нь холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам, заавар аргачлалыг мөрдөн ажиллах бөгөөд үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаастай холбоотой хууль зүйн дүгнэлтийг дараах агуулгын хүрээнд гаргана.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

11.14.1. үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн эсэх, үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх;

11.14.2. үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангаж байгаа эсэх;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

11.14.3. үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, нийтэд санал болгон нэмж хувьцаа гаргаж буй үнэт цаас гаргагчийн хувьд түүний дотоод дүрэм, журмууд нь Хорооноос баталсан компанийн засаглалын кодекст нийцсэн эсэх;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

11.14.4. бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;

11.14.5. сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;

11.14.6. үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;

11.14.7. үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх;

11.14.8. үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;

11.14.9. компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд

үндэслэн үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох;

11.14.10. үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх;

11.14.11. татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх.

11.15. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч нь энэ журмын 11.14-д зааснаас бусад үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой хууль зүйн дүгнэлтийг дараах агуулгын хүрээнд гаргана.

11.15.1. үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх;

11.15.2. бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх;

11.15.3. сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;

11.15.4. Хорооноос баталсан компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан эсэх, үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн өмнө хуулиар хүлээсэн үүрэг, тэдгээрийн эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэртэй холбоотой шаардах эрх хэрэгжүүлэх нөхцөлийг хангасан эсэх;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

11.15.5. үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх.

11.16. Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэгч нь холбогдох хууль тогтоомж, аудитын олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас батлан гаргасан журам, зааварарга, аргачлалыг мөрдөж, аудиторуд нь чанарын хяналтын бодлого, дотоод журмуудыг хэрэгжүүлэн ажиллах ба үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

11.16.1. олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу аудитын үйлчилгээг үзүүлэх;

11.16.2. аудитын компани нь өөр ямар нэг ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг компанитай хамтарч дүгнэлт гаргахгүй байх;

11.16.3. мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах.

11.17. үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа болон нэмж гаргаж буй хувьцаа, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор хийгдсэн аудитын дүгнэлтэд дараах мэдээллийг тусгасан байна.

11.17.1. нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан нь холбогдох санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/-д нийцэж байгаа эсэх;

11.17.2. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналтын тогтолцоо нь СТОУС-д нийцэж буй эсэх, хувь нийлүүлсэн хөрөнгө болон түүний ашиглалтын үр ашигтай байдлыг хангаж чадах эсэх;

11.17.3. үнэт цаасны танилцуулга, хавсаргасан баримт бичигт тусгагдсан санхүүгийн мэдээлэл нь бодит байдалд нийцэж байгаа эсэх.

11.18. Энэ журмын 11.17-д заасан аудитын дүгнэлтээс гадна үйлчилгээ үзүүлэгч

аудитынкомпаниас ирүүлэх тодорхойлох захидалд үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, үнэт цааснытанилцуулгад тусгасан мэдээлэл нь үнэн зөв, СТОУС-ын дагуу тайлагнасан талаар баталж, үйлчилгээ үзүүлсэн этгээдтэй сонирхлын зөрчил үүсгээгүй, хараат бус ажилласан эсэх зэрэг мэдээллийг тусгасан байна.

11.19. Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч, эсхүландеррайтер нь холбогдох хууль тогтоомж, үнэлгээний олон улсын стандарт, эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар арга, аргачлалыг мөрдөж, үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

11.19.1. үнэлгээчид нь олон улсын үнэлгээний аргачлал болон холбогдох хууль, журмыг дагаж мөрдөн үйл ажиллагаа авуулдаг байх;

11.19.2. хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч нь шаардлагатай тохиолдолд ижилтөстэй үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагатай хамтарч үнэлгээг хийх боломжтой байх;

11.19.3. хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч нь нийтэд санал болгон анх удаа болон нэмж хувьцаа гаргаж буй үнэт цаас гаргагчийн хөрөнгөнд үнэлгээ хийж байгаа тохиолдолдуг үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд аудит хийхгүй байх.

11.20. Хороонд бүртгүүлсэн аудитын компани нь үнэт цаас гаргагчийн жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргана.

АРВАН ХОЁР. Хариуцлага

12.1. Үнэт цаас гаргагчаас энэ журмаар тогтоосон мэдээллийг холбогдох маягтаар тогтоосон хугацаанд ирүүлээгүй, худал хуурмаг, төөрөгдүүлсэн шинжтэйгээр ирүүлсэн гэж үзвэл Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг үндэслэн Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хүлээлгэх үндэслэл болно.

12.2. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

12.3. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

- Хавсралт 1: Хорооны бүртгэлд үнэт цаасыг бүртгүүлэх тухай өргөдөл*
- Хавсралт 2: Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээдийн гадаад улсад үнэт цаас гаргах, эсхүл гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх тухай мэдэгдэл*
- Хавсралт 3: Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгон худалдсан тухай тайлан*
- Хавсралт 4: Үнэт цаас гаргагчийн тогтоосон хугацааны болон тухай бүр мэдээлэх мэдээллийн агуулга, хэлбэр*
- Хавсралт 5: Үнэт цаасны зах зээлд оролцогчдод хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдээр бүртгүүлэхийг хүссэн өргөдөл*

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 1 дүгээр хавсралт

ХОРООНЫ БҮРТГЭЛД ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙӨРГӨДӨЛ

Огноо:/..../....
	Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1.	Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	
1.1.	Оноосон нэр:	Монгол:
		Англи:
1.2.	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани
		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани
1.3.	Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай
		<input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай
1.4.	Үүсгэн байгуулагдсан огноо: Он, сар, өдөр	
1.5.	Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:	
1.6.	Регистрийн дугаар:	
1.7.	Үйл ажиллагааны чиглэл:	
1.8.	Үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл:	<input type="checkbox"/> Иргэн <input type="checkbox"/> Хуулийн этгээд
	1.8.1. Иргэн бол түүний	
	Овог, нэр:	
	Иргэний харьяалал:	
	Регистр /паспорт/-ийн дугаар:	
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:	Мөнгөн дүн:
		Тоо ширхэг:

		Эзэмшиж буй хувь:
	1.8.2. Хуулийн этгээд бол түүний	
	Нэр:	
	Улсын бүртгэлийн дугаар:	
	Регистрийн дугаар:	
	Үйл ажиллагааны чиглэл:	
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:	Мөнгөн дүн:
		Тоо ширхэг:
		Эзэмшиж буй хувь:
1.9.	Гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг хувьцаа эзэмшигчийн талаарх мэдээлэл:	
1.10.	Оршин байх албан ёсны хаяг /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:	
1.11.	Цахим хуудас:	
1.12.	Цахим шуудангийн хаяг:	
1.13.	Холбоо барих утас:	
	Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны бүртгэлд дараах үнэт цаасыг бүртгүүлэхээр энэхүү өргөдлийг гаргаж байна. Үнэт цаасны бүртгэлийн журамд заасан холбогдох ... нүүр баримт бичгийг хавсарган хүргүүлэв.	
2.	Үнэт цаасны мэдээлэл	
2.1.	Үнэт цаасны нэр:	
2.2.	Өмнө аль нэгэн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх болон үнэт цаас гаргасан улс, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:	
2.3.	Өмнө нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллага, түүнийг	

	<i>бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрийн дугаар, огноо:</i>	
2.4.	<i>Өмнө гаргасан үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо ширхэг, код, ISIN код:</i>	
2.5.	<i>Бүртгүүлэх үнэт цаасны төрөл:</i>	<i>Анх удаа хувьцаа гаргах Нэмж хувьцаа гаргах Хувьцаанд хөрвөх опцион гаргах Хувьцаанд хөрвөх өрийн хэрэгсэл гаргах Өрийг хувьцаагаар солих</i>
2.6.	<i>Үнэт цаас гаргах арилжаа эрхлэх байгууллага:</i>	
	<i>Хувьцаа гаргах бол түүний</i>	
2.7.	<i>Тоо ширхэг:</i>	
2.8.	<i>Нэрлэсэн үнэ:</i>	
2.9.	<i>Нийтэд санал болгох үнэ, хэлбэр:</i>	
2.10.	<i>Нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ:</i>	
2.11.	<i>Үнэт цаасыг нийтэд санал болгон худалдахаар төлөвлөсөн хугацаа:</i>	
2.12.	<i>Үнэт цаас гаргах замаар нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн зориулалтын талаарх товч мэдээлэл:</i>	
	<i>Опцион гаргах бол түүний</i>	
2.13.	<i>Тоо ширхэг:</i>	
2.14.	<i>Опционы үнэ, хугацаа:</i>	
2.15.	<i>Суурь хувьцааны үнэ:</i>	
2.16.	<i>Худалдан авч болох хувьцааны тоо</i>	
	<i>Хувьцаанд хөрвөх өрийн хэрэгсэл гаргах бол түүний</i>	
2.17.	<i>Тоо ширхэг:</i>	

2.18.	<i>Нэрлэсэн үнэ:</i>	
2.19.	<i>Гаргах үнэ /зах зээлийн үнэ/:</i>	
2.20.	<i>Хугацаа, хүү:</i>	
2.21.	<i>Хүүгийн төрөл /хөвөх, тогтмол г.м/:</i>	
2.22.	<i>Хөрвүүлэх хугацаа:</i>	
2.23.	<i>Хөрвүүлэх үнэ:</i>	
2.24.	<i>Хөрвүүлэх харьцаа:</i>	
2.25.	<i>Бусад нөхцөл /хугацаанаас өмнө эргүүлэн худалдаж авах г.м/</i>	
	Өрийг хувьцаагаар солих бол түүний	
2.26.	<i>Тоо ширхэг:</i>	
2.27.	<i>Нэрлэсэн үнэ:</i>	
2.28.	<i>Нэгж хувьцаанд хөрвүүлэх үнэ:</i>	
2.29.	<i>Хувьцаанд хөрвүүлэх харьцаа:</i>	
2.30.	<i>Нийт өрийн хэмжээ:</i>	
2.31.	<i>Өр үүссэн шалтгаан:</i>	
3.	Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зөвлөгөө өгсөн зохицуулалттай хуулийн этгээдийн мэдээлэл	
3.1.1.	<i>Андеррайтерийн оноосон нэр /туслах андеррайтертай оролцож байгаа бол энэ болон дараах мэдээллийг мөн бичнэ/:</i>	
3.1.2.	<i>Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:</i>	
3.1.3.	<i>Регистрийн дугаар:</i>	
3.1.4.	<i>Эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:</i>	

3.1.5.	<i>Оршин байх албан ёсны хаяг /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:</i>	
3.1.6.	<i>Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:</i>	
3.2.1.	<i>Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:</i>	
3.2.2.	<i>Бүртгэлтэй улс, бүртгэлийн дугаар:</i>	
3.2.3.	<i>Регистрийн дугаар:</i>	
3.2.4.	<i>Хороонд бүртгүүлсэн тогтоолын дугаар, огноо:</i>	
3.2.5.	<i>Оршин байх албан ёсны хаяг /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:</i>	
3.2.6.	<i>Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:</i>	
3.3.	<i>Үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргахтай холбоотойгоор ямар нэгэн хөрөнгийн үнэлгээний байгууллага, хөндлөнгийн шинжээчтэй гэрээ байгуулан ажилласан тухай мэдээлэл:</i>	

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны танилцуулга, бусад баримт бичигт үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

<p>1. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....” ..К-ийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>4. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: андеррайтерийн компанийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
<p>2. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....” ..К-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>5. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: андеррайтерийн компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
<p>3. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....” ..К-ийн Ерөнхий нягтлан бодогч</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>6. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал хуулийн зөвлөх “.....” ..К-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>

Өргөдөл гаргасан огноо:.....

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан
ажиллах ажилтны овог нэр, албан тушаал,
холбоо барих утас:

--

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө/

<p>Өргөдөл хүлээн авсан ажилтны овог нэр:</p>	<p>Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:</p>	<p>Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:</p>
---	--	--

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар
сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан
“Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 2 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСАД БҮРТГЭГДСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ГАДААД
УЛСАД ҮНЭТ ЦААС ГАРГАХ, ЭСХҮЛ ГАДААД УЛСЫН АРИЛЖАА
ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛЭХ ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ
МЭДЭГДЭЛ**

Огноо:/...../.....
	Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1.	Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	
1.1.	Оноосон нэр:	Монгол:
		Англи:
1.2.	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани
		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани
1.3.	Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай
		<input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай
1.4.	Үүсгэн байгуулагдсан огноо: Он, сар, өдөр	
1.5.	Регистрийн дугаар:	
1.6.	Үйл ажиллагааны чиглэл:	
1.7.	Оршин байх албан ёсны хаяг:	
1.8.	Цахим хуудас:	
1.9.	Цахим шуудангийн хаяг:	
1.10.	Холбоо барих утас:	
2.	Үнэт цаасны мэдээлэл	
2.1.	Үнэт цаасны нэр, нэрлэсэн үнэ, тооширхэг:	

2.2.	<i>Хувьцаа гаргаж буй тохиолдолд бүртгүүлэх арилжаа эрхлэх байгууллагын нэр, улс:</i>	
2.3.	<i>Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ, зориулалт:</i>	
2.4.	<i>Санал болгох хөрөнгө оруулагч:</i>	
3.	Үнэт цаас гаргагчид мэргэжлийн зуучлагчийн мэдээлэл	
3.1.	<i>Зуучлагчийн нэр:</i>	
3.2.	<i>Бүртгэлтэй улс:</i>	
3.3.	<i>Регистрийн дугаар:</i>	
3.4.	<i>Үйл ажиллагааны чиглэл:</i>	
3.5.	<i>Оршин байх албан ёсны хаяг:</i>	
3.6.	<i>Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:</i>	
	Баталгаажуулалт:	

Энэхүү мэдэгдлийг Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.3-т заасны дагуу гадаад улсад үнэт цаас гаргах, эсхүл гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас бүртгүүлэх тохиолдолд Хороонд хүргүүлж, мэдэгдэнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

**ХУВЬЦААГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД
САНАЛ БОЛГОН ХУДАЛДСАН ТУХАЙ
ТАЙЛАН**

Огноо:/..../....
	Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1.	Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	
1.1.	Оноосон нэр:	
1.2.	Гаргасан үнэт цаасны нэр, төрөл, тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хугацаа, хүү, хүү төлөгдөх нөхцөл, код, ISIN код:	
1.3.	Оршин байх албан ёсны хаяг /Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын хаягийг мөн бичнэ/:	
1.4.	Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:	
1.5.	Нийтэд санал болгон үнэт цаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий зохицуулагч байгууллагын шийдвэрийн огноо, дугаар:	
1.6.	Анхдагч зах зээлд санал болгож эхэлсэн болон дууссан огноо:	
	Энэ журмын 7.15-д заасны дагуу үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдах ажиллагааг амжилттай зохион байгуулж, хувьцааг хөрөнгө оруулагчдад хуваарилах ажиллагааг арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны хоёрдогч зах зээлд арилжих бэлтгэл хангагдсан тухай тодорхойлолтын хамт хүргүүлж байна.	
2.	Анхдагч зах зээлд худалдсан талаарх мэдээлэл	
2.1.	Анхдагч зах зээлд худалдах ажиллагааг зохион байгуулсан андеррайтер, туслах андеррайтерийн оноосон нэр	

	<i>/арилжаа эрхлэх байгууллага зохион байгуулсан бол энэ талаарх мэдээлэл/:</i>	
2.2.	<i>Анхдагч зах зээлд санал болгон худалдсан хэлбэр:</i>	<input type="checkbox"/> <i>Захиалгын бүртгэлийн аргаар</i> <input type="checkbox"/> <i>Тогтоосон үнийн аргаар</i>
2.3.	<i>Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны хувь хэмжээ, тоо ширхэг:</i>	
2.4.	<i>Нийтэд санал болгон худалдсан нэгж хувьцааны үнэ /дээд, доод, эцсийн санал болгосон үнэ/:</i>	
2.5.	<i>Үнэт цаасыг хаалттай захиалгын хүрээнд санал болгон худалдсан бол нэгж хувьцааны үнэ болон хаалттай хүрээнд санал болгон арилжсан тоо, хувь хэмжээ /энэ хэсэгт үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авсан хувьцаа эзэмшигчийн мэдээлэл мөн хамаарна/:</i>	
2.6.	<i>Өрийг хувьцаагаар сольсон бол хувьцаанд хөрвүүлсэн өрийн хэмжээ, нэгж хувьцаанд хөрвүүлэх үнэ, нийт хөрвүүлсэн хувьцааны тоо:</i>	
2.7.	<i>Үнэт цаасны танилцуулгад нийтээс татан төвлөрүүлэхээр тусгасан мөнгөн хөрөнгийн хэмжээ:</i>	
2.8.	<i>Нийтэд болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад худалдсан үнэт цаасны тоо, нийт татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн хэмжээ:</i>	
2.9.	<i>Үнэт цаасыг анхдагч зах зээлд худалдах замаар татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагын дансанд бүрэн байршуулсан эсэх:</i>	
2.10.	<i>Өрийг хувьцаагаар сольсон бол зээлдүүлэгчийн үнэт цаасны дансанд түүний хөрвүүлэн эзэмисэн хувьцаа бүрэн байршсан эсэх:</i>	
2.11.	<i>Нийтэд санал болгон анхдагч зах зээлд худалдсан үнэт цаасны 5 болон түүнээс дээш хувийг дангаар эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээдийн эзэмшиж буй үнэт цаасны тоо, хувь:</i>	

2.12.	Нэмэлт тайлбар, мэдээлэл /шаардлагатай бол/:

Тайлан гаргасан:

<p>1. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....” ХК-ийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг:.....</p> <p style="text-align: center;">(Тамга/тэмдэг)</p>	<p>3. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: андеррайтерийн компанийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг:.....</p> <p style="text-align: center;">(Тамга/тэмдэг)</p>
<p>2. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: Үнэт цаас гаргагч “.....” ХК-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p style="text-align: center;">(Тамга/тэмдэг)</p>	<p>4. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: андеррайтерийн компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p style="text-align: center;">(Тамга/тэмдэг)</p>

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУГАЦААТ ТАЙЛАГНАЛ БОЛОН ТУХАЙ БҮХ МЭДЭЭЛЭХ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА, ХЭЛБЭР

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Хороо, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь энэ журамд заасан мэдээллийг доорх зааварт заасан маягтын дагуу бэлтгэж, Хороонд ирүүлэх бөгөөд тухайн мэдээллийг өөрийн болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

1.2. Хороо нь үнэт цаас гаргагчаас хугацаат тайлагнал болон тухай бүх мэдээлэх мэдээллийг шаардлагатай тохиолдолд олон нийтэд мэдээлэх ажлыг өөрийн цахим хуудсаар дамжуулан зохион байгуулна.

1.3. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчээс үнэт цаас гаргагчийн санхүүгийн мэдээлэл нь алдаатай эсхүл эргэлзээтэй гэж үзвэл Хороонд холбогдох нотлох баримтыг хавсарган гомдол гаргах эрхтэй бөгөөд Хорооноос гомдлыг хянан үзэж, шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн шинжээч томилон хяналт шалгалт хийнэ.

1.4. Үнэт цаас гаргагч нь энэ журамд заасан мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд мэдээлэх үүрэгтэй бөгөөд худал, ташаа мэдээлэл ирүүлсэн тохиолдолд Хорооны хянан шалгагчаас Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэхийг АНХААРНА УУ!!!

ХОЁР. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилийн тайлагналын мэдээллийн агуулга

2.1. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилийн үйл ажиллагааны тайлагналын мэдээлэл нь доорх 9 төрлийн цогц мэдээллээс бүрдэнэ.

2.1.1. Үнэт цаас гаргагчийн тайлант хугацааны санхүүгийн мэдээлэл:

2.1.1.1. үнэт цаас гаргагчийн жилийн санхүүгийн тайлан тэнцэл, тодруулга;

2.1.1.2. аудитын үйлчилгээ үзүүлсэн компани нь санхүүгийн тайланд орсон мэдээлэл нь үнэн зөв, олон улсын стандартын дагуу тайлагнасныг баталж, үйлчилгээ үзүүлсэн этгээдтэй сонирхлын зөрчил үүсгээгүй, хараат бусаар ажилласан талаарх баталгаат захидал;

2.1.1.3. үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;

2.1.1.4. үнэт цаас гаргагчийн жилийн санхүүгийн тайлангийн мэдээлэлд хөрөнгө оруулагч болон хувьцаа эзэмшигч хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн нөхцөл байдал, төлбөрийн ба хөрвөх чадварыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг агуулна.

2.1.2. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагаас гаргах тайлангийн мэдээлэл: Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлт, удирдлагаас өгсөн үнэлгээ, компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, бизнесийн үйл ажиллагааг

өргөжүүлэх, ашигт ажиллагааг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ зэрэг мэдээллийг тусгасан тайланг дараах агуулгын хүрээнд гаргана.

2.1.2.1. Үйл ажиллагааны үр дүнгийн мэдээлэл: тайлант жилд үнэт цаас гаргагчийн орлогод нөлөөлсөн гадаад, дотоод орчны нөлөөллийг тусгасан дүгнэлт, мэдээлэл;

2.1.2.2. Хөрвөх чадварын болон санхүүгийн нөөц, боломжийн мэдээлэл: Үнэт цаас гаргагчийн богино, дунд, урт хугацааны төлбөрийн болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд, үнэт цаас гаргагч өөрийн санхүүгийн нөөцөөр бизнесийн үйл ажиллагаанаас бий болсон өр төлбөрийг бүрэн хариуцах боломж, шаардлагатай тохиолдолд гадаад, дотоод санхүүжилтийн эх үүсвэрээс санхүүжилт татах боломжтой эсэх дүгнэлт, мэдээлэл;

2.1.2.3. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний шинэчлэл, төрөлжилт, дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл;

2.1.2.4. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын талаарх товч мэдээлэл.

2.1.3. **Сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээлэл:** Үнэт цаас гаргагчийн санхүүгийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл, дээрх хэлцлийг хийснээр гарах үр дүн, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл;

2.1.4. **Цалин урамшууллын мэдээлэл:** Санхүүгийн жилд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат болон хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагад олгосон цалин урамшуулал, шагнал, тэдгээрийн эзэмшдэг опцион болон хувьцааны тоо ширхэг, үнэт цаас гаргагчаас баримталдаг нөхөн олговор, урамшуулал, шагналын талаарх баримталдаг бодлого;

2.1.5. **Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл:** Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, хараат, хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын чиг үүрэг, хариуцлага, гишүүдийн нэр, боловсрол, ажлын туршлага, ёс зүйн кодекс, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, мөн төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын ажлын тайланг хэлэлцсэн хувьцаа эзэмшигчдийн хурлын дүгнэлт, гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, мэдээлэл. Үнэт цаас гаргагчаас шаардлагатай тохиолдолд Хорооноос баталсан үнэлгээний аргачлалын дагуу өөрийн компанийн засаглалыг үнэлсэн үнэлгээний тайлан.

2.1.6. **Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл:** Санхүүгийн салбарт болон гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үнэт цаас гаргагч нь гадаад худалдаа болон арилжаанд бий болсон зах зээлийн эрсдэлийг удирдах чиглэлээр гаргасан үүсмэл санхүүгийн болон бусад хэрэгслийн мэдээлэл, зах зээлийн эрсдэлийг тооцдог арга аргачлал, эрсдэлийг удирдах стратегийн талаарх мэдээлэл;

2.1.7. **Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл:** Үнэт цаас гаргагчийн тайлант жил дэх эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий, хяналтын багц эзэмшигч гадаад дотоодын иргэн, аж ахуйн нэгжийн нэрс, хувьцааны тоо ширхэг, төвлөрлийн мэдээлэл;

Мөн үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшдэг охин, хараат компанийн мэдээлэл, тайлант хугацаанд Компанийн тухай хуульд заасны дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэн хувьцаа худалдсан хувьцаа эзэмшигчийн тоо, үнийн дүнгийн мэдээлэл;

2.1.8. **Ногдол ашгийн мэдээлэл:** Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого,

тухайн жилд хуваарилсан ногдол ашгийн хэмжээ, тараах хэлбэр, ногдол ашиг хуваарилахгүй тохиолдолд энэ талаарх үндэслэл, өмнөх жилд ногдол ашиг хуваарилсан тохиолдолд түүний тараалтын тайлан, мэдээлэл;

2.1.9. Нийгмийн хариуцлага: Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлан, мэдээлэл.

2.2. Үнэт цаас гаргагч нь санхүүгийн жилийн үйл ажиллагааны мэдээллийг дараах маягтын дагуу гаргана. Үүнд:

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 1/	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/</i>	
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	
<i>Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо</i>	
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	
<i>Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	
1.	<i>Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>
	<i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>
	<i>Орлогын тайлан</i>
	<i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>

	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	
<i>1.1.</i>	<i>Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт</i>	
<i>1.2.</i>	<i>Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/</i>	
<i>2.</i>	<i>Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл</i>	
<i>2.1.</i>	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	
<i>2.2.</i>	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	
<i>2.3.</i>	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	
<i>2.4.</i>	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/</i>	
<i>2.5.</i>	<i>Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;</i>	
<i>3.</i>	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	

4.	<i>Цалин урамшууллын мэдээлэл</i>
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>
6.	<i>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</i>
7.	<i>Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/</i>
8.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл</i>
9.	<i>Ногдол ашгийн мэдээлэл</i>
10.	<i>Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл</i>
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	

Овог, нэр:

Албан тушаал: “.....” ..К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:

Албан тушаал:

Гарын үсэг:

ГУРАВ. Үнэт цаас гаргагчийн хагас жилийн тайлангийн мэдээллийн агуулга

3.1. Үнэт цаас гаргагчийн хагас жилийн тайлан мэдээлэлд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай үнэт цаас гаргагчийн санхүү, үйл ажиллагаатай холбоотой цаг үеийн шинжтэй мэдээлэл агуулагдах бөгөөд дараах төрөлтэй байна. Үүнд:

3.1.1. Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргасан хагас жилийн санхүүгийн тайлан, тодруулгын мэдээлэл;

3.1.2. Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлт үүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан;

3.1.3. Тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл;

3.1.4. Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооноос хагас жилийн тайланг хэлэлцэж, тайланд тусгасан мэдээлэл үнэн зөв талаарх дүгнэлт; мэдээлэл;

3.1.5. Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний

3.1.6. Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл;

3.1.7. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны эзэмшиж буй үнэт цаас гаргагчийн хувьцааны талаарх мэдээлэл, үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, дотоод аудитын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, гүйцэтгэх удирдлагын ажлын тайланг хэлэлцсэн төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт, үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч болон нөлөө бүхий хувьцаа

эзэмшигчдийн мэдээлэл.

3.2. Хагас жилийн үйл ажиллагааны тайлагналын мэдээллийг дараах маягтын дагуу ирүүлнэ. Үүнд:

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

<p style="text-align: center;">Хагас жилийн үйл ажиллагааны тайлан /маягт 2/</p> <p style="text-align: center;"><i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i></p>	
<p><i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i></p>	
<p><i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдөр/</i></p>	
<p><i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i></p>	
<p><i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i></p>	
<p><i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i></p>	
<p><i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i></p>	
<p><i>Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i></p> <p><i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i></p>	
<p>1.</p>	<p><i>Хагас жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i></p> <p><i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i></p>
	<p><i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i></p>
	<p><i>Орлогын тайлан</i></p>
	<p><i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i></p>

	<i>Мөнгөн гүйлгээний тайлан</i>	
2.	<i>Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт /Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i>	
3.	<i>Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт</i>	
3.1.	<i>Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/</i>	
3.2.	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	
3.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл</i>	
3.4.	<i>Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого</i>	
4.	<i>Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/</i>	
5.	<i>Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээлэл</i>	
5.	<i>Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл</i>	

6.	<i>Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл</i>
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр:</p> <p>Албан тушаал: “.....” ..К-ийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:</p> <p><i>(Тамга/тэмдэг)</i></p> <p><i>/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i></p>	
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:	
<p>Овог, нэр:</p> <p>Албан тушаал:</p> <p>Гарын үсэг:</p>	

ДӨРӨВ. Үнэт цаас гаргагчийн тухай бүр мэдээлэх мэдээллийн агуулга

4.1. Үнэт цаас гаргагчаас тухай бүр мэдээлэх мэдээлэл гэдэгт хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчаас шийдвэр гаргахад шаардлагатай компанийн бизнесийн болон санхүүгийн үйл ажиллагаанд бий болсон ажил хэрэг, үйл ажиллагаатай холбоотой цогц мэдээллийг ойлгоно.

4.1.1. Компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, бизнест шууд нөлөө үзүүлэхүйц гэрээ, хэлцэл байгуулах, нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, дуусгавар болгох, татгалзах, гэрээний хугацаа дууссантай холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээг байгуулсан огноо, гэрээний нөхцөл, гэрээнд оролцогч талуудын эрх үүрэг, гэрээний нэг талд түүний охин хараат компани оролцсон эсэх талаарх мэдээлэл;

4.1.2. Шүүх, прокурор, төрийн эрх бүхий байгууллагаас үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанийг хариуцагчаар татаж, захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн, шүүхээс дампуурлын тухай хууль тогтоомжийн дагуу эрх хүлээн авагч томилогдсон талаарх мэдээлэл;

4.1.3. Үнэт цаас гаргагч нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц

худалдан авсан талаарх мэдээлэл, холбогдох гэрээ, хэлцэл;

4.1.4. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын гадуурх бүртгэлтэй холбоотой санхүүгийн болон санхүүгийн бус эрх үүрэг бий болгосон гэрээ, хэлцэл, гүйлгээтэй холбоотой мэдээллийг мэдээлэх бөгөөд мэдээлэлд гэрээ, хэлцлийн хугацаа, үнийн дүн, төлбөрийн нөхцөл, гүйлгээний товч утга, богино болон урт хугацаат түрээсийн гэрээнээс бий болсон эрх үүрэг, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой мэдээлэл;

4.1.5. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдээс СТОУС-ын дагуу компанийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан гэж үзэн дахин үнэлгээ хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд холбогдох шийдвэр, шийдвэрийг гаргах болсон нөхцөл, шаардлага, үнэ цэнэ нь буурсан хөрөнгө болон хөрөнгийн үнэ цэнийн бууралтын хэмжээ эсхүл хязгаарын тооцоолол;

4.1.6. Арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шалгуурыг хангахгүй болсонтой холбогдуулан бүртгэлийн ангилал бууруулах, эсхүл бүртгэлээс хасагдах мэдэгдэл хүлээн авсан тухай мэдээлэл. Хэрэв үнэт цаас гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд үлдэх хүсэлт гаргасан бол уг хүсэлт хүргүүлсэн огноо болон дээрх мэдэгдлийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, бүртгэлтэй хугацаанд биелүүлсэн болон хангаж чадаагүй гэрээгээр хүлээсэн үүргийн талаарх мэдээлэл;

4.1.7. Үнэт цаас гаргагчийн тайланд аудит хийж буй хараат бус нягтлан бодогч ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан зэрэг шалтгаанаар өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар мэдэгдэх бөгөөд нягтлан бодогчоос үнэт цаас гаргагчийн дээрх мэдээлэлтэй санал нийлж буй эсэх талаар мэдэгдлийг хавсаргана, эсхүл шинэ хараат бус нягтлан бодогч ажилд орсон бол ажилд томилсон шийдвэр, шинэ нягтлан бодогчийн үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлантай холбоотой гаргасан санал, дүгнэлт, зөвлөгөө;

4.1.8. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдээс компанийн өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд алдаа гарсан гэж үзсэн бол алдаатай санхүүгийн тайлангууд, алдаа гарсан гэж үзэх үндэслэл, нөхцөл, компанийн аудитын хороо, эсхүл эрх бүхий албан тушаалтан энэ талаар хараат бус нягтлан бодогчтой хэлэлцсэн эсэх талаар мэдээлэл, хараат бус нягтлан бодогчоос үнэт цаас гаргагчид санхүүгийн тайлангийн алдаатай байдлын талаар мэдэгдсэн бол нягтлан бодогчоос өгсөн мэдэгдлийн огноо, товч агуулгын талаарх мэдээлэл.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.1.9. **Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл:** Компанийн хяналтын хувьцааг худалдах болон шилжүүлэхээр хийгдсэн хэлцлийн хугацаа, товч танилцуулга, зорилго, төлбөр төлөх хэлбэр, төлбөрийн зарцуулалт, худалдан авагчийн товч танилцуулга, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, өмнөх хувьцаа эзэмшигчдийн хувь хэмжээний бууралтын талаарх мэдээлэл;

4.1.10. Компанийн эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, чөлөөлөхтэй холбоотой мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийг томилж, огцруулж, нөхөн томилох, эсвэл татгалзсан хурлын тэмдэглэл, шийдвэрийн агуулга, огноо, төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх удирдлагыг томилж, чөлөөлсөн талаарх мэдээлэл;

4.1.11. **Үнэт цаас гаргагчийн дүрэмд орсон өөрчлөлт:** Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталсан дүрмийн өөрчлөлтийг Хороо, төрийн холбогдох байгууллагад бүртгүүлсэн огноо, дугаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, эцэслэсэн дүрэм;

4.1.12. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан

компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээ болон үүнтэй холбогдуулан компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс гарсан шийдвэр, арга хэмжээний талаарх мэдээлэл;

4.1.13. Компанийн ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, зарим хэсгийг түр түдгэлзүүлсэн талаарх мэдээлэл;

4.1.14. Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулсан, үндсэн болон шинэ бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрх хүчингүй болсон эсхүл цуцлагдсан талаарх мэдээлэл;

4.1.15. Оноосон нэр, үндсэн захиргаа, оршин байх хаяг байршил өөрчлөгдсөн талаар, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, эсхүл татан буулгах талаарх мэдээлэл;

4.1.16. Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон талаарх мэдээлэл;

4.1.17. Үнэт цаас гаргагч төлбөрийн чадваргүй болох, үнэт цаас гаргагчийг татан буулгах чиглэлээр гаргасан шийдвэр.

4.2. Тухай бүр мэдээлэх мэдээллийг дараах маягтын дагуу ирүүлнэ.

Тухай бүр мэдээлэх мэдээлэл /маягт 3/	
<i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i>	
<i>Тайлагнах хугацаа /Жишээ нь: 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр/</i>	
<i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>	
<i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>	
<i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>	
<i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>	
<i>Тухай бүр мэдээлэх мэдээллийг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>	

1.	<i>Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гэрээ, хэлцлийн талаар</i>
2.	<i>Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан, түүний хараат, охин компанид аливаа захиргааны болон эрүүгийн хэрэг үүсгэсэн эсэх талаар</i>
3.	<i>Үнэт цаас гаргагч нийт активын 25 хувь ба түүнээс дээш хэмжээтэй тэнцэх үл хөдлөх хөрөнгийг бусдад шилжүүлэх, барьцаалсан эсхүл бусад компанийн хяналтын багц худалдан авсан гэрээ, хэлцлийн талаар</i>
4.	<i>Үнэт цаас гаргагчийн балансын гадуурх бүртгэлийн талаар</i>
5.	<i>Хөрөнгийн дахин үнэлгээний талаар</i>
6.	<i>Үнэт цаас гаргагч арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүргийн хэрэгжилтийн талаар</i>
7.	<i>Үнэт цаас гаргагчийн хараат бус нягтлан бодогчийн өөрчлөлтийн талаар</i>
8.	<i>Өмнөх жилүүдийн санхүүгийн тайланд алдаа гарсан бол энэ талаар /Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/</i>
9.	<i>Компанийн хяналтын багцыг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой мэдээлэл</i>

10.	<i>Компанийн эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн өөрчлөлттэй холбоотой мэдээлэл</i>
11.	<i>Үнэт цаас гаргагчийн дүрэмд орсон өөрчлөлтийн талаар</i>
12.	<i>Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн, гарсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд тухайн ажиллаж байсан компанийн хувьцааг бирж болон биржийн бус зах зээл дээр худалдах, худалдан авахыг хориглосон арга хэмжээний талаар</i>
13.	<i>Компанийн ёс зүйн дүрэмд орсон өөрчлөлтийн талаар</i>
14.	<i>Шинэ техник, технологи нэвтрүүлэх, шинэ бүтээгдэхүүн, бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах болон барааны тэмдэг эзэмших эрхийн талаар</i>
15.	<i>Оноосон нэр, хаяг байршлын өөрчлөлт, салбар, төлөөлөгчийн газрын талаар</i>
16.	<i>Үйл ажиллагааны чиглэл, түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон эсэх талаар</i>
17.	<i>Төлбөрийн чадваргүй болох, үнэт цаас гаргагчийг татан буулгах шийдвэрийн талаар</i>

--	--

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:

Албан тушаал: “.....” ..К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 378 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр:

Албан тушаал:

Гарын үсэг:

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ОРОЛЦОГЧДОД ХӨНДЛӨНГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭР
БҮРТГҮҮЛЭХИЙГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ**

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,
Засгийн газрын IV байр,

Бага тойруу -3,
Улаанбаатар-15160,
Монгол улс.

Хэнээс:

.....
.....
.....

/өргөдөл гаргагчийн овог, нэр, эрхэлж буй албан тушаал, байгууллагын хаяг, утас, факс,
электрон шуудангийн хаяг/

.....

/Байгууллагын нэр ХК, ХХК, ХХН/

Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн эсвэл нөхөрлөлийн гишүүн:

№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар	Хаяг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/

Байгууллагын гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтан нь /төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, нэгжгийн удирдлага, дотоод хяналтын ажилтнууд/ дараах хүмүүс болно:

№	Овог, нэр	Одоогийн эрхэлж байгаа ажил	Регистрийн дугаар	Мэргэжлийн байгууллагад эрхлэх албан тушаал

Хөндлөнгийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдүүдийн эрх авсан мэргэжилтний талаарх мэдээлэл:

№	Овог, нэр	Регистрийн дугаар	Гэрийн хаяг	Тухайн ажил үйлчилгээг эрхэлсэн хугацаа	Албан тушаал	Тухайн ажил үйлчилгээг эрхлэх эрхийн үнэмлэхийн дугаар

Бүртгүүлэхээр хүргүүлсэн баримтыг Санхүүгийн зохицуулах хорооны ... оны ... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолоор батлагдсан “...”-ын шаардлагад нийцүүлэн үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдээр бүртгэн авна уу.

Бид үйл ажиллагаандаа Иргэний хууль, Компанийн хууль, Үнэт цаасны зах зээлийн тухайхууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Аудитын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллахба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/...../

/гарын үсэг/

/...../

/овог, нэр/

/...../

/албан тушаал/

/тамга тэмдэг/

ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмаар нийтэд санал болгон гаргах аймаг, нийслэлийн Засаг даргын үнэт цаас, олон улсын санхүүгийн байгууллагын өрийн хэрэгсэл, компанийн өрийн хэрэгсэл /цаашид “бонд” гэх/- ийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны бүртгэлд бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах, бондыг анхдагч зах зээлд санал болгох, худалдах, түүний хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх, бонд гаргагч, зохицуулалттай этгээд, Хорооны эрх, үүрэг болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой харилцааг зохицуулна.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.2. Засгийн газрын үнэт цаас, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас болон энэ журмын 3.2-т зааснаас бусад Биржийн бус зах зээлд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хаалттай хүрээнд санал болгох аймаг, нийслэлийн Засаг даргын, олон улсын санхүүгийн байгууллага болон компанийн бондын бүртгэлтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.3. Энэ журмын 3.2-т заасан бондыг анхдагч зах зээлд санал болгох, худалдах, хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.4. Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд гадаад улсад үнэт цаас гаргах, эсхүл гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх тохиолдолд Хороонд мэдэгдэх харилцааг энэ журмаар зохицуулна.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.5. Нээлттэй хувьцаат компанийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондыг бүртгэхтэй холбоотой харилцааг Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмаар, бусад харилцааг энэ журмаар зохицуулна.

1.6. Хаалттай хувьцаат компанийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй нийтэд санал болгох бондын бүртгэлтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

ХОЁР. НИЙТЭД САНАЛ БОЛГОН БОНД ГАРГАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга бонд гаргахад Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг, компани нь дараах шалгуур, шаардлагыг тус тус бүрэн хангасан байна:

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.1.1. хаалттай хувьцаат компани, эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэртэй бол гурваас доошгүй жилийн өмнө үүсгэн байгуулагдсан, Хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн гурван жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

2.1.2. Хороонд хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;

2.1.3. хөрөнгө оруулагчдын өмнө хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлдэг байх;

2.1.4. өмнө нь нийтэд санал болгон бонд гаргасан этгээд бол хоёр болон түүнээс дээш удаа бондын хүүгийн болон үндсэн төлбөрийг тогтсон хугацаанаас хоцроож, төлбөрийн тасалдал

учруулж байгаагүй;

2.1.5. энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй нийтэд санал болгох бонд гаргагч нь хувьцаат компани хэлбэртэй байх;

2.1.6. үйлчилгээ үзүүлэх андеррайтерийн компанийн холбогдох этгээд биш байх.

2.2. Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий андеррайтерийн компани, энэ журмын 2.3.3- т заасан этгээдээс бусад бонд гаргагч нь андеррайтерийн компанитай “Андеррайтерийн гэрээ” байгуулсан байх бөгөөд аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын санхүүгийн байгууллага нь уг гэрээг байгуулж болно.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.3. Дараах этгээдийн нийтэд санал болгон гаргах бондыг бүртгэх асуудлыг Хороо ажлын 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

2.3.1. арилжаа эрхлэх байгууллагын I ангилалд хувьцаа нь бүртгэлтэй;

2.3.2. Монгол Улсын Засгийн газраас, эсхүл Засгийн газрын нэгдэн орсон олон улсын санхүүгийн байгууллагаас баталгаа гаргасан;

2.3.3. Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран эрэмбэлсэн шилдэг 100 аж ахуйн нэгжээр сүүлийн гурван жилийн хугацаанд нэг болон түүнээс дээш удаа шалгарсан;

2.3.4. Монгол Улсын Хөгжлийн банк;

2.3.5. хоёр болон түүнээс доошгүй удаа нийтэд санал болгон бонд гаргаж байсан бол үндсэн болон хүүгийн нийт төлбөрийг бүрэн төлж дууссанаас хойш 12 сар өнгөрөөгүй.

2.3.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга

2.3.7. Олон улсын санхүүгийн байгууллага

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор нэмсэн /

2.4. Бонд гаргагчид Засгийн газар, эсхүл энэ журмын 2.1-д заасан шалгуурыг хангасан гуравдагч этгээд баталгаа гаргасан бол тухайн этгээдэд энэ журмын 2.1.1 дэх заалт хамаарахгүй.

2.5. Бонд гаргагч нь бондын үүргийн гүйцэтгэлийг хангах гуравдагч этгээдээс тусгайлан гаргасан баталгаа, батлан даалттай байж болох бөгөөд бонд гаргагч компанийн хувьд энэ журмын 2.6-д зааснаас бусад тохиолдолд барьцаа хөрөнгө нь бонд гаргагчийн гаргасан, энгийн хувьцаа эсхүл түүнд хөрвөх нөхцөлтэй үнэт цааснаас бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй байна.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.6. Бонд гаргагч нь нээлттэй хувьцаат компани бол тухайн компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан дааж болох бөгөөд батлан даах хувьцаа нь бонд гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны 50 хувиас дээшгүй байна.

2.7. Энэ журмын 2.6-д заасны дагуу батлан даасан хувьцааны үнэлгээг тогтоохдоо арилжаа эрхлэх байгууллагын албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзах бөгөөд барьцаалах үнэлгээ нь тухайн хувьцааны үнэлгээний 70 хувиас илүүгүй байна.

2.8. Бонд гаргагч нь дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон, эсхүл энэ журмын 2.3.3-т заасан этгээд 1 жилээс бага хугацаатай 5 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий бонд гаргах тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болно.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.9. Бонд гаргагч нь энэ журамд заасан шаардлагыг хангаагүй бол Хороо бондыг бүртгэхээс татгалзах ба татгалзсан шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган бонд гаргагчид энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВ. БОНДЫГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАХ, БҮРТГЭХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

3.1. Бонд гаргагч нь нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бондыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ:

3.1.1. Бонд гаргагч аймаг, нийслэлийн Засаг дарга нь дараах баримт бичгийг:

3.1.1.1. албан хүсэлт, бондыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1/;

3.1.1.2. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас бонд гаргахтай холбоотойгоор гаргасан шийдвэр;

3.1.1.3. Засгийн газраас олгосон үнэт цаас гаргах тухай зөвшөөрөл;

3.1.1.4. Албан мэдэгдэл /Хавсралт 4-а/ эсхүл бондын танилцуулга.

3.1.2. Бонд гаргагч компани нь дараах баримт бичгийг:

3.1.2.1 албан хүсэлт, бондыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1/;

3.1.2.2. бондын танилцуулга;

3.1.2.3. андеррайтерийн компанитай байгуулсан гэрээ, Хороонд гаргасан андеррайтерийнтодорхойлох захидал;¹

3.1.2.4. хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн 6 сараас дээшгүй хугацааны санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан аудиторын Хороонд гаргасан тодорхойлох захидал;

3.1.2.5. бонд гаргагчид гуравдагч этгээд барьцаа, баталгаа, батлан даалт гаргасан болталуудын байгуулсан гэрээ;

3.1.2.6. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан/

3.1.3. Олон улсын санхүүгийн байгууллага нь дараах баримт бичгийг:

3.1.3.1. Монгол Улсад нэгдэх ороход байгуулсан олон улсын гэрээний хуулбар;

3.1.3.1. албан хүсэлт, бондыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1/;

3.1.3.2. Олон улсын санхүүгийн байгууллагаас бонд гаргахтай холбоотойгоор гаргасан шийдвэр;

3.1.3.3. Албан мэдэгдэл /Хавсралт 4-б/ эсхүл бондын танилцуулга;

3.1.3.4. бонд гаргагчид гуравдагч этгээд барьцаа, баталгаа, батлан даалт гаргасан бол талуудын байгуулсан гэрээ;

3.1.3.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор нэмсэн/

3.2. Нийтэд санал болгон гаргасан бонд нь Хороонд бүртгэлтэй байгаа аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын санхүүгийн байгууллага, компани биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд гаргах бондыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ:

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.2.1. албан хүсэлт, бондыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 2/;

3.2.2. бонд гаргагчийн хаалттай хүрээнд бонд гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.2.3. гуравдагч этгээд барьцаа, баталгаа, батлан даалт гаргасан бол тухайн барьцаа, баталгаа, батлан даалттай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр, бонд гаргагчтай байгуулсан гэрээ;

3.2.4. биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тухай мэргэжлийн холбооны шийдвэр;

3.2.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

3.3. Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд гадаад улсад үнэт цаас гаргах, эсхүл гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх тохиолдолд дараах баримт бичгийг Хороонд хүргүүлж, мэдэгдэнэ:

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.3.1. албан бичиг, мэдэгдэл /Хавсралт 3/;

3.3.2. бонд гаргагчийн гадаад улсад бонд гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.3.3. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.

3.4. Бондын танилцуулгад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5-д зааснаас гадна дараах болон шаардлагатай гэж үзсэн бусад мэдээллийг тусгасан байна:

3.4.1. бонд гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.4.2. бонд гаргагчид гуравдагч этгээд хөрөнгөө барьцаалуулсан, баталгаа гаргасанбол дараах мэдээллийг тусгана:

3.4.2.1. тухайн этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.4.2.2. тухайн этгээдийн тухай мэдээлэл болон хуулийн этгээд бол сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан.

3.4.3. бонд гаргагч болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдүүдийн хооронд үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар гаргасан мэдэгдэл;

3.4.4. сүүлийн 3 жилийн болон 6 сараас дээшгүй хугацааны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын байгууллагын дүгнэлт;

3.4.5. бонд гаргахтай холбоотой гаргасан зардлыг татан төвлөрүүлсэн хөрөнгөнөөс зарцуулах бол энэ тухай мэдээлэл;

3.4.6. энэ журмын дөрөвдүгээр бүлэгт заасан “Бонд гаргах хөтөлбөр” хэрэгжүүлэх бол татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө, шаардлагатай бусад мэдээлэл;

3.4.7. энэ журмын 3.6-д заасан бондын гэрээний үндсэн нөхцөл;

3.4.8. ногоон бонд гаргах бол бонд гаргагчийн үйл ажиллагааны ерөнхий стратеги, татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, удирдлага, тайлагналын үйл явц, хөндлөнгийн баталгаажуулалт хийлгэсэн эсэх болон шаардлагатай бусад мэдээлэл бүхий “Ногоон танилцуулга” /Хавсралт 4/;

3.4.9. ногоон бонд гаргагчийн санхүүжүүлэх үйл ажиллагаа эсхүл үйлдвэрлэх эцсийн бүтээгдэхүүн нь “ногоон”, “байгаль орчинд ээлтэй” болохыг баталгаажуулах зорилгоор хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагыг томилж, дүгнэлт гаргуулсан бол уг дүгнэлт;

3.4.10. дараах сануулгыг эхний хуудсанд тодоор бичсэн байна:

“Энэхүү танилцуулгад тусгасан бондыг Санхүүгийн зохицуулах хороо бүртгэсэн нь уг үнэт цаасанд гаргасан аливаа баталгаа биш бөгөөд түүний агуулсан аливаа мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг Хороо хариуцахгүй!

Үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагч таны хувьд ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ үйлдэл байдгийг онцгойлон анхаарч, бондын танилцуулга, бонд гаргах ажиллагааг сайтар судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.”

3.5. Бондын танилцуулгыг дараах байдлаар баталгаажуулна.

3.5.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь бонд гаргахдаа бондын танилцуулгыг бэлтгэсэн бол Засаг дарга, санхүү, төрийн сангийн газрын дарга, андеррайтерийн компанитай гэрээ байгуулсан бол уг компанийн гүйцэтгэх захирал тус тус гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

3.5.2. Компанийн хувьд бонд гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, андеррайтерийн компанийн гүйцэтгэх захирал тус тус гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан/

3.5.3. Олон улсын санхүүгийн байгууллага нь бонд гаргахдаа бондын танилцуулгыг бэлтгэсэн бол байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээд, андеррайтерийн компанитай гэрээ байгуулсан бол уг компанийн гүйцэтгэх захирал тус тус гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор нэмсэн/

3.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын санхүүгийн байгууллагаас бусад бонд гаргагч нь бондын үндсэн нөхцөл бүхий Бондын гэрээг бичгээр байгуулах бөгөөд уг гэрээг нэг талаас бонд гаргагч, нөгөө талаас хөрөнгө оруулагчдыг төлөөлөн андеррайтер байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.7. Энэ журмын 3.6-д заасан Бондын гэрээнд дараах мэдээллийг тусгасан байна.

3.7.1. бондын нэрлэсэн үнэ, тоо, хугацаа, төрөл, хүүгийн төрөл, түвшин, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх хуваарь;

3.7.2. хүүгийн төлбөрийг тооцоолох аргачлал;

3.7.3. барьцаа, баталгаа, батлан даалтын тухай;

3.7.4. энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бол хөрвүүлэх нөхцөл, журам;

3.7.5. хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдах, худалдан авах нөхцөлтэй бол нөхцөл, журам;

3.7.6. бонд гаргагчийн санхүүгийн чадавхыг сайжруулахтай холбоотой нэмэлт мэдээлэл;

3.7.7. бонд гаргагч мэдээллийг хөрөнгө оруулагчид хүргэх давтамж, хэлбэр;

3.7.8. хөрөнгө оруулагчийн болон бонд гаргагчийн эрх, үүрэг, хариуцлага;

3.7.9. бонд гаргагчид хориглох зүйлс;

3.7.10. бонд гаргагчид хориглоогүй, хэрэгжүүлж болох бусад зүйлс;

3.7.11. төлбөрийн тасалдал /дефолт/ болсонд тооцох нөхцөлийг тодорхойлох бөгөөд тухайн нөхцөл үүссэн тохиолдолд санхүүгийн чадавхыг сайжруулах арга зам, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх журам;

3.7.12. төлбөрийн чадваргүйд тооцох нөхцөлийг тодорхойлох бөгөөд тухайн нөхцөл үүссэн тохиолдолд хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг хэрэгжүүлэх журам;

3.7.13. шаардлагатай бусад.

3.8. Нийтэд санал болгон гаргасан бондын үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийг барьцаалах бол барьцааны гэрээг нэг талаас бонд гаргагч, нөгөө талаас хөрөнгө оруулагчдыг төлөөлөн андеррайтер байгуулж, гарын үсэг зурж, тамга,

тэмдэг дарж баталгаажуулсан байна.

3.9. Бонд гаргагч нь энэ журамд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлж, Хороонд цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүргүүлнэ.

3.10. Нийтэд санал болгон гаргах бонд, түүний танилцуулгыг бүртгэх эсэх асуудлыг Хороо тухайн бонд гаргагчаас ирүүлсэн бондын танилцуулга, бусад баримт бичиг болон арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн дүгнэлт зэргийг хянаж, ажлын 20 өдөрт шийдвэрлэнэ.

3.11. Энэ журмын 2.3-т заасан этгээдийн нийтэд санал болгон гаргах бонд, түүний танилцуулга, аймаг, нийслэлийн Засаг даргын хувьд бондын танилцуулга бэлтгээгүй бол Албан мэдэгдлийг бүртгэх эсэх асуудлыг Хороо тухайн бонд, түүний танилцуулга, эсхүл Албан мэдэгдлийг бүртгэсэн тухай арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн ажлын 10 өдөрт шийдвэрлэнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.12. Энэ журмын 3.2-т заасан этгээдийн гаргах хаалттай бондыг бүртгэх эсэх асуудлыг Хороо тухайн бондыг биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тухай мэргэжлийн холбооны шийдвэрийг үндэслэн ажлын 10 өдөрт шийдвэрлэнэ.

3.13. Бонд гаргагчийн ирүүлсэн баримт бичиг нь агуулгын хувьд дутуу, зөрүүтэй, тодорхойгүй тохиолдолд Хороо нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга ирүүлэхийг бонд гаргагчид мэдэгдэнэ.

3.14. Хороо Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид болон энэ журамд заасны дагуу бүртгэхээс татгалзах үндэслэлтэй гэж үзвэл бондыг бүртгэхээс татгалзаж, бонд гаргагчид энэ тухай албан бичгээр мэдэгдэнэ.

3.15. Хороо бондыг бүртгэсэн тухай шийдвэрийг бонд гаргагч, андеррайтер, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон арилжаа эрхлэх байгууллага эсхүл мэргэжлийн холбоонд тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

3.16. Нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлсэн бондын танилцуулга, аймаг, нийслэлийн Засаг дарга болон олон улсын санхүүгийн байгууллагын хувьд бондын танилцуулга бэлтгээгүй бол Албан мэдэгдэл тус бүрд Хорооны “Бүртгэв” тэмдэглэл хийж арилжаа эрхлэх байгууллага болон Хороо тус тус нэг хувийг хадгалах бөгөөд бонд гаргагч болон андеррайтерт мөн тэмдэглэгээ бүхий танилцуулга шаардлагатай бол тэдгээрийн гаргасан хүсэлтийг үндэслэн зохих тэмдэглэгээг эх хувь тус бүрд хийж, хүргүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

3.17. Хаалттай хувьцаат компани нь энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондыг Хороонд бүртгүүлсэн бол түүний хөрвөх энгийн хувьцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад ажлын 10 өдрийн дотор бүртгүүлнэ.

3.18. Хороо энэ журмын 3.3-т заасан мэдэгдлийг хүлээн авсан тухай албан бичгийг ажлын гурван өдрийн дотор тухайн үнэт цаас гаргагчид хүргүүлнэ.

3.19. Энэ журмын 3.3-т заасан этгээд нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаасаа бүртгүүлсэн, эсхүл бүртгэлээс хасуулсан тохиолдолд тус тус тухайн байгууллагын шийдвэрийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.

3.20. Бонд гаргагчийн гаргасан бондын төлбөрийн тасалдал болж, бондын танилцуулга, гэрээнд заасан нөхцөлд өөрчлөлт оруулах бол бондын бүртгэлд өөрчлөлт оруулна.

3.21. Бондын бүртгэлд өөрчлөлт оруулахад дараах баримт бичгийг Хороонд, бонд нь бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын журамд заасан баримт бичгийг тухайн байгууллагад

тус тус зэрэг хүргүүлнэ:

3.21.1. үндэслэл бүхий албан хүсэлт;

3.21.2. өмнө хийсэн болон хийх шаардлагатай төлбөрийн мэдээлэл;

3.21.3. бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотойгоор хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр авсан арга хэмжээний тухай мэдээлэл;

3.21.4. бондын гэрээнд заасан нөхцөлд өөрчлөлт оруулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.21.5. бондын танилцуулгад орсон өөрчлөлтийн тухай дэлгэрэнгүй мэдэгдэл;

3.21.6. бондын гэрээний төсөл;

3.21.7. бонд гаргагчийн шаардлагатай гэж үзсэн бусад.

3.22. Бондын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт, холбогдох баримт бичгийг Хороо хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хянаж, бүртгэлд өөрчлөлт оруулсан тухай холбогдох этгээдийн шийдвэрийг үндэслэн бондын бүртгэлд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.23. Хороо бондыг дараах тохиолдолд бүртгэлээс хасна:

3.23.1. бонд гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлсөн;

3.23.2. бонд гаргагч нь бондын гэрээнд заасны дагуу нийт гаргасан бондын тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч, эсхүл бонд эзэмшигч хөрөнгө оруулагч нь бонд гаргагчид нийт гаргасан бондын тодорхой хэсгийг эргүүлэн худалдаж, тухайн бондыг бүртгэлээс хасуулах хүсэлт гаргасан;

3.23.3. хөтөлбөр хэрэгжүүлж, тэргүүн ээлжид гаргасан бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлсөн;

3.23.4. нийтэд санал болгох бондыг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сарын дотор танилцуулгад заасан хэмжээгээр анхдагч зах зээлд санал болгоогүй, эсхүл санал болгосон боловч уг үйл ажиллагаа амжилтгүй болсон;

3.23.5. шүүх болон эрх бүхий төрийн байгууллагаас бонд гаргагчийг татан буулгах шийдвэр гаргасан.

3.24. Бонд гаргагч нь бондыг бүртгэлээс хасуулахад арилжаа эрхлэх байгууллагын, эсхүл мэргэжлийн холбооны бүртгэлээс тэргүүн ээлжид хасуулсан байна.

3.25. Бонд гаргагч энэ журмын 3.1-д заасан буюу нийтэд санал болгон гаргасан бондыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасуулахад дараах баримт бичгийг Хороонд хүргүүлнэ:

3.25.1. албан хүсэлт;

3.25.2. хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тухай мэдэгдэл, холбогдох баримт;

3.25.3. бондыг энгийн хувьцаанд хөрвүүлсэн бол үнэт цаас эзэмшигчийн өмчлөх эрх баталгаажсан тухай төвлөрсөн хадгаламжийн байгууллагын мэдэгдэл;

3.25.4. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

3.26. Энэ журмын 3.2-т заасан этгээд биржийн бус зах зээлд гаргасан бондыг бүртгэлээс хасуулахад дараах баримт бичгийг Хороонд хүргүүлнэ:

3.26.1. албан хүсэлт;

3.26.2. хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлсэн тухай мэдэгдэл;

3.26.3. бондыг хассан тухай мэргэжлийн холбооны шийдвэр;

3.26.4. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

3.27. Хороо энэ журмын 3.25, 3.26-д заасан баримт бичгийн бүрдэл, агуулгыг ажлын 10 өдрийн дотор хянаж, холбогдох этгээдийн бүртгэлээс хассан тухай шийдвэрийг үндэслэн Хорооны бүртгэлээс хасах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.28. Нийтэд санал болгох бондыг анхдагч зах зээлд санал болгож, уг үйл ажиллагаа амжилтгүй болсон тохиолдолд захиалгыг цуцлах мэдэгдлийг андеррайтерт хүргүүлж, захиалгыг бүрэн цуцалснаас хойш ажлын таван өдрийн дотор бондын бүртгэлийг Хорооны хуралдаанаар хүчингүй болгоно.

3.29. Энэ журмын 3.23.5-д заасан шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор бондын бүртгэлийг Хорооны хуралдаанаар хүчингүй болгоно.

3.30. Хороо бондыг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг бонд гаргагч, арилжаа эрхлэх байгууллага, эсхүл мэргэжлийн холбоо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, андеррайтерт тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан ажлын гурван өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.

3.31. Андеррайтер нь Монголбанкны Зээлийн мэдээллийн санд бонд гаргагчийн хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн төлбөрийн үүргийн мэдээллийг Хорооны шийдвэрийг үндэслэн тухай бүрд нийлүүлж, шинэчилнэ.

3.32. Энэ журмын 2.3.3-т заасан этгээдийн хувьд бондын гэрээг бичгээр, эсхүл цахимаар хөрөнгө оруулагчтай байгуулж, гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан байна.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор нэмсэн/
ДӨРӨВ. БОНД ГАРГАХ ХӨТӨЛБӨР

4.1. Энэ журмын 2.3 болон 5-д заасан этгээд нийтэд санал болгох тодорхой үнийн дүн бүхий бондуудыг бүхэлд /нийтэд/ нь нэг удаа бүртгүүлж, тэдгээрийг нэг удаа, эсхүл хэд хэдэн удаа хэсэгчлэн санал болгох Бонд гаргах хөтөлбөр /цаашид ‘хөтөлбөр’ гэх/-ийг хэрэгжүүлж болно.

4.2. Бонд гаргагч нь хөтөлбөр хэрэгжүүлэх тухайгаа бондын танилцуулгад, аймаг, нийслэлийн Засаг дарга болон олон улсын санхүүгийн байгууллагын хувьд бондын танилцуулга бэлтгээгүй бол Албан мэдэгдэлд тодорхой тусгана.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.3. Хөтөлбөрийн хүрээнд санал болгох бондыг хэсэгчлэн гаргах бол анхны нийлүүлэлтийгэнэ журмын 6.2-т заасан хугацаанд хийх ба бондыг Хороонд бүртгүүлснээс хойш дараах хугацаанд хөтөлбөрийг хэрэгжүүлж, үлдэх хэсгийг санал болгоно:

4.3.1. төслийн хөрөнгө оруулалт хийх зориулалттай бол 24 сарын дотор;

4.3.2. эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зориулалттай бол 18 сарын дотор;

4.3.3. бусад зориулалттай бол 12 сарын дотор.

4.4. Хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгох нийт бондуудын тоо, татан төвлөрүүлэхээр зорьж байгаа хөрөнгийн хэмжээ, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх нөхцөл, үнэ, хүү ныхарилцан адилгүй байж болно.

4.5. Хөтөлбөрийн хүрээнд бондыг анхдагч зах зээлд нийлүүлэх тухай бүрд энэ журмын 6.5-д заасан мэдэгдлийг Хороонд хүргүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

4.6. Хороо энэ журмын 6.5-д заасан мэдэгдэл, хавсралт баримт бичгийг хүлээн авч ажлын гурван өдөрт хянах бөгөөд дараах тохиолдолд нийтэд санал болгох бондын захиалгын бүртгэлийг зогсоож болно:

4.6.1. хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй;

4.6.2. энэ журмын 2.1.2-т заасан шаардлагыг хангаагүй;

4.6.3. төрийн эрх бүхий байгууллагаас, эсхүл хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагаас ногоон бонд гаргагч нь ‘ногоон’, ‘байгаль орчинд ээлтэй’ гэх ойлголтыг буруу ашигласан болохыг тогтоосон тухай, эсхүл уг шаардлагад нийцээгүй болсон болэнэ тухай олон нийгэд мэдээлээгүй бол.

4.7. Хөтөлбөрийн хүрээнд бүртгүүлсэн Бондын танилцуулгыг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сар тутамд шинэчлэн Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийгэд мэдээлнэ.

4.8. Энэ журмын 4.7-д заасан бондын шинэчилсэн танилцуулга нь бонд гаргагчийн бизнесийн орчин, санхүүгийн байдалд орсон өөрчлөлтүүд болон үүсч болзошгүй нөхцөл байдал, хөрөнгө оруулалтын шийдвэрт материаллаг нөлөө үзүүлэхүйц үйл явдал болсон, эсхүл болох ньтодорхой байгаа асуудлууд зэрэг бонд гаргагчийн шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл бүхий анх бүртгүүлсэн Бондын танилцуулгын нэмэлт-хавсралт хэлбэртэй байна.

ТАВ. НОГООН БОНД ГАРГАХ

5.1. Бонд гаргагч нь Монгол Улсын “Ногоон таксономи” эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу шинээр хэрэгжүүлэх эсхүл одоохэрэгжүүлж байгаа төсөл, үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор ‘ногоон бонд’ гаргаж болно.

5.2. Нийгэд санал болгон ногоон бонд гаргагч нь бонд гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа эсхүл үйлдвэрлэх эцсийн бүтээгдэхүүн нь “Ногоон таксономи” эсхүл олон улсын холбогдох стандарт, шалгуурт заасан ангилал, шалгуурын дагуу “ногоон”, “байгаль орчинд ээлтэй” болохыг баталгаажуулах зорилгоор хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагыг томилж, дүгнэлт гаргуулж болно.

5.3. Энэ журмын 5.2-т заасан хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

5.3.1. ногоон бонд гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаанд иж бүрэн үнэлгээ хийх туршлагатай;

5.3.2. байгаль орчны зорилтуудын төлөвлөлт, хэрэгжилт, биелэлтийг үнэлэх чиглэлээр мэргэшсэн;

5.3.3. ногоон бонд гаргагч болон түүний эрх бүхий албан тушаалтан, зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээс хараат бус, аливаа сонирхлын зөрчилгүй;

5.3.4. олон улсын холбогдох байгууллагаас гаргасан хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагуудад зориулсан стандарт бүхий удирдамжийг мөрддөг, гэрчилгээжүүлэх системийн дагуу магадлан итгэмжлэгдсэн.

5.4. Ногоон бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгийг ногоон бонд гаргагч нь тусгай дансанд байршуулж, зөвхөн энэ журмын 5.1-т заасан зориулалтын дагуу ашиглана.

5.5. Бондын хугацаа дуусахад ногоон бондын хөрөнгөөр санхүүжүүлсэн дүн болон үлдэгдэл хөрөнгө нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүнгээс багагүй байна.

5.6. Ногоон бонд гаргагч нь татан төвлөрүүлсэн хөрөнгийн удирдлага, зарцуулалт, хөрөнгө хуваарилалт болон санхүүгийн тайланд жил бүр аудит хийлгэх ба хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулагч байгууллагаар дүгнэлт гаргуулсан бол тухайн татан төвлөрүүлсэн хөрөнгөбүрэн хуваарилагдаж дуусах хүртэлх хугацаанд жил бүр тухайн байгууллагаар ногоон үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт гаргуулна.

5.7. Энэ журмын 8.6.3-т заасан Ногоон бондын тайланг хөндлөнгийн мэргэжлийн

баталгаажуулалтын байгууллага хянан баталгаажуулж болно.

5.8. Ногоон бонд гаргагч нь энэ журмын 5.2, 5.6, 5.7-т заасны дагуу хөндлөнгийн баталгаажуулагч байгууллагыг авч ажиллуулсан бол хөндлөнгийн баталгаажуулагч байгууллагын гаргасан тайланг Ногоон бондын тайланд тусгаж, компанийн цахим хуудсаар олоннийгэд мэдээлнэ.

5.9. Ногоон бонд гаргагч энэ журам эсхүл холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг зөрчсөн бол уг зөрчлийг арилгах чиглэлээр Хорооноос үүрэг өгөх бөгөөд гаргасан зөрчлийг арилгаагүй тохиолдолд Хороо энэ тухай холбогдох байгууллагууд болон олон нийтэд нэн даруй мэдэгдэнэ.

ЗУРГАА. БОНДЫГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОХ, ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААГ ЭХЛҮҮЛЭХ

1.1. Хороо нийтэд санал болгон гаргах бондыг бүртгэх тухай шийдвэрээр тухайн бондыг үнэт цаасны бүртгэлд бүртгэх болон анхдагч зах зээлд санал болгох зөвшөөрлийг нэгэн зэрэг олгоно.

1.2. Бондыг анхдагч зах зээлд санал болгох, захиалга авах үйл ажиллагааг Хороонд бүртгүүлснээс хойш зургаан сарын дотор гүйцэтгэх бөгөөд бондыг олон нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг ажлын 10 өдрийн дотор хийж гүйцэтгэнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.3. Бондыг Албан мэдэгдэл, эсхүл бондын танилцуулгад тусгасан нөхцөл, журамд заасан арга хэлбэрээр анхдагч зах зээлд санал болгож, худалдана.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.4. Энэ журмын 6.3-т заасан ажиллагааг хэрэгжүүлэхээс өмнө андеррайтер, аймаг нийслэлийн хувьд андеррайтерийн компанитай гэрээ байгуулаагүй бол Засаг дарга нь стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад бондын талаар танилцуулж, санал болгож болно.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.5. Андеррайтер, аймаг нийслэлийн хувьд андеррайтерийн компанитай гэрээ байгуулаагүй бол Засаг дарга нь бондыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг ажиллагааг эхлүүлэхээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэх бөгөөд мэдэгдэл нь дараах агуулгатай байна:

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.5.1. захиалга авч эхлэх огноо, үргэлжлэх хугацаа;

1.5.2. санал болгох бондын хэмжээ, үнэ;

1.5.3. санал болгох арга, хэлбэр.

1.6. Хөтөлбөр хэрэгжүүлж байгаа этгээд нь бондын нийлүүлэлтийг хийхэд энэ журмын 6.5-д заасан мэдэгдэлд дараах баримт бичгийг хавсаргана:

1.6.1. өмнөх улирлын санхүүгийн ерөнхий үзүүлэлт;

1.6.2. бондын танилцуулга, эсхүл Албан мэдэгдэлд заасан үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан, мэдээлэл.

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.7. Анхдагч зах зээлийн захиалга авах үйл ажиллагаа нь ажлын таван өдрөөс илүүгүй хугацаатай байна.

1.8. Андеррайтер нь бондыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагааг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

1.8.1. захиалга авах;

1.8.2. танилцуулгад тусгасан бол авсан захиалгын үндсэнд үнэ тогтоох;

1.8.3. захиалгын хуваарилалтыг хийх.

1.9. Андеррайтер нь бондын хуваарилалтыг хийхдээ ижил нөхцөлтэй захиалга бүхий хөрөнгө оруулагчийн захиалгын хуваарилалтыг стратегийн хөрөнгө оруулагч болон мэргэжлийнхөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдээс бусад хөрөнгө оруулагчдад тэгш зарчмаарбуюу цаг хугацааны дарааллаар, эсхүл хувь тэнцүүлэн хийж, байршуулна.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.10. Бонд гаргагчийн дүрэмд өөрөөр заагаагүй бол энгийн хувьцаа эзэмшигч нь хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондыг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.

1.11. Энэ журмын 6.10-д заасан эрхийг хэрэгжүүлэхэд бонд гаргагчийн энгийн хувьцаа эзэмшигчийн захиалгын эзэмшиж байгаа хувьцааны тоонд хувь тэнцэх хэсгийг тэргүүн ээлжид хуваарилах бөгөөд илүү гарсан захиалгын хуваарилалтыг энэ журмын 6.9-д заасан зарчмаар хийж байршуулна.

1.12. Бонд гаргагч нь warrant гаргаж хөрөнгө оруулагчид санал болгосон бол warrant эзэмшигч нь бонд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх тохиолдолд анхдагч зах зээлийн захиалга дуусахаас өмнө бондын зохих төлбөрийг гүйцэтгэнэ.

1.13. Андеррайтер нь бонд гаргагчтай тохиролцсоны үндсэн дээр бондыг анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах ажиллагааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан зохион байгуулж болох бөгөөд энэ тохиолдолд бондыг тогтоосон үнээр санал болгоно.

1.14. Андеррайтер нь бондыг анхдагч зах зээлд санал болгож, хуваарилалтыг хийн, андеррайтертай гэрээ байгуулаагүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын санхүүгийн байгууллага нь анхдагч зах зээлд санал болгосон тухай тайлан /Хавсралт 5/-г захиалгыг авч дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийн хамт тус тус Хороонд хүргүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.15. Бондыг анхдагч зах зээлд санал болгон худалдах үйл ажиллагаа амжилттай болсон тухай мэдэгдлийг Хороо андеррайтерт, аймаг нийслэлийн хувьд андеррайтерийн компанитай гэрээ байгуулаагүй бол Засаг даргад, олон улсын санхүүгийн байгууллагын хувьд андеррайтерийн компанитай гэрээ байгуулаагүй бол олон улсын санхүүгийн байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээдэд хүргүүлэх бөгөөд, уг мэдэгдлийг хүргүүлэх хүртэлх хугацаанд татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг бонд гаргагчийн холбогдох дансанд тусгаарлан байршуулна.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.16. Андеррайтер нь захиалгын бүртгэлийн аргаар бондын захиалгыг бүрдүүлэх тохиолдолд үнийг бонд гаргагчийн саналыг харгалзан тогтооно.

1.17. Андеррайтер нь нийтэд санал болгон бонд гаргах үйл ажиллагааг хоёр удаа дараалан амжилттай зохион байгуулж чадаагүй нь тухайн этгээдийн андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл болно.

1.18. Хороо энэ журмын 6.14-т заасан тайланг хүлээн авч, андеррайтер нь анхдагч зах зээлд бондыг амжилттай байршуулж, аливаа зөрчил гаргаагүй гэж үзвэл олон нийтэд мэдээлж, үнэт

цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэлийг баталгаажуулах мэдэгдлийг, арилжаа эрхлэх байгууллагад бондын хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг ажлын гурван өдөрт багтаан Хорооны даргын албан бичгээр тус тус хүргүүлнэ.

ДОЛОО. БОНД ГАРГАГЧ, ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭД, ХОРООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

7.1. Бонд гаргагч дараах эрхтэй:

- 7.1.1. нээлттэй бонд гаргагч нь андеррайтераас гаргасан нарийвчилсан шинжилгээ, судалгаа, хийсэн үнэлгээ, дүгнэлтэд үндэслэн нийтэд санал болгох бондын үнэ, хүүгийн түвшинг тогтоох;
- 7.1.2. Хорооны бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан хүсэлт нь хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцын мэдээ, мэдээллээр хангагдах;
- 7.1.3. нийтэд санал болгон гаргах бондыг тодорхой үнэ, хувь хэмжээгээр худалдан авах эрхийг гэрчлэх варрант гаргах;
- 7.1.4. компанийн санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгох;
- 7.1.5. бондын танилцуулга, гэрээнд заасан бол нийтэд санал болгон гаргасан бондыг хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдан авах;
- 7.1.6. энэ журмын 7.5.3, 7.5.4-т заасан арилжаа эрхлэх байгууллагын шаардлага нь үндэслэлгүй гэж үзсэн, эсхүл бүртгэхээс татгалзсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд гомдол гаргах.

7.2. Бонд гаргагч нь дараах үүрэгтэй:

- 7.2.1. энэ журмын 2.3.3-т заасан болон аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын санхүүгийн байгууллагаас бусад нээлттэй бонд гаргагч компани нь андеррайтертай гэрээ байгуулсан байх;

/Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

- 7.2.2. санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох эрх бүхий байгууллагаар зэрэглэл тогтоолгох бол зэрэглэл тогтооход шаардлагатай үнэн зөв, бүрэн мэдээллийг тухайн байгууллагад гарган өгөх;
- 7.2.3. Хорооноос бондын бүртгэлтэй холбоотой аливаа мэдээлэл хүргүүлэхийг шаардсан бол тодруулга, нэмэлт баримт бичгийг бонд гаргагч нь заасан хугацаанд Хороонд хүргүүлэх;
- 7.2.4. нээлттэй бонд гаргагч нь бондыг анхдагч зах зээлд амжилттай санал болгосон тохиолдолд ажлын таван өдрийн дотор тухайн гаргасан бондын үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болох эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ эсхүл мэдэгдлийг улсын бүртгэлд бүртгүүлэх;
- 7.2.5. холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
- 7.2.6. бондыг Хороонд бүртгүүлж, энэ журмын 6.2-т заасан хугацаа дууссанаас хойш тухайн бондыг нийтэд санал болгох тохиолдолд уг хугацаа дуусахаас ажлын 10 өдрөөс доошгүй хугацааны өмнө бондын танилцуулгыг шинэчлэн бүртгүүлэх хүсэлтийг арилжаа эрхлэх байгууллагад гаргаж, Хороонд мэдэгдэл хүргүүлэх;
- 7.2.7. нээлттэй бонд гаргагч нь зэрэглэл тогтоолгосон бол хагас жил, бүтэн жил тутам зэрэглэлийг шинэчлэх;
- 7.2.8. бонд гаргагчид гуравдагч этгээд баталгаа, батлан даалт гаргасан бол бондын танилцуулгад уг этгээдийн тодорхой, үнэн зөв, бүрэн, мэдээллийг тусгах;
- 7.2.9. Албан мэдэгдэл эсхүл бондын танилцуулга, гэрээнд заасан бол хөрөнгө

- оруулагчийн саналаар түүний бондыг хугацаанаас нь өмнө худалдан авах;
- 7.2.10. тухайн гаргасан бондыг бүртгүүлэхтэй холбоотойгоор Хороонд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан холбогдох дүгнэлт зэрэг бусад баримт бичгийг бондын хугацаа дуусаж, үндсэн болон хүүгийн төлбөрийг бүрэн төлж дуусах хүртэлх хугацаанд компани дээрээ хадгалах;
- 7.2.11. аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын санхүүгийн байгууллага нь энэ журмын 6.15-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор бондыг анхдагч зах зээлд санал болгосон тухай болон эргэн төлөлтийн хуваарийн талаарх мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх.

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор нэмсэн/

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7.3. Андеррайтер дараах эрхтэй:

- 7.3.1. хөрөнгө оруулагчийн шийдвэр гаргахад шаардлагатай бонд гаргагчийн талаарх хуулиар хориглосноос бусад бүхий л мэдээллийг бонд гаргагчаас гаргуулан авах;
- 7.3.2. бондыг анхдагч зах зээлд тодорхой хэмжээгээр багцлан стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал болгох, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн худалдан авах;
- 7.3.3. үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бонд гаргагчийн тогтмол болон тухай бүр нийтэд мэдээлэл хүргэх үйлчилгээг үзүүлэх.

7.4. Андеррайтер дараах үүрэгтэй:

- 7.4.1. бондын танилцуулгыг бэлтгэх, анхдагч зах зээлийн захиалгыг авах, хуваарилах, худалдах болон байршуулах үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
- 7.4.2. хоёр болон түүнээс дээш тооны андеррайтер хамтран синдикат хэлбэрээр ажиллах тохиолдолд тэргүүлэх болон туслах андеррайтерийн чиг үүрэг, хариуцлагыг оролцогч талуудын хооронд байгуулсан гэрээнд тодорхой тусгах;
- 7.4.3. анхдагч зах зээлийн захиалга авах явцад харилцагчийг таньж мэдэх, аливаа сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх;
- 7.4.4. Хороонд бүртгүүлсэн бондын танилцуулгыг нийтэд үнэ төлбөргүй хүргэх, сонирхсон бүх этгээдийг танилцах боломжоор хангах;
- 7.4.5. андеррайтер мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх явцад олж авсан хувь хүний болон байгууллагын нууцтай холбоотой мэдээ, мэдээлэл, баримт бичгийг гуравдагч этгээдэд задруулахгүй байх;
- 7.4.6. үйлчилгээ үзүүлсэн бонд гаргагчийн бондын хүүгийн болон үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хяналт тавих;
- 7.4.7. бонд гаргагч төлбөрийн чадваргүй болж, хүүгийн болон үндсэн төлбөрөө төлөөгүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах.

7.5. Арилжаа эрхлэх байгууллага дараах эрхтэй:

- 7.5.1. өөрийн баталсан бүртгэлийн журмын дагуу нийтэд санал болгох бондыг өөрийн бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасах;
- 7.5.2. бүртгэлийн нарийвчилсан шаардлага, шалгуурыг хууль, энэ журамд нийцүүлэн дараах байдлаар тогтоох;
- 7.5.2.1. бонд гаргагчийн үйл ажиллагааны онцлог, салбар, цар хүрээ болон бусад хүчин зүйлтэй уялдуулан ангилалтайгаар тогтоох;

7.5.2.2. үнэт цаас нь тухайн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй этгээдийн нийтэд санал болгон гаргах бондын бүртгэлд хөнгөвчилсөн шалгуур тогтоох.

7.5.3. бондыг бүртгэхтэй холбоотой нэмэлт мэдээлэл, тодруулга, баримт бичиг шаардах;

7.5.4. бүртгэлийн шаардлага, шалгуур болон бондын танилцуулгын бүрдэл нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй, тооцоолол, судалгаа нь зөрүүтэй, бодит байдалд нийцээгүй тохиолдолд тухайн бондыг бүртгэхээс татгалзах;

7.5.5. бонд гаргагч нь арилжаа эрхлэх байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, бүртгэлийн шаардлагыг хангахгүй болсон бол бүртгэлээс хасах;

7.5.6. энэ журмын 7.5.5-д заасан үндэслэлээр бүртгэлээс хасагдсан бонд гаргагчийн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй бусад үнэт цаасыг бүртгэлээс хасах.

7.6. Арилжаа эрхлэх байгууллага дараах үүрэгтэй:

7.6.1. хууль, Хорооны журам болон бүртгэлийн шаардлага, шалгуурыг хангасан эсэхийг хянаж, тухайн бонд гаргагч, түүний гаргах бонд нь зохих шалгуурыг хангасан бол бондыг бүртгэх эсэх асуудлыг хамтын шийдвэрийн зарчмаар шийдвэрлэх;

7.6.2. бондыг бүртгэхтэй холбоотой хяналтын үйл ажиллагааг ажлын 15 өдрийн дотор гүйцэтгэх;

7.6.3. хяналтын үйл ажиллагааны явцад аливаа нэмэлт мэдээлэл, тодруулга, баримт бичиг шаардсан, эсхүл үндэслэл бүхий татгалзсан шийдвэр гаргасан бол бонд гаргагчид энэ тухай мэдэгдлийг албан бичгээр, хувийг тухай бүрд Хороонд тус тус хүргүүлэх;

7.6.4. бондын бүртгэлтэй холбоотой шийдвэр, тодорхойлолт, “Бүртгэв” тэмдэглэл бүхий бонд гаргагчаас хүргүүлсэн бондын танилцуулга, эсхүл Албан мэдэгдэл, бусад баримт бичгийн хуулбарын хамт дээрх шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын хоёр өдрийн дотор Хороонд хүргүүлэх;

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

7.6.5. андеррайтерийн анхдагч зах зээлийн захиалга авах үйл ажиллагаа нь бондын танилцуулгад заасан журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, дүгнэлт гаргах;

7.6.6. Хорооноос хүргүүлсэн мэдэгдлийн үндсэнд бондын хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх;

7.6.7. бондыг энэ журмын 7.5.5-д заасан болон бонд гаргагчийн хүсэлтээр бүртгэлээс хассан бол шийдвэр болон мэдэгдэл /Хавсралт 7/-ийг шаардлагатай бусад баримт бичгийн хамт ажлын хоёр өдөрт багтаан Хороонд хүргүүлэх.

7.7. Хороо дараах эрхтэй:

7.7.1. нийтэд санал болгон гаргах бонд болон энэ журмын 3.2-т заасан бондыг бүртгэх, бүртгэлийн шаардлага хангаагүй бол бүртгэхээс татгалзах, бүртгэлээс хасах;

7.7.2. төлбөрийн тасалдалд орж, бондын танилцуулга, Бондын гэрээнд заасан нөхцөл бүрдсэн бол бүртгэлд өөрчлөлт оруулах;

7.7.3. энэ журмын 6.5-д заасан мэдэгдлийг хүлээн авч, журмын 4.6-д заасан нөхцөл бүрдсэн бол захиалгын бүртгэлийг зогсоох;

7.7.4. бонд гаргагч энэ журмын 7.2.6-д заасан хугацаанд Хороонд мэдэгдэл хүргүүлээгүй бол тухайн бондын нийтэд санал болгохыг зөвшөөрсөн бүртгэлийг хүчингүй болгох.

7.8. Хороо дараах үүрэгтэй:

7.8.1. бонд гаргагчаас энэ журмын 7.1.6-д заасны дагуу гаргасан гомдлыг хянах;

7.8.2. нийтэд санал болгон гаргах бондыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол бонд

гаргагчийн зүгээс тавьж буй ямар нэгэн нөхцөл болзолтойгоор бүртгэхгүй.

НАЙМ. БОНД ГАРГАГЧИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

8.1. Нээлттэй бонд гаргагч нь өөрөө, эсхүл андеррайтертай байгуулсан гэрээний үндсэн дээр энэ журамд заасан мэдээллийг тухайн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөсбондыг Хорооны бүртгэлээс хасах хүртэлх хугацааны туршид тогтоосон хэлбэр, давтамжаар Хороо, арилжаа эрхлэх байгууллага болон олон нийтэд Монгол хэлээр, шаардлагатай бол гадаад хэлээр давхар мэдээлнэ.

8.2. Бонд гаргагч нь компанийн, эсхүл орон нутгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар мэдээлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

8.3. Нийтэд мэдээлэх арга, хэлбэрийг бондын танилцуулгад тусгах бөгөөд андеррайтертай байгуулсан гэрээнд нэмэлтээр тусгаж болно.

8.4. Бонд гаргагчид гуравдагч этгээд баталгаа, батлан даалт гаргаж, уг этгээд нь гаргасан баталгааг хэрэгжүүлэх боломжгүй болох нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ тухай Хороо, арилжаа эрхлэх байгууллага болон олон нийтэд нэн даруй мэдээлнэ.

8.5. Бонд гаргагчийн бусад төрлийн үнэт цаас нь арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй бол Хороо болон тухайн арилжаа эрхлэх байгууллагын холбогдох мэдээллийн ил тод байдлын журмыг мөн дагаж мөрдөнө.

8.6. Нээлттэй бонд гаргагч компани нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг энэ журмын Хавсралт 8-д заасан маягт болон шаардлагатай гэж үзсэн бусад хэлбэрээр дарааххугацаанд

Хороо, арилжаа эрхлэх байгууллага, олон нийтэд хүргүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

8.6.1. Улирлын тайлан /Маягт БГ-У-ын дагуу/-г дараа сарын 10-ны өдрийн дотор, хоёр дугаар улирлын тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор/;

8.6.2. Жилийн тайлан /Маягт БГ-Ж-ын дагуу/-г дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор;

8.6.3. ногоон бонд гаргасан бол Ногоон бондын тайлан /Маягт НБ-Ж-ын дагуу/-г дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор;

8.6.4. жилийн санхүүгийн тайланг Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулан дараа оны 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор.

8.7. Нээлттэй бонд гаргагч нь дараах тохиолдолд зохих мэдээллийг Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд тухайн үйл явдал болсноос хойш ажлын гурван өдрийн дотор мэдээлнэ:

8.7.1. бондын танилцуулга, аймаг, нийслэлийн Засаг дарга, олон улсын санхүүгийн байгууллагын хувьд бондын танилцуулга бэлтгээгүй бол Албан мэдэгдэлд заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орсон;

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

8.7.2. бонд гаргах шийдвэрт заасны дагуу өөрийн гаргасан бондыг төлөгдөххугацаанаас өмнө эргүүлэн худалдан авахаар шийдвэрлэсэн;

8.7.3. бусад санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчаас зээл авсан, тэдний өмнө хүлээсэн нэмэлт үүрэг үүссэн;

8.7.4. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон; хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орсон;

8.7.5. эрх бүхий байгууллагын шийдвэрээр бонд гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;

8.7.6. бонд гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, хугацааг сунгуулсан, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон;

8.7.7. бонд гаргагч нь гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргасан;

8.7.8. бонд гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан.

8.8. Бонд гаргагч нь бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээллийг нэн даруй буюу 24 цагийн дотор Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

8.9. Аймаг, нийслэлийн Засаг даргын хувьд энэ журмын 8.7.3, 8.7.4, 8.7.5, 8.7.6, 8.7.7, 8.7.8, 8.7.9 дэх заалт хамаарахгүй.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор нэмсэн/

8.10. Аймаг, нийслэлийн Засаг дарга болон олон улсын санхүүгийн байгууллага нь олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт болон эргэн төлөлтийн талаарх мэдээллийг улирал тутамд дараа сарын 10-ны өдрийндотор, 8.7-д заасан мэдээллийг тухай бүрд Хороо, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

ЕС. ХАРИУЦЛАГА

9.1. Бонд гаргагч нь энэ журмаар тогтоосон хугацаанд мэдээллийг холбогдох маягт, хэлбэрээр хүргүүлээгүй, худал хуурмаг, төөрөгдүүлсэн шинжтэйгээр мэдээлсэн гэж үзвэл түүнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийг үндэслэн Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

9.2. Хороо энэ журмын биелэлтэд хяналт тавьж, зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

9.3. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

- Хавсралт 1 Нийтэд санал болгон гаргах бондыг бүртгүүлэх тухай өргөдөл*
- Хавсралт 2 Хаалттай хүрээнд гаргах бондыг бүртгүүлэх тухай өргөдөл²*
- Хавсралт 3 Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд гадаад улсад үнэт цаас гаргах, эсхүл гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх бондын тухай мэдэгдэл*
- Хавсралт 4 Ногоон танилцуулга*
- Хавсралт 4-а Албан мэдэгдэл*
- Хавсралт 4-б Албан мэдэгдэл*
- Хавсралт 5 Бондын анхдагч зах зээлд санал болгон худалдсан тухай тайлан*
- Хавсралт 6 Арилжаанд оруулахыг зөвшөөрсөн бондыг бүртгэсэн тухай дүгнэлт /Арилжаа эрхлэх байгууллага/*
- Хавсралт 7 Арилжаанд оруулахыг зөвшөөрсөн бондыг бүртгэлээс хассан тухай мэдэгдэл /Арилжаа эрхлэх байгууллага/*
- Хавсралт 8 Бонд гаргагчийн тогтмол хүргүүлэх мэдээлэл*

Маягт БГ-УГ - Улирлын тайлан

Маягт БГ-ЖТ - Жилийн тайлан

Маягт НБГ-ЖТ – Ногоон бонд гаргагчийн жилийн тайлан

НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ
БОНДЫГ БҮРТГҮҮЛЭХ
ӨРГӨДӨЛ

Огноо:/...../.....
(0000,сс,өө)

Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1. Бонд гаргагчийн мэдээлэл

1.1. Нэр:

1.2. Бонд гаргагчийн хэлбэр³:

Хувьцаат компани
ISIN код:
 Хязгаарлагдмал хариуцлагатай компани
 Аймаг / нийслэл
 Олон улсын санхүүгийн байгууллага

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.3. Хөрөнгө оруулалтын хэлбэр

Дотоодын хөрөнгө оруулалттай
 Гадаадын хөрөнгө оруулалттай

1.4. Үүсгэн байгуулагдсан огноо:

1.5. Улсын бүртгэлийн дугаар:

³ Аймаг, нийслэл бол ‘Бондын мэдээлэл’ хэсгийг бөглөнө үү.

1.6. Регистрийн дугаар:

1.7. Үйл ажиллагааны чиглэл:
/чиглэл тус бүрийг бичнэ/

1.8. Компанийн тухай хуулийн 6.14- д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх? Тийм
 Үгүй

Тийм бол товч мэдээлэл:

1.9. Эзэмшдэг тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн дугаар, эзэмисэн огноо, олгосон эрх бүхий байгууллага, хугацаа:

1.10. Өөрийн хөрөнгийн хэмжээ /тоо болон үсгээр/:

1.11. Хаяг:

1.12. Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл /5 болон түүнээс дээш хувь эзэмшигч тус бүрийг бичнэ/:

Иргэн	Хуулийн этгээд
Овог, нэр:	Нэр:
Иргэний харьялал:	Бүртгэлтэй улс:
Регистр /наспорт/-ийн дугаар:	Регистрийн дугаар:
Эзэмшиж буй хувь:	Эзэмшиж буй хувь:
	Үйл ажиллагааны чиглэл:
	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ:
	Эцсийн өмчлөгч:

<i>Холбоо барих утас:</i>	<i>Холбоо барих утас, хаяг:</i>
---------------------------	---------------------------------

2. Бондын мэдээлэл

2.1.	<i>Бондыг гаргах арилжаа эрхлэх байгууллага, бүртгүүлсэн огноо, шийдвэрийн дугаар:</i>	
2.2.	<i>Бондын нэр:</i>	
2.3.	<i>Тоо ширхэг:</i>	
2.4.	<i>Нэрлэсэн үнэ:</i>	
2.5.	<i>Хугацаа:</i>	
2.6.	<i>Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:</i>	
2.7.	<i>Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа:</i>	
2.8.	<i>Бусад нөхцөл /хугацаанаас өмнө хөрөнгө оруулагч эргүүлэн худалдах, бонд гаргагч худалдаж авах. хувьцаанд хөрвөх нөхцөлтэй г.м/</i>	
2.9.	<i>Нийтээс татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:</i>	
2.10	<i>Тодорхой хэмжээгээр хэсэгчлэн гаргах /трагчаар/ бол ерөнхий мэдээлэл:</i>	
2.11	<i>Нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:</i>	

2.12. *Бонд гарган татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн зориулалтын тухай мэдээлэл:*

- Гаргасан бонд, өр, төлбөрийг дахин санхүүжүүлэх,*
- Эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх,*
- Хөрөнгө оруулалт,*
- Бусад /тодорхойлж бичнэ/.*

2.13. *Барьцаа хөрөнгийн мэдээлэл:*

2.14 *Баталгаа, батлан даагчтай бол түүний мэдээлэл:*

Баталгаа, батлан даагч хуулийн этгээдийн:

Нэр:

РД:

Сонирхлын зөрчилтэй эсэх:

Өөрийн хөрөнгийн хэмжээ:

Батлан даалтын хэмжээ:

Эцсийн өмчлөгч:

3. Бонд гаргагчийн андеррайтерийн мэдээлэл

3.1. *Андеррайтерийн нэр*

*Синдикат хэлбэрээр оролцож байгаа бол,
хамтрагч андеррайтер:*

3.2. *Нийтэд санал болгон бонд гаргах үйл ажиллагаанд хүлээсэн үүргийн мэдээлэл:*

- Бондыг бүхэлд нь худалдан авах,*
- Бондыг хэсэгчлэн худалдан авах,*
- Дээд зэргийн хүчин чармайлт гаргах,*
- Арилжаалагдаагүй үлдэх хэсгийг худалдан авах.*
- Бонд гаргагчийн мэдээллийг олон нийтэд хүргэх*

“.....” аймаг /нийслэл Улаанбаатар хот /компани бид энэхүү өргөдөлд заасан бонд, түүний танилцуулга /албан мэдэгдэл/-ыг арилжаа эрхлэх “.....” байгууллагад бүртгүүлсэн тул Хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлж, анхдагч зах зээлд санал болгох хүсэлтэй тул холбогдох журмын дагуу шийдвэрлэж, зохих зөвшөөрлийг олгож өгнө үү.

Баталгаажуулалт:

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан ажиллах ажилтны овог нэр, албан тушаал, холбоо барих утас, цахим шуудан:

--

[Хорооны тусгай тэмдэглэл]

ХААЛТТАЙ ХҮРЭЭНД
ГАРГАХ БОНДЫГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Огноо:/...../.....
(оооо,сс,өө)

Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1. Бонд гаргагчийн мэдээлэл

1.1. Нэр:

1.2. Бонд гаргагчийн хэлбэр⁵

Хувьцаат компани / ISIN код/
 Хязгаарлагдмал хариуцлагатай компани
 Аймаг / нийслэл
 Олон улсын санхүүгийн байгууллага

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

1.3. Хөрөнгө оруулалтын хэлбэр

Дотоодын хөрөнгө оруулалттай
 Гадаадын хөрөнгө оруулалттай

1.4. Үүсгэн байгуулагдсан огноо:

1.5. Улсын бүртгэлийн дугаар:

1.6. Регистрийн дугаар:

1.7. Үйл ажиллагааны чиглэл:
/чиглэл тус бүрийг бичнэ/

1.8. Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?

Тийм
 Үгүй
Тийм бол товч мэдээлэл:

1.9. Эзэмшдэг тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн дугаар, эзэмшсэн огноо, олгосон эрх бүхий байгууллага, хугацаа:

⁴ Энэхүү өргөдлийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.3-т заасан нийтэд санал болгон гаргасан бонд нь Хороонд бүртгэлтэй байгаа этгээд хаалттай хүрээнд буюу биржийн бус зах зээлд нэмж гаргах бондыг бүртгүүлэх хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороонд гаргахад бөглөнө. /Журмын 3.2 дахь хэсгийг харна уу./

⁵ Аймаг, нийслэл бол ‘Бондын мэдээлэл’ хэсгийг бөглөнө үү.

1.10. Өөрийн хөрөнгийн хэмжээ

/тоо болон үсгээр/:

1.11. *Хаяг:*

1.12. *Бүртгэлтэй байгаа үнэт цаасны мэдээлэл /Бүртгэлтэй байгаа үнэт цаас тус бүрийн мэдээллийг бичнэ/*

<i>Нэр, төрөл:</i>
<i>ISIN код:</i>
<i>СЗХ-нд бүртгүүлсэн огноо:</i>
<i>Нэрлэсэн үнэ:</i>
<i>Тоо, ширхэг:</i>
<i>Сүүлийн 52 долоо хоногийн дундаж хани:</i>
<i>Бонд бол:</i>
<i>Хугацаа:</i>
<i>Хүү:</i>
<i>Хүү төлөх давтамж:</i>
<i>Барьцаа, батлан даалттай эсэх:</i>

1.13. *Хувьцаа эзэмшигчийн мэдээлэл /5 буюу түүнээс дээш хувь эзэмшигч/:*

<i>Иргэн</i>	<i>Хуулийн этгээд</i>
<i>Овог, нэр:</i>	<i>Нэр:</i>
<i>Иргэний харьялал:</i>	<i>Бүртгэлтэй улс:</i>
<i>Регистр /паспорт/-ийн дугаар:</i>	<i>Регистрийн дугаар:</i>
<i>Эзэмшиж буй хувь:</i>	<i>Эзэмшиж буй хувь:</i>
	<i>Үйл ажиллагааны чиглэл:</i>
	<i>Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ</i>
	<i>Эцсийн өмчлөгч:</i>
<i>Холбоо барих утас:</i>	<i>Холбоо барих утас, хаяг:</i>

2. Бондын мэдээлэл

2.1. *Биржсийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн шийдвэрийн огноо, дугаар:*

2.2. *Бондын нэр:*

2.3. *Тоо ширхэг:*

2.4. *Нэрлэсэн үнэ:*

2.5. *Хугацаа:*

2.6. *Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:*

2.7. *Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа:*

2.8. *Бусад нөхцөл /хугацаанаас өмнө хөрөнгө оруулагч эргүүлэн худалдах, бонд гаргагч худалдаж авах. хувьцаанд хөрвөх нөхцөлтэй г.м/*

2.9. *Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:*

2.10. *Тодорхой үе шаттай гаргах бол ерөнхий мэдээлэл:*

2.11. *Хаалттай хүрээнд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:*

2.12. *Бонд гаргах замаар татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн зориулалтын талаарх товч мэдээлэл:*

<i>Эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх</i> <i>Хөрөнгө оруулалт</i> ----- ----- -----

2.13. *Барьцаа, баталгааны мэдээлэл:*

2.14. *Батлан даагчтай бол түүний мэдээлэл:*

<i>Баталгаа, батлан даагч хуулийн этгээд:</i> <i>Нэр:</i> <i>РД:</i> <i>Сонирхлын зөрчилтэй эсэх:</i> <i>Өөрийн хөрөнгийн хэмжээ:</i> <i>Батлан даалтын хэмжээ:</i> <i>Эцсийн өмчлөгч:</i>
--

3. Бонд гаргагчийн мэргэжлийн зуучлагчийн мэдээлэл

3.1.	<i>Зуучлагчийн нэр</i>	
3.2.	<i>Улсын бүртгэлийн дугаар:</i>	
3.3.	<i>Регистрийн дугаар:</i>	
3.4.	<i>Тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:</i>	
3.5.	<i>Оршин байх албан ёсны хаяг:</i>	
3.6.	<i>Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:</i>	

3.7. *Хаалттай хүрээнд бонд гаргах үйл ажиллагаанд хүлээсэн үүргийн мэдээлэл: Бондыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн худалдан авах*
 Дээд зэргийн хүчин чармайлт гаргах

Баталгаажуулалт:

МОНГОЛ УЛСАД БҮРТГЭГДСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭД
ГАДААД УЛСАД ҮНЭТ ЦААС ГАРГАХ, ЭСХҮЛ
ГАДААД УЛСЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ЭРХЛЭХ
БАЙГУУЛЛАГАД БҮРТГҮҮЛЭХ БОНДЫН ТУХАЙ
МЭДЭГДЭЛ

Огноо:/...../.....
(0000,сс,өө)

Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1. Бонд гаргагчийн мэдээлэл

- 1.1. Нэр:
- 1.2. Хуулийн этгээдийн хэлбэр Хувьцаат компани
 Хязгаарлагдмал хариуцлагатай компани
- 1.3. Хөрөнгө оруулалтын хэлбэр Дотоодын хөрөнгө оруулалттай
 Гадаадын хөрөнгө оруулалттай
- 1.4. Үүсгэн байгуулагдсан огноо:
- 1.5. Улсын бүртгэлийн дугаар:
- 1.6. Регистрийн дугаар:
- 1.7. Үйл ажиллагааны чиглэл:
/чиглэл тус бүрийг бичнэ/
- 1.8. Компанийн тухай хуулийн 6.14-д
заасан компанийн нэгдлийн
оролцогч эсэх? Тийм
 Үгүй
Тийм бол товч мэдээлэл:
- 1.9. Эзэмидэг тусгай зөвшөөрөл,
тусгай зөвшөөрлийн дугаар,
эзэмисэн огноо, олгосон эрх бүхий
байгууллага, хугацаа:
- 1.10. Өөрийн хөрөнгийн хэмжээ /тоо
болон үсгээр/:
- 1.11. Хаяг:

2. Бондын мэдээлэл

⁶ Энэхүү мэдэгдлийг Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.3-т заасны дагуу гадаад улсад үнэт цаас гаргах, эсхүл гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх тохиолдолд Хороонд мэдэгдэнэ.

- 2.1. Бонд гаргах арилжаа эрхлэх
байгууллагын нэр, улс:
- 2.2. Бондын нэр:

- 2.3. Тоо ширхэг:
- 2.4. Нэрлэсэн үнэ:
- 2.5. Хугацаа:
- 2.6. Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:
- 2.7. Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа:
- 2.8. Бондыг гаргах валют:
- 2.9. Бусад нөхцөл /хугацаанаас өмнө хөрөнгө оруулагч эргүүлэн худалдах, бонд гаргагч худалдаж авах. хувьцаанд хөрвөх нөхцөлтэй г.м/
- 2.10. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:
- 2.11. Санал болгох хөрөнгө оруулагч: Олон нийт болон мэргэжлийн хөрөнгө оруулагч,
 Мэргэжлийн хөрөнгө оруулагчид.
- 2.12. Бонд гаргах замаар татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн зориулалтын талаарх товч мэдээлэл:
 Гаргасан бонд, өр, төлбөрийг дахин санхүүжүүлэх,
 Эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх,
 Хөрөнгө оруулалт,
 Бусад.
- -----

- 2.13. Барьцаа, баталгааны мэдээлэл:

3. Бонд гаргагчийн мэргэжлийн зуучлагчийн мэдээлэл

- 3.1. Зуучлагчийн нэр⁷
- 3.2. Бүртгэлтэй улс:
- 3.3. Регистрийн дугаар:
- 3.4. Үйл ажиллагааны чиглэл:
- 3.5. Оршин байх албан ёсны хаяг:
- 3.6. Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:

⁷Синдикат хэлбэрээр оролцож байгаа бол бусад зуучлагчийн мэдээллийг мөн бичнэ.

- 3.7. Бонд гаргах үйл ажиллагаанд хүлээсэн үүргийн мэдээлэл:

- Бондыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн худалдан авах,*
- Дээд зэргийн хүчин чармайлт гаргах,*
- Бусад хэлбэр.*

Баталгаажуулалт:

НОГООН ТАНИЛЦУУЛГА

/БОНД/

Огноо:/.../....
(оооо,сс,өө)

Энэхүү танилцуулга нь нийтэд санал болгон ногоон бонд гаргагч -ийн үйл ажиллагааны ерөнхий стратеги, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, удирдлага, тайлагналын үйл явц, /хийлгэсэн бол: хөндлөнгийн баталгаажуулалтын байгууллагын дүгнэлт/, мөн төлөвлөсөн үйл ажиллагааны Монгол Улсын ‘Ногоон таксономи’ болон бусад олон улсын холбогдох ногоон бондын стандарт, шалгуурт нийцсэн байдлыг холбогдох талуудад тайлбарлах зорилготой бөгөөд Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 3.4-т заасан Бондын танилцуулгын салшгүй хэсэг юм.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Бонд гаргагчийн нэр:

Бондын нэр:

Хөндлөнгийн мэргэжлийн баталгаажуулалтын байгууллагын нэр /дүгнэлт гаргуулсан бол/:

1. Стратеги болон үндэслэл

1.1. Байгаль орчны зорилтууд, ногоон бонд гаргах болсон шалтгааны талаар болон байгууллагын ерөнхий стратеги, үйл ажиллагаатай хэрхэн уялдсан тухай

--

Санхүүжүүлэхээр төлөвлөж байгаа үйл ажиллагааны байгаль орчны зорилтуудад оруулах хувь нэмрийг тэмдэглэнэ үү? /Монгол Улсын ‘Ногоон таксономи’ болон бусад олон улсын холбогдох ногоон бондын стандарт, шалгууртай уялдсан байна/

1.2.

- Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулах;
- Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх;
- Бохирдлоос сэргийлэх;

- Байгалийн нөөцийг хамгаалах, зөв зохистой ашиглах;
- Хүн амын амьжиргааг сайжруулах.

1.3. Удирдлагын систем, бүтцийн тухай

--

1.4. Шаардлагатай бусад мэдээлэл:

--

2. Ногоон үйл ажиллагаа

2.1. Үйл ажиллагааны ангилал /‘Ногоон таксономи’-д заасны дагуу/

--

2.2. Байгаль орчны зорилтуудад оруулах хувь нэмэр

--

2.3. Ногоон үйл ажиллагааны өмнөх болон түүнийг хэрэгжүүлс ний дараа хүрэх үр дүн, нөлөөллийн үнэлгээ, үзүүлэлтүүд

--

2.4. Ногоон төсөл/арга хэмжээний жагсаалт, тэдгээрт хуваарилах хөрөнгийн тооцоолол

--

2.5. Хориглох үйл ажиллагааны жагсаалт

--

2.6. Чөлөөт хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл

--

2.7. Шаардлагатай бусад мэдээлэл

--

--

3. Тайлагнал

3.1. Тайлангийн нэр, олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж

<i>3.2. Хэрэгжүүлэх үйл ажиллагааны байгаль орчны зорилгод оруулсан хувь нэмрийг илэрхийлэх чанарын болон тоон үзүүлэлтүүд</i>

АЛБАН МЭДЭГДЭЛ

/.....аймаг /нийслэл хот-ын бонд/

Огноо:/.../....
(0000,сс,өө)

Энэхүү Албан мэдэгдэл нь нийтэд санал болгон бонд гаргах аймаг/нийслэл хот-ын үйл ажиллагааны ерөнхий стратеги төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа, түүний Монгол Улсын Засгийн газар /орон нутгийн баримталж байгаа бодлогод нийцсэн байдал, мөн тэдгээрийн хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг тайлагнахтай холбоотой төлөвлөгөөг хөрөнгө оруулагч, холбогдох талуудад толилуулах зорилготой юм.

1. Ерөнхий мэдээлэл

- | | |
|--|--|
| 1.1. Бонд гаргагч /аймаг/нийслэл хот-ын нэр: | |
| 1.2. Бонд гаргахтай холбоотойгоор гаргасан Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрийн огноо, дугаар | |
| 1.3. Засгийн газраас олгосон зөвшөөрлийн огноо, дугаар | |
| 1.4. Бондын нэр: | |
| 1.5. Зэрэглэл /зэрэглэл тогтоолгосон бол/: | |
| 1.6. Зэрэглэл тогтоосон байгууллагын нэр /зэрэглэл тогтоолгосон бол/: | |
| 1.7. Тоо ширхэг: | |
| 1.8. Нэрлэсэн үнэ: | |
| 1.9. Хугацаа: | |
| 1.10. Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/: | |
| 1.11. Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа /дэлгэрэнгүй хуваарийг хавсаргав/: | |
| 1.12. Бусад нөхцөл /хугацаанаас өмнө хөрөнгө оруулагч эргүүлэн худалдах, бонд гаргагч худалдаж авах нөхцөлтэй г.м/ | |
| 1.13. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ: | |
| 1.14. Тодорхой үе шаттай буюу Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх бол дэлгэрэнгүй мэдээлэл: | |
| 1.15. Стратегийн хөрөнгө оруулагч болон/эсхүл олон нийтэд санал болгон худалдахаар төлөвлөсөн хугацаа: | |
| 1.16. Үнэт цаасаар гэрчлэгдэх хөрөнгө | |

оруулагчийн эрх, үүрэг:

1.17. Андеррайтер, үнэт цаас гаргахтай холбоотойгоор мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээд, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага:

1.18. Анхдагч зах зээлд санал болгох арга, хэлбэр:

Арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан тогтсон үнийн аргаар олон нийтэд санал болгох;

Андеррайтерийн компаниар дамжуулан дараах аргаар олон нийтэд санал болгох /Андеррайтертай гэрээ байгуулсан бол. Дараах аргын аль нэгийг сонгоно уу/

Захиалгын бүртгэлийн арга

Тогтсон үнийн арга

Бонд гаргагч дангаар олон нийтэд санал болгох

2. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. аймаг /нийслэл хот нь олон нийтэд санал болгон бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.

2.1.1. Үйл ажиллагаа – 1 /Бусад үйл ажиллагааг мөн агуулгын дагуу бичнэ үү/

2.1.1.1. Нэр:

2.1.1.2. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь [%]:

2.1.1.3. Хэрэгжүүлж эхлэх, дуусах болон нийт хугацаа:

2.1.1.4. Хэрэгжүүлэгч этгээд:

Орон нутаг;

Хувийн хэвшил;

Төр, хувийн хэвшлийн түншилэл.

2.1.1.5. Бэлэн байдлын үнэлгээ:

Зураг төсөл;

Техник, эдийн засгийн үнэлгээ;

Байгал орчны нөлөөллийн үнэлгээ;

Тусган гүйцэтгэгч;

Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт;

Шаардлагатай бусад

.....

.....

2.1.6. Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл

2.2. Удирдлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлагын систем, бүтцийн тухай

2.3. Хориглох үйл ажиллагааны жагсаалт

2.4. *Чөлөөт хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл*

2.5. *Шаардлагатай бусад мэдээлэл:*

3. Тайлагнал

3.1. *Тайлангийн нэр, олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж*

3.2. *Хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үе шат, үр дүнг илэрхийлэх чанарын болон тоон үзүүлэлтүүд*

3.3.

Үйл ажиллагааны тайлан хариуцсан ажилтан /алба, нэгж/-ны холбоо барих хаяг, утас, цахим хаяг

[БАТАЛГААЖУУЛАЛТ]

АЛБАН МЭДЭГДЭЛ

/Олон улсын санхүүгийн байгууллагын бонд/

Огноо:/.../....
(0000,сс,өө)

Энэхүү Албан мэдэгдэл нь нийтэд санал болгон бонд гаргах олон улсын байгууллагын үйл ажиллагааны ерөнхий стратеги төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагаа, түүний Монгол Улсын Засгийн газар /орон нутгийн баримталж байгаа бодлогод нийцсэн байдал, мөн тэдгээрийн хэрэгжилт, үр дүн, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг тайлагнахтай холбоотой төлөвлөгөөг хөрөнгө оруулагч, холбогдох талуудад толилуулах зорилготой юм.

1. Ерөнхий мэдээлэл

- 1.1. Бонд гаргагчийн харьяалах улс, хотын нэр:
- 1.2. Бонд гаргахтай холбоотойгоор гаргасан эрх бүхий этгээдийн шийдвэрийн огноо, дугаар
- 1.3. Бондын нэр:
- 1.4. Зэрэглэл /зэрэглэл тогтоолгосон бол/:
- 1.5. Зэрэглэл тогтоосон байгууллагын нэр /зэрэглэл тогтоолгосон бол/
- 1.6. Тоо ширхэг:
- 1.7. Нэрлэсэн үнэ:
- 1.8. Хугацаа:
- 1.9. Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:
- 1.10. Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа /дэлгэрэнгүй хуваарийг хавсаргав/:
- 1.11. Бусад нөхцөл /хугацаанаас өмнө хөрөнгө оруулагч эргүүлэн худалдах, бонд гаргагч худалдаж авах нөхцөлтэй г.м/
- 1.12. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:
- 1.13. Тодорхой үе шаттай буюу Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлэх бол дэлгэрэнгүй мэдээлэл:
- 1.14. Стратегийн хөрөнгө оруулагч болон/эсхүл олон нийтэд санал болгон худалдахаар төлөвлөсөн хугацаа:
- 1.15. Үнэт цаасаар гэрчлэгдэх хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг:
- 1.16. Андеррайтер, үнэт цаас гаргахтай холбоотойгоор мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа бусад этгээд, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлага:

1.17. Анхдагч зах зээлд санал болгох арга,

хэлбэр:

- Арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан тогтсон үнийн аргаар олон нийтэд санал болгох;
- Андеррайтерийн компаниар дамжуулан дараах аргаар олон нийтэд санал болгох /Андеррайтертай гэрээ байгуулсан бол. Дараах аргын аль нэгийг сонгоно уу/
 - Захиалгын бүртгэлийн арга
 - Тогтсон үнийн арга
 - Бонд гаргагч дангаар олон нийтэд санал болгох

2. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2.1. олон улсын байгууллага нь олон нийтэд санал болгон бонд гаргах замаар татан төвлөрүүлсэн хөрөнгөөр дараах үйл ажиллагааг санхүүжүүлэхээр төлөвлөсөн болно.

2.1.1. Үйл ажиллагаа – 1 /Бусад үйл ажиллагааг мөн агуулгын дагуу бичнэ үү/

2.1.2. Нэр:

2.1.3. Төсөвт өртөг, татан төвлөрүүлсэн хөрөнгөнд эзлэх хувь [%]:

2.1.4. Хэрэгжүүлж эхлэх, дуусах болон нийт хугацаа:

2.1.5. Бэлэн байдлын үнэлгээ:

- Зураг төсөл;
- Техник, эдийн засгийн үнэлгээ;
- Байгал орчны нөлөөллийн үнэлгээ;
- Тусган гүйцэтгэгч;
- Бусад мэргэжлийн байгууллагаас гаргасан дүгнэлт;
- Шаардлагатай бусад

.....

.....

2.1.6. Тухайн үйл ажиллагаа нь төр, орон нутгийн бодлого, стратегид нийцсэн байдал, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө, хүрэх үр дүн, учирч болзошгүй эрсдэл зэрэг болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл

2.2. Удирдлага, хэрэгжүүлэх үйл ажиллагааны удирдлагын систем, бүтцийн тухай

2.3. Хориглох үйл ажиллагааны жагсаалт

2.4. *Чөлөөт хөрөнгийн удирдлагатай холбоотой мэдээлэл*

--

2.5. *Шаардлагатай бусад мэдээлэл:*

--

3. Тайлагнал

3.1. *Тайлангийн нэр, олон нийтэд хүргэх хэлбэр, давтамж*

--

3.2. *Хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үе шат, үр дүнг илэрхийлэх чанарын болон тоон үзүүлэлтүүд*

--

3.3.

Үйл ажиллагааны тайлан хариуцсан ажилтан /алба, нэгж/-ны холбоо барих хаяг, утас, цахим хаяг

--

[БАТАЛГААЖУУЛАЛТ]

**БОНДЫН АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД
САНАЛ БОЛГОН ХУДАЛДСАН
ТУХАЙ ТАЙЛАН⁸**

Огноо:/.../...
(оооо,сс,өө)

Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1. Бондын мэдээлэл	
1.1. Бонд гаргагчийн нэр:	
1.2. Андеррайтер:	
1.3. Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:	
1.4. Бондын нэр:	
1.5. Бүртгэлтэй тоо, ширхэг:	
1.6. Нийт үнийн дүн:	
2. Санал болгосон тухай мэдээлэл	
2.1. Захиалга авч эхэлсэн огноо, үргэлжилсэн хугацаа:	
2.2. Санал болгосон тоо ширхэг:	
2.3. Санал болгосон хэлбэр:	<input type="checkbox"/> Захиалгын бүртгэлийн арга, Тогтсон үнийн арга.
2.4. Санал болгосон үнэ /захиалгын бүртгэлийн аргаар санал болгосон бол дээд, доод үнийг мөн бичнэ/:	
2.5. Татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:	
2.6. Хүлээн авсан саналын үнийн дүн, хувь:	
2.7. Бондын хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бол: Транчийн дугаар: Өмнө гаргасан нийт бондын хэмжээ: Цаашид гаргах үлдэгдэл бондын хэмжээ:	

2.8. Анхдагч зах зээлд хүлээн авсан саналын мэдээлэл

Агуулга	Хөрөнгө оруулагч	Харилцагч
---------	------------------	-----------

⁸ Андеррайтер нь бондын анхдагч зах зээлийн захиалгыг авч дууссанаас хойш ажлын гурван өдрийн дотор хуваарилалтыг хийж, энэхүү тайланг арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолтийн хамт Хороонд хүргүүлнэ.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

	Олон нийт	Мэргэжлийн ⁹ болон ногоон хөрөнгө оруулагч	Андеррайтерийн	Бусад
Хөрөнгө оруулагчдын тоо				
Үнийн дүн				
Хувь				

2.9. Бусад хэлцлийн мэдээлэл

Андеррайтерийн худалдан авсан:

тоо ширхэг:
үнийн дүн:
хувь:

Журмын 6.4-д заасан
этгээдийн худалдан
авсан:

тоо ширхэг:
үнийн дүн:
хувь:

2.10. Бондыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх хэрэгжүүлсэн этгээдийн мэдээлэл:

Хөрөнгө оруулагчийн тоо:
Үнийн дүн:
Хувь:

2.11. Анхдагч зах зээлийн захиалга авах үйл ажиллагааны явцад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой байж болзошгүй сэжигтэй гүйлгээ хийгдсэн эсэх:

Тийм /авсан арга хэмжээний тухай мэдээллийг бичнэ үү/
 Үгүй

2.12. Анхдагч зах зээлд бондыг амжилттай санал болгосон эсэх:

Амжилттай Амжилтгүй

2.13. Хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэхээр санал болгож байгаа хугацаа

3. Арилжаа эрхлэх байгууллагын тодорхойлолт

3.1. Үнэт цаасыг хоёрдогч зах зээл дээр арилжих бэлтгэл хангагдсан тухай тодорхойлолт:

3.2. Хорооны журмын дагуу явагдсан эсэх:

3.3. Захиалгын бүртгэлийг хийх явцад аливаа харилцагч, хөрөнгө оруулагчаас санал, гомдол гаргасан эсэх: /тийм бол тодорхой бичнэ үү/

3.4. Дээрх мэдээлэл үнэн зөв эсэх:

Баталгаажуулалт:

Андеррайтер:

Бонд гаргагч:

Арилжаа эрхлэх байгууллага:

“.....” ХХК-ИЙН
АРИЛЖААНД ОРУУЛАХЫГ ЗӨВШӨӨРСӨН
БОНДЫГ БҮРТГЭСЭН ТУХАЙ
ДҮГНЭЛТ

Огноо:/.../....
(0000,сс,өө)

Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1. Ерөнхий мэдээлэл

1.1. Бонд гаргагчийн:	Нэр: Үүсгэн байгуулагдсан огноо: Регистрийн дугаар:
1.2. Андеррайтер:	
1.3. Аудитор:	
1.4. Хуулийн дүгнэлт гаргасан этгээд:	
1.5. Хөрөнгийн үнэлгээ хийсэн этгээд:	
1.6. Бусад дүгнэлт гаргасан этгээд:	
1.7. Баталгаа, батлан даалт гаргасан этгээд:	
1.8. Бондын нэр:	
1.9. Нэрлэсэн үнэ:	
1.10. Бүртгэсэн тоо, ширхэг:	
1.11. Хугацаа:	
1.12. Хүү, төрөл /тогтмол, хөвөгч г.м/:	
1.13. Хүү, үндсэн төлбөр төлөх давтамж, хугацаа:	
1.14. Нийтээс татан төвлөрүүлэхээр төлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:	
1.15. Гаргасан бондын үүргийн гүйцэтгэлийг хангах барьцаа хөрөнгийн мэдээлэл:	

1.16. *Бонд гаргах хөтөлбөр хэрэгжүүлж, тодорхой хэмжээгээр хэсэгчлэн гаргах /транчаар/ бол ерөнхий мэдээлэл:*

--

2. Бүртгэлийн үйл ажиллагааны мэдээлэл

2.1. *Бондыг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авсан огноо:*

--

2.2. *Хүлээн авсан баримт бичиг, хуудас:*

--

2.3. *Баримт бичгийг хянасан багийн гишүүн, албан тушаал:*

--

2.4. *Бонд гаргагч, түүний мэргэжлийн зөвлөхийн хийсэн танилцуулга, уулзалтын огноо, оролцогч талуудын мэдээлэл, хэлэлцсэн асуудал:*

--

2.5. *Арилжаа эрхлэх байгууллагаас бонд гаргагчид нэмэлт баримт бичиг, тайлбар, тодруулга хүссэн албан бичиг хүргүүлсэн эсэх /тийм бол огноо, дугаар болон албан бичиг тус бүрийн хуулбарыг энэхүү дүгнэлтэд хавсаргана/:*

--

2.6. *Бонд гаргагчаас арилжаа эрхлэх байгууллагын шаардлагын дагуу нэмэлт тайлбар, тодруулга бүхий хариу хүргүүлсэн эсэх /тийм бол огноо, дугаар болон албан бичиг тус бүрийн хуулбарыг энэхүү дүгнэлтэд хавсаргана./*

--

2.7. *Бонд гаргагчийн эрхэлж байгаа үйл ажиллагаа, эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хүрээнд холбогдох эрх бүхий төрийн болон төрийн бус байгууллагаас үйл ажиллагаа болон бонд гаргахтай холбоотой тодруулга, тодорхойлолтыг авсан эсэх болон түүнтэй холбоотой мэдээлэл:*

--

2.8. *Бонд гаргагчийн олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт болон хөрөнгө оруулагчийн эрх, үүргийн талаарх мэдээлэл:*

2.9. *Бонд гаргагчийн цаашид явуулах үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, түүнийг хэрхэн удирдах талаарх хүсэлт гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, төлөвлөгөөнд өгөх арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт:*

2.10. *Нэмэлт тайлбар /шаардлагатай бол/:*

Тус нь нийтэд санал болгон гаргах дээрх бондыг холбогдох хууль, журмын хүрээнд хянаж, аливаа нөхцөл, болзолгүйгээр өөрийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн болно.

Санхүүгийн зохицуулах хороо энэхүү бондыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.2-т заасны дагуу анхдагч зах зээлд арилжих зөвшөөрлийг олгосон тохиолдолд тус байгууллага нь Хорооны “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам”-ын 7.6.5-д заасны дагуу зохих хяналтыг хэрэгжүүлэх болно.

/Энэ хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 68 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

Жич: “.....” –ийн /арилжаа эрхлэх байгууллагын нэр/ /эрх бүхий байгууллага/-ийн /огноо/-ны өдрийн..... дугаар тогтоолоор батлагдсан “Бүртгэлийн журам”-ийн дагуу бонд гаргагчаас ирүүлсэн баримт бичгийг хянасан тухай ‘хяналтын хуудас /нийт.....хуудас/-ыг хавсаргав.

Дүгнэлт гаргасан:

Овог, нэр:
Албан тушаал:
Гарын үсэг:

Овог, нэр:
Албан тушаал:
Гарын үсэг:

Овог, нэр:
Албан тушаал:
Гарын үсэг:

Овог, нэр:
Албан тушаал:
Гарын үсэг:

Хянасан:

Овог, нэр:
“.....”-ийн гүйцэтгэх захирал
Гарын үсэг:
(тэмдэг)

“ ”/арилжаа эрхлэх байгууллагын нэр/–ийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн
 бондыг бүртгэсэн тухай дүгнэлтийн
 ХАВСРАЛТ

БОНДЫГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Бонд гаргагчийн нэр:

Бондын нэр:

Андеррайтерийн нэр:

Д/д	Журмын		Бүртгэлийн шаардлага хангасан эсэх*	Тайлбар	Үнэт цаасны танилцуулга дахь хуудасны	
	Заалтын дугаар	Заалт			дугаар	тоо
1						
2						
3						
...						

*- 'тийм' эсхүл 'үгүй' тэмдэглэл хийнэ

“.....” БОНД ГАРГАГЧИЙН
АРИЛЖААНД ОРУУЛАХЫГ ЗӨВШӨӨРСӨН
БОНДЫГ БҮРТГЭЛЭЭС ХАССАН ТУХАЙ
МЭДЭГДЭЛ

Огноо:/.../....
(0000,сс,өө)

Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

Арилжаа эрхлэх байгууллагын
бүртгэлээс бондыг хассан үндэслэл:

Бонд гаргагчийн хүсэлтээр
 Арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрээр

1. Ерөнхий мэдээлэл

1.1. Бонд гаргагчийн:

Нэр:
Арилжаа эрхлэх байгууллагад бондыг бүртгүүлсэн
огноо:
Бондын
нэр:
код:
ISIN код:
хугацаа дуусах огноо:

1.2. Андеррайтер:

1.3. Баталгаа, батлан даалт
гаргасан этгээд:

2. Бүртгэлээс хасахтай холбоотой үйл ажиллагааны мэдээлэл

2.1. Бонд гаргагч бондыг бүртгэлээс хасуулах хүсэлт гаргасан

2.1.1. Бондыг бүртгэлээс хасуулах
хүсэлтийг хүлээн авсан огноо:

2.1.2. Хүлээн авсан баримт бичиг,
хуудас:

2.1.3. Баримт бичгийг хянасан
багийн гишүүн, албан
тушаал:

2.1.4. Бонд гаргагчийн хөрөнгө
оруулагчийн өмнө хүлээсэн
үүргийн хэрэгжилтийн
талаарх мэдээлэл:

2.2. Бонд гаргагч гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй, бүртгэлийн шаардлагыг хангахгүй болсон

2.2.1. Бонд гаргагч гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүй, бүртгэлийн шаардлагыг хангахгүй болсон тухай дэлгэрэнгүй мэдээлэл:

2.2.2. *Бонд гаргагч гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой арилжаа эрхлэх байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээлэл:*

2.2.3. *Бондыг бүртгэлээс хассанаар хөрөнгө оруулагчид учирч болзошгүй эрсдэлийн талаар арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт:*

2.2.4. *Нэмэлт тайлбар /шаардлагатай бол/:*

Жич: “.....” –ийн /арилжаа эрхлэх байгууллагын нэр/...../эрх бүхий байгууллага/-ийн /огноо/-ны өдрийн..... дугаар тогтоолоор батлагдсан “Бүртгэлийн журам”-ийн дагуу бонд гаргагчаас ирүүлсэн баримт бичгийг хянасан тухай ‘хяналтын хуудас /нийтхуудас/-ыг хавсаргав.

Дүгнэлт гаргасан:

Овог, нэр:
Албан тушаал:
Гарын үсэг:

Овог, нэр:
Албан тушаал:
Гарын үсэг:

Овог, нэр:
Албан тушаал:
Гарын үсэг:

Овог, нэр:
Албан тушаал:
Гарын үсэг:

Хянасан:

Овог, нэр:

“.....”-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(тэмдэг)

БОНД ГАРГАГЧИЙН
УЛИРЛЫН ТАЙЛАН¹⁰

Огноо:/...../.....
(0000,сс,өө)

Бонд гаргагчийн нэр:		Тайлангийн:	жил:	
Регистрийн дугаар:			улирал:	
Бонд гаргасан огноо:			дугаар:	
		Гаргасан бондын:	нэр:	
			хугацаа дуусах огноо:	
			тоо ширхэг:	
			үнийн дүн:	
		Бүртгэлтэй бонд:	тоо ширхэг:	

1. Бонд гаргагчийн ерөнхий мэдээлэл

- 1.1. Нэр:
- 1.2. Үүсгэн байгуулагдсан огноо:
- 1.3. Үйл ажиллагааны чиглэл:
- 1.4. Ажилчдын тоо:
- 1.5. ТУЗ-ийн дарга:
- 1.6. Гүйцэтгэх захирал:
- 1.7. Хаяг:

- 1.8. Холбоо барих утас:
- 1.9. Цахим хаяг, шуудан:
- 1.10. Аудитор, гэрээ байгуулсан огноо.:
- 1.11. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн огноо:
- 1.12. Бондын код:
ISIN код:
- 1.13. Олон нийтэд мэдээлэл хүргэсэн арга, хэлбэр, хэвлэл:

-
-

¹⁰ Бонд гаргагч нь энэхүү ‘Улирлын тайлан’-г дараа сарын 10-ны өдрийн дотор, хоёрдугаар улирлын тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн хамт Санхүүгийн зохицуулах хороо, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлж, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Энэхүү тайланг гаргахад бонд гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой Маягтад зааснаас бусад шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулагчдад хүргэхийг зөвлөж байна.

1.14. Баталгаа, батлан даалт гаргасан этгээд:

1.15. Шаардлагатай бусад:

----- ----- -----

2. Үйл ажиллагааны мэдээлэл

2.1. Тайлант хугацаанд хийсэн борлуулалтын мэдээлэл:

Нийт борлуулалтын тоо, дүн:

Иргэн/Байгууллагын нэр /хамгийн их дүнтэйг бичнэ үү/:	Үнийн дүн /мянган төгрөг/:
1:	
2:	
3:	
Нийт дүн:	

2.2. Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтын мэдээлэл:

Нийт худалдан авалтын тоо, дүн:

Иргэн/Байгууллагын нэр /хамгийн их дүнтэйг бичнэ үү/:	Үнийн дүн /мянган төгрөг/:
1:	
2:	
3:	
Нийт дүн:	

2.3. Тайлант хугацаанд шинээр үүссэн үүрэг /зээл, өрийн хэрэгсэл, батлан даалт, баталгааны гэрээ, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөр г.м/-ийн мэдээлэл:

Нийт үүргийн тоо, дүн:

Иргэн/Байгууллагын нэр /хамгийн их дүнтэйг бичнэ үү/:	Үнийн дүн /мянган төгрөг/:
1:	
2:	
3:	
Нийт дүн:	

2.4. Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны төлөвлөгөөний явцын мэдээлэл:

----- ----- -----

2.5. *Шаардлагатай бусад мэдээлэл:*

<p>-----</p> <p>-----</p> <p>-----</p>
--

3. Санхүүгийн мэдээлэл:

3.1. Санхүү байдлын тайлан

	Санхүүгийн үзүүлэлтүүд	Тайлант үед	Өмнөх оны мөн үед	Өмнөх оны жилийн дун
	<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
	<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</i>			
	<i>Дансны ба бусад авлага</i>			
	<i>Бараа материал</i>			
	<i>Урьдчилж төлсөн зардал/тооцоо</i>			
	<i>Бусад эргэлтийн хөрөнгө</i>			
	<i>Эргэлтийн хөрөнгийн дүн</i>			
	<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
	<i>Үндсэн хөрөнгө</i>			
	<i>Биет бус хөрөнгө</i>			
	<i>Бусад эргэлтийн бус хөрөнгө</i>			
	<i>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</i>			
	<i>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</i>			
	<i>Богино хугацаат өр төлбөр</i>			
	<i>Дансны ба бусад өглөг</i>			
	<i>Татварын өглөг</i>			
	<i>Богино хугацаат зээл</i>			
	<i>Урьдчилж орсон орлого</i>			
	<i>Богино хугацаат өр төлбөрийн дүн</i>			
	<i>Урт хугацаат өр төлбөр</i>			
	<i>Урт хугацаат зээл</i>			
	<i>Урт хугацаат өр төлбөрийн дүн</i>			
	<i>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</i>			
	<i>Эздийн өмч</i>			
	<i>Хувьцаат капитал</i>			
	<i>Халаасны хувьцаа</i>			
	<i>Нэмж төлөгдсөн капитал</i>			
	<i>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл</i>			
	<i>Эздийн өмчийн бусад хэсэг</i>			
	<i>Тайлант үеийн ашиг (алдагдал)</i>			
	<i>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</i>			
	<i>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</i>			
	<i>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</i>			

3.2. Орлогын тайлан

	Санхүүгийн үзүүлэлтүүд	Тайлант үед	Өмнөх оны мөн үед	Өмнөх оны жилийн дун
	<i>Борлуулалтын орлого (цэвэр)</i>			
	<i>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</i>			
	<i>Нийт ашиг (алдагдал)</i>			
	<i>Бусад орлого</i>			
	<i>Борлуулалт, маркетингийн зардал</i>			
	<i>Ерөнхий ба удирдлагын зардал</i>			
	<i>Санхүүгийн зардал</i>			
	<i>Бусад зардал</i>			
	<i>Бусад ашиг (алдагдал)</i>			
	<i>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</i>			
	<i>Орлогын татварын зардал</i>			
	<i>Татварын дараах ашиг (алдагдал)</i>			

**БОНД ГАРГАГЧИЙН
ЖИЛИЙН ТАЙЛАН¹¹**

Огноо:/...../.....
(0000,сс,өө)

Бонд гаргагчийн нэр:		Тайлангийн:	жил:	
Регистрийн дугаар:			дугаар:	
Бонд гаргасан огноо:				

Гаргасан бондын:	нэр:	
	хугацаа дуусах огноо:	
	тоо ширхэг:	
	үнийн дүн:	
Бүртгэлтэй бонд:	тоо ширхэг:	

1. Бонд гаргагчийн ерөнхий мэдээлэл

- 1.2. Нэр:
- 1.2. Үүсгэн байгуулагдсан огноо:
- 1.3. Үйл ажиллагааны чиглэл:
- 1.4. Ажилчдын тоо:
- 1.5. ТУЗ-ийн дарга:
- 1.6. Гүйцэтгэх захирал:
- 1.7. Хаяг:
- 1.8. Холбоо барих утас:
- 1.9. Цахим хаяг, шуудан:
- 1.10. Аудитор, гэрээ байгуулсан огноо.:
- 1.11. Арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн огноо:
- 1.12. Бондын код:
- ISIN код:

-
-

¹¹ Бонд гаргагч нь энэхүү ‘Жилийн тайлан’-г хоёрдугаар сарын 10-ны өдрийн дотор, жилийн санхүүгийн тайлангийн хамт Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлж, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Энэхүү тайланг гаргахад бонд гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой Маягтад зааснаас бусад шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулагчдад хүргэхийг зөвлөж байна.

- | | |
|---|--|
| 1.13. Олон нийтэд мэдээлэл хүргэсэн арга, хэлбэр, хэвлэл: | |
| 1.14. Баталгаа, батлан даалт гаргасан этгээд: | |
| 1.15. Шаардлагатай бусад: | |

----- ----- -----

2. Үйл ажиллагааны мэдээлэл

2.1. Тайлант хугацаанд хийсэн борлуулалтын

мэдээлэл: Нийт борлуулалтын тоо, дүн:

Иргэн/Байгууллагын нэр /хамгийн их дүнтэйг бичнэ үү/:	Үнийн дүн /мянган төгрөг/:
1:	
2:	
3:	
4:	
5:	
Нийт дүн:	

2.2. Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтын

мэдээлэл: Нийт худалдан авалтын тоо, дүн:

Иргэн/Байгууллагын нэр /хамгийн их дүнтэйг бичнэ үү/:	Үнийн дүн /мянган төгрөг/:
1:	
2:	
3:	
4:	
5:	
Нийт дүн:	

2.3. Тайлант хугацаанд хийсэн их хэмжээний хэлцлийн

мэдээлэл: Нийт хэлцлийн тоо, дүн:

Иргэн/Байгууллагын нэр /хамгийн их дүнтэйг бичнэ үү/:	Үнийн дүн /мянган төгрөг/:
1:	
2:	
3:	
Нийт дүн:	

2.4. Тайлант хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн

мэдээлэл: Нийт хэлцлийн тоо, дүн:

Иргэн/Байгууллагын нэр /нийт хэлцлийг бичнэ үү/:	Үнийн дүн /мянган төгрөг/:
1:	
2:	
....	
....	
Нийт дүн:	

- 2.5. *Тайлант хугацаанд шинээр үүссэн үүрэг /зээл, өрийн хэрэгсэл, батлан даалт, баталгааны гэрээ, шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөр г.м/-ийн мэдээлэл:*
Нийт үүргийн тоо, дүн:

<i>Иргэн/Байгууллагын нэр /хамгийн их дүнтэйг бичнэ үү/:</i>	<i>Үнийн дүн /мянган төгрөг/:</i>
<i>1:</i>	
<i>2:</i>	
<i>3:</i>	
<i>4:</i>	
<i>5:</i>	
<i>Нийт дүн:</i>	

- 2.6. *Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны төлөвлөгөөний явцын мэдээлэл:*

<p>-----</p> <p>-----</p> <p>-----</p>
--

- 2.7. *Хорооноос баталсан компанийн засаглалын зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдсөн тухай мэдээлэл:*

<p>-----</p> <p>-----</p> <p>-----</p>
--

- 2.8. *Онцлох үйл явдлын мэдээлэл*

<p>-----</p> <p>-----</p> <p>-----</p>
--

- 2.9. *Шаардлагатай бусад мэдээлэл:*

<p>-----</p> <p>-----</p>
<p>-----</p>

- 2.10. *Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тов:*

3. Санхүүгийн мэдээлэл:

- 3.1. Бонд гаргагч болон баталгаа, батлан даалт гаргасан этгээдийн Санхүү байдлын тайлан**

	Санхүүгийн үзүүлэлтүүд	Тайлант үед	Өмнөх оны мөн үед
	<i>Эргэлтийн хөрөнгө</i>		
	<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</i>		

	<i>Дансны ба бусад авлага</i>		
	<i>Бараа материал</i>		
	<i>Урьдчилж төлсөн зардал/тооцоо</i>		
	<i>Бусад эргэлтийн хөрөнгө</i>		
	<i>Эргэлтийн хөрөнгийн дүн</i>		
	<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>		
	<i>Үндсэн хөрөнгө</i>		
	<i>Биет бус хөрөнгө</i>		
	<i>Бусад эргэлтийн бус хөрөнгө</i>		
	<i>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</i>		
	<i>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</i>		
	<i>Богино хугацаат өр төлбөр</i>		
	<i>Дансны ба бусад өглөг</i>		
	<i>Татварын өглөг</i>		
	<i>Богино хугацаат зээл</i>		
	<i>Урьдчилж орсон орлого</i>		
	<i>Богино хугацаат өр төлбөрийн дүн</i>		
	<i>Урт хугацаат өр төлбөр</i>		
	<i>Урт хугацаат зээл</i>		
	<i>Урт хугацаат өр төлбөрийн дүн</i>		
	<i>ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН</i>		
	<i>Эздийн өмч</i>		
	<i>Хувьцаат капитал</i>		
	<i>Халаасны хувьцаа</i>		
	<i>Нэмж төлөгдсөн капитал</i>		
	<i>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл</i>		
	<i>Эздийн өмчийн бусад хэсэг</i>		
	<i>Тайлант үеийн ашиг (алдагдал)</i>		
	<i>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</i>		
	<i>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</i>		
	<i>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</i>		

3.2. Бонд гаргагчийн орлогын тайлан

	Санхүүгийн үзүүлэлтүүд	Тайлант үед	Өмнөх оны мөн үед
	<i>Борлуулалтын орлого (цэвэр)</i>		
	<i>Борлуулсан бүтээгдэхүүний өртөг</i>		
	<i>Нийт ашиг (алдагдал)</i>		
	<i>Бусад орлого</i>		
	<i>Борлуулалт, маркетингийн зардал</i>		
	<i>Ерөнхий ба удирдлагын зардал</i>		
	<i>Санхүүгийн зардал</i>		
	<i>Бусад зардал</i>		

	<i>Бусад ашиг (алдагдал)</i>		
	<i>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</i>		
	<i>Орлогын татварын зардал</i>		
	<i>Татварын дараах ашиг (алдагдал)</i>		

**НОГООН БОНД ГАРГАГЧИЙН
ЖИЛИЙН ТАЙЛАН**

Огноо:/.../....
(0000,сс,өө)

Бонд гаргагчийн нэр:		Тайлангийн:	жил:	
Регистрийн дугаар:			давтамж:	
Бонд гаргасан огноо:			дугаар:	
			дараагийн тайлангийн хугацаа:	
Хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын нэр (хэрэв байгаа бол):		Энэхүү тайланг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан эсэх:		
		Гаргасан бондын:	нэр:	
			хугацаа дуусах огноо:	
			тоо ширхэг:	
			үнийн дүн:	
		Бүртгэлтэй бонд:	тоо ширхэг:	

1. Ерөнхий мэдээлэл

1.1. Бонд гаргагчийн гаргасан ногоон бонд нь холбогдох стандарт, шалгуурыг хангасан хэвээр байгаа эсэх?

- Тийм
 Үгүй

1.2. Монгол Улсын ‘Ногоон таксономи’ болон холбогдох бусад олон улсын ногоон бондын стандарт, шалгуурт заасан ангиллын дагуу ногоон бонд гаргагчийн үйл ажиллагааны байгаль орчны зорилгод оруулсан хувь нэмрийг харуулах, тайлагнахад ашиглах чанарын болон тоон үзүүлэлтүүд.

--

1.3. Тайланг бэлтгэсэн аргачлал:

- Төсөл нэг бүрээр гаргасан тайлан
 Бүх төслүүдийг нэгтгэн багц байдлаар гаргасан тайлан

2. Татан төвлөрүүлсэн хөрөнгө хуваарилалтын болон үйл ажиллагааны үр дүн, нөлөөллийн тайлан

2.1. Төсөл нэг бүрийн хувьд гаргах тайлан

Д/д	Монгол Улсын ‘Ногоон таксономи’-н холбогдох ангилал	Төслийн нэр	Товч тайлбар	Батлагдсан хөрөнгийн мөнгөн дүн (сая төгрөг)	Ногоон бондын хөрөнгөөр санхүүжүүлэх хувь хэмжээ	Өмнөх хугацаанд хуваарилсан хөрөнгийн дүн (сая төгрөг)	Санхүүжүүлсэн хувь хэмжээ	ногоон бондын хөрөнгөөс ашигласан хувь хэмжээ	Гүйцэтгэсэн үр дүн	Байгаль орчинд үзүүлсэн ашиг тус/үр нөлөө
-----	---	-------------	--------------	--	--	--	---------------------------	---	--------------------	---

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын гуравдугаар хавсралт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ САНАЛ ГАРГАХ, ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмаар хувьцаат компани /цаашид “компани” гэх/-ийн гаргасан хувьцааг бүхэлд нь, эсхүл хувьцааны хяналтын багцаас дээш хувийг сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах, компанийн нийт гаргасан энгийн хувьцааны хяналтын багцаас дээш хувийг худалдан авсан этгээд Компанийн тухай хуулийн 57.1-д заасан үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдан авах санал гаргах үүрэгтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

Хоёр.Сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах

2.1.Компанийн хувьцааг бүхэлд нь, эсхүл хувьцааны хяналтын багцаас дээш хувийг компанийн хувьцаа эзэмшигч дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран, эсхүл хувьцаа эзэмшдэггүй этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.1.1-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааг худалдан авахаар энэ журамд заасны дагуу худалдан авах саналыг Хороо, арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон нийтэд нэгэн зэрэг мэдэгдэнэ.

2.2.Сайн дурын үндсэн дээр худалдан авах саналыг компанид мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс эхлэн компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд уг саналыг гаргасанд тооцно. Худалдан авах саналыг хүлээж авсан компани өөрийн цахим хуудсанд байршуулна.

2.3.Сайн дурын үндсэн дээр санал гаргахтай холбоотой мэдэгдэлд дараах зүйлийг тусгана:

2.3.1.Худалдан авах санал гаргаж буй этгээд болон холбогдох этгээдийн хувьцаа эзэмшигчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, хэрэв хуулийн этгээд бол нэр, хаяг, холбоо барих утас, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар;

2.3.2.Худалдан авах саналын эхлэх, дуусах он, сар, өдөр;

2.3.3.Худалдан авахаар зарласан нийт хувьцааны тоо ширхэг;

2.3.4.Худалдах саналыг хүлээн авах өдөр;

2.3.5.Хувьцааг худалдан авах төлбөрийг гүйцэтгэх өдөр;

2.3.6.Худалдан авах санал гаргагчийн компанид эзэмшиж байгаа хувьцааны тоо хэмжээ, хувь;

2.3.7.Санал гаргагч болон холбогдох этгээд өөр компанийн хувьцааг эзэмшиж байгаа бол тэр талаарх мэдээлэл;

2.3.8.Худалдан авах санал гаргах болсон шалтгаан, зорилго;

2.3.9.Нэгж хувьцааг худалдан авахаар санал болгох үнэ (Хувьцаа худалдан авахаар санал болгох үнэ нь тухайн хувьцааны сүүлийн зургаан сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй байна. Хэрэв сүүлийн зургаан сар тухайн хувьцаа арилжигдаагүй бол 52 долоо хоногийн жигнэсэн дунджаас доошгүй байна);

2.3.10.Санал гаргагчийн харилцагч үнэт цаасны компанийн холбогдох утас;

2.3.11.Энэхүү журмын 2.5-д заасан саналыг гаргаж байгаа бол банкнаас тухайн худалдан авахаар санал болгож буй хувьцааг худалдан авах санхүүгийн чадвартайг нотолсон баримт;

2.3.12.Худалдан авах санал гаргагчийн худалдах саналыг хүлээн авах шуудангийн хаяг.

2.4.Сайн дурын үндсэн дээр худалдан авах саналын хүчинтэй байх хугацаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.7-д заасны дагуу санал гаргаснаас хойш нэг сараас доошгүй, гурван сараас дээшгүй байна.

2.5.Сайн дурын үндсэн дээр гаргах худалдан авах саналд банкны баталгааг хавсаргана. Уг баталгаа нь хувьцааг худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх төлбөрийн чадвартай болохыг нотолж, худалдан авах саналыг хүлээн авагчдын хувьцааг худалдан авах санал гаргагч нь худалдан авахгүй байх, төлбөрийг хугацаанд нь гүйцэтгээгүй тохиолдолд төлбөрийг гүйцэтгэх баталгаа болж өгнө.

Гурав.Үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр худалдан авах санал гаргах

3.1.Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран худалдан авсан хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 57.1-д заасан худалдан авах санал гаргах үүргийн дагуу санал гаргана.

3.2.Үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр гаргах худалдан авах санал гаргагч нь компанийн хувьцааг худалдан авах саналаа Хороо, арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон компанид бичгээр мэдэгдэнэ.

3.3.Үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр гаргах худалдан авах санал нь компанид хүрсэн өдрөөс эхлэн компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд уг саналыг гаргасанд тооцно.

3.4.Үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр санал болгохтой холбоотой баримт бичигт дараах зүйлийг тусгана:

3.4.1.Худалдан авах санал гаргаж буй этгээд болон холбогдох этгээдийн хувьцаа эзэмшигчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, хэрэв хуулийн этгээд бол нэр, хаяг, холбоо барих утас, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар;

3.4.2.Худалдан авахаар зарласан нийт хувьцааны тоо ширхэг ;

3.4.3.Худалдан авах саналын эхлэх, дуусах он, сар, өдөр;

3.4.4.Худалдах саналыг хүлээн авах өдөр;

3.4.5.Санал гаргаж буй хувьцаа эзэмшигч болон холбогдох этгээдийн тухайн компанийн эзэмшиж буй хувьцааны тоо ширхэг;

3.4.6.Хувьцаа худалдан авахаар санал болгох үнэ (Хувьцаа худалдан авахаар санал болгох үнэ нь тухайн хувьцааны сүүлийн зургаан сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доошгүй байна. Хэрэв сүүлийн зургаан сар тухайн хувьцаа нь арилжигдаагүй бол 52 долоо хоногийн жигнэсэн дунджаас доошгүй байна);

3.4.7.Хувьцааг худалдан авах төлбөрийг гүйцэтгэх өдөр;

3.4.8.Худалдан авах санал гаргах болсон шалтгаан, зорилго;

3.4.9.Худалдан авах санал гаргагчийн худалдах саналыг хүлээн авах шуудангийн хаяг.

3.5.Үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр санал гаргаагүй этгээдийн эзэмшиж байгаа хувьцаа нь уг саналыг гаргаж зохих журмын дагуу хэрэгжүүлэх хүртэл хугацаанд Компанийн тухай хуулийн 62.1.9-62.1.16-д заасан асуудлаар саналын эрхгүй байна.

3.6.Үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр худалдан авах саналын хүчинтэй байх хугацаа нь Компанийн тухай хуулийн 57.6-д зааснаар олон нийтэд саналаа зарласнаас хойш 30-аас доошгүй хоног байна.

3.7.Энэ журмын 3.1 дэх заалт нь зөвхөн компанийн хяналтын багцаас дээш хувийг худалдан авахад хамаарах бөгөөд бэлэглэл, өв залгамжлал, үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор хувьцааг өмчлөлд шилжүүлэх зэрэг худалдахаас бусад хэлбэрээр дээрх хэмжээний хувьцааны өмчлөлд өөрчлөлт орсон тохиолдолд уг заалт хамаарахгүй.

Дөрөв.Худалдан авах ажиллагаанд оролцогч талуудын эрх, үүрэг

4.1.Худалдан авах санал хүлээн авч буй хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа худалдах санал гаргаж буй өргөдлийг журмын 2.3.12 болон 3.4.9 дүгээр хэсэгт заасан шуудангийн хаяг руу шуудангаар, эсхүл

харилцагч үнэт цаасны компанид хүргүүлнэ. Үнэт цаасны компанид хүргэсэн тохиолдолд тухайн үнэт цаасны компани нь санал гаргагчид бичгээр хүргэнэ.

4.2.Худалдан авах саналын хүчинтэй хугацаанд 1-ээс дээш худалдах санал хүлээн авсан тохиолдолд хамгийн сүүлд ирсэн саналыг хүчинтэйд тооцно.

4.3.Худалдан авах санал гаргагч хувьцааг худалдан авах төлбөрийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хувьцаагаа худалдаж буй хувьцаа эзэмшигч банкны баталгааны дагуу төлбөрийг төлүүлэх, худалдан авах санал гаргагчийн данснаас мөнгийг өөрийн данс руу шилжүүлэх, эсхүл худалдан авах саналын гэрээг цуцлан, хувьцаагаа эргүүлэн авах бүрэн эрхтэй.

Тав.Худалдан авах саналыг нийтэд зарлах, сурталчлах

5.1.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.3-т заасны дагуу компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа болон холбогдох этгээдтэй хамтран эзэмшиж байгаа этгээд нь уг хувьцааны хяналтын багцын хэмжээ нь таван хувиар нэмэгдсэн, буурсан тохиолдол бүрд ажлын таван өдрийн дотор Хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэх ба нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

5.2.Кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.2-т заасны дагуу компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан Хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэх ба нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх үүрэгтэй.

5.3.Худалдан авах санал гаргагч нь худалдан авах санал гаргасан тухай мэдээллийг өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевиз болон арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ.

5.4.Энэ журмын 5.3-т заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.

5.5.Компани болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь худалдан авах санал гаргагчийг худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах үүрэгтэй бөгөөд хэрэв 1-ээс дээш худалдан авах санал гаргагч байвал тэдгээрийг адил тэгш мэдээллээр хангана.

Зургаа.Худалдан авах саналын биелэлтэд хяналт тавих

6.1.Худалдан авах саналын хэрэгжилтэд дараах байдлаар хяналт тавина:

6.1.1.Худалдан авах санал гаргагч нь энэ журамд заасны дагуу саналаа нийтэд сурталчилж байгаа эсэх, худалдан авах санал зарласны дараах тухайн үнэт цаасны арилжааны явц, худалдан авах саналтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд Хорооны Ажлын алба;

6.1.2.Худалдан авах саналын дагуу хувьцаа худалдан авахад шаардагдах мөнгөн хөрөнгө нь хувьцаа худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх төлбөрийн чадвартай болохыг баталгаа гаргасан байгууллага;

6.1.3.Худалдан авах санал гаргагчийн үнэт цаасны компанид өгсөн хувьцаа худалдан авах захиалга нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгэгдсэн эсэх, арилжааны сүлжээнд байршсан эсэхэд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон арилжаа эрхлэх байгууллага тус тус хяналт тавина.

6.2.Энэхүү журмын 2.3, 3.4-т заасан бичиг баримтыг журмын 5.3-т заасны дагуу мэдээлээгүй, худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх төлбөрийн чадвартай болохыг нотолсон байгууллагын баталгаа зэргийг хавсаргаагүй тохиолдолд энэ нь худалдан авах саналыг Хороо хүчингүйд тооцох үндэслэл болно.

6.3.Зах зээлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх үүднээс сайн дурын болон үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр худалдан авах санал гаргаснаас хойш арилжаа эрхлэх байгууллага

арилжааны хяналтыг тухай бүр хийж холбогдох тайлан, дүгнэлтийг Хороонд худалдан авах ажиллагаа дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор хүргүүлнэ.

Долоо.Худалдан авах үйл ажиллагаа

7.1.Худалдан авах саналын дагуу хувьцаагаа худалдахаар өгсөн захиалгын бүртгэл хөтөлсөн үнэт цаасны компани нь уг захиалгыг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгүүлж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагань худалдан авах санал дуусах өдөр, захиалгын талаарх мэдээллийг арилжаа эрхлэх байгууллагад худалдан авах санал дуусахаас өмнө хүргүүлнэ.

7.2.Худалдан авах саналыг хүлээн авч худалдах захиалга өгсөн хувьцаа эзэмшигч хувьцаагаа тухайн саналаас бусад нөхцлөөр бусдад арилжих бол өмнө өгсөн захиалгаа цуцалсны дараа өөр бусдад арилжиж болно.

7.3.Арилжаа эрхлэх байгууллага нь санал амжилттай хэрэгжих болсон тохиолдолд худалдан авах саналын хугацаа дуусмагц, худалдан авах саналын дагуу хийгдэх хэлцлүүдийг нэгтгэн нэг удаагийн арилжаагаар гүйцэтгэнэ.

7.4.Худалдан авах саналын хугацаа дуусмагц худалдан авах санал гаргагч тухайн хугацаанд хувьцаа худалдан авсан тухай тайланг гаргаж ажлын 5 өдөрт багтаан Хороонд ирүүлнэ.

Найм. Хориглох зүйлс, хариуцлага

8.1.Дараах тохиолдолд худалдан авах санал гаргах, худалдан авах саналын үндсэн дээр хувьцаа худалдан авахыг хориглоно:

8.1.1.Энэхүү журмаар тогтоосон худалдан авах саналын мэдээллийг нэгдмэл сонирхолгүй хувьцаа эзэмшигчдэд хүргээгүй, эсхүл тэдгээр баримт бичигтэй танилцах боломжоор хангаагүй;

8.1.2.Хорооноос зөвшөөрсөн худалдан авах саналын мэдээллийг санал гаргаснаас хойш өөрчилсөн.

8.2.Худалдан авах санал гаргагч нь арилжааны явцад үнийн саналаа өөрчлөхийг хориглоно.

8.3.Аливаа этгээдээс компанийн хувьцаа эзэмшигч, тэдгээрийн мэргэжлийн зөвлөхийг төөрөгдүүлэх зорилгоор худалдан авах санал зарлахтай холбоотой үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

8.4.Худалдан авах саналын хугацаанд худалдан авах санал гаргагч нь саналд зааснаас өөр нөхцлөөр тухайн хувьцааг худалдан авахыг хориглоно.

8.5.Худалдан авах санал зарлах үүрэг бүхий этгээд хуульд заасан журмын дагуу худалдан авах санал гаргаагүй, хувьцаа эзэмшигчдийг хууран мэхлэх ажиллагаа явуулсны улмаас худалдан авах санал нь энэ журмын 6.2-т зааснаар хүчингүй болсон бол Компанийн тухай хуулийн 57.2-т зааснаар тухайн этгээдийн эзэмшиж буй хувьцаа саналын эрхгүйд тооцогдоно. Энэ талаар Хороо болон арилжаа эрхлэх байгууллага олон нийтэд мэдээнэ.

8.6.Энэ журмын холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

ҮНЭТ ЦААС БАРЬЦААЛАХ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь барьцаалуулагчийн бусдын өмнө хүлээх үүргийн гүйцэтгэлийг түүний эзэмшил дэх үнэт цаасаар хангуулах, барьцаанд тусгаарлуулах, үнэт цаасны барьцааны тухай мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, барьцааны эрх үүссэнийг нийтэд мэдэгдэх, үүргийн гүйцэтгэлтэй холбоотойгоор барьцаалагч, барьцаалуулагч, гуравдагч этгээдийн хооронд үүссэн харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмын харилцаанд Иргэний хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны баталсан холбогдох журмыг дагаж мөрдөнө.

1.3. Энэхүү журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад хамрагдаагүй хязгаарлагдмал хариуцлагатай компани, хаалттай хувьцаат компанийн үнэт цаас, зохицуулалттай зах зээлд арилжаалахыг зөвшөөрөөгүй бусад төрлийн үнэт цаасыг барьцаалахтай болон Төв банк /Монголбанк/-ны үнэт цаас, репо арилжаа, үнэт цаасны маржин арилжаа, үнэт цаас зээлдүүлэхтэй холбоотойгоор үүсэх харилцааг зохицуулахгүй болно.

ХОЁР. Үнэт цаасыг барьцаанд тавих үйл ажиллагаа

2.1. Барьцаалагч нь барьцаалуулагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр барьцааны мэдэгдлийг хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг бүртгэх цахим мэдээллийн сан /цаашид “цахим мэдээллийн сан” гэх/-д бүртгүүлж, баталгаажуулсны үндсэн дээр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад үнэт цаасаа тусгаарлуулна.

2.2. Барьцааны мэдэгдэл нь цахим мэдээллийн санд бүртгэгдэж, баталгаажигдсанаар хүчин төгөлдөр болох бөгөөд энэ тохиолдолд барьцаалагч нь барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлнэ.

2.3. Барьцаалуулагч нь цахим мэдээллийн санд баталгаажсан барьцааны талаарх мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлж болно.

2.4. Барьцаалуулагч нь барьцааны мэдэгдлийн бүртгэлийн хугацааг сунгах тухай мэдэгдлийг гаргаагүй бол цахим мэдээллийн санд бүртгүүлснээс хойш гурван жилийн хугацаанд барьцааны мэдэгдлийн бүртгэл хүчинтэй байна.

2.5. Энэхүү журмын 2.4-т заасан хугацаанаас өмнө барьцаалуулагч дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон, үүнтэй холбогдуулан шүүхээс барьцааны зүйлийг барьцаалагч этгээдийн эзэмшилд шилжүүлэх шийдвэр гарсан тохиолдолд барьцаалагч нь барьцааны бүртгэлийг цуцлах тухай мэдэгдлийг гурван өдрийн дотор цахим мэдээллийн санд хүргүүлнэ.

2.6. Барьцаалагч нь цахим мэдээллийн сангаас баталгаажуулсан барьцаа цуцлагдсан талаарх мэдээллийг 2.5 дахь хэсэгт дурдагдсан шүүхийн шийдвэрийн хамт Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хүргүүлнэ.

2.7. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь энэ журмын 2.6 дахь хэсэгт заасан баримт материалд үндэслэн барьцаалагчийн холбогдох дансанд өмчлөх эрхийг шилжүүлнэ.

2.8. Барьцаалагч болон барьцаалуулагчийн зөвшөөрлөөр барьцааны мэдэгдлийн бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах, бүртгэлийн хугацааг сунгах, цуцлах тохиолдолд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан шаардлагын дагуу гаргана.

ГУРАВ. Үнэт цаас тусгаарлах, өмчлөх эрхийг шилжүүлэх, тусгаарлалтаас чөлөөлөх үйл ажиллагаа

3.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь барьцаалуулагчийн үнэт цаас тусгаарлуулах хүсэлт, бусад холбогдох баримт материалыг дараах мэдээллүүдийн хамт барьцаалагчаасалбан бичгээр авсны дараагаар үнэт цаас тусгаарлах үйл ажиллагааг гүйцэтгэнэ. Үүнд:

3.1.1. Анхны мэдэгдлийн бүртгэлийн дугаар;

3.1.2. Барьцаалуулагчийн талаарх мэдээлэл:

3.1.2.а. Монгол Улсын иргэн бол регистрийн дугаар;

3.1.2.б. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт буюу түүнтэй адилтгах баримт бичгийн дугаар;

3.1.2.в. Хуулийн этгээд бол улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, нэр;

3.1.3. Барьцаанд байршуулах үнэт цаасны тоо ширхэг, нэрлэсэн үнэ, хаалтын ханш.

3.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь холбогдох хууль тогтоомжоор тогтоосон шаардлагын дагуу үнэт цаас тусгаарлуулах хүсэлт болон барьцааны талаарх мэдээлэл, бусад холбогдох баримт материалыг хянаж үзсэний үндсэн дээр цахим мэдээллийн санд баталгаажсан барьцааг тусгаарлах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь цахим мэдээллийн санд баталгаажсан барьцааг үнэт цаасны тусгаарлалтад бүртгэсэн тухай мэдэгдлийг барьцаалагчид ажлын 3 өдрийн дотор албан бичгээр хүргүүлнэ.

3.4. Цахим мэдээллийн санд баталгаажсан барьцааг үнэт цаасны тусгаарлалтад бүртгэх, тусгаарлалтаас чөлөөлөхтэй холбоотойгоор үүсэх нарийвчилсан харилцааг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын холбогдох журмаар зохицуулах ба кастодиан нь тус байгууллагын гишүүнчлэлийнхээ хүрээнд дээрх үйл ажиллагааг эрхэлж болно.

ДӨРӨВ. Хороонд мэдээлэл хүргүүлэх

4.1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага нь дараах мэдээллийг улирал тутам хэвлэмэл хэлбэрээр Хороонд ирүүлнэ. Үүнд:

4.1.1. Барьцааны гэрээ болон үндсэн үүрэг үүсгэж буй гэрээний талаарх мэдээлэл;

4.1.2. Тусгаарлагдсан үнэт цаастай холбоотой өмчлөх эрхийн асуудал шүүх, хяналтын байгууллагаар шийдэгдэхээр болсон бол уг ажиллагаа, үр дүнгийн талаарх мэдээлэл;

4.1.3. Шаардлагатай бусад нэмэлт мэдээлэл.

ТАВ. Хариуцлага

5.1. Хороо нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага тусгаарлалтад байгаа үнэт цаасыг бүртгэх, уг бүртгэлийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх, үнэт цаас барьцаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ журам болон холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага, нөхцөлийг баримталж байгаа эсэхэд зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох хуульд заасан хариуцлага ногдуулна.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ДОТООД МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ, ТҮҮНИЙГ МЭДЭЭЛЭХ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид “Хороо” гэх/ үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээлэл /цаашид “дотоод мэдээлэл” гэх/-д тооцогдох мэдээллийн агуулга, жагсаалтыг тодорхойлох, түүний эзэмшигчийг тогтоох, дотоод мэдээлэл эзэмшигчийн үнэт цаасны зах зээлд явуулах үйл ажиллагааг зохицуулахад оршино.

ХОЁР.Үнэт цаасны дотоод мэдээлэл

2.1.Дотоод мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна:

2.1.1.хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэл /Хувьцаа эзэмшигчийн овог, нэр, түүний өмчлөлд буй үнэт цаасны тоо, оршин суугаа хаяг/;

2.1.2.үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага, кастодиан банк дахь харилцагчийн үндсэн болон холболтын дансны мэдээлэл;

2.1.3.зохицуулалттай этгээдтэй байгуулсан харилцагчийн гэрээ, үнэт цаас эзэмшигчийн үнэт цаасны зах зээлд ажиллах бодлого, зорилго, үйл ажиллагаатай холбогдсон мэдээ баримт;

2.1.4.үнэт цаасны зах зээлд оролцогчдын үйл ажиллагаанд Хорооноос болон эрх бүхий байгууллагаас хийсэн шалгалтын тайлан, бусад материалд орсон нийтэд тараагдаагүй мэдээ баримт;

2.1.5.үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн, кастодианы үйл ажиллагаа явуулахад хэрэглэдэг тооцоолох машины санах байгууламжид агуулж байгаа мэдээ;

2.1.6.үнэт цаасны арилжааны гүйлгээний мэдээ, дансны хуулга, харилцагчдын захиалгын сангийн мэдээлэл;

2.1.7.үнэт цаас гаргагчийн өмчийн үнийн дүнгийн 25 болон түүнээс дээш хувийн өөрчлөлт;

2.1.8.үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, бизнесийн орчинд гарсан томоохон өөрчлөлтүүд;

2.1.9.үнэт цаас гаргагчийн ашиг, алдагдал 25 болон түүнээс дээш хувиар өөрчлөгдөх;

2.1.10.үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн 25 хувь болон түүнээс дээш хэмжээтэй тэнцэх хэмжээний өр, зээлийн өөрчлөлт;

2.1.11.үнэт цаас гаргагч шинэ төрлийн үйл ажиллагаа эхлэх, үйл ажиллагааг зогсоох, үйл ажиллагаагаа худалдах;

2.1.12.үнэт цаас гаргагчийн борлуулалтын орлогын 25-аас дээш хувийг эзлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл түдгэлзэх, хүчингүй болох, эсхүл хуульд заасан тохиолдолд худалдах, бэлэглэх зэрэг аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэх;

2.1.13.үнэт цаас гаргагчийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаа эзэмшигчдийн өмч болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ боловсруулалтын шатанд болон батлагдсан;

2.1.14.санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд нь өмнөх жилүүдийн болон ирээдүйд төлөвлөсөн тооцооноос 25 хувиас илүү хэмжээгээр өөрчлөгдөх;

2.1.15.үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгийн 15 хувь болон түүнээс дээш хэмжээний өр төлбөр, нийт хөрөнгийн 2 хувь болон түүнээс дээш хэмжээний хүү, алданги, торгууль төлөх үүрэг үүссэн тохиолдол;

- 2.1.16.хөрөнгө оруулалт, санхүүжилттэй холбоотой чухал шийдвэр гарсан (томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө худалдаж авах, шинэ бүтээгдэхүүн гаргах, шинэ техник, технологийг нэвтрүүлэх);
- 2.1.17.шинэ нээлт хийх, патент авах, ач холбогдол бүхий тусгай зөвшөөрөл эзэмших;
- 2.1.18.үнэт цаас гаргагчийн ирээдүйн үйл ажиллагаанд нөлөөлөх ач холбогдол бүхий арга хэмжээнүүд;
- 2.1.19.үнэт цаас гаргагчийн удирдлагын бүтэц, хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэгч этгээдийн бүтэцэд орсон өөрчлөлтүүд;
- 2.1.20.хувьцааны хяналтын багцыг аливаа этгээд дангаараа, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авахаар тохиролцоонд хүрсэн, авсан;
- 2.1.21.үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны өмчлөлд байгаа хувьцааны багцад 5-аас дээш хувиар өөрчлөлт орсон;
- 2.1.22.үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг нь зогсоохоор нэхэмжлэл гаргасан, түүний эрх бүхий албан тушаалтан, хувьцааны хяналтын багц эзэмшигчдийн үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэгдсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн;
- 2.1.23.үнэт цаас гаргагч нь охин болон хараат компанитай болсон;
- 2.1.24.охин болон хараат компанийн үйл ажиллагаа, хөрөнгө, эзэмшигчдийн өмч, өр, төлбөр, ашигт гарсан томоохон өөрчлөлтүүд;
- 2.1.25.үнэт цаас гаргагч ногдол ашиг хуваарилах шийдвэр болон ногдол ашиг тараахтай холбогдсон бусад мэдээлэл;
- 2.1.26.Хороо, хөрөнгийн бирж, бусад эрх бүхий байгууллагаас бүртгэлтэй үнэт цаасны арилжааг түр зогсоох, бүртгэлээс хасах шийдвэр гарсан;
- 2.1.27.үнэт цаас гаргагч нь аливаа хэлбэрээр өөрчлөн байгуулагдах тухай шийдвэр гаргасан;
- 2.1.28.үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл нь өрийг хувьцаагаар солих тухай шийдвэр гаргасан;
- 2.1.29.үнэт цаас гаргагчийг татан буулгах, үйл ажиллагааг дуусгавар болгох тухай шийдвэр гаргасан;
- 2.1.30.үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэх эрх бүхий байгууллагын шийдвэр.

ГУРАВ.Үнэт цаасны дотоод мэдээлэл эзэмшигч

- 3.1.Дотоод мэдээлэл эзэмшигчид дараах этгээд хамаарна:
- 3.1.1.Үнэт цаас гаргагч, түүний толгой болон охин, хараат компанийн эрх бүхий албан тушаалтан;
- 3.1.2.Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргасан хувьцааны хяналтын багцыг эзэмшигч;
- 3.1.3.Өөрийн албан үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдон аль нэг үнэт цаас гаргагчтай холбоотой дотоод мэдээллийг олж авах боломжтой, эсхүл олж авсан Хороо, хөрөнгийн бирж, үнэт цаасны зах зээлд оролцогч зохицуулалттай этгээдийн ажилтан, тэдгээрийн холбогдох этгээд;
- 3.1.4.Үнэт цаас гаргагчийн хараат бус зөвлөхүүд болох хуульч, аудитор, үнэлгээчин, бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ажилтан;
- 3.1.5.Энэ журмын 2.1.13-д заасны дагуу үнэт цаас гаргагчтай аливаа гэрээ байгуулсан, эсхүл гэрээ байгуулахаар завдаж буй этгээд, тэдгээр нь хуулийн этгээд бол эрх бүхий албан тушаалтан;
- 3.1.6.Энэ журмын 3.1.1-3.1.5-д заасан үүрэгт албан тушаал өөрчлөгдсөнөөс хойш 1 жилийн хугацаа өнгөрөөгүй байгаа этгээд.
- 3.2. Дотоод мэдээлэл эзэмшигч нь дараах үүрэгтэй:
- 3.2.1.үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа

мөрдлөг болгон ажиллах

3.2.2.хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах

3.2.3.үнэт цаасны зах зээлийн талаар нийтэд мэдээлэх, холбогдох мэдээ мэдээллийг зохих хууль тогтоомжийн дагуу хөрөнгө оруулагчдад хүргэх

3.2.4.үнэт цаасны зах зээл дээр өөрт оногдсон ажил үүргийг ил тод, шударга гүйцэтгэх

3.2.5.байгууллага, иргэдээс гаргасан санал, өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэх

3.2.6.дотоод мэдээллийн нууцыг хадгалах.

ДӨРӨВ.Дотоод мэдээлэл эзэмшигчдийн үйл ажиллагаа

4.1.Дараах үйл ажиллагааг явуулсан тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэгт заасан хориглосон үйл ажиллагааг явуулсан гэж үзнэ:

4.1.1.дотоод мэдээлэл эзэмшиж буй давуу талаа ашиглан ашиг олох зорилгоор өөрийн болон бусад холбогдох этгээдийн дансаар үнэт цаасыг худалдах, худалдан авах арилжаа хийх;

4.1.2.дотоод мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах, мэдээлэх, эсхүл гуравдагч этгээд дотоод мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.3.дотоод мэдээлэл ашиглан үнэт цаас худалдаж авах, худалдахыг гуравдагч этгээдэд зөвлөх, санал болгох;

4.1.4.дотоод мэдээллийг эзэмшиж буй гуравдагч этгээд, өөрийн болон бусад холбогдох этгээдийн дансаар үнэт цаасыг худалдах, худалдан авах, бусдад санал болгох, дотоод мэдээллийг дамжуулах, түүнчлэн дотоод мэдээллийг олж авах нөхцөлийг бүрдүүлэх;

4.1.5.энэ журмын 3.1.5-д заасан этгээд нь дотоод мэдээлэл эзэмшиж байх хугацаандаа гэрээ хэлцэл хийж буй үнэт цаас гаргагчийн болон түүний холбогдох этгээдийн үнэт цаасыг худалдах, худалдан авах, мөн түүнчлэн худалдан авах, худалдахыг гуравдагч этгээдэд зөвлөх, ятгах, үнэт цаас гаргагчтай хийж буй гэрээ хэлцлийн талаарх нийтийн хүртээл болоогүй байгаа мэдээллийг гуравдагч этгээдэд дамжуулах;

4.1.6.хөрөнгө оруулагчдыг төөрөгдөлд оруулах мэдээллийг нийтийн хүртээл болгох;

4.1.7.дотоод мэдээлэл эзэмшигчид нь энэ журмын 2.1-т заасан мэдээллийг нийтийн хүртээл болгохоос өмнө уг мэдээллийг санамсаргүй болон санаатайгаар бусдад дамжуулж, бусдад олж авах нөхцөлийг бүрдүүлэх.

4.2.Хороо, Хөрөнгийн бирж болон хуулийн дагуу эрх бүхий бусад төрийн хянах, зохицуулах байгууллагын шаардлагын дагуу мэдээлэл хүргүүлсэн нь энэ журмын 4.1 дэх заалтыг зөрчсөнд тооцогдохгүй.

4.3.Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж буй этгээд нь хууль журмаар тогтоосон өөрийн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа дараах тохиолдлыг дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсонд тооцохгүй:

4.3.1.Хууль тогтоомжийн дагуу баталгаажуулсан харилцагчийн захиалгыг биелүүлэх үйл ажиллагаа;

4.3.2.Аль нэг компанийн хяналтыг авах, нэгтгэхтэй холбоотой дотоод мэдээлэлд үндэслэсэн дараах үйл ажиллагаа:

4.3.2.1.хяналтыг нь авах гэж буй компанийн үнэт цаас эзэмшигчдээс тухайн саналыг хүлээн авах /хүлээн авахгүй байх/ талаар үүрэг хүлээх, дэмжих эсэх талаарх саналыг судлах;

4.3.2.2.хяналтыг авах, нэгтгэхтэй холбогдуулан худалдан авахаар санал болгож буй үнэт цаасны оронд санал болгож буй, эсхүл худалдан авах ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор гаргаж буй өөр үнэт цаасыг гаргах, байршуулах үйл ажиллагаанд андеррайтерын үйлчилгээ үзүүлэх;

4.3.2.3.хяналтыг авах, нэгтгэхтэй холбогдуулан худалдан авахаар санал болгож буй үнэт цаасны төлбөрийг төлөхтэй холбоотой ажиллагаа;

4.3.3.Хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэсэн гүйлгээтэй холбогдон гарах эрсдэлийг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;

4.3.4.Хороо болон хөрөнгийн биржийн дүрэм журмын дагуу нийтийн хүртээл болгох мэдээлэлд хамаарахгүй мэдээлэлд үндэслэн хийсэн ажил, гүйлгээ;

ТАВ.Дотоод мэдээллийг нийтэд мэдээлэх, хяналт тавих

5.1.Үнэт цаас гаргагч, зохицуулалттай этгээд болон мэдээллийг нийтийн хүртээл болгох үүрэг бүхий бусад байгууллага нь энэ журмын 2.1-т заасан мэдээллүүдийг үнэн зөв, бүрэн төгс, цаг тухайд нь нийтэд хүргэх үүрэгтэй.

5.2.Энэ журмын 4.1 дэх заалтыг зөрчсөн гэж үзэж, холбогдох арга хэмжээ авахын тулд тухайн хуулийн этгээдийн холбогдох ажилтан нь дотоод мэдээлэл эзэмшигч мөн эсэх, дотоод мэдээллийг мэдсэн байх боломжтой эсэх зэрэг нөхцөл байдлыг сайтар судлан тогтоосон байна.

5.3.Дотоод мэдээллийг нийтэд мэдээлэх, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих ажлын хүрээнд Хорооны улсын байцаагч дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

5.3.1.Дотоод мэдээллийг тогтоосон хугацаанд нийтийн хүртээл болгохыг үнэт цаас гаргагч, зохицуулалттай этгээдээс шаардах;

5.3.2.Нийтийн хүртээл болгох шаардлагатай дотоод мэдээллийг нийтийн хүртээл болгох тохиромжтой хугацааг тогтоох;

5.3.3.Үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн дотоод мэдээлэл, түүнийг эзэмшигчдийн талаарх мэдээллийг гаргуулан авах, танилцах;

5.3.4.Энэ журмын 4.1-т заасан үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор үнэт цаас гаргагч болон зохицуулалттай этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хийх;

5.3.5.Хяналт шалгалтын ажлын хүрээнд өөрийн болон бусдын нэрийн өмнөөс дотоод мэдээлэл ашиглан үнэт цаасны арилжаанд оролцсон байж болзошгүй гэж үзсэн этгээдийн үнэт цаасны арилжааны бүхий л мэдээллийг арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төлбөр тооцооны байгууллага, үнэт цаасны хадгаламжийн байгууллага, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдээс гаргуулан авах;

5.3.6.Дотоод мэдээлэл эзэмшигч этгээдийн гаргасан зөрчлийг гэмт хэргийн шинж чанартай гэж үзвэл холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн хууль хяналтын байгууллагад шилжүүлэх;

5.3.7.Хяналт шалгалтын ажлын хүрээнд олж авсан дотоод мэдээллийн нууцыг хадгалах, хувийн ашиг сонирхолд ашиглахгүй, гуравдагч этгээдэд санаатай болон санамсаргүй дамжуулахгүй байх.

ЗУРГАА.Хариуцлага

6.1.Энэ журмыг зөрчсөн талаар гуравдагч этгээд болон арилжаа эрхлэх байгууллагын үндэслэл бүхий мэдээлэлд Хорооны Ажлын алба хяналт тавьж, үнэт цаасны арилжааг зогсоох, үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, мэргэжилтний ажил, үйлчилгээ явуулах эрхийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болно.

6.2.Энэ журмаар тогтоосон үүргээ биелүүлээгүй болон журмын 4.1-т заасан үйл ажиллагаа явуулсан дотоод мэдээлэл эзэмшигчдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын зургаадугаар хавсралт

**ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙХУУЛИЙН
ЭТГЭЭД МОНГОЛ УЛСАД ҮНЭТ ЦААС ГАРГАХ, МОНГОЛ УЛСЫН АРИЛЖАА
ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙХУУЛИЙН ЭТГЭЭД ГАДААД УЛСАД
ГАРГАХ ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг Монгол Улсад гаргах, үнэт цаасыг Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл /цаашид “Хорооны бүртгэл” гэх/-д бүртгэх, мөн Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад үнэт цаас гаргах, Хороонд бүртгүүлэх, үнэт цаасыг гадаадын болон дотоодын зах зээл хооронд хөрвүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн Монгол Улсад гаргах үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг тухайн арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны бүртгэлийн журмаар, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэн хадгалахтай холбоотой харилцааг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагын журмаар тус тус зохицуулна.

1.3. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь гадаад улсад гаргасан тодорхой төрлийн суурь үнэт цаасанд тулгуурлан Монгол Улсын хадгаламжийн бичиг гаргах, Монгол Улсад анх гаргасан үнэт цаасанд суурилан гадаад улсын хадгаламжийн бичиг гаргахтай холбоотой харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон тусгай журмаар зохицуулна.

1.4. Энэхүү журам нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлгүй хуулийн этгээдийн үнэт цаасыг Монгол Улсад анхдагч бүртгэл хийхтэй холбоотой харилцаанд хамаарахгүй.

1.5. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь үнэт цаасаа Хороонд бүртгүүлж, олон нийтэд санал болгосны дараахь үйл ажиллагаатай холбоотой харилцаанд өөрийн харьяалах улс болон үнэт цаасаа бүртгүүлсэн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагын хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх эрх нь нээлттэй байна. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасаа анх бүртгүүлсэн, хуулийн этгээдийн харьяалах улс болон Монгол Улсын хууль тогтоомжийн хооронд зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд гадаад улсын үнэт цаасны зах зээлийн холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөнө.

1.6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.3-т заасан этгээд гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон тусгай журмаар зохицуулна.

1.7. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд үнэт цаасаа

Хорооны болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлсний үндсэн дээр үнэт цаасаа Монгол Улсын үнэт цаасны зах зээлд гаргасныг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулсан гэж үзэхгүй.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ГАДААД УЛСАД ГАРГАХҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Монгол Улсын арилжаа эрхлэх бүртгэлтэй хуулийн этгээд үнэт цаасаа гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэн арилжаалж болох бөгөөд энэ талаар аливаа мэдэгдэл хийхээс өмнө Хороонд мэдэгдэнэ.

2.2. Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг тухайн гадаад улсын үнэт цаас бүртгэх эрх бүхий этгээдээс бүртгэх шийдвэр гарсан тохиолдолд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 17.2-т заасны дагуу Хороонд бүртгүүлнэ.

2.3. Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь энэхүү журмын 2.1-т зааснаар Хороонд мэдэгдэхдээ гадаад улсын зохицуулах байгууллага болон арилжаа эрхлэх байгууллагад хувьцаагаа бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтын хуулбарыг Хороонд хүргүүлнэ.

2.4. Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь тухайн гадаад улсын үнэт цаас бүртгэх эрх бүхий этгээдээс бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийн хуулбарыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.

2.5. Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг тухайн гадаад улсын үнэт цаас бүртгэх эрх бүхий этгээдээс бүртгэх тухай шийдвэрийг хүлээн авснаас хойш Хороо ажлын 20 хоногт багтаан үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулна.

2.6. Энэхүү журмын 2.1-т заасан хуулийн этгээд нь анхдагч зах зээлд арилжигдсан үнэт цаасны хэмжээ, үнэ, зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн нийт дүнгийн талаарх мэдээ, тайланг тухайн улсын холбогдох байгууллагад хүргүүлснээс хойш ажлын таван өдөрт багтаан Хороонд хүргүүлнэ.

ГУРАВ. ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ҮНЭТ ЦААСЫГ ХОРООНЫ БҮРТГЭЛД БҮРТГЭХ, НИЙТЭД САНАЛ БОЛГОХ, ХУДАЛДАХ

3.1. Монгол Улсад үнэт цаасаа гаргах гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь дараахь шалгуурыг хангасан байна:

3.1.1. Гадаад улсын хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, тухайн улсын хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдийн эрхтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байх;

3.1.2. Хуулийн этгээдийн өөрийн харьяалах улс, эсхүл үнэт цаасаа бүртгүүлэн арилжиж байгаа улс болон арилжаа эрхлэх байгууллагын харьяалах улсын үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллага нь Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага (International Organization of Securities Commission)-ын гишүүн байх;

3.1.3. Анхдагч бүртгэлийг хийлгэсэн арилжаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18.4-т заасны дагуу Хорооноос тогтоосон гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагын жагсаалтад багтсан байх;

3.1.4. Үнэт цаасны анхдагч бүртгэлийг хийлгэсэн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллага болон үнэт цаасны зохицуулагч байгууллагад Монгол Улсад тухайн үнэт цаасны хоёрдогч бүртгэлийг хийлгэх гэж байгаа талаар албан ёсоор мэдэгдсэн байх;

3.1.5. Хороо болон арилжаа эрхлэх байгууллагатай харилцах, мэдээлэл солилцох, тухайн хуулийн этгээдийг Монгол Улсад төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эсхүл хуулийн этгээдийг томилсон байх;

3.1.6. Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагаас давхар бүртгүүлэх хүсэлтийг дэмжсэн тухай санал өгсөн байх.

3.2. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь Монгол Улсад гаргах үнэт цаасаа Хорооны бүртгэлд болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг нэгэн зэрэг гаргаж болох бөгөөд гагцхүү Хорооны бүртгэлд бүртгүүлснээр нийтэд санал болгох эрхтэй болно.

3.3. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь үнэт цаасаа Хорооны бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг гаргахдаа дараахь бичиг баримтыг Монгол хэл дээрх орчуулгын хамт ирүүлнэ. Англи болон монгол хэл дээр бэлтгэсэн бичиг баримтын хооронд утга агуулгын зөрүү гарвал англи хэл дээрх эх хувийг хүчинтэйд тооцно:

3.3.1. Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 1-д заасан Маягт/;

3.3.2. Энэхүү журмын 3.4 дэх хэсгийн дагуу боловсруулсан хуулийн этгээдийн танилцуулга;

3.3.3. Зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөнтухай төлбөрийн баримт.

3.3.4. Үнэт цаас гаргах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлаас, эсхүл тухайн хуулийн этгээдийн эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр;

3.3.5. Хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.3.6. Хуулийн этгээдийн сүүлийн жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан;

3.3.7. Хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн гаргасан хууль зүйн дүгнэлт.

3.4. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн танилцуулгад дараахь мэдээллийг тусгах бөгөөд тухайн хуулийн этгээдийн харьяалах улсын хууль тогтоомж болон үнэт цаасаа анх бүртгүүлсэн арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журмын дагуу тодорхойлж тусгана:

3.4.1. Хуулийн этгээдийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа;

3.4.2. Хуулийн этгээдийн үүсгэн байгуулагдсан улсын нэр болон анх бүртгүүлсэн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагын нэр, тухайн арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн үнэт цаасны төрөл, тоо, бүртгэл хийлгэсэн огнооны талаарх мэдээлэл;

3.4.3. Монгол Улсад гаргаж байгаа үнэт цаасны тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ болон тэдгээрийг нийтэд санал болгон арилжих нөхцөл;

3.4.4. Хуулийн этгээдийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;

3.4.5. Хуулийн этгээдийн өмнө зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнийн талаарх мэдээлэл;

3.4.6. Хуулийн этгээдийн сүүлийн жилийн эцсийн санхүүгийн аудитлагдсан тайлан;

3.4.7. Холбогдох этгээд болон уг этгээдтэй хийсэн гэрээ хэлцлийн талаар олон нийтэд мэдээлсэн эх сурвалж, холбоосны талаарх мэдээлэл;

3.4.8. Ногдол ашиг хуваарилах нөхцөлийн талаарх мэдээлэл;

3.4.9. Нийтэд санал болгох үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг болон хувьцаанд хөрвөх үнэт цаас бол тухайн үнэт цаасыг хувьцаанд хөрвүүлэх нөхцөл, журмын талаарх мэдээлэл;

3.4.10. Монгол Улсад үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах төлөвлөгөө;

3.4.11. Хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын талаарх удирдлагын байр суурийг илэрхийлэх мэдээлэл;

3.4.12. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 18.3-т заасан үнэт цаасаа анх бүртгүүлсэн улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийн зохицуулалтын зөрүүтэй байдал, үүний улмаас үнэт цаас эзэмшигчид учирч болох эрсдэл, эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах зохицуулалт;

3.5. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь үнэт цаасаа Хорооны болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгүүлэх, нийтэд санал болгох, худалдахтай холбоотой ажиллагаанд Хорооноос андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран оролцоно.

3.6. Энэхүү журмын 3.3.7-д заасан хууль зүйн дүгнэлтэд дараахь асуудлыг тусгасан байна:

3.6.1. хуулийн этгээд нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх;

3.6.2. төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх нь хүчин төгөлдөр эсэх;

3.6.3. сүүлийн нэг жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;

3.6.4. үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр хуулийн этгээдийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;

3.6.5. үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх;

3.6.6. үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх.

3.7. Энэ журмын 3.3.7, 5.2-т заасан дүгнэлтийг олон улсад нэр хүнд бүхий мэргэжлийн байгууллага, эсхүл Хороонд бүртгүүлсэн хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

3.8. Энэхүү журмын 3.2-т заасан хүсэлтийг тухайн хуулийн этгээд зэрэг гаргасан тохиолдолд арилжаа эрхлэх байгууллагын бүртгэсэн талаарх холбогдох шийдвэрийг Хороо хүлээн авснаас хойш ажлын 20 өдрийн дотор Хорооны бүртгэлд бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзсан үндэслэл бүхий шийдвэрийн аль нэгийг гаргаж, ажлын 10 өдрийн дотор холбогдох

шийдвэрийг хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

3.9. Хороо нь шийдвэр гаргахад зайлшгүй шаардлагатай нэмэлт баримт бичигтэй танилцах шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хүртэл өдрийн хугацаагаар сунгаж болно.

3.10. Хороо нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн Монгол Улсад гаргах үнэт цаасыг Хорооны бүртгэлд бүртгэх тухай шийдвэр гаргаснаар тухайн хуулийн этгээд нь үнэт цаасаа үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд бүртгүүлэн хадгалуулах болон нийтэд санал болгох, худалдах эрхтэй болно. Хороо болон арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны бүртгэл нь хуулийн этгээдийн Монгол Улсад шинээр гаргаж буй үнэт цаас болон тухайн төрлийн өмнө нь гаргасан бүх үнэт цаасанд хамаарна.

3.11. Хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9.10.2-9.10.6 дахь заалтад заасан үндэслэлээр болон энэхүү журмын 3.1-д заасан шалгуурыг хангаагүй тохиолдолд бүртгэхээс татгалзана.

3.12. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг Хорооны бүртгэлд бүртгэхээс татгалзсан шийдвэр гарснаас хойш нэг жилийн дотор тухайн хуулийн этгээд тухайн үнэт цаасыг бүртгүүлэхээр дахин хүсэлт гаргах эрхгүй.

3.13. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь үнэт цаасаа нэгтгэх, хуваах, эргүүлэн худалдан авах, бусад үнэт цаасанд хөрвүүлэх, солих тухай бүр Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад мэдэгдэх бөгөөд арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн саналыг үндэслэн Хорооны хуралдаанаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулна.

3.14. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь анх бүртгүүлсэн гадаад улсын зах зээлд тухайн төрлийн үнэт цаасыг нэмж гаргах, опцион хэрэгжүүлэх замаар үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулсан тохиолдолд холбогдох мэдээллийг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болон төвлөрсөн хадгаламжийн төвд албан бичгээр мэдэгдэх ба үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн мэдэгдлийг үндэслэж, Хорооны даргын тушаалаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулна.

3.15. Хорооны бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасыг нийтэд санал болгох, арилжих ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11, 12 дугаар зүйлд заасан нийтлэг журам болон холбогдох эрх бүхий арилжаа эрхлэх байгууллагын журмын дагуу гүйцэтгэнэ.

3.16. Хороо нь хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд гагцхүү хуульд заасан үндэслэлээр, эсхүл гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийн дагуу гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн Монгол Улсад гаргасан үнэт цаасыг Хорооны бүртгэлээс хасна.

3.17. Анхдагч бүртгэл хийсэн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагаас тухайн хуулийн этгээдийн үнэт цаасыг өөрийн бүртгэлээс хасах тухай шийдвэр гаргасан тохиолдолд Хороо уул хуулийн этгээдийн үнэт цаасыг анхдагч бүртгэл хийсэн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрийг үндэслэн нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасаж болно.

**ДӨРӨВ. ХОРОО, АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА БОЛОН
ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

4.1. Хороо дараахь эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ:

4.1.1. Энэхүү журмын 6.1-д заасны дагуу хөрвүүлснээс бусад тохиолдолд Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн Монгол Улсад гаргасан үнэт цаасыг бүртгэх, бүртгэлээс хасах шийдвэр болон үнэт цаасны бүрдүүлбэрт¹ орох өөрчлөлтийг тус тус Хорооны тогтоолоор гаргах.

4.1.2. Энэхүү журмын 4.3.1-т заасны дагуу гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдээс Хороонд гомдол гаргасан тохиолдолд Хороо нь арилжаа эрхлэгч байгууллагын шийдвэрийг үндэслэлтэй эсэхийг хянах бөгөөд арилжаа эрхлэх байгууллагаас уг асуудалтай холбоотой нэмэлт тайлбар, шаардлагатай мэдээллийг шаардаж болно.

4.1.3. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь үнэт цаасаа бүртгэлээс хасуулах хүсэлт гаргасан тохиолдолд тухайн хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавих үүрэгтэй.

4.1.4. Энэхүү журмын 3.14-д заасны дагуу гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт орсон тохиолдолд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлсэн мэдэгдлийг үндэслэн үнэт цаасны бүртгэлд холбогдох өөрчлөлтийг оруулна.

4.1.5. Энэхүү журмын 6.3-т заасан хөрвүүлэх ажиллагааг гүйцэтгэсэн тухай бүр холбогдох тайлан мэдээллийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс ирүүлэхийг шаардана.

4.2. Арилжаа эрхлэх байгууллага дараахь эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ:

4.2.1. Арилжаа эрхлэх байгууллага нь өөрийн бүртгэлийн журмын дагуу гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг өөрийн бүртгэлээс хасах эрхтэй.

4.2.2. Арилжаа эрхлэх байгууллага нь шаардлагатай тохиолдолд гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдээс нэмэлт баримт бичиг, тайлбар, тодруулга шаардах эрхтэй.

4.2.3. Арилжаа эрхлэх байгууллага нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдэд өөрийн үнэт цаасны бүртгэлийн журмын шаардлагаас хөнгөлөх чөлөөлөх эрх нь нээлттэй байна.

4.2.4. Арилжаа эрхлэх байгууллага нь үнэт цаасны бүртгэлийн ангиллын шалгуур үзүүлэлтийг гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд хангаж байгаа эсэх нийтэд санал болгож байгаа хуулийн этгээдийн танилцуулгын бүрдэл зэргийг хянах үүрэгтэй.

4.2.5. Арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 4.2.4-т заасан ажиллагааг ажлын 14 өдрийн дотор гүйцэтгэх бөгөөд тухайн гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг өөрийн арилжааны бүртгэлийн жагсаалтад оруулахыг зөвшөөрч шийдвэрлэсэн тохиолдолд уг шийдвэрээ ажлын хоёр өдрийн дотор Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

¹Энэ журамд заасан үнэт цаасны бүрдүүлбэр гэдэгт үнэт цаасны төрөл, үнэт цаасны нэрлэсэн үнэ, эргэлтэд гаргасан үнэт цаасны тоо ширхгийг хамааруулна.

4.2.6. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахаар хүсэлт гаргаж, арилжаа эрхлэх байгууллага уг хүсэлтийг өөрийн журмын дагуу хянаж, бүртгэлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн тохиолдолд гаргасан шийдвэрийг 'Бүртгэв' тэмдэглэл бүхий тухайн хуулийн этгээдийн ирүүлсэн баримт бичгийн хуулбарын хамт ажлын хоёр өдрийн дотор Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

4.2.7. Арилжаа эрхлэх байгууллага нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн Монгол Улсад гаргасан үнэт цаасны арилжаанд хяналт тавих үүрэгтэй.

4.2.8. Арилжаа эрхлэх байгууллага нь гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн Монгол Улс дахь мэдээллийн ил тод байдлыг хангуулах чиглэлээр тухайн хуулийн этгээдийн анхдагч бүртгэл хийлгэсэн арилжаа эрхлэх байгууллагатай нягт хамтран ажиллах үүрэгтэй.

4.2.9. Арилжаа эрхлэх байгууллага нь энэхүү журмын 4.2.1-т заасан шалтгаанаар үнэт цаасыг өөрийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай мэдэгдэл, холбогдох шийдвэрийг ажлын хоёр өдөрт багтаан гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд болон Хороонд хүргүүлэх үүрэгтэй.

4.2.10. Энэхүү журмын 3.14-д заасны дагуу гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт орсон тохиолдолд холбогдох мэдээллийг үнэт цаас гаргагчаас албан бичгээр хүлээн авч, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн мэдэгдэлд үндэслэн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах үүрэгтэй.

4.3. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь дараахь эрхийг эдэлж, үүрэг хүлээнэ:

4.3.1. Хуулийн этгээд нь Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагаас энэхүү журмын 4.2.9-т заасан бүртгэлээс хасах тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл Хороонд гомдол гаргах эрхтэй.

4.3.2. Хуулийн этгээд нь үнэт цаасыг бүртгэхээс татгалзсан тухай Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар Хорооны Хяналтын зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

4.3.3. Хуулийн этгээд нь үнэт цаасаа бүртгүүлэх, бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, эсхүл бүртгэлээс хасуулахтай холбоотой Хороонд гаргасан хүсэлтээ хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцын мэдээ, мэдээллээр хангагдах эрхтэй.

4.3.4. Хуулийн этгээд нь үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулах, компанийн хэлбэрийг өөрчлөх, бүртгэлээс хасуулах тохиолдолд энэ тухай мэдэгдлийг арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд нэгэн зэрэг гаргах эрхтэй.

4.3.5. Хуулийн этгээд нь нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой Хорооноос шаардсан тодруулга, нэмэлт баримт бичгийг заасан хугацаанд хүргүүлэх үүрэгтэй.

4.3.6. Хуулийн этгээд нь өөрийн харьяалах улсын хууль тогтоомж болон арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах эрхтэй бөгөөд компанийн засаглалын кодекс, стандарт нэгэн адил хамаарна.

4.3.7. Хуулийн этгээд нь арилжаа эрхлэх байгууллага болон Хороонд хүргүүлсэн хуулийн этгээдийн танилцуулга, түүнд хавсаргасан холбогдох бүх аримт бичиг, хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт зэрэг үнэт цаас бүртгүүлэхтэй холбоотой материалыг Хорооны бүртгэлд бүртгэх тухай тогтоол гарснаас хойш 10 жилийн хугацаанд өөр дээрээ хадгалах үүрэгтэй.

4.3.8. Хуулийн этгээд нь өөрийн харьяалах улсын хууль, анхдагч бүртгэл хийлгэсэн арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журам, стандартын дагуу хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч болон нийтэд мэдээлэх мэдээ, мэдээлэл, мэдэгдлийг тухай бүр Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллага болон өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлж байх үүрэгтэй.

4.3.9. Хуулийн этгээд нь ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргасан бол Монгол Улсад гаргасан үнэт цаасанд ногдох ногдол ашгийг Монгол Улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр хийж гүйцэтгэнэ.

4.3.10. Хуулийн этгээд нь өөрийн харьяалах улсын үнэт цаас бүртгэгч байгууллага болон Монгол Улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй гэрээ байгуулсны үндсэн дээр үнэт цаасаа гадаадын болон дотоодын зах зээл хооронд хөрвөх нөхцөлөөр хангуулах эрхтэй.

4.3.11. Хуулийн этгээд нь гадаад улсын зах зээлд тухайн төрлийн үнэт цаасыг нэмж гаргах тохиолдолд урьдчилан Хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад албан бичгээр мэдэгдсэн байна.

ТАВ. ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МОНГОЛ УЛСАД ГАРГАСАН ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

5.1. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад гаргасан үнэт цаасаа бүртгэлээс хасуулахдаа дараахь баримт бичгийг Хороонд хүргүүлнэ. Үүнд:

5.1.1. албан хүсэлт болон хуулийн этгээдийн эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр;

5.1.2. Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасахад татгалзах зүйлгүй болох талаарх тодорхойлолт, бүртгэлээс хассан тухай шийдвэр;

5.1.3. үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагаас тухайн хуулийн этгээдийн үнэт цаасыг бүртгэлээс хасахтай холбоотой санал, дүгнэлт, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн эсэх тухай тодорхойлолт болон хуулийн этгээд хувьцаа эзэмшигчийн тусгаарлагдсан хувьцааны талаарх мэдээ, мэдээлэл;

5.1.4. Хувьцаа эзэмшигчийн хувьцаанд ногдох мөнгөн хөрөнгийг тухайн хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд шилжүүлсэн баримт;

5.1.5. Энэхүү журмын 5.2-т заасан хууль зүйн дүгнэлт;

5.1.6. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн төлбөрийн баримт.

5.2. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь үнэт цаасны бүртгэлээс хасуулахтай холбоотой асуудлаар хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа

эрхлэх хуулийн этгээдтэй гэрээ байгуулж, дүгнэлт гаргуулах бөгөөд дүгнэлтэд дараахь асуудлыг тусгасан байна. Үүнд:

5.2.1. үнэт цаасыг бүртгэлээс хасах шийдвэр нь хүчин төгөлдөр эсэх;

5.2.2. үнэт цаасыг бүртгэлээс хасах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажиллагаа нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх.

5.3. Хороо нь үнэт цаасыг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН БОЛОН ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД ДАВХАР БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮНЭТ ЦААСЫГ ХӨРВҮҮЛЭХ

6.1. Монгол Улсын болон гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад давхар бүртгэлтэй хуулийн этгээдийн үнэт цаасыг эзэмшигч нь үнэт цаасаа дотоодын болон гадаадын зах зээл хооронд хөрвүүлж болно.

6.2. Үнэт цаас эзэмшигч нь үнэт цаасаа хөрвүүлэх хүсэлтээ Монгол Улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх этгээдэд хүргүүлнэ.

6.3. Монгол Улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь хөрвүүлэх ажиллагааг гүйцэтгэж, холбогдох өөрчлөлтийг бүртгэсэн талаарх тайлан мэдээллийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад тухай бүрд мэдэгдэнэ.

6.4. Хуульд өөрөөр заагаагүй бол энэхүү журмын 6.1-д заасны дагуу хөрвүүлсэн үнэт цаасны хэмжээ нь тухайн үнэт цаас гаргагчийн Монгол Улсад бүртгэгдэж арилжаалсан нийт үнэт цаасны 80 хувьд хүрсэн тохиолдолд тухайн үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагын үнэт цаасны бүртгэлээс хасах үндэслэл болно.

6.5. Энэхүү журмын 6.4-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд арилжаа эрхлэх байгууллага тухайн үнэт цаас гаргагчийн Монгол Улсад бүртгэлтэй, эргэлтэд байгаа үнэт цаасны тоо хэмжээг нэмэгдүүлэх эсэх талаар үнэт цаас гаргагчтай зөвшилцөж болно.”

ДОЛОО. БУСАД

7.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлагыг Хорооны улсын байцаагч ногдуулна.

7.2. Энэхүү журмын 6.1-д заасан хариуцлага хүлээлгэсэн нь тухайн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

“Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасны бүртгэл”-ын 1 дүгээр хавсралт

**ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД
БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД
МОНГОЛ УЛСАД ГАРГАХ ҮНЭТ ЦААСЫГ
БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ**

Огноо:/...../.....

Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1. ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр, оноосон нэр:	
Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:	
Регистрийн дугаар:	
Үйл ажиллагааны чиглэл:	
1.1. ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	
Үүсгэн байгуулагч этгээд	Хуулийн этгээд Иргэн

1.1.1. Хуулийн этгээд бол түүний нэр	<i>Монгол</i>					
	<i>Англи</i>					
<i>Үүсгэн байгуулагдсан огноо</i>	<i>Он</i>		<i>Сар</i>		<i>Өдөр</i>	
<i>Улсын бүртгэлийн дугаар</i>						
<i>Регистрийн дугаар</i>						
<i>Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээдэд оруулсан хөрөнгийн хэмжээ, хувь</i>			<i>₮</i>	<i>буюу</i>	<i>%</i>
<i>Хаяг байршил</i>	<i>Улс</i>					
	<i>Хот</i>					
	<i>Баг/хороо</i>					
	<i>Гудамж, байр</i>					
	<i>Тоот</i>					
	<i>Холбоо барих утас</i>					
<i>Цахим хуудас</i>						
<i>Цахим хаяг</i>						
1.1.2. Иргэн бол түүний						
<i>Овог</i>						
<i>Нэр</i>						
<i>Иргэний харьяалал</i>						
<i>Регистр /паспорт/-ийн дугаар</i>						
<i>Албан ёсны хаяг байршил</i>						
<i>Эрхэлж байгаа ажил, албан тушаал</i>						
<i>Ажлын хаяг</i>						
<i>Эзэмшсэн мэргэжил</i>						
<i>Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ</i>	<i>₮</i>					
<i>Харилцах дансны үлдэгдэл</i>	<i>₮</i>					
<i>Хадгаламжийн дансны үлдэгдэл</i>	<i>₮</i>					

1.2. ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

<i>Хуулийн этгээдийн нэр</i>	<i>Монгол</i>					
	<i>Англи</i>					
<i>Үүсгэн байгуулагдсан огноо</i>	<i>Он</i>		<i>Сар</i>		<i>Өдөр</i>	
<i>Улсын бүртгэлийн дугаар</i>						
<i>Регистрийн дугаар</i>						
<i>Үйл ажиллагааны чиглэл</i>						
<i>Хаяг байршил</i>	<i>Улс</i>					
	<i>Хот</i>					
	<i>Баг/хороо</i>					
	<i>Гудамж, байр</i>					
	<i>Тоот</i>					
	<i>Холбоо барих утас</i>					
<i>Хуулийн этгээдийн Монгол Улсад төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эсхүл хуулийн этгээдийн талаарх мэдээлэл:</i>						
<i>Эрх бүхий албан тушаалтны овог, нэр/ Хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр:</i>						
<i>Хаяг байршил:</i>	<i>Улс</i>					
	<i>Хот</i>					
	<i>Баг/хороо</i>					
	<i>Гудамж, байр</i>					
	<i>Тоот</i>					
<i>Цахим хуудас:</i>						
<i>Цахим хаяг:</i>						
<i>Холбоо барих утас:</i>						
<i>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн мэдээлэл</i>						

#	Овог	Нэр	РД/	Утас	Мэргэжил	Хараат, хараат бус
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						

Санхүүгийн зохицуулах хорооны нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд дараахь үнэт цаасыг бүртгүүлэхээр энэхүү өргөдлийг гаргаж байна.

ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

Үнэт цаасны нэр:

Өмнө аль нэгэн арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй эсэх болон үнэт цаас гаргасан улс, бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага:

Өмнө нийтэд санал болгон үнэтцаас гаргахыг зөвшөөрсөн эрх бүхий байгууллага, түүнийг бүртгэсэн арилжаа эрхлэх байгууллагын шийдвэрийн дугаар, огноо:

<i>Өмнө гаргасан үнэт цаасны төрөл, нэрлэсэн үнэ, тоо ширхэг, код, ISIN код:</i>	
--	--

<i>Монгол Улсад гаргах үнэт цаасны төрөл:</i>	
---	--

<i>Монгол Улсад үнэт цаасаа гаргах арилжаа эрхлэх байгууллага:</i>	
--	--

<i>Тоо ширхэг:</i>	
--------------------	--

<i>Нэрлэсэн үнэ:</i>	
----------------------	--

<i>Хугацаа, хүү, үндсэн болон хүүгийн төлбөр төлөх хугацаа</i>	
--	--

<i>Үнэт цаасны нийтэд санал болгох хувь хэмжээ, хэлбэр, үнэ:</i>	
--	--

<i>Үнэт цаас гаргах замаар олон нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ:</i>	
--	--

<i>Үнэт цаасыг Монгол Улсад нийтэд санал болгон арилжихаар төлөвлөсөн хугацаа:</i>	
--	--

Үнэт цаас гаргах замаар олон нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалтын талаарх товч мэдээлэл:

--

ГАДААД УЛСЫН АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГАД БҮРТГЭЛТЭЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН МЭДЭЭЛЭЛ

<i>Андеррайтерийн оноосон нэр</i>	
<i>/синдикат хэлбэрээр оролцож байгаа бол энэ болон дараахь мэдээллийг мөн бичнэ/:</i>	
<i>Бүртгэлтэй улс, улсын бүртгэлийн дугаар:</i>	
<i>Регистрийн дугаар:</i>	
<i>Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэхтусгай зөвшөөрлийн дугаар, огноо:</i>	
<i>Оришин байх албан ёсны хаяг /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:</i>	
<i>Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:</i>	
<i>Хуулийн зөвлөгөө өгсөн компанийн оноосон нэр:</i>	

<i>Бүртгэлтэй улс, бүртгэлийн дугаар:</i>	
---	--

<i>Регистрийн дугаар:</i>	
---------------------------	--

<i>Эрх бүхий байгууллагаас олгосон энэхүү үйл ажиллагааг эрхлэхтусгай зөвшөөрлийн дугаар, огноо:</i>	
--	--

<i>Оршин байх албан ёсны хаяг</i> <i>/Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:</i>	
--	--

<i>Шуудангийн болон цахим шуудангийн хаяг, холбоо барих утас:</i>	
---	--

Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд нь энэхүү үнэт цаас гаргахтай холбоотойгоор ямар нэгэн хөндлөнгийн шинжээч, мэргэжилтэнтэй гэрээ байгуулан ажилласан болон энэ тухай мэдээлэл:

--

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг хуулийн этгээдийн танилцуулгад үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

<i>1. Овог, нэр:.....</i>	<i>4. Овог, нэр:.....</i>
---------------------------	---------------------------

<p>Албан тушаал: Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд “.....” компанийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>Албан тушаал: андеррайтерийн компанийн ТУЗ-ийн дарга</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
<p>2. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд “.....” компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>5. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал: андеррайтерийн компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>
<p>3. Овог, нэр:</p> <p>Албан тушаал: Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд “.....” компанийн Ерөнхий нягтлан бодогч</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>	<p>6. Овог, нэр:.....</p> <p>Албан тушаал:.....хуулийн зөвлөх “.....” компанийн гүйцэтгэх захирал</p> <p>Гарын үсэг:.....</p> <p>(Тамга/тэмдэг)</p>

Өргөдөл гаргасан огноо:.....

Өргөдөлтэй холбоотой асуудлыг
хариуцан ажиллах ажилтны овогнэр,
албан тушаал, холбоо барихутас:

--

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө/

Өргөдөл хүлээн авсан ажилтны овог нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын долоодугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХАДГАЛАМЖИЙН БИЧГИЙГ БҮРТГЭХ,НИЙТЭД САНАЛ БОЛГОН АРИЛЖИХ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын хадгаламжийн бичиг /цаашид “Хадгаламжийн бичиг”гэх/ гаргагчид тавих нөхцөл, шаардлагыг тогтоох, хадгаламжийн бичиг гаргах, үнэт цаасны бүртгэлд бүртгэх, нийтэд санал болгох болон арилжихтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Гадаад улсын хадгаламжийн бичиг гаргахтай холбогдох харилцаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулах бөгөөд энэ журмын үйлчлэлд хамаарахгүй.

1.3. Энэ журам нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж болон эдгээртэй нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний бусад актад нийцсэн байна.

Хоёр. Хадгаламжийн бичиг гаргагчид тавих нөхцөл, шаардлага

2.1. Хадгаламжийн бичиг гаргагч нь гадаад улсын болон дотоодын үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх этгээд байна.

2.2. Хадгаламжийн бичиг гаргагч нь гадаад улсын хуулийн этгээд байх тохиолдолд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1. Тухайн хуулийн этгээд нь хоёроос доошгүй удаа хадгаламжийн бичиг амжилттай гаргаж арилжаалсан туршлагатай байх;

2.2.2. Дотоодын кастодианы үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдтэй тухайн хадгаламжийн бичиг гаргах тухай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх.

Гурав. Хадгаламжийн бичиг гаргах, үнэт цаасны бүртгэлд бүртгэх

3.1. Хадгаламжийн бичгийн суурь үнэт цаас гаргагч нь өөрийн улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомж болон компанийн дүрмийн дагуу хадгаламжийн бичиг гаргах тухай шийдвэрийг гаргасан байна.

3.2. Гадаадын суурь үнэт цаас гаргагч нь өөрийн харьяалах улсын үнэт цаасны хадгаламжийн байгууллагад хадгаламжийн бичиг гаргагчийн нэр дээр үнэт цаасыг хадгалуулах хадгаламжийн гэрээг хадгаламжийн бичиг гаргагчтай байгуулсан байна.

3.3. Хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичгээ үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх, нийтэд арилжаалах зөвшөөрлийн хүсэлтээ энэ журамд заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-нд гаргана.

3.4. Хороо хадгаламжийн бичгийг үнэт цаасны нэгдсэн бүртгэлд бүртгэснээр үнэт цаасны арилжаанд оруулах ба хөрөнгө оруулагчдын эрх, үүрэг, хариуцлага болон бусад холбогдох харилцааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжоор зохицуулна.

3.5. Хадгаламжийн бичиг гаргах тухай шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

3.5.1. суурь үнэт цаас гаргагчийн нэр, оршин байгаа газар, түүний харьяалах гадаад улсын хуулийн дагуу хуулийн этгээдийнх нь хувьд ялгагдах шинжийг тодорхойлсон бусад

мэдээлэл;

3.5.2. суурь үнэт цаасны хэлбэр, төрөл, ангилал;

3.5.3. хадгаламжийн бичиг эзэмшигчийн суурь үнэт цаасаар гэрчлэгдсэн эрх;

3.5.4. тухайн гаргалтын нэг хадгаламжийн бичгээр өмчлөх эрх нь гэрчлэгдэх суурь үнэт цаасны тоо;

3.5.5. эргэлтэд байж болох хадгаламжийн бичгийн дээд хязгаар.

3.6. Хадгаламжийн бичиг гаргагч нь суурь үнэт цаас гаргагчтай хадгаламжийн гэрээ байгуулсны үндсэн дээр хадгаламжийн бичиг гаргах бөгөөд хадгаламжийн гэрээнд дараах зүйлсийг заавал тусгасан байна. Үүнд:

3.6.1. хадгаламжийн бичгийг арилжаалах нөхцөл;

3.6.2. хадгаламжийн бичиг гаргагч болон хадгаламжийн бичиг эзэмшигч хоорондын эрх, үүрэг, гэрээг зөрчсөнөөс үүсэх хариуцлагын тухай;

3.6.3. хадгаламжийн бичиг гаргагч нь өөрийн нэр дээр данс нээлгэн бүртгэсэн суурь үнэт цаасны тоо нь арилжаанд байгаа хадгаламжийн бичгийн тоонд нийцсэн байх нөхцөлийг хангах талаар хадгаламжийн бичиг гаргагч байгууллага болон кастодианы үүрэг;

3.6.4. хадгаламжийн бичиг эзэмшигчийн суурь үнэт цаасны тухайд эдлэх эрх, үүрэг, суурь үнэт цаасаар тодорхойлогдох саналыг нь нэгтгэн уламжлах, саналын дүнг танилцуулах журмын тухай, ногдол ашиг болон бусад үр шимийг хүртэх эрхийг эдлүүлэхтэй холбогдох ажиллагааг хэрхэн зохион байгуулах журам;

3.6.5. суурь үнэт цаас болон суурь үнэт цаас гаргагчийн талаарх тухайн улсын болон Монгол Улсын хууль тогтоомжид нийтэд мэдээлэхээр заасан зохих мэдээллийг тухай бүрсаадгүй гаргаж өгөх талаар суурь үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг;

3.6.6. хадгаламжийн бичиг эзэмшигчийн өмнө суурь үнэт цаас гаргагч үүрэг хүлээж байгаа эсэх тухай мэдээлэл;

3.6.7. хадгаламжийн бичиг эзэмшигчийн анхны шаардлагаар хадгаламжийн бичгийг цуцлах, холбогдох суурь үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг гүйцэтгэх, хадгаламжийн бичиг эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хадгаламжийн бичгийг цуцалж болохгүй тухай;

3.6.8. хадгаламжийн бичиг эзэмшигчийн хүсэлтийн дагуу хадгаламжийн бичгийг холбогдох суурь үнэт цаасанд хөрвүүлэх нөхцөл болон хадгаламжийн бичиг эзэмшигчийн эсхүл суурь үнэт цаас өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр тэдгээрийг захиран зарцуулах, бусдад шилжүүлэх болон хөрвүүлэхгүй байх тухай;

3.6.9. Хороо, хөрөнгийн биржид шаардлагатай мэдээллийг саадгүй гаргаж өгөх үүргийн талаар, уг үүргийг хэрэгжүүлэхэд талууд хэрхэн хамтарч ажиллах тухай;

3.6.10. хадгаламжийн бичиг гаргагчийн зүгээс суурь үнэт цаас болон хадгаламжийн бичгийн бүртгэл, төлбөр, тооцоо, хадгалалтын зохион байгуулалт;

3.6.11. хэрэв суурь үнэт цаас болон хадгаламжийн бичгийн хадгалалтыг эрх бүхийөөр кастодиан байгууллагаар хийлгэх тохиолдолд энэ харилцааг хэрхэн зохицуулах тухай;

3.6.12. суурь үнэт цаасны орлого болон бусад төлбөрийг хадгаламжийн бичиг эзэмшигчид олгох хугацаа;

3.6.13. энэ журмын 3.6.12-г заасан орлого болон бусад төлбөрийг олгохдоо хадгаламжийн бичиг гаргагчийн авах үйлчилгээний шимтгэлийн дээд хязгаар, тийнхүү шимтгэл

авах үндэслэл;

3.6.14. суурь үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг хэрэгжүүлэх зорилгоор хадгаламжийн бичиг эзэмшигчдийн жагсаалтыг гаргах журам, хугацаа;

3.6.15. хадгаламжийн бичиг гаргагч эсхүл кастодиан зэрэг арилжааны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийг өөрчлөх, үйлчилгээг бусдад шилжүүлэх нөхцөл;

3.6.16. хадгаламжийн гэрээнд өөрчлөлт оруулах, түүнийг дуусгавар болгох, цуцлахтай холбоотой зохицуулалт;

3.6.17. суурь үнэт цаас болон хадгаламжийн бичиг гаргагч нь хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах баталгаа;

3.6.18. энэ гэрээнээс үүссэн харилцаанд Монгол Улсын хуулийг хэрэглэх тухай зохицуулалт.

3.7. Энэ журмын 3.6-д заасан хадгаламжийн гэрээ нь тухайн хадгаламжийн бичгийн танилцуулгын салшгүй хэсэг байна.

3.8. Хадгаламжийн бичгийн танилцуулгад хадгаламжийн бичиг гаргагч болон суурь үнэт цаас гаргагчийн талаарх мэдээллийг тусгасан байна.

3.9. Суурь үнэт цаас гаргагчийн тухай мэдээллийг Хорооноос баталсан үнэт цаасны бүртгэлийн харилцааг зохицуулсан журамд заасны дагуу бэлтгэх бөгөөд дараах зүйлсийг нэмж тусгасан байна. Үүнд:

3.9.1. суурь үнэт цаасны эрсдэлийн шинжилгээ;

3.9.2. нэгж хадгаламжийн бичиг болон түүгээр гэрчлэх суурь үнэт цаас хоёрын хөрвөх харьцаа;

3.9.3. хадгаламжийн бичгийн гаргаж болох дээд хэмжээ /ширхгээр/;

3.9.4. хадгаламжийн бичигт үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, мэдээлэл авах болон хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэх журам;

3.9.5. суурь үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгийн хэмжээ, гаргасан үнэт цаасны тоо ширхэг, тэдгээрийн нэрлэсэн үнэ, тухайн суурь үнэт цаасны хяналтын багцыг эзэмшиж байгаа үнэт цаас эзэмшигчийн нэрсийн жагсаалт.

3.10. Хадгаламжийн бичиг гаргагчийн тухай мэдээлэлд дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

3.10.1. хадгаламжийн бичиг гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газар, хаяг, шуудангийн хаяг, хадгаламжийн бичиг гаргах эрх бүхий тухай мэдээлэл;

3.10.2. хадгаламжийн бичиг гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.10.3. хадгаламжийн бичиг гаргаж байсан туршлага;

3.10.4. хадгаламжийн бичигт үндэслэн санал өгөх, ногдол ашиг авах, мэдээлэл авах болон хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэх журам.

3.11. Хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичгийг Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

3.11.1. хадгаламжийн бичгийг бүртгүүлэх тухай хүсэлт;

3.11.2. хадгаламжийн бичиг гаргах тухай суурь үнэт цаас гаргагчийн шийдвэрийн хуулбар;

3.11.3. суурь үнэт цаас гаргагчийн үнэт цаас тухайн гадаад улсын хөрөнгийн бирж,

зохицуулагч байгууллагаас хадгаламжийн бичиг гаргахад татгалзах зүйлгүй тухай албанмэдэгдэл;

3.11.4. хадгаламжийн бичгийн танилцуулга болон хадгаламжийн гэрээ;

3.11.5. хадгаламжийн бичиг гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.11.6. хадгаламжийн бичиг эзэмшигчид үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлсний тухай мэдээлэл;

3.11.7. хэрэв хадгаламжийн бичиг гаргагч нь гадаад улсын хуулийн этгээд бол хоёроос доошгүй удаа хадгаламжийн бичиг амжилттай гаргаж арилжаалсан туршлагатай эсэхийг нотлох баримт;

3.11.8. хадгаламжийн бичиг гаргахад бэлтгэсэн баримт материал нь холбогдох хууль тогтоомжтой нийцэж буй эсэх талаар хууль зүйн дүгнэлт;

3.11.9. хүсэлтэд заасан мэдээллийг нотлох бусад нэмэлт баримт, материалууд;

3.11.10. зохицуулалтын үйлчилгээний хураамж төлсөн баримт.

3.12. Хороо бүрдүүлбэр нь бүрэн хүсэлтийг хүлээж авснаас хойш ажлын 20 хоногт шийдвэрлэнэ.

3.13. Хороо дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзаж болно. Үүнд:

3.13.1. тухайн суурь үнэт цаас нь Хороонд бүртгэлтэй болон Монгол Улсын үнэт цаасны зах зээлд арилжаалагдаж байгаа;

3.13.2. ирүүлсэн баримт бичиг нь агуулгын хувьд хоорондоо зөрчилтэй, тоон үзүүлэлт нь зөрүүтэй буюу дахин магадлах шаардлагатай;

3.13.3. баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл хуурамч мэдээ, баримт тусгасан нь илэрсэн;

3.13.4. хадгаламжийн бичиг гаргагч нь төлбөрийн болон хөрвөх чадваргүй болох нь тогтоогдсон.

Дөрөв. Хадгаламжийн бичгийг нийтэд санал болгон арилжих

4.1. Хадгаламжийн бичиг болон түүний танилцуулгыг Хороо бүртгэснээр түүнийг нийтэд танилцуулах, арилжаалахыг зөвшөөрнө.

4.2. Хороо, арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлсэн хадгаламжийн бичгийг зөвхөн нийтэд санал болгон худалдана.

4.3. Хадгаламжийн бичгийн суурь үнэт цаас нь аливаа төлбөрийн даалгавар, барьцаа, батлан даалт зэрэг үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгээгүй байна.

4.4. Хадгаламжийн гэрээнд заасны дагуу хадгаламжийн бичиг гаргагч нь суурь үнэт цаас гаргагчийн хувьд зуучлагчийн үүрэг гүйцэтгэнэ.

4.5. Хадгаламжийн бичгийг бусдад худалдахад түүнийг баталгаажуулсан суурь үнэт цаасны өмчлөх эрх худалдан авагчид шилжсэнд тооцно.

4.6. Хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичгийг нийт гаргаж болох дээд хязгаараар Хороонд бүртгүүлэх бөгөөд уг хязгаарын дотор суурь үнэт цаасыг хадгаламжийн бичигт хөрвүүлэн Монгол улсын үнэт цаасны зах зээлд арилжих, хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэх, хүчингүй болгосон хадгаламжийн бичгийг нөхөн гаргахад Хороонд тухай бүр бүртгүүлэхийг шаардахгүй. Уг ажиллагааг Хөрөнгийн бирж болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд, кастодианы шууд хяналтад Хадгаламжийн бичиг гаргагч хэрэгжүүлнэ.

4.7. Хадгаламжийн бичгийг анх удаа нийтэд санал болгон худалдах ажиллагаанд Хорооноос баталсан үнэт цаасны бүртгэлийн харилцааг зохицуулсан журмыг баримтална.

4.8. Хадгаламжийн бичиг гаргагчийг суурь үнэт цаас гаргагчтай байгуулсан хадгаламжийн гэрээний хүрээнд түүний даалгавар гүйцэтгэгч гэж үзэх бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.

4.9. Хадгаламжийн бичгийн өмчлөх эрхийн нэгдсэн бүртгэлийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд хэрэгжүүлэх бөгөөд харин гадаад улсад үндсэн бүртгэл бүхий суурь үнэт цаасыг хадгалуулахыг заавал шаардахгүй.

4.10. Хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичиг эзэмшигчдэд олгох мөнгөн төлбөрийг Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэнэ.

4.11. Хадгаламжийн бичигт өөрчлөлт оруулах хүсэлтийг Хороо хүлээн авснаас хойш ажлын 20 хоногийн дотор хянаж, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчөөгүй бол өөрчлөлтийг бүртгэх буюу эсхүл бүртгэхээс татгалзсан тухай үндэслэл бүхий хариу өгнө.

4.12. Хадгаламжийн бичиг гаргагч нь энэ журмын 4.6-д заасан хязгаарыг өөрчлөх хүсэлтэй нөхцөлд Хороонд хадгаламжийн бичиг бүртгүүлэх хүсэлтийг энэ журмын дагуу дахин гаргана.

Тав. Хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэх болон арилжааны тайлан гаргах

5.1. Хадгаламжийн бичгийг хэдийд ч суурь үнэт цаасанд хөрвүүлж болох ба хөрвүүлэх ажиллагаа нь хариу төлбөргүй хэлцэл байна.

5.2. Хадгаламжийн бичиг эзэмшигч хүсэлт гаргасан тохиолдолд Хадгаламжийн бичиг гаргагч нь түүний хүсэлтээр суурь үнэт цаасанд хөрвүүлж, суурь үнэт цаас байршиж буй улс дахь тухайн хадгаламжийн бичиг эзэмшигчийн үнэт цаасны данс руу шилжүүлнэ.

5.3. Энэ журмын 5.2-т заасан хүсэлт биелээгүйн улмаас үүссэн хохирлыг хадгаламжийн бичиг гаргагч хариуцна.

5.4. Хадгаламжийн бичгийг хөрвүүлэхдээ дараах дарааллыг баримталж холбогдох ажиллагааг гүйцэтгэнэ:

5.4.1. хадгаламжийн бичиг эзэмшигч нь хууль тогтоомжид заасны дагуу хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлэхээр хадгаламжийн бичиг гаргагчид шилжүүлнэ;

5.4.2. хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичгийг хүлээн авсан даруйд суурь үнэт цаасыг тухайн хадгаламжийн бичиг эзэмшиж байсан хөрөнгө оруулагчийн суурь үнэт цаас байршиж буй улс дахь үнэт цаасны дансанд шилжүүлнэ;

5.4.3. хадгаламжийн гэрээнд заасан хадгаламжийн бичгийг хөрвүүлэхдээ түүнтэй холбоотой аливаа төлбөр, татвар төлж барагдуулах зэрэг нөхцөлийг бүрэн хангагдсан байх явдлыг хадгаламжийн бичиг гаргагч хариуцна;

5.4.4. хадгаламжийн бичгийг суурь үнэт цаасанд хөрвүүлж хөрөнгө оруулагчийн дансанд шилжүүлснээр суурь үнэт цаасны эзэмших эрх хадгаламжийн бичиг гаргагчаас хөрөнгө оруулагч руу шилжинэ.

5.5. Хадгаламжийн бичгийг хөрвүүлэх болон нийт хадгаламжийн бичгийг эргүүлэн татах ажиллагааны журмыг хадгаламжийн гэрээгээр зохицуулна.

5.6. Нийт хадгаламжийн бичгийг эргүүлэн татах тохиолдолд энэ тухай Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд,

кастодианы үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд болон нийтэд 30-аас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх үүрэгтэй.

5.7. Хадгаламжийн бичиг гаргагч нь хөрвүүлсэн болон нэмж гаргасан хадгаламжийн бичгийн талаарх хагас жилийн тайланг тухайн жилийн 7 дугаар сард, жилийн тайланг дараа оныэхний сард багтаан Хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, нийтэд мэдээлнэ.

5.8. Хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичиг гаргах дээд хязгаар, хадгаламжийн бичгийн үлдэгдэл болон арилжих боломжтой хадгаламжийн бичгийн мэдээллийг өдөр бүр үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулж мэдээлнэ.

Зургаа. Хадгаламжийн бичиг гаргах үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг

6.1. Хадгаламжийн бичиг эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

6.1.1. хадгаламжийн бичиг гаргагчаас түүний талаар болон суурь үнэт цаасны талаарх мэдээллийг монгол хэлээр хүлээн авах;

6.1.2. өөрийн эзэмшиж буй хадгаламжийн бичгийн хувь хэмжээгээр суурь үнэт цаасанд ногдох саналын эрхийг эдлэх, саналаа хадгаламжийн бичиг гаргагчаар дамжуулан өгөх, үр дүнтэй нь танилцах;

6.1.3. өөрийн эзэмшил дэх хадгаламжийн бичигт ногдох ногдол ашиг, хүү зэрэг үр шимийг хүлээн авах, түүнийг захиран зарцуулах;

6.1.4. хадгаламжийн гэрээнд заасан нөхцөл, журмын хүрээнд өөрийн эзэмшил дэх хадгаламжийн бичгээ суурь үнэт цаасанд хөрвүүлэх;

6.1.5. Суурь үнэт цаас эзэмшигчтэй ижил түвшинд мэдээлэл авах;

6.1.6. хадгаламжийн бичиг эзэмшигчтэй холбоотой хадгаламжийн бичиг гаргагчаас үзүүлсэн үйлчилгээний хөлсийг тухай бүр хадгаламжийн гэрээнд заасан хувь хэмжээгээр төлөх үүрэг хүлээнэ.

6.2. Хадгаламжийн бичиг гаргагч нь дараах эрх, үүрэгтэй байна. Үүнд:

6.2.1. хадгаламжийн гэрээг хэрэгжүүлэхийг суурь үнэт цаас гаргагчаас шаардах;

6.2.2. хадгаламжийн гэрээнд заасан харьцаагаар гаргасан хадгаламжийн бичгийг баталгаажуулж буй холбогдох суурь үнэт цаасыг өөрийн эсхүл гэрээний үндсэн дээр үүрэг хүлээлгэсэн кастодианы хадгалалтад байлгах;

6.2.3. хадгаламжийн бичиг эзэмшигч нь өөрийн эзэмшил дэх хадгаламжийн бичгээ суурь үнэт цаасанд хөрвүүлэн эзэмшсэнээс бусад тохиолдолд арилжаанд байгаа хадгаламжийн бичгийн тоонд тохирох суурь үнэт цаасыг хадгалах;

6.2.4. суурь үнэт цаас гаргагчаас холбогдох мэдээлэл ирүүлэхийг шаардах, ирсэн мэдээллийг орчуулан зохих журмын дагуу хадгаламжийн бичиг эзэмшигчдэд хүргэх;

6.2.5. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон хадгаламжийн гэрээнд заасны дагуу хадгаламжийн бичиг гаргагч нь хадгаламжийн бичиг эзэмшигчийн саналын эрхийг төлөөлж болно;

6.2.6. суурь үнэт цаас гаргагчаас аливаа ногдол ашиг хуваарилсан тохиолдолд түүнийг тухайн орны мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэн олгох ажлыг гэрээний дагуу гүйцэтгэх;

6.2.7. хадгаламжийн бичиг эзэмшигчийн ногдол ашиг авах болон бусад эрхийг шуурхай бөгөөд шударгаар суурь үнэт цаас гаргагчид уламжлах, эрхийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

6.2.8. нийт гаргасан хадгаламжийн бичгийн бүртгэлийг хөтлөх, тогтоосон хязгаарын хүрээнд хадгаламжийн бичгийг нэмж гаргах, хадгаламжийн бичгийг хүчингүй болгонсуурь үнэт цаасанд хөрвүүлэх;

6.2.9. хадгаламжийн бичиг гаргах дээд хязгаар, хадгаламжийн бичгийн үлдэгдэл болон арилжих боломжтой хадгаламжийн бичгийн мэдээллийг өдөр бүр нийтэд мэдээлэхээр арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх.

6.3. Суурь үнэт цаас гаргагч нь дараах эрх, үүрэгтэй байна:

6.3.1. гадаад улсад хадгаламжийн бичиг гаргах суурь үнэт цаас гаргагч хадгаламжийн гэрээнд заасны дагуу суурь үнэт цаасыг тухай бүр хадгаламжийн бичиг гаргагчийн кастодианы хадгалалтад шилжүүлэх;

6.3.2. хадгаламжийн бичиг гаргах ажиллагаа, түүний арилжааны талаар болон хадгаламжийн бичиг эзэмшигчдийн бүртгэлийн талаар хадгаламжийн бичиг гаргагчаас мэдээлэл авах;

6.3.3. холбогдох мэдээллийг тухай бүр хадгаламжийн бичиг гаргагчид шуурхай хүргэх, хүргэсэн мэдээллийг зохих журмын дагуу нийтэд мэдээлэх ажиллагаанд хяналт тавих;

6.3.4. хадгаламжийн бичиг гаргагчаас нийт гаргасан хадгаламжийн бичиг эзэмшигчдээс ирүүлсэн саналыг нэгтгэн ирүүлснийг зохих журмын дагуу шалгах, зөвшөөрөх, холбогдох санал хураалтад хамруулах, үр дүнг хариу мэдэгдэх.

Долоо. Бусад

7.1. Хадгаламжийн бичиг гаргагч болон суурь үнэт цаасыг хадгалж байгаа кастодианы үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд төлбөрийн чадваргүй болсон, төлбөрийн чадваргүй болох ноцтой нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ тухай Хороонд мэдэгдэх бөгөөд холбогдох үйлчилгээ үзүүлэх гэрээний эрхийг эрх бүхий өөр байгууллагад шилжүүлэх арга хэмжээг Хороо авна.

7.2. Хадгаламжийн бичиг гаргагч, түүний кастодианд хадгалагдаж байгаа хадгаламжийн бичиг, суурь үнэт цаас, тэдгээрийн төлбөр, ногдол ашиг, ногдол хувь зэрэг мөнгөн хөрөнгө нь уг этгээдийн хөрөнгийн эсрэг гарсан аливаа нэхэмжлэл, үүргийн гүйцэтгэлд хамаарахгүй.

7.3. Хадгаламжийн бичиг гаргагч, түүний кастодиан нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, онцгой дэглэм тогтоогдсон, эрх хүлээн авагч томилогдсон тохиолдолд энэхүү журмын 7.1-т заасны дагуу хөрөнгийг эрх бүхий этгээдэд шилжүүлэх арга хэмжээг Хороо авна.

7.4. Энэхүү журмаар тогтоосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын наймдугаар хавсралт

НОГДОЛ АШИГ ТАРААХ АЖИЛЛАГАА

1. Бэлэн мөнгө эсхүл компанийн хувьцаа болон бусад этгээдийн үнэт цаас хэлбэрээр хуваарилсан ногдол ашгийг зөвхөн эрх бүхий зуучлагч байгууллага болох “ҮЦТХТ” ХХК- аар дамжуулан ногдол ашиг тараалгах гэрээний үндсэн дээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор тарааж, ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлж байхыг нээлттэй хувьцаат компаниудын удирдлагуудад даалгасугай.

2. Давуу эрхийн хувьцаа болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь арилжааны банк дахь өөрийн харилцах болон хадгаламжийн дансанд ногдол ашгийг шилжүүлж авахаар бичгээр хүсэлт гаргаж, холбогдох мэдээллийг өгсөн тохиолдолд ногдол ашгийг нээлттэй хувьцаат компани хувьцаа эзэмшигчийн дансанд байршуулах боломжтойг тэмдэглэсүгэй.

3. “ҮЦТХТ” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны хадгаламжийн журам”-ын дагуу ногдол ашгийг зуучлуулан тараалгахад хадгалуулагчаас авч буй үйлчилгээний хөлс болох 100 /нэг зуу/ төгрөгийн шимтгэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллахыг “ҮЦТХТ” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл /Л.Сонор/-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дараах чиг үүрэг бүхий байгууллагуудаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийн мэдээллийг тогтмол хүргэж ажиллахад анхаарч ажилласугай.

1/ “ҮЦТХТ” ХХК-аар дамжуулан ногдол ашиг тараалгах гэрээ байгуулснаас хойш ажлын 5 хоногийн дотор хувьцаа эзэмшигчид болон брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй этгээдүүдэд хүргэж, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын дагуу тус Хороонд мэдэгдэж байхыг “ҮЦТХТ” ХХК /Ж.Байгалмаа/-д;

2/ “ҮЦТХТ” ХХК-аас брокер, дилерийн компаниудад ногдол ашиг хуваарилахтай холбоотой мэдээлэл ирсэн даруйд холбогдох хувьцаа эзэмшигчдэд ажлын 5 хоногт багтаан мэдээллийн сувгуудыг ашиглан түгээхийг брокерийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудад тус тус үүрэг болгосугай.

5. Хэрэв хувьцаа эзэмшигч нь үнэт цаасны дансгүй бол түүнд хуваарилагдсан ногдол ашгийг хувьцааны данс нээгдсэн тухай бүр дансанд нь байршуулахыг “ҮЦТХТ” ХХК-д зөвшөөрсүгэй.

6. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 38 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

7. Энэхүү тогтоолоор өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй тохиолдолд хууль тогтоомжид заасан холбогдох арга хэмжээ авахыг хувьцаат компаниуд, “ҮЦТХТ” ХХК, брокерийн компаниудын төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гүйцэтгэх удирдлагад анхааруулсугай.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын есдүгээр хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ЭЗЭМШИХТЭЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬД ЗААСАН ШАЛГУУРЫГ МӨРДҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих

2.1. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаар дамжуулан олон нийтэд хувьцаагаа санал болгон худалдах, эсхүл худалдсан төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг худалдан авах хүсэлтэй аливаа этгээд нь улс төрд нөлөө бүхий этгээд эсэх, эсхүл улс төрд нөлөө бүхий этгээдийн хамаарал бүхий этгээд эсэх, мөн өөрөө дангаараа, эсхүл холбогдох этгээд нь, эсхүл холбогдох этгээдийн хамт тухайн компанийн нөлөө бүхийн хувьцаа эзэмшигч эсэх талаарх мэдээллийг энэ журмын хавсралтаар тогтоосон асуулгын загварын дагуу үнэт цаасны брокерын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд (цаашид “үнэт цаасны брокер” гэх)-д үнэн зөв мэдүүлнэ.

2.2. Энэ журмын 2.1-д заасан мэдээллийг харилцагч мэдүүлэхээс татгалзсан тохиолдолд үнэт цаасны брокер тухайн харилцагчид төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээ үзүүлэхгүй.

2.3. Үнэт цаасны брокер нь энэ журмын 2.1-д заасан мэдээллийг хүлээн авч, үйлчилгээ үзүүлэх явцад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шаардлагыг тухайн харилцагч хангахгүй гэж үзвэл харилцагчид хувьцаа худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.

2.4. Үнэт цаасны брокер нь энэ журмын 2.1-д заасан харилцагчийн талаарх мэдээллийг цахим хэлбэрээр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд (цаашид “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” гэх)-д тухай бүр хүргүүлнэ.

2.5. Үнэт цаасны брокер нь төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нэмж хувьцаа худалдан авах тохиолдолд энэ журмын 2.4-д заасан мэдээллийг тухай бүр шинэчлэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.6. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь энэ журмын 2.4-2.5-д заасны дагуу ирүүлсэн мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэж, боловсруулах бөгөөд төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд болон улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээдийн талаарх мэдээллийн нэгдсэн сантай байна.

2.7. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь энэ журмын 2.6-д заасны дагуу ирүүлсэн мэдээллийг нэгдсэн байдлаар бүртгэж, боловсруулах явцад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шаардлагыг тухайн хувьцаа эзэмшигч хангахгүй болсон, эсхүл хангахгүй болсон гэж үзэх үндэслэл бүхий нөхцөл байдал үүссэн бол энэ тухай холбогдох мэдээллийг ажлын нэг өдрийн дотор Хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.8. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв нь төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох болон ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргаснаас хойш ажлын нэг өдрийн дотор Хороонд цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.9. Хорооны Ажлын албанаас томилсон албан тушаалтан энэ журмын 2.6-д заасан мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхтэй.

2.10. Энэ журмын 2.9-т заасан албан тушаалтан нь мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нууц мэдээллийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх үүрэгтэй.

Гурав. Бусад

3.1. Хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шаардлагыг мөрдүүлэх, хяналт тавих зорилгоор шаардлагатай тохиолдолд эрх бүхий төрийн байгууллагаас холбогдох мэдээллийг лавлах, тодруулах, гаргуулан авч болно.

3.2. Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл бүхий нөхцөл байдал үүссэн болон бусад шаардлагатай тохиолдолд Хорооноос эрх бүхий төрийн байгууллага, үнэт цаас гаргагчид ажлын гурван өдрийн дотор мэдэгдэнэ.

“Төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих”-ын хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААГ ХУДАЛДАН АВАХАД ХАРИЛЦАГЧААС АВАХ АСУУЛГА

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5¹, 6² дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх зорилгоор харилцагч таныг улс төрд нөлөө бүхий этгээд³ эсэх, эсхүл улс төрд нөлөө бүхий этгээдийн хамаарал бүхий этгээд⁴ эсэх, мөн дангаараа, эсхүл таны холбогдох этгээд⁵ нь, эсхүл та холбогдох этгээдийн хамт тухайн компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч⁶ эсэх талаарх мэдээллийг энэхүү асуулгаар цуглуулах болон тус мэдээллийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Санхүүгийн зохицуулах хороонд дамжуулах, тэдгээр нь боловсруулалт хийхийг зөвшөөрч байна уу?

¹ “Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт энэ хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компани болсон төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн Үнэт цаасны зах зээлийн тухайхуулийн 4.1.29-д заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.”

² “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.5-д заасан улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээд биржээр арилжаалах төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг эзэмшихийг хориглоно.”

³ Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;

⁴ тухайн нийтийн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг;

⁵ а.хувь хүний тухайд тухайн хүний эхнэр, нөхөр, хүү, охин, өргөмөл хүү, өргөмөл охин буюу дагавар хүү, дагавар охин, хүргэн, бэр, ач, зээ, өөрийн болон түүний эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, хойд эцэг, хойд эх, ах, эгч, дүү, эцэг нэгтэй буюу эх нэгтэй ах, эгч, дүү;

б.тухайн хүн эрх бүхий албан тушаалтнаар нь ажилладаг хуулийн этгээд;

в.холбогдох этгээд дангаар, эсхүл хамтдаа эзэмших саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг компани болон хуулийн этгээд;

г.тухайн этгээд ажил олгогч бол түүний ажилтан;

д.компани бол түүний толгой, хараат, охин, зэргэлдээ компани;

е.Санхүүгийн зохицуулах хорооноос "холбогдох этгээд" гэж тодорхойлсон бусад этгээд.

⁶ тухайн компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны тав болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийг;

- а) Тийм б) Үгүй

2. Та улс төрд нөлөө бүхий этгээд, эсхүл түүний хамаарал бүхий этгээд мөн үү?

- а) Тийм б) Үгүй

3. Та энэхүү төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч мөн үү? Тийм бол хэдэн хувийг эзэмшдэг вэ? /5% хүрээгүй тохиолдолд та нэмэлт хувьцаа авах боломжтой, хэрэв худалдан авах захиалгын хэмжээ 5%-д хүрэхээр байгаа нөхцөлд таны захиалга биелэх боломжгүй болохыг анхаарна уу/

- а) Тийм (.....%) б) Үгүй

4. Таны холбогдох этгээд энэхүү төрийн болон орон нутгийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшдэг үү? Тийм бол холбогдох этгээдтэй холбоотой мэдээллийг оруулна уу. /таны холбогдох этгээдийн эзэмшиж буй хувьцаа нь 5% хүрээгүй тохиолдолд та 5% хүртэл нэмэлт хувьцаа худалдан авах боломжтой/

- а) Тийм б) Үгүй

ХОЛБОГДОХ ЭТГЭЭДҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ				
ТӨХК-ийн хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол				
№	Овог, нэр	Регистрийн дугаар	Ямар холбоотой болох	Хэдэн хувийг эзэмшдэг болох
1				
2				
...				
ТӨХК-ийн хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол				
№	Оноосон нэр	Регистрийн дугаар	Ямар холбоотой болох	Хэдэн хувийг эзэмшдэг болох
1				
2				
...				

5. Санхүүгийн зохицуулах хорооноос Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавихтай холбогдуулан таны болон энэхүү анкетад бөглөгдсөн этгээдийн талаарх мэдээллийг баталгаажуулах зорилгоор шаардлагатай тохиолдолд Авлигатай тэмцэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, болон бусад хууль сахиулах байгууллагаас дүгнэлт, лавлагаагаргуулан авах, мэдээлэл цуглуулахыг зөвшөөрч байна уу?

а) Тийм

б) Үгүй

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын аравдугаар хавсралт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төрлийн хувьд нээлттэй, хаалттай, эсхүл өмчлөлийн хувьд хувийн, төрийн болон орон нутгийн өмчийн, оролцоотой эсэх, үйл ажиллагааны онцлог, ээлжит болон ээлжит бус эсэхээс үл хамааран хувьцаат компани /цаашид “компани” гэх/ нь энэхүү журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид “хурал” гэх/-ын зарыг хүргэж, зохион байгуулна.

1.3. Энэхүү журмын 1.2-т зааснаас бусад компани хурлыг холбогдох хууль тогтоомж болон өөрийн компанийн дүрэмд заасан журмын дагуу зарлан хуралдуулж болох бөгөөд энэхүү журмыг баримтлан хурлыг хуралдуулах нь нээлттэй болно.

ХОЁР. ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАХ

2.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь компанийн ээлжит хурлыг Компанийн тухай хуулийн 59.4-т заасан хугацаанд зарлан хуралдуулна.

2.2. Компанийн тухай хуульд заасан хурал зарлах эрх бүхий этгээд шаардлагатай тохиолдолд компанийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

2.3. Хурал хуралдуулах шийдвэрт Компанийн тухай хуулийн 60.2-т заасан зүйлийг заавал тусгах ба хурал хуралдуулах шийдвэр гарсан өдрөөс хойш 40-өөс доошгүй хоногийн дараа ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулна.

2.4. Хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад бусад гэсэн хэсэг байх шаардлагатай бол энэ нь зөвхөн Компанийн тухай хуулийн 62.1-д заасан асуудал байна.

2.5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн тухай хуулийн 64.2-т заасны дагуу хурал зарлагч этгээд тогтоох бөгөөд энэ өдөр нь энэхүү журмын 3.6-д заасны дагуу хурал хуралдуулах тухай зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь өдөр байхаар тогтооно.

2.6. Хурал хуралдуулах тухай шийдвэрийг гаргаснаас хойш 3 хоногийн дотор хурал зарлагч этгээд нь энэхүү журмын нэгдүгээр хавсралт болох “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад тус тус хүргүүлнэ.

2.7. Энэхүү журмын 2.6-д заасан мэдэгдэлд дараах баримт, материалыг хавсаргана. Үүнд:

2.7.1. хурал хуралдуулах тухай шийдвэр;

2.7.2. хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар;

2.7.3. хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа;

2.7.4. Компанийн тухай хуулийн 80.11-т нийцүүлэн хурал хуралдуулах шийдвэр гаргасан ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд тусгагдсан хуралд оролцсон гишүүд, хурлаар хэлэлцсэн асуудал, санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон санал хураалтын дүн, гаргасан шийдвэр зэргийн баримт материал;

2.7.5. Компанийн тухай хуулийн 61.2-д заасны дагуу хурал зарлагч санал шаардлага гаргаж, тус хуулийн 61.7-д заасан үндэслэлээр хурал зарлаж байгаа бол хурлын мэдэгдэлд дараах баримт, материалыг хавсаргана. Үүнд:

2.7.5.1. ТУЗ-д санал шаардлага хүргүүлснийг нотлох баримт /албан бичгийн хуулбар, түүнийг хүлээн авсан ТУЗ-ийн даргын гарын үсэг, санал шаардлагад өгсөн ТУЗ-ийн хариу, хариу өгөөгүй тохиолдолд хурал зарлаж буй хувьцаа эзэмшигчийн тайлбар/;

2.7.5.2. Саналын эрх бүхий хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг эзэмшиж буйг батлах хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн тодорхойлолт.

2.8. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь хуралд оролцоно.

2.9. Компанийн тухай хуулийн 64.7, 68.5-д заасантай нийцүүлж ТУЗ бүртгэх өдрөөс хойш хувьцаа худалдан авсан этгээдийг хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх эрх бүхий этгээдийн бичгээр ирүүлсэн зөвшөөрлийг үндэслэн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд өөрчлөлт оруулна.

2.10. Компани нь хурлын шийдвэрийг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.8 болон 56.1.6-д заасны дагуу нэн даруй нийтэд мэдээлж, дараах холбогдох баримт бичиг, мэдээллийг хуульд заасан хугацаа буюу хурал хуралдсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ. Үүнд:

2.10.1. Ирцийн бүртгэл, итгэмжлэлээр оролцож буй этгээдийн бүртгэл, ирцийн баталгаажилт,

2.10.2. Саналын хуудасны хуулбарууд;

2.10.3. Тооллогын комиссын дарга, гишүүдийг томилсон шийдвэр;

2.10.4. Тооллогын комиссын дарга, гишүүдийн анкет;

2.10.5. Тооллогын комиссын шийдвэрүүд;

2.10.6. Хурлын тэмдэглэл, хурлын шийдвэрүүд;

2.10.7. Шаардлагатай бусад баримтууд.

2.11. Компани нь энэ журмын 2.10-т заасан хугацаанд ээлжит хурлын материалыг ирүүлээгүй бол Хороо ажлын 10 өдрийн дотор Компанийн тухай хуулийн 59.7-д заасны дагуу энэ тухай нийтэд мэдээлнэ.

2.12. Хуралтай холбоотой мэдээллийг Хорооноос өгөх эсхүл хурал хуралдуулахтай холбоотой маргаан гарсан тохиолдолд энэ журамд заасны дагуу Хороонд ирүүлсэн хурлын мэдэгдэл, хурлын материал, түүнээс гарсан шийдвэр болон холбогдох бусад баримт материалыг эх хувь болгон ашиглана.

2.13. Энэхүү журмын Хоёрдугаар хавсралтын дагуу Хорооны хянан шалгагч “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийн хяналтын хуудас”-аар хурлын мэдэгдэлд хяналт тавина.

2.14. Хорооны улсын байцаагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хяналт тавьж болно.

ГУРАВ. ХУРЛЫН ЗАР ХҮРГЭХ

3.1. Хурал зарлагч этгээд энэ журмын 2.7-д заасны дагуу хурлын мэдэгдлийг хавсралт материалын хамт Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад тус тус 2 хоногийн өмнө ирүүлсний дараа хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдээлнэ.

3.2. Компанийн тухай хуулийн 60.4-т заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг гарснаас хойш 5 хоногийн дотор хурлын зарыг энэ журмын 3.1-т заасны дагуу нийтэд мэдээлнэ.

3.3. Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг хурал хуралдахаас 30 болон түүнээс багагүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан хоёр ба түүнээс дээш удаа хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлнэ.

3.4. Энэ журмын 3.3-т заасан мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлнэ.

3.5. Хурал зарлагч этгээд нь хурлын зарыг энэ журмын 3.3-т зааснаас гадна утас, факс, электрон шуудан зэрэг холбоо харилцааны боломжит бусад хэрэгслийг ашиглан хувьцаа эзэмшигчдэд хүргэж болно.

3.6. Хурал зарлагч этгээд нь энэхүү журмын 2.5-д заасан хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдөр гэдгийг арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар нийтэд хүргэсэн өдрийг тооцно.

3.7. Хурлын зард дараах мэдээллийг заавал тусгана:

3.7.1. компанийн оноосон нэр, байршил, хурал хийх өдөр, цаг, газар;

3.7.2. хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр;

3.7.3. хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт;

3.7.4. хурлаас гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг;

3.7.5. хурал зохион байгуулах комиссын дарга, гишүүдийн утас, электрон шуудангийн хаяг, ажиллах цагийн хуваарь;

3.7.6. компанийн дүрэмд заасан болон хурал зарлагч этгээдээс шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

3.8. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан хурлын ирц хүрээгүй тохиолдолд энэ тухай тэмдэглэл, протокол үйлдэж, хойшлогдсон хурлын товыг тогтоож, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг гарган хурлыг хойшлуулна. Хурал хойшлогдсон тухай мэдэгдлийг холбогдох материалын хамт Хороо, арилжаа эрхлэх байгууллагад ажлын 4 өдөрт багтаан тус тус ирүүлнэ.

3.9. Хойшлогдсон хурлыг Компанийн тухай хуулийн 69.6-д заасантай нийцүүлж ажлын 20 өдрийн дотор хуралдуулах бөгөөд уг хурал хуралдахаас ажлын 7-оос доошгүй өдрийн өмнө хойшлогдсон хурал болох газар, өдөр, цагийг энэ журмын 3.3-т заасан хэлбэр, шаардлагын дагуу дахин мэдээлнэ.

3.10. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 5 хоногт багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ.

3.11. Энэхүү журмын 2.6, 2.10, 2.11, 2.12 болон 3.1, 3.10 дахь заалтууд хаалттай компанид хамаарахгүй.

ДӨРӨВ. ХУРЛЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЗОХИОН БАЙГУУЛАХ

4.1. Компанийн дүрэм, эсхүл ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааны журамд дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг мэдээллийн технологийн шийдэл

ашиглан зайнаас зохион байгуулахаар нэмэлт зохицуулалтыг оруулан хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

4.1.1.ТУЗ-ийн хоёр болон түүнээс дээш тооны хараат бус гишүүн, эсхүл компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцааны 10 болон түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа болон тэдгээрийн саналын эрхийг хууль болон гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээд санал, шаардлага гаргасан;

4.1.2.ТУЗ шийдвэр гаргасан.

4.2.Энэхүү журмын 4.1-д заасан хурлыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно.Үүнд:

4.2.1.зайнаас /мэдээллийн технологи, программ хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах/;

4.2.2.хосолсон /танхим болон зайнаас/.

4.3. Компани өөрийн боловсруулсан, эсхүл гэрээний үндсэн дээр бусад этгээдийн мэдээллийн технологи, программ хангамжийг ашиглан хурлыг зохион байгуулж болно.

4.4.Хурал зарлагч этгээд нь энэ журмын 4.3-т заасан цахим хурлыг зохион байгуулах мэдээллийн технологи, программ хангамжийн талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг энэ журмын 2.6-д заасан хугацаанд Хороонд хүргүүлнэ.

4.5.Цахим хурал зохион байгуулах мэдээллийн технологи, программ хангамж нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна.

4.5.1.Хувьцаа эзэмшигчдэд дараах боломжийг олгосон байх:

4.5.1.1.хурлын зар, дэг, хэлэлцэх асуудалтай холбоотойгоор урьдчилж бэлдсэн болон хурлын үеэр тавигдсан баримт, материалтай танилцах;

4.5.1.2.цахимаар болон биеэр бүртгүүлэх;

4.5.1.3.санал болон асуултыг цахимаар болон цаасан хэлбэрээр урьдчилан хүргүүлэх;

4.5.1.4.хурлын уйл ажиллагааг онлайн хэлбэрээр шууд үзэх;

4.5.1.5.хурлын үеэр цахимаар санал өгөх, асуулт тавих, хэлэлцүүлэгт оролцох;

4.5.1.6.саналын хуудас хүчингүй болох эрсдэлийг хаах /саналын хуудас бүрэн гүйцэд, зөв бөглөгдсөн эсэхэд анхааруулга өгөх/;

4.5.1.7.хурлын шийдвэр, санал хураалтын дүнтэй шуурхай танилцах;

4.5.1.8.компанийн цахим архивын баримттай танилцах.

4.5.2.Мэдээллийн нууцлал, ашиглалт, хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг хангасан байх.

4.5.3.Хорооны мэдээллийн сантай холбогдох боломжтой байх

4.6.Компани нь хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулах тохиолдолд дор дурдсан үүргийг хүлээнэ:

4.6.1.хуралд оролцохоор бүртгүүлэх хүсэлт гаргагчийн биеийн байцаалт, итгэмжлэлээр оролцох этгээдийн итгэмжлэлийг хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалттай тулган баталгаажуулах /Хуралд оролцох эрх бүхий этгээдийг танин баталгаажуулах, мэдээлэл илгээх, нууцлалыг хангах зорилгоор баталгаат цахим шуудан болон гар утасны дугаар зэрэг нэмэлт мэдээллийг шаардаж болно/;

4.6.2.мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан нэвтрэх эрх, нууц үгийг хуралд оролцохоор бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчдийн цахим шуудан, эсхүл гар утасны дугаараар дамжуулан илгээх;

4.6.3.хуралд ашиглах программ хангамжийг ашиглах заавар, зөвлөгөө бүхий мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх;

4.6.4.хурлын үеэр хувьцаа эзэмшигчдэд шуурхай зөвлөгөө, туслалцаа үзүүлэх мэдээлэл харилцааны цахим суваг болон шуурхай утасны дугаар ажиллуулах;

4.6.5.хурлын материалыг цахим хурал дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор Хорооны мэдээллийн санд хүргүүлэх;

4.6.6.хурлын материал, хурлын үйл явцын бүтэн дүрс бичлэг, санал хураалтын баримт зэргийг засварлах, өөрчлөх боломжгүй хэлбэрт шилжүүлэн компанийн цахим архивын баримт болгох.

4.7.Хурлыг хуралдуулах боломжгүй техникийн нөхцөл үүссэн тохиолдолд хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг ТУЗ товлоно.

4.8. Энэ журмын 4.7-д давагдашгүй хүчин зүйлсээс болсон нөхцөл байдал мөн хамаарна.

ТАВ. БУСАД

5.1. Хурлыг компанийн ерөнхий захиргаа байрлаж байгаа газраас өөр газарт хуралдуулахаар товлосон бол хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн хамгийн их төвлөрөлтэй, аливаа зардал, чирэгдэлгүйгээр оролцох боломжтой газарт хурлыг хуралдуулна.

5.2. Хуралд оролцоогүй, эсхүл эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигч нь хурал зарлагч этгээдийг Компанийн тухай хуулийн 66.9 болон энэ журмын 3.1-3.4, 3.7, 4.4, 4.5, 4.6-д заасныг зөрчсөн гэж үзэн Хороонд гомдол гаргаж болно.

5.3. Гаргасан гомдол нь үндэслэлтэй гэж Хороо үзвэл хувьцаа эзэмшигчдийн хурал, эсхүл тухайн шийдвэрийг Компанийн тухай хуулийн 70.2-т заасан эрх хэмжээний дагуу хүчингүйд тооцно.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1. Энэхүү журмын хэрэгжилтэд Хорооны улсын байцаагч хяналт тавина.

6.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын зар”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	
Хаяг:	
Хурал хуралдах өдөр, цаг:	
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	
Хурлын төрөл:	Ээлжит
	Ээлжит бус
Хурал зарлагч:	ТУЗ
	ТУЗ-ын хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн санал, шаардлага гаргасан /нэр/
	Саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч санал, шаардлага гаргасан /нэр/
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	
Олон нийтэд зарлах огноо:	
Бүртгэлийн өдөр:	
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	
Хүргүүлсэн огноо:	
Хурлын даргын нэр:	
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо: ширхэг
 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /...../

..... оны дүгээр сарын –ны өдөр

“Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын зар”-ын хоёрдугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	ЗҮЙЛ	ТАЙЛБАР
1	Компанийн нэр:	
2	Хаяг, байршил:	
3	ГУЗ-ийн хурал хийсэн огноо:	
4	Хурал зарлагчийн мэдээлэл:	
5	Хороонд ирүүлсэн огноо /Хурал хуралдуулах шийдвэр гарснаар хойш 3 хоногийн дотор/:	
6	Олон нийтэд зарлах огноо /Хурал хуралдуулах шийдвэр гарснаар хойш 5 хоногийн дотор/:	
7	Эхний зарласнаас хойш 15 хоногт дахин зарласан эсэх:	
8	Бүртгэлийн өдөр /нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15-20 дахь хоног/:	
9	Хэлэлцэх асуудал /Компанийн тухай хуулийн 60.2 дахь хэсэгтэй нийцэж буй эсэх/:	
10	Саналын хуудасны загвар:	
11	Саналын хуудас хүлээн авах өдөр:	
12	Хурлын даргын нэр:	
	Хурлын комиссын гишүүдийн нэр:	
13	Хурал хуралдах огноо /шийдвэр гарснаас хойш 40-өөс доошгүй хоног/:	
14	Хурал хуралдуулах газар, байршил, хаяг:	
	Хурал хуралдуулах огноо, цаг:	
15	Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн нэр:	
	Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн гарын үсэг:	
	Хурлын мэдэгдэл хянасан огноо:	

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын арван нэгдүгээр хавсралт

ХААЛТТАЙ ХК-ИЙН ХУВЬЦААГ БҮРТГЭХ, ХАДГАЛАХ, ӨМЧЛӨХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Энэ журмаар үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага /цаашид "хадгалагч" гэх/-д хаалттай хувьцаат компани /цаашид "хадгалуулагч" гэх/-ийн хувьцааг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах болон үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх болон уг эрх бусдад шилжсэнийг бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү харилцаанд Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ны холбогдох журмыг удирдлага болгоно.

1.3. Энэхүү журмаар зөвхөн Компанийн тухай хуулийн 3.8-д заасан хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулах бөгөөд нийтэд санал болгон гаргах үнэт цаас, хаалттай хүрээнд санал болгон гаргах өрийн хэрэгслийг бүртгэх, хадгалах харилцааг зохицуулахгүй болно.

ХОЁР. НЭР ТОМЬЁО

2.1. Энэхүү журамд заасан дараах нэр томьёог дор дурьдсан утгаар ойлгоно.

2.1.1. "хадгалагч" гэж үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

2.1.2. "хадгаламж" гэж үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид үнэт цаасыг тоо ширхэг, нэгдсэн дугаар, хувьцаа эзэмшигчдийн нэр хаягаар нь биет бусаар буюу электрон хэлбэрээр тусгай бүртгэл хөтлөн хадгалах цогц хадгаламжийг;

2.1.3. "биет бус үнэт цаас" гэж тусгайлан хэвлээгүй, бүрдүүлбэр нь тооцоолох машины санах байгууламжид байгаа үнэт цаасыг;

2.1.4. "хүсэлт гаргагч" гэж өөрийн хувьцаагаа бүртгүүлэн хадгалуулахаар хадгалагч байгууллагад хүсэлт гаргасан хуулийн этгээдийг;

2.1.5. "хадгалуулагч" гэж Компанийн тухай хуулийн 3.8-д заасан хаалттай хувьцаат компанийг;

2.1.6. "хууль хяналтын байгууллага" гэж шүүх, прокурор, цагдаагийн байгууллагыг.

ГУРАВ. ХУВЬЦААГ БҮРТГЭХ

3.1. Энэхүү журмын 2.1.4-д заасан компани нь үнэт цаасны хадгаламжид бүртгүүлэх хүсэлтийг дараах баримт материалын хамт хадгалагч талд гаргана.

3.1.1. хувьцаа бүртгүүлэх хүсэлт /хавсралт-1/

3.1.2. компанийн хэлбэрийг хаалттай хувьцаат компани болгон шийдвэрлэх тухай эрх бүхий байгууллагын шийдвэр;

3.1.3. улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.4. компанийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.5. компанийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

3.1.6. компанийн болон түүний салбар, төлөөлөгчийн газрын эрх бүхий албан тушаалтан, холбоо барих үнэт цаас хариуцсан ажилтны анкет;

3.1.7. компанийн татвар, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хугацаа хэтэрсэн өртэй эсэх талаарх лавлагаа;

3.1.8. зээлийн барьцаанд үүргийн гүйцэтгэл хангуулахаар хувьцаагаа барьцаалсан эсэх лавлагаа;

3.1.9. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн болон компанийн засаглалыг хэрхэн хэрэгжүүлэн ажилладаг талаарх мэдээлэл.

3.2. Хүсэлт гаргагч нь журмын 3.1-т заасан баримт бичгийг Монгол хэл дээр үнэн зөв хоёр хувь бүрдүүлж хадгалагчид албан бичгээр хүргүүлнэ.

3.3. Хадгалагч нь хүсэлт гаргагчаас ирүүлсэн бичиг баримтыг хянаж, энэ журамд заасан бүрдлийг бүрэн хангасан гэж үзвэл хувьцаа бүртгүүлэх хүсэлтийг ажлын 10 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.4. Хадгалагч хүсэлт гаргагчийн хувьцааг бүртгэхээс татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэл бүхий тайлбарыг албан бичгээр ажлын 5 хоногт багтаан хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

3.5. Хадгалагч нь Хорооны 2013 оны 280 дугаар тогтоолоор баталсан "Хаалттай хувьцаат компанийн тухай журам"-ын 3.1-д заасны дагуу компанийн ирүүлсэн эх баримт бичгийн нэг хувийг Хороонд заавал ирүүлнэ.

3.6. Энэхүү журмын хавсралт 2-т заасан мэдээлэл нь хувьцааг бүртгэх шийдвэрийн салшгүй хэсэг байна.

ДӨРӨВ. ХУВЬЦААГ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД ХАДГАЛАХ

4.1. Хадгалагч нь хадгалуулж буй хувьцааг төрөл тус бүрээр нэгдсэн дугаар (код) өгч хадгаламжид бүртгэнэ.

4.2. Хадгалагч нь хадгалуулагчтай хувьцааны хадгаламжийн болон түүнтэй холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ байгуулна.

4.3. Энэхүү журмын 4.2-т заасан хувьцааны хадгаламжийн гэрээнд хадгаламжийн хэлбэр, хадгалуулах хувьцааны төрөл, тоо ширхэг, хадгаламжийн үйлчилгээний хөлсний хэмжээ, хөлс төлөх хугацаа, хадгаламжийн гэрээг цуцлах нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгээгүйгээс үүсэх хариуцлагыг тодорхой тусгасан байна.

ТАВ. ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

5.1. Дараах тохиолдолд хадгалуулагчийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулна.

5.1.1. хадгалуулагч нь нэмж хувьцаа гаргах эсхүл хувьцааг хэсэгчлэн хасах тухай шийдвэр гаргасан;

5.1.2. хадгалуулагч нь нэгдэх, нийлэх, хуваах, тусгаарлах болон өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдсан;

5.1.3. хадгалуулагч нь хувьцааг хуваах, нэгтгэх, нэрлэсэн үнийг өөрчлөх тухай шийдвэр гаргасан;

5.1.4. бүртгэлтэй хувьцааны нэр өөрчлөгдсөн;

5.1.5. хууль, холбогдох журамд заасан бусад үндэслэл.

5.2. Хадгалуулагч нь хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг энэхүү журмын 5.1-д заасан өөрчлөлт орсон өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан холбогдох баримт бичгийн хамт хадгалагчид гаргана.

5.3. Хадгалагч нь энэхүү журмын 5.2-т заасан баримт бичгийг ажлын 5 хоногт хянан шийдвэрлэнэ.

5.4. Хадгалагч нь шаардлагатай гэж үзвэл бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбоотой нэмэлт баримт бичгийг ирүүлэхийг хадгалуулагчаас шаардаж болно.

5.5. Энэхүү журмын хавсралт 3-т заасан мэдээлэл нь хадгалагчийн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэрийн салшгүй хэсэг байна.

ЗУРГАА. ХУВЬЦААГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

6.1. Хадгалуулагчийн хувьцааг дараах тохиолдолд хадгаламжаас хасна.

6.1.1. компанийн хэлбэрийг өөрчлөх тухай шийдвэр гаргасан;

6.1.2. хадгалуулагч нь дампуурсан, татан буугдсан, эсхүл дампуурах, татан буулгахтай холбоотой ажиллагааг эхлүүлсэн, дампуурлын хэрэг гүйцэтгэгч, татан буулгах комисс томилогдсон;

6.1.3. Дампуурлын тухай хууль, Банкны тухай хуульд заасны дагуу хууль хяналтын байгууллагын шийдвэр гарч, хадгалуулагчид хэрэг гүйцэтгэгч, бүрэн эрхт төлөөлөгч, эрх хүлээн авагч томилсон.

6.2. Хадгалуулагч нь хувьцаагаа үнэт цаасны хадгаламжийн байгууллагын бүртгэлээс хасуулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

6.3. Хадгалуулагч нь хувьцаагаа бүртгэлээс хасуулах хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт хадгалагчид гаргана.

6.4. Хадгалагч нь хувьцааг хадгаламжаас хасахтай холбоотой шаардлагатай гэж үзсэн нэмэлт баримт бичгийг ирүүлэхийг хадгалуулагчаас шаардаж болно.

6.5. Хадгалуулагч нь хувьцаа эзэмшигчийн өмнө хуулиар хүлээсэн аливаа үүргээ биелүүлээгүй нь түүний хувьцааг хадгаламжийн бүртгэлээс хасахгүй байх үндэслэл болно.

ДОЛОО. ХУВЬЦААНЫ ӨМЧЛӨХ ЭРХИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ

7.1. Хадгалуулагчаас ирүүлсэн албан бичиг, цахим болон хэвлэмэл хэлбэрээр ирүүлсэн хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлийг үндэслэн хадгаламжид хувьцаа эзэмшигч тус бүрийн нэрээр үнэт цаасны тоо ширхэгийн дагуу бүртгэлийг хөтлөнө.

7.2. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид дансаа нээлгээгүй хувьцаа эзэмшигчийн үнэт цаасыг хадгалуулагчийн дансанд түр бүртгэнэ.

7.3. Хадгалагч нь баримт хүлээн авсан дэс дарааллыг баримтлан өмчлөх эрх бүртгэх үйл ажиллагааг цахим тооцоолуурын сүлжээний тусламжтайгаар гүйцэтгэнэ.

НАЙМ. ӨМЧЛӨХ ЭРХ БУСДАД ШИЛЖСЭНИЙГ БҮРТГЭХ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

8.1. Хувьцааны өмчлөх эрх шилжүүлэн авч байгаа этгээд өмчлөх эрх шилжүүлэн бүртгүүлэх хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт ажлын 5 хоногийн дотор хадгалагч байгууллагад гаргана.

8.2. Хадгалагч нь хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, өв залгамжлах эрхийн гэрчилгээ, бэлэглэлийн гэрээ, хууль хяналтын болон эрх бүхий байгууллагын тогтоол шийдвэрийг үндэслэн өмчлөх эрхийг шилжүүлж бүртгэл хөтлөнө.

8.3. Хадгалагч нь худалдах, худалдан авах гэрээний дагуу дараах баримтыг үндэслэн хувьцааны өмчлөх эрх шилжсэнийг бүртгэнэ.

8.3.1. худалдах, худалдан авах гэрээний нотариатаар гэрчлүүлсэн эх хувь;

8.3.2. худалдах, худалдан авах гэрээний дагуу хийгдсэн төлбөр төлөгдсөн баримтын хуулбар эсхүл бэлнээр төлсөн бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

8.3.3. талуудын цахим үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.

8.4. Хадгалагч нь хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлд өв залгамжлалаар өөрчлөлт оруулах тохиолдолд дараах баримтыг үндэслэн хувьцааны өмчлөх эрх шилжсэнийг бүртгэнэ.

8.4.1. өвлөгчийн өв хүлээн авахыг хүссэн өргөдөл;

8.4.2. өв залгамжлах эрхийн гэрчилгээ;

8.4.3. өвлөгчийн цахим үнэмлэхний хуулбар;

8.4.4. өвлүүлэгчийн гэрээслэл.

8.5. Хадгалагч нь өв нээгдсэн тухай мэдэгдэл ирсэн тохиолдолд өвлөгчид шилжих хүртэл хугацаагаар өвлүүлэгчийн данснаас гүйлгээ хийхийг хориглоно.

8.6. Хадгалагч нь хувьцааны өмчлөх эрхийг бэлэглэлээр бүртгэх тохиолдолд Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 162 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бусдад бэлэглэх, өвлүүлэх тухай" журамд заасан баримт, материалыг үндэслэн бүртгэнэ.

8.7. Хадгалагч нь хууль хяналтын болон эрх бүхий байгууллагын хүчин төгөлдөр тогтоол, шийдвэр эсхүл үл маргах журмаар өмчлөх эрх шилжсэнийг бүртгэх тохиолдолд дараах баримтыг үндэслэнэ.

8.7.1. хувьцаа эзэмшигчийн хүсэлт, гэрээ дүгнэсэн акт;

8.7.2. шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудас.

8.8. Хадгалагч нь энэхүү журамд заасан өмчлөх эрхийн гүйлгээтэй холбоотой баримтын бүрдэл, шаардлага хангасан тохиолдолд өмчлөх эрх шилжсэнийг бүртгэх бөгөөд шаардлага хангаагүй тохиолдолд өмчлөх эрх шилжүүлэн бүртгэл хийхээс татгалзах эрхтэй.

8.9. Гүйлгээний баримт шаардлага хангахгүй тохиолдолд баримтын бүртгэл хөтлөж буцаан хүлээлгэн өгнө.

ЕС. ХУВЬЦААГААР ГЭРЧЛЭГДСЭН ӨМЧЛӨХ ЭРХЭЭР ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛ ХАНГАХ

9.1. Хаалттай хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй хувьцаагаар үүргийн гүйцэтгэл хангуулахаар зээлийн барьцааны зүйлд бүртгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд дараах шаардлагыг хангасан байна.

9.1.1 дансны үлдэгдэл нь үүргийн гүйцэтгэл хангах хувьцааны нэр төрөл, тоо ширхэгтэй хүрэлцэхүйц байх;

9.1.2 тухайн гүйлгээг хийх хугацаанд уг хувьцаа тусгаарлагдаагүй байх.

9.2. Хаалттай хувьцаат компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй хувьцааг зээлийн барьцаанд тусгаарлуулах бүртгэл хийлгэхэд дараах баримтыг бүрдүүлнэ.

9.2.1. үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлт;

9.2.2. хувьцаа эзэмшигчийн өөрийн эзэмшиж буй хувьцаагаар үүргийн гүйцэтгэл хангахыг зөвшөөрсөн тухай батламжийг 3 хувь үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байх;

9.2.3. хэрэв хуулийн этгээд өөрийн эзэмшлийн хувьцааг зээлийн барьцаанд тусгаарлуулах тохиолдолд тухайн компанийн эрх бүхий байгууллага /төлөөлөн удирдах зөвлөл байхгүй бол гүйцэтгэх захирал/-ын шийдвэр;

9.2.4. талуудын хооронд байгуулсан нотариатаар гэрчлүүлсэн зээлийн болон барьцааны гэрээ.

9.3. Хадгалагч нь хувьцааг үүрэг гүйцэтгэгчийн хүсэлт, талуудын гэрээ дүгнэсэн актыг үндэслэн тусгаарлалтаас чөлөөлнө.

9.4. Хадгалагч нь хувьцааг тусгаарлан бүртгэсэн болон тусгаарлалтаас чөлөөлсөн тухай мэдэгдлийг үүрэг гүйцэтгүүлэгчид албан бичгээр мэдэгдэнэ.

9.5. Хадгалагч нь үүрэг гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн дансанд дараах баримт, бичгийг үндэслэн хувьцааг шилжүүлнэ.

9.5.1. зээлийн гэрээ дүгнэсэн акт;

9.5.2. шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр.

9.6. Гэрээ дүгнэсэн актад хувьцааны нэр, тоо ширхэг, үнэ ханш, хүлээн авагчийн данс зэргийг тодорхой тусгасан байна.

АРВ. ХАРИЛЦАГЧИЙН ХҮСЭЛТ БОЛОН БУСАД ШААРДЛАГАТАЙ ТОХИОЛДОЛД ХУВЬЦААГ ТУСГААРЛАХ

10.1. Хадгалагч нь дараах тохиолдолд хувьцааг тусгаарлаж болно.

10.1.1 Хорооны улсын байцаагчийн албан шаардлага;

10.1.2 хууль хяналтын байгууллагын мэдэгдэл;

10.1.3 хувьцаа эзэмшигчийн өөрийн хүсэлт.

10.2. Хувьцааг тусгаарлалтаас чөлөөлөхдөө тусгаарлуулсан этгээд эсхүл дээд шатны албан тушаалтны шийдвэр, хувьцаа эзэмшигчийн хүсэлтийг үндэслэнэ.

10.3. Хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр тусгаарлагдсан хувьцааг тусгаарлах тухай хууль хяналтын байгууллагаас аливаа хүчин төгөлдөр шийдвэр ирүүлсэн тохиолдолд харилцагчийн хүсэлтийг үл харгалзан хууль хяналтын байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлнэ.

АРВАН НЭГ. МЭДЭЭ, СУДАЛГАА

11.1. Хадгалуулагчийн хүсэлтээр хатгалагч нь компанийн хувьцаа эзэмшигчдийн судалгааг дэлгэрэнгүй болон хураангуй хэлбэрээр гаргаж өгнө.

11.2. Хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр түүний хувьцаа эзэмшлийн талаарх тодорхойлолтыг монгол болон англи хэл дээр гаргаж өгнө.

АРВАН ХОЁР. ХАДГАЛАГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС, ХУРААМЖ, ШИМТГЭЛ

12.1. Энэхүү журамаар зохицуулсан хувьцааны бүртгэл, хадгалалт, бүртгэлд өөрчлөлт оруулах, өмчлөх эрх шилжүүлэх, бүртгэлээс хасах, хадгаламжид буй хувьцааны мэдээ, судлагаатай холбоотой аливаа үйлчилгээний шимтгэл, хураамжийн хувь хэмжээг хадгалагч, хадгалуулагчийн хооронд байгуулсан гэрээ болон хадгалагчийн тогтоосон журмаар зохицуулна.

АРВАН ГУРАВ. ХАРИУЦЛАГА

13.1. Хадгалагч өөрийн хадгаламжид хувьцааг бүртгэсэн нь уг хувьцаатай холбоотой аливаа эрсдлийн баталгаа болохгүй.

13.2. Хадгалагч хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй бүртгэлийн үнэн зөв байдлыг хариуцна.

13.3. Хадгалуулагч нь компанийн дүрэмд дурьдсан хувьцааны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулсан тухай бүр хадгалагчид албан бичгээр мэдэгдэн өөрчлөлт оруулах бөгөөд энэ тухай мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг хадгалагч тал хариуцахгүй.

13.4. Хадгалуулагч нь баримт бичгийг хуурамчаар бүрдүүлэх, нуун дарагдуулахыг хориглох ба үүнээс үүдэн гарсан хохирлыг хадгалагч тал хариуцахгүй.

13.5. Хувьцаа эзэмшигч нь худалдах, худалдан авах гэрээгээр бусдад өмчлөх эрхээ шилжүүлсэн, хувьцаа эзэмшигч хоорондоо аман болон аливаа хэлцэлээр өмчлөх эрхэд өөрчлөлт оруулсан тохиолдолд тухай бүр хадгалагч талд бүртгүүлэх бөгөөд бүртгүүлээгүйгээс үүдэн гарах эрсдлийг хадгалагч тал хариуцахгүй болно.

“Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх
эрх шилжүүлэх үйл ажиллагаа”-ны I дүгээр хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИД
ХУВЬЦАА БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Огноо:/...../....

Хаана: “.....” ХХК-д

.....
.....

(хаяг, утас, факс, шуудангийн ба электронишуудангийн хаяг)

Хэнээс:

/хуулийн этгээдийн нэр/

.....
.....

(хаяг, утас, факс, шуудангийн ба электронишуудангийн хаяг)

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 20... оны ... дугаар сарын-ны өдрийн Тоот
тогтоолыг үндэслэн үнэт цаасаа бүртгүүлэн хадгалуулах хүсэлт гаргаж байна.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

.....

/албан тушаал/

/тамга тэмдэг/

/...../ /...../

/гарын үсэг/

/овог, нэр/

“Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх
эрх шилжүүлэх үйл ажиллагаа”-ны 2 дугаар хавсралт

ХАДГАЛАМЖИД БҮРТГЭХ ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлт		Хувьцааны бүртгэл
Хувьцааны код:		
Хувьцааны нэр:		
Хувьцааны төрөл:		
Нийт хувьцааны тоо: /ширхэг/		
Хувьцаа эзэмшигч:	Овог нэр	
	Тоо /ширхэг/	
	Хувь /%/	
Хувьцаа эзэмшигч:	Овог нэр	
	Тоо /ширхэг/	
	Хувь /%/	
Хувьцаа эзэмшигч:	Овог нэр	
	Тоо /ширхэг/	
	Хувь /%/	
Нэрлэсэн үнэ: /төгрөг/		
Хувьцааны нийт үнийн дүн: /төгрөг/		

“Хаалттай ХК-ийн хувьцааг бүртгэх, хадгалах, өмчлөх
эрх шилжүүлэх үйл ажиллагаа”-ны 2 дугаар хавсралт

ХУВЬЦААНЫ ХАДГАЛАМЖИЙН БҮРТГЭЛД ОРОХ ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ

..... хаалттай хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын
.. оны дугаар сарын-ны өдрийн дугаар тогтоолыг үндэслэн хувьцааны
хадгаламжийн бүртгэлд дараах өөрчлөлтийг оруулав.

Үзүүлэлт	Хувьцааны бүртгэл
Хувьцааны код:	
Хувьцааны нэр:	
Хувьцааны төрөл:	
Нийт хувьцааны тоо:	
Нэгжийн нэрлэсэн үнэ: /төгрөг/	
Бүртгэлд орсон өөрчлөлт	
Нэмэгдсэн/хасагдсан/ хувьцааны тоо:	
Нэг бүрийн үнэ:	
Дүрмийн санг нэмэгдүүлэх /хасагдуулах/ дүн:	
Хувьцааг хуваах, нэгтгэх замаар өөрчилсөн тухай мэдээлэл:	
Нэрлэсэн үнэ өөрчилсөн тухай мэдээлэл:	
Хувьцааны нэр өөрчилсөн тухай мэдээлэл:	
Нийт гаргасан хувьцааны тоо: /ширхэг/	
Хувьцааны нийт үнийн дүн: /төгрөг/	

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын арван хоёрдугаар хавсралт

ХААЛТТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТУХАЙ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид Хороо гэх/ хаалттай хувьцаат компани /цаашид компани гэх/-д хэрэгжүүлэх хяналттай холбогдсон харилцааг зохицуулж хаалттай хувьцаат компанийн хувьцааг үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад /цаашид хадгаламжийн байгууллага гэх/ бүртгэх харилцааны зарчмыг тогтооход оршино.
- 1.2. Энэхүү журмаар компанийн хувьцааг хадгаламжийн байгууллагад бүртгэн хадгалах, хадгаламжид өөрчлөлт оруулах, хадгаламжаас хасахтай холбогдсон нарийвчилсан горимыг зохицуулахгүй бөгөөд Хорооноос тогтоосон журмаар зохицуулна /
- 1.3. Энэхүү журмаар хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх хадгаламжийн байгууллагад тавих нөхцөл, шаардлагыг тогтоохгүй бөгөөд Хорооноос баталсан бусад журмаар зохицуулна.

ХОЁР. Хаалттай хувьцаат компани ба түүний хувьцаа

- 2.1. Дараах бүх нөхцлийг хангасан хувьцаат компанийг хаалтгайд тооцно:
 - 2.1.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байх;
 - 2.1.2. Гаргасан хувьцаа нь нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэгдээгүй байх.
- 2.2. Хаалттай хувьцаат компани нь нээлттэй болон төрлөө өөрчлөх зорилгоор нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлснээс бусад тохиолдолд өөрийн хувьцаа, түүнийг худалдан авах эрхийн бичиг болон тэдгээрт хөрвөх үнэт цаасыг нийтэд санал болгохыг хориглоно.
- 2.3. Хаалттай хувьцаат компани нээлттэй болон төрлөө өөрчлөхөд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооноос баталсан нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийн журмыг баримтлана.
- 2.4. Хаалттай хувьцаат компанийн гаргасан хувьцаа зөвхөн хаалттай хүрээнд арилжаалагдана.
- 2.5. Хаалттай хүрээ гэдэгт үнэт цаасаа аливаа мэдээллийн хэрэгслийг ашиглан зарлаж сурталчилахгүйгээр худалдагч, худалдан авагч талуудын тохиролцсон гэрээний үндсэн дээр үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас гадуур худалдахыг ойлгоно.

ГУРАВ. Хаалттай хувьцаат компанийг бүртгэхийг зөвшөөрөх

- 3.1. Хадгаламжийн байгууллага хаалттай хувьцаат компанийн хувьцааг анх бүртгэх болон нэмж гаргаж байгаа хувьцааг бүртгэх хүсэлтийг хүлээн авч шаардлага хангасан гэж үзвэл компанийн ирүүлсэн эх бичиг баримтын нэг хувийг Хороонд заавал ирүүлнэ.
- 3.2. Хорооны дарга зөвхөн хувьцааг бүртгэхээс татгалзсан тохиолдолд шийдвэр гаргаж, уг шийдвэртээ татгалзах болсон үндэслэл, шалтгаанаа дурьдаж Хадгаламжийн байгууллагад хүргүүлэх бөгөөд шийдвэр гаргах хугацаа энэ журмын 3.1-т заасан бичиг баримтыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногоос хэтрэхгүй байна.

3.3. Энэ журмын 3.2-т заасан шийдвэрийг гаргахдаа ирүүлсэн бичиг баримт нь Компанийн тухай хууль тогтоомжид нийцсэн эсэх, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн эсэхийг харгалзана.

3.4. Энэ журмын 3.3-т заасан нөхцөл байдал арилсан нөхцөлд хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгүүлэх хүсэлтийг дахин гаргаж болно.

ДӨРӨВ. Хаалттай хувьцаат компанийн хувьцааг хадгаламжийн байгууллага бүртгэн хадгалах, хадгаламжид өөрчлөлт оруулах, хадгаламжаас хасах

4.1. Хадгаламжийн байгууллага хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах нөхцөл, хаалттай хувьцаат компаниас ирүүлэх бичиг баримтын бүрдлийг холбогдох хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.

4.2. Хувьцааны өмчлөх эрхийг бүртгэх, шилжүүлэхэд Хадгаламжийн байгууллагын үндэслэх бичиг баримт нь худалдагч, худалдан авагч талын хооронд байгуулсан гэрээ, өв залгамжлах эрхийн гэрчилгээ, бэлэглэлийн гэрээ, шүүхийн шийдвэр байх бөгөөд бусад шаардлагатай бичиг баримтыг хадгаламжийн байгууллага холбогдох хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.

4.3. Хадгаламжийн байгууллагын шаардах бичиг баримт нь хэлцэл хүчин төгөлдөр гэдгийг нотлоход зайлшгүй шаардлагатай бичиг баримт байна.

ТАВ. Хаалттай хувьцаат компанийн баримтлах журам

5.1. Хаалттай хувьцаат компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу нийтэд санал болгон үнэт цаас гаргасан нээлттэй хувьцаат компанийн үүргийг хүлээхгүй.

5.2. Хаалттай хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэхэд Хорооноос тогтоосон хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг баримтлана.

5.3. Хаалттай хувьцаат компани нь 50 буюу түүнээс доош тооны хувьцаа эзэмшигчтэй бол энэ журмын 5.2-т заасан журмыг мөрдөхгүй байж болно. Энэ тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх арга, журмыг компанийн дүрэмд заавал тусгана.

5.4. Хаалттай хувьцаат компани ньногдол ашиг хуваарилахдаа Хорооноос тогтоосон хувьцаат компанийн ногдол ашиг тараалтад хяналт тавих журмыг баримтлана.

5.5. Хаалттай хувьцаат компани нь 50 буюу түүнээс доош тооны хувьцаа эзэмшигчтэй бол энэ журмын 5.4-т заасан журмыг мөрдөхгүй байж болно.

5.6. Хаалттай хувьцаат компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авсан этгээд нь бусад хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааг худалдан авахаар санал болгохдоо Хорооноос тогтоосон журмыг баримтлана.

ЗУРГАА. Бусад

6.1. Хаалттай хувьцаат компанийн талаарх аливаа гомдлыг Хорооны маргаан таслах зөвлөлд гаргана.

6.2. Маргаан таслах зөвлөл нь талуудын гаргасан нотлох баримтад тулгуурлан шийдвэр гаргана. Маргаан таслах зөвлөлийн үйл ажиллагааг Хорооноос тогтоосон бусад журмаар зохицуулна.

ДОЛОО. Хариуцлага

7.1. Компанийн тухай хууль, энэ журмыг зөрчсөн этгээдэд маргаан таслах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Хорооны улсын байцаагч Компанийн тухай хуульд заасны дагуу хариуцлага ногдуулна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын арван гуравдугаар хавсралт

САНАЛ ХУРААХ КУМУЛЯТИВ АРГА

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Энэ журмыг зөрчиж ТУЗ-ийн гишүүдийг сонгосон тохиолдолд тухайн сонгуулийн дүн хүчингүй болно.

ХОЁР.ТУЗ-ИЙН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ СОНГОХ

2.1. Кумулятив аргыг хэрэглэхэд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн нэг хувьцаа нь компанийн дүрмээр тогтоосон ТУЗ-ийн нийт гишүүдийн тоотой тэнцүү саналын эрхтэй байна.

2.2. Кумулятив аргыг хэрэглэж, сонгогдсон ТУЗ-ийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

ГУРАВ.САНАЛ ӨГӨХ

3.1. Хувьцаа эзэмшигч энэ журмын 2.1-д заасан саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг, эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

Жишээ нь: Хувьцаа эзэмшигч А нэр бүхий ХК-ийн 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг. Тус компанийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй, үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоожээ. Хувьцаа эзэмшигч А-ийн 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй болно.

Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.

ДӨРӨВ.САНАЛЫН ЭРХИЙГ ТООЛОХ

4.1. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тус тусад нь тоолно. Ердийн гишүүдийг сонгох тооллогоор хамгийн олон саналын эрх авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр, хараат бус гишүүдийг сонгох тооллогоор хамгийн олон саналын эрх авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр тус тус сонгоно.

Жишээ нь: “С” ХК-ийн дүрмээр ТУЗ нь 9 гишүүнтэй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрх бүхий нийт 1,000 ширхэг хувьцааг эзэмшиж байгаа 6 хувьцаа эзэмшигч оролцсон. ТУЗ-ийн 6 энгийн, 3 хараат бус гишүүнийг тус тус сонгохоор саналын эрхийг тоолно.

Хувьцаа эзэмшигч А - 10; Хувьцаа эзэмшигч Б - 40; Хувьцаа эзэмшигч В - 50; Хувьцаа эзэмшигч Г - 200; Хувьцаа эзэмшигч Д - 300;

Хувьцаа эзэмшигч Е - 400 ширхэг хувьцааг тус тус эзэмшдэг.

Саналын хуудаст нийт 14 иргэн /8 иргэн ердийн, 6 иргэн хараат бус/ ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн /Нэр дэвшигчдийг 1-14 гэж дугаарлав/.

Журамд зааснаар ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо ердийн болон хараат бус гишүүдээр нь зааглаж, саналын эрхийг тусад нь тоолно. Кумулятив аргыг хэрэглэхэд хуралд оролцож буй 6 хувьцаа эзэмшигчийн 1,000 ширхэг хувьцаа 9-өөр үржигдэн нийт 9,000 саналын эрхтэй болсон.

Доорх хүснэгтээр үзэхэд, ТУЗ-ийн ердийн гишүүнд 1, 2, 3, 4, 6, 7 гэсэн дугаар бүхий 6 нэр дэвшигч, хараат бус гишүүнд 9, 10, 14 гэсэн дугаартай 3 нэр дэвшигч хамгийн өндөр оноог авснаар сонгогдоно.

Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	ТУЗ-ийн гишүүний тоо	Нийт саналын эрхийн тоо	ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын эрхийн хуваарилалт								Хараат бус гишүүнд нэр дэвшигчдэд өгсөн саналын эрхийн хуваарилалт					
				1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
А	10	9	90	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	90
Б	40	9	360	0	0	0	0	0	0	0	0	0	360	0	0	0	0
В	50	9	450	0	0	0	0	0	0	0	0	0	450	0	0	0	0
Г	200	9	1,800	900	300	0	0	0	0	0	0	600	0	0	0	0	0
Д	300	9	2,700	0	600	0	0	0	600	0	0	400	0	0	600	0	500
Е	400	9	3,600	0	0	900	900	0	400	900	0	0	0	0	200	0	300
Дүн	1,000	9	9,000	900	900	900	900	0	1000	900	0	1000	810	0	800	0	890

Жич: Дээрх жишээнээс үзэхэд, ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох тооллогоор хамгийн өндөр саналын эрх авсан нэр дэвшигчдээс хамгийн багадаа 900 саналын эрх авсан нэр дэвшигч сонгогдсон бол хараат бус гишүүний хувьд хамгийн багадаа 810 саналын эрхээр сонгогдсон байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын арван дөрөвдүгээр хавсралт

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНЫ ХЯНАЛТ ТАВИХ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, Хорооноос батлан гаргасан журмын дагуу үнэт цаас гаргагчаас ирүүлсэн болон бусад мэдээлэлд үндэслэн хувьцаат компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавьж, дүгнэлт өгөх, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийн талаар нийтэд мэдээлэл хүргэх, хууль хэрэгжүүлэх талаар хугацаатай үүрэг даалгавар өгөх, захиргааны хариуцлага оногдуулах, үйл ажиллагааг нь түр зогсоох зэргээр хууль хэрэгжүүлэх ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж, Хорооноос тогтоосон журамд заасан мэдээллийг тогтоосон хугацаанд, тогтоосон хэлбэрээр Хороонд ирүүлж байна.

ХОЁР. ХК-ийн ээлжит хурлыг хуралдуулсан Байдалд хяналт тавих

2.1. “Компанийн тухай” хуулийн 60.3-т заасны дагуу ХК нь хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг тайлангийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу 5 дугаар сарын 1 гэхэд хуралдуулж, компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт болон хуулиар хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулсан бусад асуудлыг хэлэлцэж батлах ёстой. Мөн хуулийн 61.1-д заасны дагуу хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай шийдвэрийг компанийн ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэрт:

1/ хурал хуралдах газар, өдөр, цаг;

2/ хурлаар хэлэлцэх асуудал;

3/ хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр;

4/ хуралд бэлтгэх явцад хувь нийлүүлэгчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, цаг;

5/ санал авах хуудсын агуулга;

6/ санал авах хуудсыг хүлээн авах сүүлчийн өдөр зэргийг заасан байх ёстой.

2.2. Хурал хуралдуулах шийдвэр гаргасанаас хойш 10 хоногийн дотор Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам”-д заасны дагуу “Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хороонд ирүүлнэ. Энэ мэдэгдэл болон хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнд холбогдох бичиг баримтад үндэслэн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрт “Компанийн тухай” хуулийн 60.2-т заасан зүйлсийг бүрэн тусгасан эсэх, хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдуулахаар зарласан эсэх, хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт орсон эсэх, хурлаар хэлэлцэх асуудлын талаархи мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөлтэй танилцах боломж хувьцаа эзэмшигчид олгосон эсэх, энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигчдэд хурлаар хэлэлцэх асуудалд санал

оруулах, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшүүлэх, санал ирүүлэх тухай мэдэгдлийг бичгээр хүргэсэн эсэх, хурал хуралдуулах өдөр, цаг, газар нь сонирхсон хувьцаа эзэмшигч хуралд оролцох боломж, нөхцлийг хангаж байгаа эсэх, компанийн төв захиргаа оршин байгаа газраас өөр газарт хуралдуулахаар тогтоосон бол хувьцаа эзэмшигчдийн олонх нь оршин сууж байгаа газрыг сонгосон эсэх зэрэгт хяналт тавина.

2.3. Эдгээр шаардлагыг хангаагүй байвал Улсын байцаагчийн шаардлагаар залруулах үүрэг хүлээлгэнэ. Цаг хугацааны хувьд залруулах арга хэмжээ авах боломжгүй болсон, эсхүл байцаагчийн шаардлагад заасан хугацаанд залруулах арга хэмжээ аваагүй нь хувьцаа эзэмшигчийн хуралд оролцож санал өгөх, мэдээлэл авах эрхийг ноцтой зөрчихөд хүргэнэ гэж үзвэл хурлыг дахин зарлан хуралдуулах шаардлага тавина.

2.4. Хорооны дээр заасан журмын дагуу хурлын тухай мэдээллийг хувь нийлүүлэгчдийн хурал хуралдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд хүргэх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр нийтэд хүргэж байгаа байдалд Монголын хөрөнгийн бирж хяналт тавьж, Хороонд мэдээлж байна.

2.5. Жил бүрийн 4 дүгээр сарын 1 гэхэд “Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл”- ийг Хороонд ирүүлээгүй хувьцаат компанийн хяналтын зөвлөлд ээлжит хурлаа хууль, журамд нийцүүлэн хуралдуулах тухай хугацаатай шаардлагыг хүргүүлж, биелүүлээгүй бол “Компанийн тухай” хуулийн 59.7-д заасны дагуу хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргаагүй бол Санхүүгийн зохицуулах хороо тухайн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болсныг нийтэд мэдээнэ.

2.6. “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 20.1.8-д хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг нийтэд нэн даруй мэдээлж, холбогдох баримт бичиг, мэдээллийг хурал хуралдсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Хороо, хөрөнгийн биржид хүргүүлэх.

Хороонд ирүүлсэн хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл, шийдвэрийг үндэслэн хурлын ирц “Компанийн тухай” хуулиар болон компанийн дүрмээр тогтоосон хурал хүчин төгөлдөр байх хэмжээнд хүрсэн эсэх, хурлыг зарласан хугацаанд, зарласан байранд хуралдуулсан эсэх, хурлаар хэлэлцсэн асуудал нь ТУЗ-ийн хуралд хуралдуулах тухай шийдвэрт заасан асуудалтай тохирч байгаа эсэх, хурлаас гарсан шийдвэр нь хууль, тогтоомж болон компанийн дүрэмд нийцэж байгаа эсэх, хурлын явцад хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг ямар нэг байдлаар хязгаарласан эсэхэд хяналт тавина.

2.7. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй бөгөөд шаардлагатай гэж үзвэл Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг нэмж оруулах журмыг компанийн дүрэмд зааж болно.

2.8. Хурлыг нийтэд зарлалгүй хуралдуулсан, зарласан хэдий ч хугацаа нь Хорооноос тогтоосон журмыг зөрчсөн, хурлын ирц “Компанийн тухай” хуулиар болон компанийн дүрмээр тогтоосон хурал хүчин төгөлдөр байх хэмжээнд хүрээгүй бол хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэх бөгөөд энэ тухай дүгнэлтийг Улсын ахлах байцаагч гаргаж, хууль журамд нийцүүлэн дахин хуралдуулах шаардлагыг бичгээр гаргаж, хүргүүлнэ.

ГУРАВ. ХК-ийн санхүүгийн тайланд үндэслэн тавих хяналт

3.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6-д зааснаар хагас жилийн болон болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлэх үүрэгтэй.

Жил бүрийн 2 дугаар сарын 20-ны дотор ХК-ийн жилийн санхүүгийн тайланг хүлээн авч, аудитаар баталгаажуулсан эсэх, уг тайланд Сангийн сайдын 2004 оны 12 дугаар сарын 22-ны

өдрийн 248 тоот тушаалаар баталсан “Санхүүгийн тайлан, түүний тодруулга бэлтгэх заавар”, Хорооноос баталсан “Үнэт цаас гаргагч, үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах байгууллагад мөрдөх дансны үлгэрчилсэн жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, санхүүгийн тайлангийн тодруулгын маягт”-д заасан нэмэлт тайлбар, тодруулгыг бүрэн тусгасан эсэх, үзүүлэлтүүдийн хоорондын тохироо барьж байгаа эсэх, өнгөрсөн үеийн тайлангийн эцсийн үлдэгдэл нь тухайн тайлангийн эхний үлдэгдэлтэй тохирч байгаа эсэхийг хянана.

3.2. Хувь нийлүүлсэн хөрөнгө гэсэн хэсэгт тусгагдсан үзүүлэлтүүд нь Хороонд бүртгэлтэй хувьцааны бүртгэлийн үзүүлэлтүүдтэй тохирч байгаа эсэх, хувьцааны тоо ширхэг, нэрлэсэн үнэ зэргийг балансад зөв тусгасан эсэхийг хянана.

3.3. Халаасны хувьцаа авсан бол энэ тухай Хороонд мэдэгдсэн эсэх, халаасны хувьцааг авах, зарах тухай шийдвэрийг зохих хууль журмын дагуу гаргасан эсэх зэргийг хянана.

3.4. Хөрөнгө оруулалт гэсэн хэсэгт тусгасан дүнд өөрчлөлт гарсан бол ямар шалтгааны улмаас өөрчлөлт гарсан энэ тухай мэдээлэл ирүүлсэн эсэхийг хянана.

3.5. Хороонд өмнө нь ирүүлсэн мэдээлэлд тусгагдсан үйл явдлыг санхүүгийн тайлан болон түүний тодруулгад тусгасан эсэх, тусгасан бол энэ нь өмнө ирүүлсэн мэдээлэлтэй тохирч байгаа эсэхийг хянана.

3.6. Өнгөрсөн тайлангийн жилд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан компанийн хувьд ногдол ашгийн хуваарилалтыг санхүүгийн тайланд хэрхэн тусгасан энэ нь “Ногдол ашгийн тайлан”-гийн үзүүлэлттэй тохирч байгаа эсэхийг шалгана.

3.7. Ашигтай ажилласан компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн асуудалд ногдол ашиг хуваарилах эсэх тухай асуудал, хуваарилахгүй бол шалтгааныг тайлагнах тухай асуудлыг оруулсан эсэхэд хяналт тавина.

ДӨРӨВ. Мэдээллийн санд ирүүлсэн мэдээлэлд үндэслэн тавих хяналт

4.1. ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тухай болон өөрчлөгдсөн тухай мэдээлэлд үндэслэн ТУЗ-ийн сонгох асуудлыг хуульд нийцүүлэн хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэсэн эсэх, гишүүд нь “Компанийн засаглалын кодекс”- т заасан шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт тавина. Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад өөрчлөлт оруулна.

4.2. ХК-ийн их хэмжээний хэлцэл хийсэн тухай мэдээлэлд үндэслэн уг хэлцлийг хуульд нийцүүлэн эрх бүхий удирдах байгууллагын хурлаар шийдвэрлэсэн эсэх, энэ хэлцлийг хийсэнтэй холбогдон компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварт мэдэгдэхүйц өөрчлөлт орсон бол энэ талаар зээлдүүлэгчдэд мэдэгдсэн эсэхэд хяналт тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.3. ХК-ийн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн тухай мэдээлэлд үндэслэн уг хэлцлийг хуульд нийцүүлэн эрх бүхий удирдах байгууллагын хурлаар хараат бус гишүүдийн саналаар шийдвэрлэсэн эсэх, энэ хэлцлийн талаар хувь нийлүүлэгчдэд мэдээлэл үүргээ хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.4. ХК... оны /улирлын/ ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийн үндэслэлийг хянаад, Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулга болон ногдол ашиг тарааж байгаа компанийн тухай мэдээлэлд нэмэлт оруулна.

4.5. ХК-ийн хувьцааны ногдол ашгийн тайланг үндэслэн ногдол ашгийг зарласан хугацаандаа тараасан эсэхэд хяналт тавьж, тараагдаагүй үлдэгдлийг санхүүгийн тайланд өр болгон тусгасан эсэхийг шалгана. Нэгдсэн судлагаанд оруулж, ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.6. ХК өөрийн үнэт цаасыг худалдан авсан, худалдсан тухай мэдээнд үндэслэн өөрийн үнэт цаасыг худалдан авах талаар хууль, журамд заасан шаардлагыг хэрхэн биелүүлсэнд хяналт

тавьж, мэдээллийг нэгдсэн судлагаанд оруулж, ХК-ийн хувийн хэрэгт хадгална. Дараа нь жил улирлын санхүүгийн тайлан ирүүлсэн үед тайлангийн үзүүлэлттэй тулган шалгана.

4.7. ХК-ийн эрх бүхий албан тушаалтны өмчлөлд байгаа хувьцааны багцад өөрчлөлт гарсан тухай мэдээлэлд үндэслэн хуульд заасан мэдэгдлийг ирүүлсэн эсэх, ТУЗ-ийн хараат бус гишүүн хувьцаа эзэмшигч болсон эсэх, хувьцааны багц эзэмшигч өөрчлөгдсөн эсэх зэрэгт хяналт тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.8. ХК охин /хараат/ компанитай болсон, /хяналтаа шилжүүлсэн/ тухай мэдээлэлд үндэслэн энэ асуудлыг хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэсэн эсэхэд хяналт тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална. Дараа нь жил улирлын санхүүгийн тайлангийн “хөрөнгө оруулалт” гэсэн үзүүлэлттэй тулган шалгана.

4.9. ХК-ийн төрийн /орон нутгийн/ өмчлөлийн хувьцаа худалдагдсан тухай мэдээлэлд үндэслэн нэгдсэн судалгаа гаргаж, үүнтэй холбогдон бусад хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээг ТУЗ авч хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавина.

4.10. ХК-ийн хувьцааны хяналтыг багцыг нэгдмэл сонирхолтой этгээд эзэмших болсон тухай мэдээлэлд үндэслэн эдгээр этгээд хуулиар бусад хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавьж, биелүүлээгүй бол шаардлага хүргүүлнэ.

4.11. ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийг өөрчлөн байгуулах төслийг баталсан тухай мэдээлэлд үндэслэн уг мэдээллийг хувьцаа эзэмшигчиддээ хүргэсэн эсэхэд хяналт тавьж, Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулга болон өөрчлөн байгуулагдаж байгаа компанийн тухай мэдээлэлд нэмэлт оруулна.

4.12. Компанийн томоохон зээлдүүлэгчид, харилцагчдын тухай мэдээлэлд үндэслэн сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгдэж байгаа эсэх, компанийн ТУЗ-д томоохон зээлдүүлэгчид, харилцагчдын төлөөлөл байгаа эсэхэд хяналт тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.13. Компанийн нэр, төв захиргааны оршин байх газар өөрчлөгдсөн тухай мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална. Улсын бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулсан эсэхэд хяналт тавина.

4.14. Компанийн салбар, төлөөлөгчийн газрын тухай мэдээлэлд үндэслэн салбар, төлөөлөгчийн газрыг байгуулах шийдвэрийг компанийн дүрмийн дагуу гаргасан эсэхийг хянаж, мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална. Улсын бүртгэлд холбогдох өөрчлөлт оруулсан эсэхэд хяналт тавина.

4.15. Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд гарсан өөрчлөлтийн тухай мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина.

4.16. Компанийн аудиторыг сонгон гэрээ байгуулсан, өөрчилсөн тухай мэдээлэлд үндэслэн хараат бус байх шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянаад, мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. Дараа нь санхүүгийн тайлан ирсэн үед тайланг баталгаажуулсан аудитийн компани мөн эсэхийг хянаана. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.17. Компанийн дүрэмд орсон өөрчлөлтийн тухай мэдээлэлд үндэслэн дүрмийн өөрчлөлт нь “Компанийн тухай” хуульд нийцэж байгаа эсэхийг хянаад, ХК-ийн хувийн хэрэгт хадгална. Хуульд нийцээгүй өөрчлөлт оруулсан бол яагаад нийцээгүй болох тухай болон хэрхэн залруулах талаар шаардлага хүргүүлж, улсын бүртгэлийн албанд энэ тухай мэдээлэл хүргэнэ.

4.18. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /дүрмийн сан/ -г нэмэгдүүлэх, хорогдуулах төслийг ТУЗ баталсан тухай мэдээлэлд үндэслэн шийдвэрийг хууль, компанийн дүрмийн дагуу гаргасан эсэхийг хянаж, мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. Дараа нь Хороонд ирүүлсэн хувьцааны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлттэй тулган шалгана.

4.19. Компанийн үл хөдлөх хөрөнгийг худалдсан, барьцаалсан, ямар нэг хэлбэрээр бусдад шилжүүлсэн тухай мэдээлэлд үндэслэн шийдвэрийг хууль, компанийн дүрмийн дагуу гаргасан эсэхийг хянаж, их хэмжээний хэлцэлд хамаарахаар бол мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. Дараа нь санхүүгийн тайлан ирүүлсэн үед мөнгөн гүйлгээний тайланд тусгагдсан мэдээлэлтэй тулган шалгана. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.20. Компанийн үйл ажиллагаа, хяналтын багц эзэмшигчид болон ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтнуудын үйлдэлтэй холбоотой асуудлаар хууль хяналтын байгууллагад хэрэг үүсгэсэн, эсхүл тэдгээр этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдож, хуулийн дагуу шийтгэгдсэн тухай мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. Шийтгэгдээгүй боловч хэрэг үүсгэсэн бол энэ нь тухайн этгээдийг тохиромжтой этгээд гэж үзэхэд ямар нэг нөлөө үзүүлэх эсэх асуудлаар шалгалт хийж, дүгнэлт өгнө. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.21. Нийтэд санал болгон шинээр болон нэмж үнэт цаас гаргах төслийг ТУЗ, хувь нийлүүлэгчдийн хурлаар баталсан тухай мэдээлэлд үндэслэн шийдвэрийг хууль, компанийн дүрмийн дагуу гаргасан эсэхийг хянаж, мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална. Төсөл болон холбогдох баримтыг Хороонд хугацаанд нь ирүүлж, үнэт цаас бүртгүүлэх хүсэлтээ гаргасан эсэхийг хянана. Ирүүлсэн үед нь мэдээллийг тулган шалгана.

4.22. Компанийн үл хөдлөх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийлгэсэн тухай тайланд үндэслэн санхүүгийн тайланд өөрчлөлт оруулсан эсэх, оруулсан бол зөв бүрэн тусгасан эсэхэд хяналт тавьж, мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.23. Компанийн борлуулалтын орлогын 10-аас дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл хүчингүй болсон, лицензийг худалдсан, барьцаалсан, аливаа хэлбэрээр шилжүүлсэн тухай мэдээлэлд үндэслэн уг шийдвэрийг хууль болон компанийн дүрэмд заасан журмын дагуу гаргасан эсэхийг хянаад, мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. Энэ тухай санхүүгийн тайланд тусгагдсан эсэхийг хянана. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.24. Компанийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбогдон үүсч болох эрсдэлийн тухай мэдээллийг Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.25. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны арилжааны тайланг үндэслэн үнэт цаасыг бүртгэх тухай Хорооны шийдвэр, арилжааны ханш тогтолтод хяналт тавьж, Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

4.26. Хувь нийлүүлэгчдийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдуулах тухай мэдэгдэлд үндэслэн ээлжит хурлыг хуулиар тогтоосон хугацаанд хуралдуулахаар зарласан эсэх, ээлжит бус хурлыг эрх бүхий этгээд зарлаж байгаа эсэхэд хяналт тавьж, Хорооны веб хуудсанд байгаа ХК-ийн танилцуулгад тавина. ХК-ийн хувийн хэрэгт хадгална.

ТАВ. Компанийн засаглалын кодекст үндэслэх хяналт

5.1. Кодексийн хэрэгжилтэд ирүүлсэн мэдээлэлд тулгуурлан хяналт тавьж, жилийн эцэст кодексийн хэрэгжилтэд дүгнэлт өгнө.

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн Өргөдөл гомдолд үндэслэх хяналт

6.1. Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн өргөдөл гомдлын дагуу шалгалт хийж, өргөдөл дурьдсан гомдлын дагуу албан шаардлага хүргүүлэх, боломжтой бол Хороонд байгаа мэдээлэлд үндэслэн хариу өгөх арга хэмжээ авна.

6.2. Өргөдлийн дагуу шаардлага хүргүүлсэн бол хугацаанд нь ирүүлж байгаа эсэхэд хяналт тавина. Хугацаанд нь хариу ирүүлээгүй, ирүүлсэн хариу болон холбогдох эс үйлдэл, үйлдлээс үндэслэн компани нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг зөрчсөн, тэдэнд хохирол учруулсан гэсэн дүгнэлт гаргасан бол хувийн хэрэгт нь байгаа зөрчлийн тэмдэглэлд бичилт хийнэ. Компанийн ямар албан тушаалтанд хандсанд хариу ирүүлээгүй, эсхүл ямар албан тушаалтан тухайн зөрчил, хууль бус үйлдэлд буруутай гэж үзсэн тухайгаа тэмдэглэх бөгөөд энэ нь тухайн этгээдийг тохиромжтой этгээд биш гэж тооцох үндэслэл болж болно.

ДОЛОО. Олон нийтийн мэдээллийн Хэрэгслийн мэдээнд үндэслэх хяналт

7.1. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, радио, телевиз, портал сайтүүд, сонин зэрэг мэдээллийн хэрэгсэлд гарсан компанийн тухай мэдээллийг боломжит хэлбэрээр цуглуулан хувийн хэрэгт хадгалах нь компанийн зайны хяналт хариуцсан мэргэжилтний үүрэг байна. Хорооны бусад ажилтнууд ч Хорооны хяналт, зохицуулалтад байгаа байгууллагуудын талаарх аливаа мэдээллийг харсан, сонссон, уншсан тухайдаа хариуцсан ажилтанд нь мэдээлэхийг өөрийн мэргэжлийн үүрэг гэж үзнэ.

7.2. Мэдээллийн хэрэгслээс мэдээлэл авах боломжоор аль болох хангахын тулд Ажлын албан холбогдох арга хэмжээ авна.

7.3. Мэдээллийн хэрэгслээс авсан мэдээллийг боломжит хэлбэрээр /хэвлэгдсэн бол цаасаар, сонссон үзсэн бол тэмдэглэж, сайтаас авсан бол файл хэлбэрээр/ компанийн хувийн хэрэгт хадгалах бөгөөд энэ мэдээлэл нь мэдээллийн сангийн журмаар Хороонд ирүүлэх ёстой бол ирүүлсэн эсэхийг, ирүүлсэн бол агуулгын хувьд ижил байгаа эсэхийг хянаана. Мэдээлэл нь компанийн үнэт цаасны арилжааны идэвх, үнэ хашид нөлөөлж болно гэж үзэж байвал энэ талаар компаниас тайлбар шаардана.

7.4. Мэдээлэл нь компанийн болон удирдлагын үйл ажиллагаатай холбоотой шүүмжлэл байвал хувийн хэрэгт тэмдэглэн ээлжит шалгалтын үед үндэслэлийг шалгана. Компанийн хувь заяанд ноцтой нөлөөлж болох үйл явдлын тухай мэдээллийн мөрөөр шалгалт хийж болно. Энэ асуудлаар газрын хэмжээнд зөвлөлдөөд, ажлын албанд танилцуулж, шалгалт хийх шаардлагатай эсэх талаар шийдвэр гаргана.

НАЙМ. Төрийн болон бусад байгууллагаас ирүүлсэн гомдол, хүсэлт бусад мэдээлэлд үндэслэх шалгалт

8.1. Бусад байгууллагаас Хороонд ирүүлсэн хүсэлт, гомдол, мэдээлэл нь аль нэг ХК- тай холбогдолтой бол уг баримтыг хүлээн авсан ажилтан хариуцсан мэргэжилтэнд нь заавал танилцуулж, хувийн хэрэгт нь оруулна.

8.2. Хүлээн авсан гомдол хүсэлт, мэдээллийн дагуу хариу өгөх, мэдээлэл хүргүүлэх зэрэг шаардлагатай арга хэмжээ аваад, хэрэв мэдээлэл нь ХК-ийн болон түүний эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой ямар нэг зөрчил дутагдлын тухай бол хувийн хэрэгт байгаа зөрчлийн тэмдэглэлд тэмдэглэнэ.

ЕС. Зайны хяналтыг дүгнэх

9.1. Жил бүрийн 1-р улиралд ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн зайны хяналтын дүнг гаргаж, нэгтгэн Хороонд танилцуулж байна.

9.2. Зайны хяналтын дүнг Компанийн засаглалын байдалд өгсөн дүгнэлт хэлбэрээр гаргаж, “сайн”, “дунд”, “хангалтгүй” гэсэн үнэлгээ өгнө. Хангалтгүй гэсэн үнэлгээ нь уг компанийн эрх бүхий албан тушаалтанд тохиромжтой этгээд гэсэн дүгнэлт өгөхөөс татгалзах, арилжаа эрхлэх байгууллагын жагсаалтаас хасах санал хүргүүлэх, нэмж гаргах үнэт цаасыг бүртгэхээс татгалзах үндэслэл болно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын арван тавдугаар хавсралт

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС

ОРШИЛ

Кодексийн зорилго

Компанийн засаглалын кодекс (цаашид "кодекс" гэх)-ийн зорилго нь компанид засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг нэвтрүүлэх замаар хөрөнгө оруулагч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, урт хугацаанд тогтвортой үнэ цэн бүтээхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Компанийн засаглал нь компанийн үйл ажиллагааг чиглүүлэх, хянах тогтолцоо бөгөөд байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, гүйцэтгэлийн хяналтын арга замыг тогтоох, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо юм. Мөн энэ ойлголтод хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцаа багтана.

Компанийн засаглалын хэрэгжилтийг хариуцах гол субъект нь төлөөлөн удирдах зөвлөл. Хувьцаа эзэмшигч нь төлөөлөн удирдах зөвлөл болон хөндлөнгийн аудитаар дамжуулан компанид зохистой засаглалын бүтэц, зохион байгуулалт бүрэлдсэн эсэхэд хяналт тавина. Компанийн засаглалын сайн туршлагыг хэрэгжүүлснээр тухайн компанийн үнэлгээ өсөх, өртөг багатай санхүүжилтийн эх үүсвэр татах, урт хугацаанд тогтвортой хөгжихөд ач холбогдолтой.

Кодексийн үйлчлэх хүрээ

Энэхүү кодекс заасан компанийн засаглалын зарчмуудын зүйл тус бүрийг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас гаргагч, даатгагч, итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг компани дагаж мөрдөнө. Үнэт цаасаа нийгэд арилжаалдаггүй хаалттай компанийн хувьд кодекс заасан зарчмуудыг нэвтрүүлж, хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Кодексийг хэрэгжүүлэх арга

Компани энэхүү кодексийн засаглалын зарчмуудыг бүрэн хэрэгжүүлэхийг эрмэлзэх ба компанийн үйл ажиллагааны онцлог, бүтэц, хэмжээ, хөгжлийн үе шат зэргээс шалтгаалан зарим нэг зүйлийг тухайлан хэрэгжүүлэх бололцоогүй, эсвэл зохион байгуулалтын илүү зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлж болно.

Кодексийн хэрэгжилтийг олон улсад түгээмэл тогтсон "Хэрэгжүүл, эсвэл тайлбарла" гэсэн зарчмаар хангана. Өөрөөр хэлбэл, компани засаглалын зарчмуудын хэрэгжилтийг тайлагнахдаа кодекс дурдсан зүйл тус бүрийг хэрхэн биелүүлсэн, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бүтэц, зохион байгуулалтын ямар арга хэмжээ авсан, биелүүлэх зорилт тавьсан бол хэрэгжүүлэх хугацааг энэхүү кодексийн хавсралт 1-ийн маягтын дагуу дэлгэрэнгүйгээр тайлбарлах үүрэгтэй. Жич: Хэрэгжилт болон тайлбарыг зүйл тус бүрээр гаргана.

Компани кодекс заасан засаглалын зарчмуудын хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа тайлагнах бөгөөд засаглалын тайланг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон компанийн цахим хуудсанд байршуулна. Жилийн үйл ажиллагааны тайланд байршуулахдаа "компанийн засаглалын зарчмуудын хэрэгжилт" гэсэн тодорхой, ойлгомжтой нэршилтэй бие

даасан бүлэг болгох, цахим хуудсанд байршуулахдаа шууд харагдахуйц "бидний тухай", "хөрөнгө оруулагчдад" гэсэн ангилалд уг холбоосыг байршуулна.

Компанийн засаглалыг сайжруулж, бэхжүүлэх нь тогтмол үргэлжлэх үйл явц тул жилд нэг удаа тайлагнаад орхих бус, төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн засаглалаа хэрхэн сайжруулах талаар хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, оролцогч талуудтай байнга зөвлөлдөж, мэдээлэл солилцон шаардлагатай арга хэмжээг тухай бүр авна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэхүү кодексийн хавсралт 2 болох "Компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэх хөтөлбөр"-ийн үлгэрчилсэн загварыг ашиглан дотооддоо мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журмыг өөрийн онцлогт нийцүүлэн баталгаажуулж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ЗАРЧМУУД, ТАЙЛБАР

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ҮНДСЭН 9 ЗАРЧИМ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт

"Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна."

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг

"Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаагаа тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг өөрөө хүлээнэ."

3. Тайлагнал, мэдээллийн ил тод байдал

"Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн зөв, бүрэн бүтэн, тэнцвэртэй байдлыг хангах арга хэмжээг авч ажиллана."

4. Аудит, хяналтын тогтолцоо

"Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана."

5. Эрсдэлийн удирдлага

"Компани эрсдэлийн удирдлагын тогтолцоог зүй зохистой, хараат бус байдлаар зохион байгуулж, уг тогтолцооны үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина."

6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал

"Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна."

7. Оролцогч талуудын эрх ашиг

"Компани нь үйл ажиллагаа явуулахдаа бусад оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэнэ."

8. Компанийн соёл

"Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанидаа бизнесийн ёс зүй, хариуцлагын өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтанд мөрдлөг болгон хэвшүүлнэ."

9. Хувьцаа эзэмшигчдийн эрх

"Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, холбогдох мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана."

НЭГДҮГЭЭР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Төлөөлөн удирдах зөвлөл нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна

1.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмаар төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.

Тайлбар 1. Зарим компанийн үйл ажиллагаанд төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын ажил үүргийн хуваарь тодорхой бус, мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаа, уялдаа муу байдал тохиолддог тул эдгээрийг нарийвчлан зохицуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамтай байх шаардлагатай. Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан компанийн үнэт зүйлс, ёс зүйн дүрэм, төсөв, эрсдэлийн хязгаарын хүрээнд компанийн стратегийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх ба гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн чиг үүргээс тодорхой заагласан байна;

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд түүний дарга болон гишүүдийн эрх, үүргийг нарийвчлан тодорхойлно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, гишүүдийг чиг үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангах, төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын хооронд харилцан хүндлэл, итгэлцэл дээр тулгуурласан ажил хэрэгч харилцааг үүсгэн бэхжүүлэх үүргийг хүлээнэ. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хуралдаанаар хэлэлцэх асуудлыг баталж, асуудал тус бүрийг хэлэлцэж, шийдвэр гаргах хангалттай боломж, цаг хугацаагаар хангах үүрэгтэй;

Тайлбар 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журамд гишүүд ямар асуудлаар болон ямар журмаар хөндлөнгийн мэргэжлийн этгээдийн зөвлөгөөг компанийн зардлаар авч болох талаар тодорхой тусгана. Ялангуяа, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдэд дээрх боломжийг энэ журмаар олгох нь тэдгээрийг гишүүнийхээ үүргийг зүй зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд тустай.

1.2. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшүүлэх журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна.

Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийг сонгохдоо тэдгээрийн ёс зүй, зан суртахуун, ажлын туршлага, мэргэжлийн ур чадвар, боловсрол, гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, шүүхээр тогтоосон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаарх мэдээллийг нэг бүрчлэн шалгана;

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан томилох асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхдээ гишүүнээр ажилласан нийт хугацаа, өмнөх бүрэн эрхийн хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үнэлгээ зэрэг мэдээллийг танилцуулна;

Тайлбар 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр нэр дэвшиж буй этгээдийн хараат бус байдлыг хэрхэн тодорхойлсон, бусад компанийн эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг эсэх талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд дэлгэрэнгүй танилцуулна;

Тайлбар 4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр нэр дэвшиж буй этгээд нь нэр дэвших хүсэлт, томилогдсон тохиолдолд ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай цаг хугацааг зориулах боломжтой, хүсэл тэмүүлэл бий гэдгээ бичгээр илэрхийлнэ.

Тайлбар 5. Шинээр томилогдож буй төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрд цалин урамшуулал, хариуцлагын даатгал, хараат бус гишүүний хувьд хараат бус байдал алдагдах нөхцөл байдал үүссэн тохиолдолд мэдэгдэх болон компанийн мэдээлэлтэй харьцах дэг журам, нууцлалын үүрэг зэргийг бичгээр танилцуулж, гарын үсэг зуруулан баталгаажуулна;

Тайлбар 6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанийн ёс зүйн дүрэм, авлига, албан тушаалын гэмт хэргээс сэргийлэх, дотоод мэдээлэл эзэмшигчид хориглох үйл ажиллагаа зэрэг дотооддоо баталж мөрддөг бодлогын баримт бичгүүд, дотоод журмыг сайн мэддэг байж, дагаж мөрдөнө;

1.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүрийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшлийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайланд дэлгэрэнгүйгээр тусгаж, өөрийн цахим хуудсанд байршуулна.

Тайлбар 1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороод, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг тус бүр жилд нэг удаа тогтмол хугацаанд үнэлж, тайлагнана. Ингэхдээ тухайн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний ажлын ур чадвар, хуралдааны ирц, компанийн үйл ажиллагаанд, ач холбогдолтой ажилд зарцуулсан цаг хугацаа, хичээл зүтгэл, гарсан үр дүнг дурдана;

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороод, гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлж болно;

Тайлбар 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын ажлын гүйцэтгэлийн үнэлгээг аль нэг хараат бус гишүүн нь хариуцаж, бусад гишүүдийнхээ саналыг авсны үндсэн дээр гүйцэтгэнэ.

1.4. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигтэй байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэр зэрэг асуудлыг тусгана.

Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримт бичигт туссан зорилтын биелэлтийг жил бүр дүгнэж, компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон компанийн цахим хуудсанд байршуулна;

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорино. Хүйсийн тэнцвэртэй байдал нь компанийн тогтвортой хөгжилд сайн нөлөөтэй болохыг баталсан олон улсын судалгаа бий тул дэлхийн олон орны компанийн засаглалын кодекст төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн эзлэх хувь гучаас доошгүй байхыг эрмэлзэхээр заасан байна;

Тайлбар 3. Хүйсийн тэнцвэртэй байдлыг төлөөлөн удирдах зөвлөлөөр зогсохгүй, компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнуудын түвшинд ч хадгалахыг эрмэлзэх нь зүйтэй. Хүйсийн бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх чиг үүргийг төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аль нэг (нэр дэвшүүлэх, эсвэл цалин урамшууллын) хороо хариуцна.

1.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, шинэчлэх сургалтад тогтмол хамруулна.

Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний мэдлэг, чадварыг тогтмол дээшлүүлэх, цаг үеийн мэдээллийг олгоход компанийн зүгээс хөтөлбөрийн дагуу зохих нөөцийг зарцуулж байх шаардлагатай.

1.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.

Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул түүнийг томилох, чөлөөлөх асуудал нь төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд хамаарна;

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын ажлын чиг үүрэгт төлөөлөн удирдах зөвлөл болон түүний дэргэдэх хороодод засаглалын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, тэдгээрийн бодлогын баримт бичиг, дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих, төлөөлөн удирдах зөвлөлийн бичиг хэрэг, хуралдааны тэмдэглэл хөтлөх, хуралдаан болон гишүүдийн сургалтыг тогтмол зохион байгуулах зэрэг асуудлууд багтана.

ХОЁРДУГААР ЗАРЧИМ. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ

2.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.

Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь хараат бус гишүүн байснаар төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа илүү нээлттэй, олон ургалч үзлийг дэмжсэн уур амьсгал бүрдэх магадлал өндөр. Төлөөлөн удирдах зөвлөл нь гүйцэтгэх удирдлагын нөлөөнд байх бус, харин түүнийг чиглүүлэх, хянах зорилгоор хараат бус гишүүнээр удирдуулах нь зүйтэй;

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус байснаар төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр гүйцэтгэх удирдлага болон энгийн гишүүдийн ашиг сонирхлоос хамааралгүй, хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг дээдлэх магадлал өндөр. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг энгийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын оролцоогүйгээр уулзаж, хамтран зөвлөлдөх боломж, бололцоог бүрдүүлнэ.

2.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам, аудитын бодлогын баримт бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагцхүү тус хорооны хүсэлтээр оролцоно.

Тайлбар 1. Аудитын хороо нь өөрийн үйл ажиллагааны журмыг боловсруулж, төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах бөгөөд аудитын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайлагналын чанарыг хангана;

Тайлбар 2. Аудитын хорооны дарга, гишүүд нь санхүүгийн тайлагналын зохих мэдлэг, туршлагатай байна. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд аудитын бодлого, хорооны үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэл, хурлын давтамж, ирцийг нийтэд мэдээлнэ;

Тайлбар 3. Аудитын хорооны дарга нь компанийн хөндлөнгийн аудитортой аливаа холбоогүй, сүүлийн гурван жилийн хугацаанд тухайн хөндлөнгийн аудитын компанид ажиллаж байгаагүй байна;

Тайлбар 4. Компани нь аудитын хорооноос эрсдэлийн удирдлагын чиг үүргийг салгаж, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх эрсдэлийн хороог тусад нь байгуулан ажиллуулж болно;

Тайлбар 5. Аудитын хорооны үйл ажиллагааны хараат бус байдлыг хангахын тулд компанийн гүйцэтгэх удирдлага, ажилтнуудыг зөвхөн тус хорооны хүсэлтээр хуралдаанд оролцуулна.

2.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагцхүү хорооны хүсэлтээр оролцоно.

Тайлбар 1. Цалин урамшууллын хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын бодлогыг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулна. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд цалин урамшууллын бодлогын баримт бичиг, хорооны үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүний дэлгэрэнгүй мэдээлэл, хурлын давтамж, ирц, зэргийг нийтэд мэдээлнэ;

2.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвшүүлэх хорооны дарга нь төлөөлөн удирдах зөвлөлийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.

Тайлбар 1. Нэр дэвшүүлэх хороо нь залгамж халааны бодлогыг боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулна. Компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд залгамж халааны бодлогын баримт бичиг, хорооны үйл ажиллагааны журам, хурлын давтамж, ирц зэргийг нийтэд мэдээлнэ;

Тайлбар 2. Нэр дэвшүүлэх хороо нь компанийн эрх бүхий албан тушаалтны мэдлэг, чадвар, ажлын туршлага нь тухайн ажлын байрны шаардлагыг хангаж байгаа эсэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн эсэх, төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн бие даасан хараат бус байдал зэргийг тогтоох ба уг хороо нь тэдгээрийг сургах, мэргэшүүлэх ажлыг хариуцна.

2.5. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын туршлага бүхий бүрэлдэхүүнтэй байна.

Тайлбар 1. Компанийн үйл ажиллагааны онцлогоос хамааран төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд, эрүүл мэндийн, аюулгүй байдлын, байгаль орчны гэх мэт байнгын болон түр хороог байгуулж болно;

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх бусад хороодын үйл ажиллагааны журам, бодлогын баримт бичиг, гишүүдийн мэдээлэл, хурлын давтамж, ирц зэргийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар нийтэд мэдээлнэ. Эдгээр хороод нь үйл ажиллагаагаа төлөөлөн удирдах зөвлөлд улиралд нэгээс доошгүй удаа тайлагнана;

Тайлбар 3. Бусад этгээдээс компанийн хувьцааг бүхэлд нь буюу хяналтын багцаас дээш хувийг худалдан авах санал ирсэн тохиолдолд энэ асуудлыг зохицуулах төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх түр хороог байгуулж, уг хороо нь хараат бус ажиллаж, хөндлөнгийн зөвлөх, шинжээчдээр гаргуулсан тайланг хувьцаа эзэмшигчдэд танилцуулна.

ГУРАВДУГААР ЗАРЧИМ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана

3.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

Тайлбар 1. Хувьцаа эзэмшигчид болон олон нийтэд хүргэх мэдээллийг цаг хугацаанд нь, бодитой, эерэг болон сөрөг мэдээллийг багтаасан тэнцвэртэй байдлаар хүргэнэ;

Тайлбар 2. Компанийн тогтмол болон тухай бүр мэдээлэх, тайлагнах талаарх журмыг цахим хуудсандаа байршуулна;

Тайлбар 3. Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журамд компанийн эрх бүхий албан тушаалтнууд, ажилтнуудын хүлээх үүрэг, мэдээллийн нууцлал, мэдээллийг боловсруулах, нийтэд мэдээлэх, тайлагнах, хөрөнгө оруулагчид болон олон нийттэй харилцах, үнэт цаасны арилжаа, бүртгэлийн мэдээлэлд алдаа, зөрүү гарсан бол түүнийг залруулах ажиллагааг тусгаж зохицуулсан байна.

3.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.

Тайлбар 1. Компанийн цахим хуудсанд үйл ажиллагааны үндсэн мэдээлэл болон засаглалын бодлогын баримт бичгүүд, дотоод дүрэм, журам, заавраа байршуулах нь хөрөнгө оруулагч, оролцогч талуудад чухал ач холбогдолтой тул эдгээр мэдээллийг бүрэн бүтэн, танилцахад дөхөмтэй хэлбэрээр байршуулахаас гадна цаг тухайд нь шинэчлэн нийтэд мэдээлнэ.

3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.

Тайлбар 1. Санхүүгийн бус тайланд байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлсээс гадна компанийн стратегийн зорилтуудад хүрэхэд ямар үр дүн гаргаж буй талаарх мэдээллийг багтаана;

Тайлбар 2. Санхүүгийн тайлагналыг хуульд заасан хугацаа, агуулга, хэлбэрээр бодитоор илэрхийлж, хангалттай, бүрэн тайлбарыг хавсаргана. Хөрөнгө оруулагчдад бизнесийн загвар, гүйцэтгэл, стратегийн зорилтууд, тэдгээрийн биелэлтийн талаар тэнцвэртэй, ойлгомжтой мэдээлэл маш хэрэгтэй байдаг. Мөн тайлагналын аргад өөрчлөлт орсон бол тэр талаар тайлбар хийж, өмнөх хугацааны тайлантай харьцуулах боломжоор хангана.

ДӨРӨВДҮГЭЭР ЗАРЧИМ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

Төлөөлөн удирдах зөвлөл нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дүнтэй байдлыг хангана

4.1. Төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитортой харьцах, хөндлөнгийн аудиторыг хуульд заасан чиг үүргээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжоор хангах талаар тусгаж, журмын хэрэгжилтэд хяналт тавина.

Тайлбар 1. Аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндлөнгийн аудитыг сонгох шалгуур, аудитын хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэл, түүнийг хэрхэн удирдах талаар тусгана;

Тайлбар 2. Аудитын хорооны үйл ажиллагааны журамд аудитын хороо, гүйцэтгэх удирдлага, хөндлөнгийн аудиторын хооронд тогтмол мэдээлэл солилцох арга хэлбэр, бүтэц, зохион байгуулалтыг тусгана;

Тайлбар 3. Хөндлөнгийн аудитороос компанид үзүүлж болох хуулиар тогтоосноос бусад үйлчилгээг аудитын хороо баталж, түүнд хяналт тавина.

4.2. Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.

Тайлбар 1. Хувьцаа эзэмшигчдэд хөндлөнгийн аудитороос асуулт асууж, хариулт авах нөхцөл, бололцоог бүрдүүлсэн байна.

4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж тэдгээрт орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэнэ.

Тайлбар 1. Дотоод аудитын тогтолцоо нь компанийн эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл ажиллагааг тогтмол хянах, үр дүнг нь сайжруулах замаар урт хугацааны тогтвортой өсөлт, хөгжилд чухал хувь нэмэр оруулна;

Тайлбар 2. Дотоод аудитын нэгжийн удирдлага нь зохих мэдлэг, чадвар, туршлагатай байх ба төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороотой шууд харилцаж, тайлагнана.

ТАВДУГААР ЗАРЧИМ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Төлөөлөн удирдах зөвлөл нь эрсдэлийн удирдлага болон компайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина.

5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.

Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн компанид учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, түүнийг хэрхэн удирдах талаар бодит, бүрэн ойлголттой байх шаардлагатай.

5.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошгүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлагнана.

Тайлбар 1. Компанийн үйл ажиллагааны чиглэл, хэмжээ, бизнесийн онцлогоос хамаарч учирч болох эрсдэл харилцан адилгүй тул төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн зорилго, алсын хараатай уялдуулан хүлээж болох эрсдэлийн төрөл, хэмжээ хязгаарыг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлнэ;

Тайлбар 2. Эрсдэлийн хороо нь компанийн эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг тогтмол хянаж, эрсдэлийг хянах, илрүүлэх дотоод хяналтын тогтолцооны үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох зөвлөмжийг төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулна;

Тайлбар 3. Компанид тулгарч байгаа эрсдэл, тэдгээрийг хэрхэн удирдаж байгаа талаар бүрэн гүйцэд мэдээллийг гүйцэтгэх удирдлагаас эрсдэлийн хороонд тогтмол хүргүүлэн заавар, удирдамж авч байх харилцааг нэвтрүүлсэн байна.

Тайлбар 4. Эрсдэлийн хорооны чиг үүргийг аудитын хороонд хариуцуулж болох ба энэ тохиолдолд эрсдэлийн удирдлагын тогтолцоо, журам, хэрэгжилтийн талаарх мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд дэлгэрэнгүйгээр тайлбарлана.

5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдаж буйгаа тайлбарлана.

Тайлбар 1. Байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын хүрээний эрсдэлүүд нь компанийн урт хугацааны тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлнө. Тиймээс хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчдын хувьд эдгээр эрсдэлийг бүрэн мэдэж, үнэлэх нь чухал;

Тайлбар 2. Компани нь энэ зөвлөмжид дурдсан мэдээллийг тайлагнахдаа заавал бие даасан тогтвортой байдлын тайлан гаргах албагүй боловч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу тогтвортой байдлын тайлан гаргадаг бол түүнийгээ эш татах замаар энэхүү кодексийн шаардлагыг хангаж болно.

5.4. Компани нь компайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба компайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд төлөөлөн удирдах зөвлөл хяналт тавина.

Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөл нь комплайнсын хяналтын заавар, жил бүрийн төсвийг батлан хүний нөөцийг томилж, шууд харьцана.

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь комплайнсын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдэд шаардлагатай туслалцаа, дэмжлэгийг үзүүлж, бие даасан хараат бус байдлыг хангана.

ЗУРГААДУГААР ЗАРЧИМ. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ

Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна

6.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.

Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлахдаа хэмжээг тодорхой илэрхийлж, үндэслэлийг ойлгомжтой тайлбарлана. Цалин, урамшууллыг төлөөлөн удирдах зөвлөлийн нийт цалингийн сан бус, гишүүн тус бүрээр, мөн хэрэв төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аливаа хорооны гишүүний хувиар хийсэн ажилд тусад нь цалин урамшуулал олгох бол түүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд тодорхой тусгана;

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд бодитоор олгосон цалин, урамшууллын хэмжээг жилийн тайланд тодорхой тусгана. Ингэхдээ төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний албан ёсны цалингаас гадна төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аливаа хорооны гишүүний хувиар, эсвэл компанитай хийсэн бусад гэрээ хэлцлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлын цалин хөлсийг оруулж, дэлгэрэнгүйгээр задлан харуулна.

6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үүргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримт бичигт тусгана.

Тайлбар 1. Цалин, урамшууллын бодлого нь цалин, урамшууллын түвшинг шударга, үндэслэл бүхий, тухайн компанийн үйл ажиллагааны чиглэл, хэмжээ, онцлогт тохируулан зах зээлд өрсөлдөхүйц хэмжээнд тогтоохыг эрмэлзсэн байна;

Тайлбар 2. Цалин, урамшууллын хэмжээг тогтоох арга ил тод байна. Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллыг тогтоохдоо төлөөлөн удирдах зөвлөл нь мэргэшсэн, хараат бус зөвлөхийн зөвлөгөөг авч болно. Хараат бус зөвлөх гэж компанийн эрх бүхий албан тушаалтан болон зөвлөх үйлчилгээний үр дүн ашиг сонирхолд нь тодорхой хэмжээгээр нөлөөлж болзошгүй аливаа этгээдээс хараат бус байх этгээдийг хэлнэ;

Тайлбар 3. Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллыг ялгавартай тогтоох нь зүйтэй. Цалин, урамшууллын бодлогод гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллыг тогтоох үндсэн зарчмуудыг тусгаж, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний цалин, урамшууллыг давхар олгох бол тэр тухай тусгайлан заасан байна. Мөн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүний цалин, урамшууллыг компанийн ашиг орлого, тухайн этгээдийн ажлын гүйцэтгэлтэй уялдуулсан байна.

6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.

Тайлбар 1. Хувьцаа эзэмшигчдэд гүйцэтгэх удирдлагад бодитоор олгосон цалин, урамшууллын дүнгийн мэдээллийг ил тод байлгана. Цалин, урамшууллын бодлогод гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын бүрэлдэхүүн хэсгүүд (үндсэн цалин, богино болон урт хугацааны шагнал, урамшуулал зэрэг)-ийг тоймлон тусгана;

Тайлбар 2. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад олгосон хувьцаа болон хувьцаанд хөрвөх опцион зэрэг урт хугацааны шагнал, урамшуулал болон тэдгээрийн хэрэгжих нөхцөлийн талаарх бүрэн мэдээллийг нийтэд ил тод байлгана;

Тайлбар 3. Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын мэдээллийг жилийн тайланд тусгахдаа өмнөх жилтэй харьцуулж болохуйц байдлаар илэрхийлнэ. Мөн хувьцаа болон хувьцаанд хөрвөх опцион зэрэг урт хугацааны шагнал, урамшууллын гүйцэтгэл, олгосон үндэслэлийг жил бүр тайлагнана;

Тайлбар 4. Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын талаар нийтэд мэдээлэхдээ өөрөөс нь тухай бүр зөвшөөрлийг авах эсвэл хөдөлмөрийн гэрээндээ энэ талаар заах нь зүйтэй.

ДОЛООДУГААР ЗАРЧИМ. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ

7.1. Компани нь төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.

Тайлбар 1. Компанийн тогтвортой өсөлтийг хангах, дунд болон урт хугацаанд үнэ цэнийг бий болгоход бусад оролцогч талууд(тухайн компанийн ажилтан, зээлдүүлэгч, харилцагч, ханган нийлүүлэгч, компанийн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн иргэн)-ын хувь нэмрийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай;

Тайлбар 2. Компанийн хөгжлийн стратегийг хариуцдаг чиглүүлэгч бүтцийн хувьд төлөөлөн удирдах зөвлөл нь оролцогч талуудын ашиг сонирхол, хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, тэдгээрийг зохистойгоор тэнцвэржүүлэн ажиллана.

7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайланд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлж ажилласан талаар тусгана.

Тайлбар 1. Оролцогч талуудтай үр дүнтэй харилцаа холбоо үүсгэхийн тулд олон улсын сайн туршлагаудыг нэвтрүүлэн тэдэнд хамаарах санхүүгийн бус мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.

7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.

7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшлүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.

НАЙМДУГААР ЗАРЧИМ. КОМПАНИЙН СОЁЛ

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд компанид бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно

8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлж, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөл нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

Тайлбар 1. Компани урт хугацааны туршид үнэ цэнээ өсгөж, хадгалж явахын тулд үйл ажиллагаандаа эрх зүй, ёс зүй, мэргэжлийн хариуцлагын тодорхой хэм хэмжээг баримтална. Компани өөрийн харилцагч, ханган нийлүүлэгч, зээлдүүлэгч, ажилтнууд, хяналт, зохицуулагчдын дунд бизнесийн нэр хүнд, хүндэтгэлийг бэхжүүлж хамгаалах талаар тодорхой арга хэмжээг хэрэгжүүлнэ;

Тайлбар 2. Компанийн үнэт зүйлс болон ёс зүйн дүрмийг төлөөлөн удирдах зөвлөл баталж, гүйцэтгэх удирдлага нь байгууллагад нэвтрүүлж, хэрэгжүүлэх ажлыг хариуцна. Үүнд гүйцэтгэх удирдлагаас чадваржуулах дотоод сургалтыг тогтмол зохион байгуулах, өөрийн үлгэр дуурайллаар зарчим, хандлагыг хэвшүүлнэ;

Тайлбар 3. Ёс зүйн дүрмийн хэрэгжилт, илэрсэн ёс зүйн зөрчил, тэдгээрийг шийдвэрлэсэн явцыг төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтмол хугацаанд хянан үзэж шаардлагатай шинэчлэл, өөрчлөлтийг хийнэ.

8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх "шүгэл үлээгчийн" тогтолцоотой байна.

Тайлбар 1. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтны үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг ёс зүйн дүрэмд тусгаж, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд зөрчлийг мэдээлэх, хариуцлага хүлээлгэх тогтолцоог бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд шинэчилнэ;

Тайлбар 2. Компанийн үнэт зүйлсийг үл хүндэтгэсэн, ёс зүйгүй, хариуцлагагүй, эсхүл хууль бус үйлдлийн талаарх мэдээллийг төлөөлөн удирдах зөвлөл, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх, хариуцлага тооцох боломжийг төлөөлөн удирдах зөвлөл өөрөө бүрдүүлсэн байна. Мөн мэдээлэл өгсөн этгээд буюу "шүгэл үлээгч"-ийн нууцлалыг хадгалах, түүний нэр хүнд, цалин урамшуулал, ажлын байрыг нь хамгаалах зохицуулалтыг нэвтрүүлнэ;

Тайлбар 3. Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудад "шүгэл үлээх" тогтолцоо, түүний дагуу мэдээллийг хэрхэн өгөх, авах, шийдвэрлэх талаар тогтмол сургалт зохион байгуулна.

8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.

Тайлбар 1. Компанийн эрх бүхий албан тушаалтан, ажилтнууд төрийн албан хаагчдад зүй бус шагнал, урамшуулал буюу авлига өгөх нь эрүүгийн гэмт хэрэг бөгөөд компанийн нэр хүндэд ихээхэн хортой үйлдэл юм. Иймд төлөөлөн удирдах зөвлөл нь авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох ажилтнуудыг зохих сургалтад тогтмол хамруулна;

Тайлбар 2. Төлөөлөн удирдах зөвлөл нь улс төрийн нам, хөдөлгөөн, улс төрийн үйл ажиллагаа явуулж буй байгууллага, иргэнд хандив өгөх, дэмжлэг илэрхийлэх талаар тодорхой зарчим, хязгааруудыг заавар, журамдаа тусгаж, хэрэгжилтэд хяналт тавина.

ЕСДҮГЭЭР ЗАРЧИМ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

Компани болон төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана

9.1. Компани хөрөнгө оруулагч болон бусад оролцогч талуудад зориулан өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан тухай бүр хүргэнэ.

Тайлбар 1. Компанийн үйл ажиллагааны үндсэн мэдээллийг хөрөнгө оруулагч (хувьцаа, бонд зэрэг компанийн гаргасан үнэт цаасыг эзэмшигч, эсвэл эзэмшигч болохыг сонирхож буй этгээд) хэдийд ч танилцаж болох хэлбэрээр, тухайлбал, компанийн цахим хуудсанд байршуулна. Мөн байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлаар оролцогч талуудтай харилцах, тэдгээрт тайлагнах ажлыг тогтмол хэрэгжүүлнэ;

Тайлбар 2. Компанийн цахим хуудсанд дараах мэдээллийг байршуулна. Үүнд: Холбоо барих, харилцах этгээдийн талаарх мэдээлэл, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд болон гүйцэтгэх удирдлагын товч намтар, компанийн дүрэм, сүүлийн тав хүртэлх жилийн санхүүгийн болон жилийн үйл ажиллагааны тайлан, үнэт цаасны арилжаа эрхлэгч болон зохицуулагч байгууллагад хүргүүлсэн, тэдгээрээс хүлээн авсан чухал шийдвэр, мэдэгдэл, хувьцаа эзэмшигчдийн хурлын зар, шийдвэр;

Тайлбар 3. Компанийн цахим хуудсанд компанийн бүтэц, түүх, бизнесийн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл, хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, ногдол ашиг тараах зэрэг томоохон үйл явдлын хуанли, гаргасан үнэт цаасны төрөл, холбогдох эрх, тэдгээрийн арилжааны үнэ ханшийн түүхэн мэдээлэл, ногдол ашгийн бодлого болон ногдол ашиг тараасан мэдээлэл, хэвлэл мэдээлэлд гаргасан мэдэгдэл, хэвлэл мэдээллийн байгууллагатай харилцах болон үнэт цаасны бүртгэл хариуцсан этгээдийн нэр, холбоо барих мэдээлэл зэргийг нийтэлнэ.

9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба хөрөнгө оруулагчидтай харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.

Тайлбар 1. Хөрөнгө оруулагчдын оролцоог хангаж, тэдгээрийн санал бодлыг хүлээн авах, мэдээлэл солилцох хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байна;

Тайлбар 2. Хөрөнгө оруулагчид болон оролцогч талуудад өөрийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг хүргэнэ;

Тайлбар 3. Хөрөнгө оруулагчдад ойлгомжтой, хялбар байдлаар мэдээллийг хүргэх, харилцах мэдээллийн цахим сувгийг хөгжүүлэн ашиглана.

9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нөхцөлийг бүрдүүлнэ.

Тайлбар 1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр гаргах, хэлэлцэх асуудлын жагсаалтыг тогтоох, хурлын зар хүргүүлэх, хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох баримт, мэдээлэлтэй урьдчилан судалж танилцах боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгох, хувьцаа эзэмшигчдийн оролцоог хангах, хурлыг удирдан явуулах санал хураах, хурлын шийдвэрийг баримтжуулах, хадгалах, тэмдэглэл хөтлөх, хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэр болон тэмдэглэлтэй танилцах боломжийг олгох зэрэг асуудлыг зохицуулсан хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тусгайлсан журмыг батлан мөрдөнө;

Тайлбар 2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хувьцаа эзэмшигчдэд тохиромжтой цаг хугацаа, байршилд зохион байгуулж, хурлын зарыг тодорхой байдлаар урьдчилан хүргүүлж, хуралд гүйцэтгэх удирдлагыг байлцуулна.

Тайлбар 3. Компани зайны технологийг ашиглан цахимаар хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, саналаа өгөх нөхцөлийг бүрдүүлнэ.

Тайлбар 4. Гадаад болон жижиг хувьцаа эзэмшигчдийн төлөөлөн удирдах зөвлөлд төлөөллөө оруулах, мэдээлэл авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд санал оруулах, санал өгөх, шүүхэд гомдол гаргах эрх зэргийг хангах талаар онцгойлон анхаарна.

9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтэцтэй холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.

Тайлбар 1. Төлөөлөн удирдах зөвлөл нь шинээр хөрөнгө татан төвлөрүүлэх арга замыг эрэлхийлэхдээ хувьцаа эзэмшигчдийн одоогийн эзэмшиж буй хувийг бууруулахгүй байхыг эрмэлзэнэ. Мөн нэмж хувьцаа гаргах тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд өөрийн хувь эзэмшилд хувь тэнцүүлэн худалдан авах боломжийг олгоно;

Тайлбар 2. Нэмж гаргасан үнэт цаасыг одоо байгаа хувьцаа эзэмшигчдэдээ хувь тэнцүүлэн худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ талаар эрх бүхий байгууллагад тайлан хүргүүлэх болон өөрийн цахим хуудсанд тайлбар хийнэ.

9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба түүний хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.

Тайлбар 1. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг гагцхүү бичгээр хийх, хэлцэл хийх зөвшөөрлийг урьдчилан авч байх, хэлцлийг шударга, зах зээлийн үнээр хийх ба хийгдсэн хэлцлийн талаарх бүрэн мэдээллийг тухай бүр цахим хуудсанд байршуулж, жилийн үйл ажиллагааны тайланд тусгана;

Тайлбар 2. Ханган нийлүүлэлтийн сувгийг хамааралтай этгээд дангаар эзэгнэх, компанийн өмч хөрөнгийг шамшигдуулах, зүй бусаар шилжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон тэдгээрийн хамааралтай этгээдэд компанийн нэрийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргаж өгөхөөс сэргийлнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын арван зургаадугаар хавсралт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Хувьцаат компанийн эрх бүхий байгууллагаас ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувь нийлүүлэгчдэд мэдээлэх, ногдол ашгийг тараах, тайлагнах асуудалд хяналт тавихад энэхүү журмыг баримтална.

ХОЁР. Ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх

2.1. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд ногдол ашиг хуваарилах талаархи заалтад нийцсэн шийдвэрийг компанийн эрх бүхий байгууллага гаргана.

Хэрэв Компанийн дүрэмд энэ тухай тусгайлан заагаагүй бол ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Компанийн төлөөлөн удирдах зөвлөл гаргана.

Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргахдаа “Компанийн тухай” хуулийн 47.3, 48 дугаар зүйлд заасан нөхцлийг баримтална.

Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт тухайн төрлийн нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ, ногдол ашгийг олгож эхлэх огноо, ямар хэлбэрээр олгох

/бэлэн мөнгө, эд хөрөнгө, үнэт цаас зэрэг/ болон хэрхэн тараах /компани өөрөө болон эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулах/ зэргийг тусгасан байна.

2.2. Ногдол ашиг авах эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдөр нь тухайн тайлангийн жилийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувь нийлүүлэгчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэх өдөр байна.

2.3. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөл гаргасан тохиолдолд уг шийдвэрийг хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд танилцуулна.

2.4. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал хуралдсанаас хойш 7 хоногоос илүүгүй байхаар тооцож ногдол ашиг тараах хугацааг тогтооно.

2.5. Ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг хувь нийлүүлэгчдийн хурлын зар мэдээг хүргэдэг журмаар олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр хувь нийлүүлэгчдэд хүргэнэ.

Уг мэдээлэлд тухайн төрлийн нэгж хувьцаанд ногдуулан хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ, ногдол ашгийн төлбөрийг ямар хэлбэрээр хийх, ногдол ашгийг тарааж эхлэх огноо, компани өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан тараах алин болох, мэргэжлийн зуучлагч байгууллагын нэр, хаяг, ногдол ашиг тараах байгууллагын ажиллах цагийн хуваарь, ногдол ашгийн талаар лавлагаа авах утасны дугаар зэргийг тусгасан байна.

2.6. Хувьцаа эзэмшигч нь арилжааны банкинд байгаа өөрийн харилцах болон хадгаламжийн дансанд ногдол ашгийг шилжүүлж авах талаар бичгээр хүсэлт гаргаж, холбогдох мэдээллийг өгсөн тохиолдолд ногдол ашгийн уг мөнгийг дансанд нь шилжүүлж болно.

2.7. 2.5-д заасан мэдээллийн хувийг хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын материалын хамт Үнэт цаасны хороонд /цаашид “Хороо” гэх/ ирүүлнэ.

ГУРАВ. Ногдол ашгийн талаар тайлан гаргах

3.1. Ногдол ашиг хуваарилалтын тайланг энэ журмын хавсралт /маягт А1- 16/-аар гаргаж жилийн санхүүгийн тайлангийн хамт 3 дугаар сарын 1-ний дотор Хороонд ирүүлнэ.

3.2. Компанийн тухай хуулийн 48.4-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд ногдол ашгийг шилжүүлсэн эсхүл төлж дууссанаас хойш ажлын 15 хоногийн дотор мөн зүйлд заасан мэдэгдлийг зээлдүүлэгчдэд хүргэнэ.

ДӨРӨВ. Хариуцлага тооцох

4.1. Ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Компанийн хуулийн 47.6-д заасны дагуу алданги төлнө.

4.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны гүйлгээний хяналтын улсын байцаагчаас хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн 38 дугаар зүйлд заасан захиргааны шийтгэл ногдуулна.

“Хувьцаат компанийн ногдол ашиг хуваарилалтад хяналт тавих”-ын 1 дүгээр хавсралт

Маягт А1-16

.....ХК-ийн хувьцааныоны

ногдол ашгийн тайлан

№	Тухайн төрлийн хувьцааны тоо	Нэгж хувьцаанд оногдуулан хуваарилсан ногдол ашгийн хэмжээ	Ногдол ашгийн нийт дүн	Ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан эрх бүхий байгууллагын нэр, шийдвэрийн огноо	Ногдол ашгийг тарааж эхлэхээр шийвэрлэсэн огноо	Олгож эхэлсэн огноо	Ногдол ашгийг хаана олгох		Ногдол ашиг олгосон тухай тайлан				
							Компани дээр	Мэргэжлийн зуучлагч байгууллагаар	Олгогдоогүй ногдол ашгийн үлдэгдэл		Хувьцаа эзэмшигч дийн тоо		
0	1	2	3	4	5	6			7	8	9	10	11
									Жинхэнэ олгосон	Компанид	Зуучлагч байгууллагад	Ногдол ашиг авсан	Ногдол ашиг аваагүй

Захирал.....

ХК-ийн ерөнхий нягтлан бодогч.....

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын арван долоодугаар хавсралт

БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь биржийн бус зах зээлийн хамрах хүрээ, удирдлага зохион байгуулалт, хяналт, зах зээлд оролцогчид, арилжаа явагдах программ хангамж, түүнд тавигдах шаардлага, арилжааны төлбөр, өмчлөх эрхийн бүртгэл, төвлөрсөн хадгаламж, мэдээллийн ил тод байдал, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны эрх, үүргийг тодорхойлох, Хорооноос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасны бүртгэл, түүнийг арилжаалахтай холбогдох харилцаа энэ журмын зохицуулалтад хамаарахгүй.

1.3. Биржийн бус зах зээл дээр Засгийн газрын өрийн хэрэгсэл болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан үнэт цаасыг нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд гарган арилжаалж болно.

1.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан компанийн өрийн хэрэгслийг нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд гаргах бол зөвхөн биржийн бус зах зээлд арилжаална.

1.5. Инновацийн тухай хуулийн 121 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн гарааны компани /цаашид “гарааны компани” гэх/ хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгохтой холбогдсон ерөнхий харилцааг энэ журмаар зохицуулна.

1.6. Гарааны компанийн биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгон гаргах хувьцааг бүртгэх, өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг энэ журмын 2.5.10- д заасан Холбооны журмаар зохицуулна.

ХОЁР. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ

2.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.2-т заасан мэргэжлийн холбоо (цаашид “Холбоо” гэх) нь биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

2.2. Холбоо нь биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг хариуцсан байнгын нэгжтэй байхаас гадна үнэт цаасны бүртгэл хариуцсан хороотой байна.

2.3. Холбоо нь дор дурдсан эрх эдэлнэ:

2.3.1. биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэлийн үйл ажиллагааг явуулах;

2.3.2. биржийн бус зах зээлийн арилжааг явуулах;

2.3.3. биржийн бус зах зээлийн үнэт цаасны төлбөр, тооцоо, бүртгэл,

хадгаламжийн үйл ажиллагааг хэвийн явуулахад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

2.3.4. биржийн бус зах зээлд үнэт цаас гаргагч компанийн тайлан, санхүүгийн мэдээллийг нэгтгэх;

2.3.5. үнэт цаасны арилжаанд оролцогч, үнэт цаас өмчлөгч болон үнэт цаас гаргагчаас шаардлагатай мэдээллийг энэ журам болон бусад холбогдох журамд заасны дагуу гаргуулан авах.

2.4. Холбоо нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

2.4.1. биржийн бус зах зээл дээрх үнэт цаасны арилжааг тогтоосон хугацаанд тасралтгүй, ил тод, алдаагүй, шударгаар зохион байгуулах;

2.4.2. биржийн бус зах зээлийн арилжааг удирдан зохион байгуулахад шаардлагатай ажлын байр, хүний нөөц, программ хангамж, техник, тоног төхөөрөмж болон санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;

2.4.3. үнэт цаасны арилжаа зохих журмын дагуу явагдаж байгаа эсэхэд хяналт тавих;

2.4.4. биржийн бус зах зээлийн арилжааг цахим программ хангамжаар дамжуулан зохион байгуулах;

2.4.5. биржийн бус зах зээлтэй холбоотой энэ журмын 7.1-д заасан мэдээллийг цахим программ хангамжаар дамжуулан олон нийтэд хүргэх;

2.4.6. Гарааны компанийн биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох хувьцааны бүртгэлийн үйл ажиллагааг шуурхай, ил тод байдлаар зохион байгуулах.

2.5. Холбоо нь биржийн бус зах зээлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулахтай холбоотой дор дурдсан харилцааг зохицуулсан журмыг боловсруулж, Санхүүгийн зохицуулах хороогоор батламжлуулна:

2.5.1. биржийн бус зах зээлийн үнэт цаасны арилжаа;

2.5.2. биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэл;

2.5.3. биржийн бус зах зээлийн үнэт цаасны арилжаанд хяналт тавих;

2.5.4. биржийн бус зах зээлийн үнэт цаасны арилжааны төлбөр, тооцоо;

2.5.5. биржийн бус зах зээлийн үнэт цаасны арилжааны мэдээллийн ил тод байдал;

2.5.6. үнэт цаасны бүртгэл хариуцсан хорооны эрх, үүрэг, үйл ажиллагаа;

2.5.7. биржийн бус зах зээлийн үнэт цаасны бүртгэл, арилжаанд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

2.5.8. биржийн бус зах зээлд үнэт цаас гаргагч компанийн тайлан, мэдээ, мэдээлэл;

2.5.9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх;

2.5.10. Гарааны компанийн биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох хувьцааны бүртгэлийн болон гарааны компанийн мэдээллийн ил тод байдал;

2.5.11. биржийн бус зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой бусад шаардлагатай харилцаа;

2.5.12. Хорооноос шаардсан бусад.

ГУРАВ. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

3.1. Биржийн бус зах зээл дээр энэ журмын 1.3-т заасан үнэт цаасыг гаргагч нь холбогдох хууль тогтоомжид заасан тухайн үнэт цаасыг гаргах эрх бүхий этгээд байна.

3.2. Компани нь компанийн өрийн хэрэгслийг нийтэд санал болгохгүйгээр хаалттай хүрээнд худалдахаар гаргах бол заавал биржийн бус зах зээлд гарган арилжаалах бөгөөд үнэт цаасаа Холбоонд бүртгүүлж, үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллагад хадгалуулна.

3.3. Хаалттай хувьцаат компани нь хувьцаагаа биржийн бус зах зээл дээр арилжаалахаар гаргаж болох бөгөөд энэ журмыг баримтлан үнэт цаасаа бүртгүүлж, арилжаална.

3.4. Гарааны компани нь хувьцаагаа үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад хадгалуулж, хаалттай хувьцаат компани хэлбэртэй болох нөхцөлд биржийн бус зах зээлд хувьцаагаа олон нийтэд санал болгоно.

3.5. Энэ журмын 3.4-т заасны дагуу хувьцаагаа биржийн бус зах зээлд санал болгож, шаардлагатай хөрөнгө оруулалтаа амжилттай татсан гарааны компанийн хувьцааг 1 жилийн хугацаанд биржийн бус зах зээлд арилжаалахгүй.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 348 дугаар тогтоолоор нэмсэн./

3.6. Гарааны компани нь андеррайтерийн компаниар дамжуулан хувьцаагаа биржийн бус зах зээлд олон нийтэд санал болгох замаар нийт 500 сая төгрөг хүртэлх мөнгөн хөрөнгийг татан төвлөрүүлэх бөгөөд гарааны компанийн хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн хугацаанаас хамааруулан тодорхой хугацаанд үе шаттайгаар хувьцаагаа санал болгож болно.

3.7. Гарааны компанитай гэрээ байгуулан хамтран ажиллах андеррайтер нь түүний холбогдох этгээд байж болохгүй.

3.8. Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим хамтран эрэмбэлсэн шилдэг 100 аж ахуйн нэгжээр сүүлийн 3 жилийн хугацаанд нэг болон түүнээс дээш удаа шалгарсан этгээдийн хувьд биржийн бус зах зээл дээр компанийн өрийн хэрэгслийг гаргахад андеррайтертай гэрээ байгуулахгүй байж болно.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ... дугаар тогтоолоор нэмсэн./

3.9. Үнэт цаас гаргагч нь дотоодын эсхүл олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгосон, эсхүл энэ журмын 3.8-д заасан этгээд 1 жилээс бага хугацаатай 5 тэрбум төгрөг хүртэлх үнийн дүн бүхий бонд гаргах бол үүргийн гүйцэтгэлийг хангах баталгаа болгож эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийг барьцаалахгүй байж болно.

ДӨРӨВ. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНД ОРОЛЦОХ ОРОЛЦОГЧИД

4.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 24.1.1, 24.1.2, 24.1.4, 24.1.5, 24.1.10, 24.1.12-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээд биржийн бус зах зээл дээр өөрийн өмчлөлийн болон өмчлөгчөөс эрх олгосон энэ журамд заасан санхүүгийн хэрэгслийг харилцан шууд худалдах, худалдан авах гэрээ байгуулах үйл ажиллагаа явуулна.

4.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-т заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдээс гадна дор дурдсан этгээд үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр дамжуулан биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох, эсхүл гарааны компанийн биржийн бус зах зээлд санал болгон гаргах хувьцааг худалдан авч болно:

4.2.1. энэ журмын 4.3-т заасан шаардлага хангасан Монгол Улсын иргэн;

4.2.2. энэ журмын 4.4-т заасан шаардлага хангасан Монгол Улсад бүртгэлтэй хуулийн

4.2.3. гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн, олон улсын банк, санхүүгийн болон хөгжлийн байгууллагууд;

4.2.4. хууль тогтоомжоор хориглоогүй бол Монгол Улсын Засгийн газар, түүний харьяа байгууллагууд, Төв банк /Монголбанк/, Монгол Улсын Хөгжлийн банк, Хадгаламжийн даатгалын корпораци, Засгийн газрын тусгай сан, Зээлийн батлан даалтын сан, бүх төрлийн даатгалын сан.

4.3. Биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох Монгол Улсын иргэн нь дараах шаардлагыг хангасан байна:

4.3.1. тухайн иргэний сүүлийн нэг жилийн сарын дундаж орлого нь 10 сая төгрөгтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээтэй, эсхүл 500 сая төгрөгөөс дээш хэмжээний цэвэр хөрөнгө /харилцах, хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгө, үнэт цаасны нийлбэр дүнгээс өр төлбөрийг хасах/-тэй байх;

4.3.2. сүүлийн 1 жилийн турш дотоодын болон гадаадын зах зээл дээр үнэт цаасны арилжаанд оролцсон туршлагатай байх.

4.4. Биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд дараах шаардлагыг хангасан байна:

4.4.1. сүүлийн 3 жилийн аль нэг жилийн борлуулалтын орлогын хэмжээ нь 2.5 тэрбум төгрөгөөс доошгүй байх;

4.4.2. өөрийн хөрөнгийн хэмжээ 1 тэрбум төгрөгөөс доошгүй байх.

4.5. Энэ журмын шаардлага хангасан Монгол Улсын иргэн, хуулийн этгээд нь гарааны компанийн биржийн бус зах зээлд гаргах хувьцааг худалдан авахад дараах шаардлагыг хангасан байх бөгөөд үүнд арилжаанд зуучилсан тухайн этгээдийн брокер хяналт тавина:

4.5.1. энэ журмын 4.3-т заасан иргэн нь тухайн санхүүгийн жилийн хугацаанд нийт цэвэр хөрөнгийн 10-аас дээшгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг нэг гарааны компанийн биржийн бус зах зээлд гаргах хувьцаанд оруулна;

4.5.2. энэ журмын 4.4-т заасан хуулийн этгээд нь тухайн санхүүгийн жилийн хугацаанд нийт өөрийн хөрөнгийн 20-оос дээшгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг нэг гарааны компанийн биржийн бус зах зээлд гаргах хувьцаанд оруулна.

4.6. Биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох иргэн, хуулийн этгээд нь энэ

журмын 4.3 болон 4.4-т заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар нотлох баримтаа өөрийн брокерт гаргаж, бүртгүүлсний үндсэн дээр арилжаанд оролцоно. Брокер нь биржийн бус зах зээлийн арилжаанд оролцож буй Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг 2 жил тутам шинэчилнэ.

4.7. Энэ журмын 4.2.1 болон 4.2.2-т заасан иргэн, хуулийн этгээд нь биржийн бус зах зээлийн арилжаанд оролцох, түүнээс үүдэн гарах эрсдэлээ өөрөө бүрэн хариуцахаа илэрхийлсэн албан бичиг, баталгааг өөрийн брокерт гаргасан байна.

4.8. Брокер нь энэ журмын 4.6-д заасан иргэн, хуулийн этгээдийн бүртгэлийг Хороо, Холбоо болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд тухай бүр хүргүүлнэ.

4.9. Биржийн бус зах зээлд оролцох эрхийг авсан Монгол Улсын иргэн, хуулийн этгээд энэ журмын 4.3 болон 4.4-т заасан шаардлагыг цаашид хангахгүй болсон нь тэдгээрийн эзэмшиж буй үнэт цаасыг биржийн бус зах зээлд худалдах эрхийг хязгаарлахгүй.

ТАВ. АРИЛЖААНЫ ПРОГРАММ ХАНГАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1. Биржийн бус зах зээлийн арилжааг тусгай программ хангамжаар дамжуулан явуулна.

5.2. Арилжааны программ нь түргэн шуурхай, тасралтгүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

5.2.1. энэ журмын 4.1-д зааснаас бусад оролцогчид нэгнийгээ таньж мэдэх боломжгүй байх;

5.2.2. арилжааны мэдээллийг арилжаанд холбогдолгүй гуравдагч этгээдээс нууцлах, системийн шифрлэлт нууцлал, аюулгүй байдлын стандартыг хангах;

- 5.2.3. зах зээлийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх боломжтой байх;
- 5.2.4. олон нийтэд мэдээлэл хүргэх нээлттэй самбартай байх;
- 5.2.5. оролцогчид өөр хоорондоо захидал харилцааны зурвас илгээх боломжоор хангагдах бөгөөд түүнийг хадгалж, түүх үүсгэх боломжтой байх;
- 5.2.6. бодит цагийн горимоор арилжааны хэлцэл биелсний дараах дор дурдсан мэдээллийг арилжаанд оролцогчид авах боломжтой байх:
 - 5.2.6.1. купон (компанийн өрийн хэрэгсэл бол);
 - 5.2.6.2. ISIN дугаар;
 - 5.2.6.3. үнэт цаас гаргагчийн нэр;
 - 5.2.6.4. хугацаа;
 - 5.2.6.5. арилжааны хэмжээ;
 - 5.2.6.6. бодит цагийн хамгийн сайн зарах болон авах үнэ болон хамгийн сүүлийн хэлцлийн үнэ;
 - 5.2.6.7. бусад шаардлагатай мэдээлэл.
- 5.2.7. дараах арга хэрэгслээр арилжааг зохион байгуулах боломжтой байх:
 - 5.2.7.1. арилжааны үнийн санал авах арга (RFQ);
 - 5.2.7.2. захиалга хийх арилжааны арга (Order driven);
 - 5.2.7.3. шаардлагатай бусад.

5.3. Арилжааны программ хангамж нь энэ журмын 5.2-т заасан шаардлагыг хангасан байхаас гадна дараах техник, технологийн шаардлагыг хангасан байна:

- 5.3.1. программ хангамжийн сервер компьютер байрлаж буй дата төв нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байх бөгөөд Tier 2 ба түүнээс дээш стандартын шаардлага хангасан байх;
- 5.3.2. төрийн албан хэрэгцээний сүлжээ болон төрийн интернэт хэрэглээний сүлжээнд холбогдох боломжтой байх;
- 5.3.3. бизнесийн тасралтгүй байдлыг хангах, гамшгийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй, уг төлөвлөгөөний дагуу нөөц төвтэй байх;
- 5.3.4. системхоорондын мэдээлэл дамжуулалт нь шууд урсгалтай боловсруулалт /STP straight-through-processing/-тай байх;
- 5.3.5. шаардлагатай бусад.

ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТӨЛБӨР, ӨМЧЛӨХ ЭРХИЙН БҮРТГЭЛ, ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖ

- 6.1. Төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд арилжааны программ хангамжаас ирүүлсэн даалгаврын дагуу үнэт цаасны арилжааны төлбөрийг гүйцэтгэж, зохих мэдээллийг үнэт цаасны хадгаламж, бүртгэлийн байгууллага, арилжаанд оролцогчдод илгээнэ.
- 6.2. Биржийн бус зах зээл дээр арилжаалагдаж буй үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг үнэт цаасны төвлөрсөн бүртгэл эсхүл тухайлсан бүртгэл хөтлөх эрх бүхий хуулийн этгээд хөтөлнө.
- 6.3. Биржийн бус зах зээл дээр арилжаалагдаж буй үнэт цаасыг үнэт цаасны төвлөрсөн бүртгэлийн санд бүртгэнэ.

ДОЛОО. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

7.1. Биржийн бус зах зээлийн арилжаа эрхлэх байгууллага нь энэ журмын 2.5.5, 2.5.10-т тус тус заасан болон дор дурдсан мэдээллийг нийтэд мэдээлнэ:

- 7.1.1. үнэт цаасны бүртгэлийн дугаар, ялгах тэмдэг;
- 7.1.2. үнэт цаасны ханш, түүнд нөлөөлж болох бусад мэдээлэл;
- 7.1.3. хэлцэл хийгдсэн он, сар, өдөр;
- 7.1.4. нийт арилжаалсан үнэт цаасны тоо;
- 7.1.5. үнэ, нээлтийн болон хаалтын ханш;
- 7.1.6. хууль тогтоомж, холбогдох журмын дагуу нийтэд мэдээлэхээр заасан бусад мэдээлэл;
- 7.1.7. Хороо шаардсан бусад мэдээлэл.

7.2. Холбоо нь долоо хоног, сар, улирлын арилжааны нэгдсэн мэдээллийг бэлтгэн нийтэд мэдээлнэ.

7.3. Холбоо нь дараах мэдээллийг Хороонд албан бичгээр болон цахимаар ирүүлнэ:

7.3.1. биржийн бус зах зээлийн нөхцөл байдлын судалгааг улирал бүр, дараа сарын 20-ны өдрийн дотор;

7.3.2. тайлант хугацааны улирлын санхүүгийн тайланг Хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын 1.3-т заасан хугацаанд;

7.3.3. хагас жилийн болон жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор;

7.3.4. биржийн бус зах зээлийн арилжааны дүн мэдээг Хорооны 2019 оны 4 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралт Маягт МС-1, 3 дугаар хавсралт Маягт МС-3-ын дагуу мөн журмын 1.3-т заасан хугацаанд;

7.3.5. Хорооноос шаардсан бусад мэдээллийг тухай бүр.

НАЙМ. ХОРООНЫ ЭРХ, ҮҮРЭГ

8.1. Хороо нь дор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

- 8.1.1. биржийн бус зах зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих;
- 8.1.2. биржийн бус зах зээлийн оролцогчдод хууль ёсны шаардлага тавих, хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах;
- 8.1.3. Холбооноос ирүүлсэн биржийн бус зах зээлийн дүрэм, журмыг батламжлах;
- 8.1.4. үнэт цаасны зах зээлийг урвуулан ашигласан болон дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцсон нөхцөл байдал тогтоогдсон бол арилжааг түр зогсоох, тухайн үнэт цаастай холбоотой гүйлгээг зогсоох, хүчингүй болгох;
- 8.1.5. гадаад улсын эрх бүхий зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцан туслалцаа үзүүлэх;
- 8.1.6. биржийн бус зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагаас тогтоосон үйлчилгээний хураамжийн хэмжээг бууруулахыг санал болгох, энэ саналыг хүлээж аваагүй тохиолдолд тухайн хураамжийн хувь хэмжээ тогтоосон шийдвэрийг хүчингүй болгох;

8.1.7. үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн үйл ажиллагааны шударга, ил тод, үр ашигтай байдлыг хангах зорилгоор зөвлөмж гаргах;

8.1.8. биржийн бус зах зээлийн үйл ажиллагаатай холбоотойгоор Холбооны үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх;

8.1.9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

8.1.10. энэ журмын 2.5-д заасан Холбооноос батламжлуулах журмын төсөлд Хорооны саналыг хүлээж аваагүй тохиолдолд журмыг батламжлахаас татгалзах;

8.1.11. энэ журмын 4.6-д заасан брокерийн мэргэжлийн хөрөнгө оруулагчийг бүртгэх үйл ажиллагаанд хяналт тавих;

8.1.12. биржийн бус зах зээлийн холбогдох дүрэм, журам зөрчсөн этгээдүүдэд хариуцлага тооцох, арилжаанд оролцох эрхийг нь түдгэлзүүлэх.

ЕС. ХАРИУЦЛАГА

9.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын арван наймдугаар хавсралт

ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ ГАРГАГЧИД ТАВИХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА, ШАЛГУУР БОЛОН ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙН СТАНДАРТ, ТҮҮНИЙГ АРИЛЖИХ

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагч болон арилжаанд оролцогч зохицуулалттай этгээдэд тавих нөхцөл, шаардлага, шалгуур тогтоох, үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний стандартыг Хорооны бүртгэлд бүртгэх, бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2.Үнэт цаасны үнэ, арилжааны индекс, гадаад валют, уул уурхайн бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдэд суурилсан үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй холбогдох харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.3.Биржийн бус зах зээлд арилжих үүсмэл санхүүгийн хэрэгслийн харилцаанд энэ журам хамаарахгүй.
- 1.4.Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагч (цаашид “арилжаа эрхлэх байгууллага” гэх) нь Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байна.
- 1.5.Үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцогч зохицуулалттай этгээд нь үнэт цаасны брокер, дилер, арилжааны төлбөрийн болон тооцооны байгууллага байна.

Хоёр.Хороо, арилжаа эрхлэх байгууллага болон арилжаанд оролцогч зохицуулалттай этгээдийн эрх, үүрэг

- 2.1.Хороо үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
 - 2.1.1.арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээг бүртгүүлэх хүсэлтийг хянах, түүнийг бүртгэх, бүртгэлтэй үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээний нөхцөл, тавигдах шаардлагуудад өөрчлөлт оруулах, бүртгэлтэй үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээг арилжаа эрхлэх байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу бүртгэлээс хасах;
 - 2.1.2.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцогчдоос тайлан, мэдээ, мэдээллийг тусгайлан заасан хугацаанд, эсхүл Хорооноос шаардлагатай гэж үзсэн үед тогтоосон хугацаанд ирүүлэхийг шаардах;
 - 2.1.3.шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ журмын 2.1.2-т заасны дагуу ирүүлсэн тайлан, мэдээ, мэдээлэлтэй холбоотойгоор нэмэлт асуулга, тодруулга шаардах;
 - 2.1.4.эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн арилжаанд оролцогчдод хүлээлгэсэн хариуцлагын талаарх мэдээллийг ил тод мэдээлэх;
 - 2.1.5.арилжаа эрхлэх байгууллага болон арилжаанд оролцогч зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх.
- 2.2.Арилжаа эрхлэх байгууллага үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:
 - 2.2.1.энэ журамд заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг урьдчилан Хороогоор хянуулсны үндсэн дээр үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх үйл ажиллагааг явуулах;
 - 2.2.2.брокер, дилерийн үйл ажиллагаанд шаардлагатай тохиолдолд нэмэлт нөхцөл, шаардлага, шалгуурыг тавих;
 - 2.2.3.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Хороотой зөвшилцсөний үндсэн дээр дараах арга хэмжээг авч болно:

2.2.3.1.үүсмэл санхүүгийн хэрэгслийн нээлттэй позициос үүдэлтэйгээр төлбөрийн тасалдал /дефолт/ болсонд тооцох нөхцөл үүсэхэд позици хаах, шилжүүлэх;

2.2.3.2.зах зээлийн оролцогч бусад этгээдэд нэмэлт маржингийн шаардлагыг тавих.

2.2.4.нэг этгээдийн, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдийн эзэмшиж болох үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний үнийн дүн, тоо хэмжээнд шаардлагатай тохиолдолд хязгаарлалт тогтоох;

2.2.5.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг ил тод, шударгаар зохион байгуулах;

2.2.6.үүсмэл санхүүгийн хэрэгслийн шинэ стандарт гэрээг судалгаа, шинжилгээний үндсэн дээр боловсруулж, Хороонд бүртгүүлэхээр холбогдох баримт бичиг, материалын хамт ирүүлэх;

2.2.7.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд арилжих стандарт гэрээний нөхцөл, шаардлагыг тогтоох, хяналт тавих, мөрдүүлэх;

2.2.8.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг урвуулан ашиглах, үнэ ханшийг гажуудуулах, төлбөр, тооцооны системд доголдол үүсэхээс сэргийлэх зорилгоор арилжаанд бодит цагийн хяналт тавих, зах зээлийн тандалт судалгаа хийх;

2.2.9.Хороо болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээд, олон нийтийг дараах мэдээллээр хангах:

2.2.9.1.үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээний нөхцөл;

2.2.9.2.үүсмэл санхүүгийн хэрэгслийг арилжихтай холбоотой дүрэм, журам, заавар;

2.2.9.3.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн үйл ажиллагаа, арилжааны программ хангамж, төлбөр, тооцоо гүйцэтгэх байгууллагын талаарх мэдээлэл.

2.2.10.ашиг сонирхлын зөрчил үүссэн, зах зээлийг урвуулан ашигласан талаар нотлох баримт гаргах чиглэлээр арилжааны бүхий л мэдээллийг аюулгүй хадгалах, бүртгэл хөтлөх;

2.2.11.биетээр хүргэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд заасан хүргэлт хийх хугацаанд биетээр хүргэх суурь хэрэгслийн нийлүүлэлтийн тоо хэмжээг тооцоолох;

2.2.12.арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн болон үйл ажиллагааны шаардлага, шалгуурыг хангаагүй, түүний өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гишүүн байгууллагыг өөрийн бүртгэлээс хасахаар шийдвэрлэсэн бол тухайн шийдвэртэй холбоотой бүхий л баримт материалыг шийдвэр гарсан өдөртөө Хороонд хүргүүлж мэдэгдэх;

2.2.13.гишүүн байгууллагаас гомдол гарсан тохиолдолд аливаа шийдвэрийг гаргахаасаа өмнө тухайн гомдлыг үндэслэлтэй эсэхийг нягталж хянасан байх ба уг асуудалтай холбоотой нэмэлт тайлбар, шаардлагатай мэдээллийг гишүүн байгууллагаас шаардаж, тэдгээрт үндэслэн асуудлыг шийдвэрлэж, гишүүн байгууллагаас ирүүлсэн гомдолтой холбоотой бүх баримт материалыг Хороонд хүргүүлэх;

2.2.14.дараах үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталж, нийтэд мэдээлнэ:

2.2.14.1.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг зохион байгуулах;

2.2.14.2.үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээний загварыг боловсруулах;

2.2.14.3.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд хяналт тавих;

2.2.14.4.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх;

2.2.14.5.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд оролцогчдын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

2.2.14.6.харилцагчийн хөрөнгөтэй харилцах, хамгаалах, хяналт тавих;

2.2.14.7.системийн аюулгүй үйл ажиллагаа, найдвартай байдлыг хангах, давагдашгүй хүчин зүйлийн үед авах арга хэмжээ;

2.2.14.8.онцгой нөхцөл байдалд авах арга хэмжээ;

2.2.14.9.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх байгууллагын гишүүнд тавигдах шаардлага, шалгуур;

2.2.14.10.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах;

2.2.14.11.арилжаа эрхлэх байгууллагын үйл ажиллагаа, ажил үйлчилгээ болон арилжаа эрхлэх байгууллага дээрх үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаатай холбоотой гарсан аливаа гомдол, маргааныг шийдвэрлэх;

2.2.14.12.шаардлагатай бусад дүрэм, журам.

2.3.Үнэт цаасны арилжааны тооцооны байгууллага (цаашид “тооцооны байгууллага” гэх) үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.3.1.энэ журамд заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг урьдчилан Хороогоор хянуулсны үндсэн дээр үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны тооцооны үйл ажиллагааг явуулах;

2.3.2.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн төлбөр тооцооны системийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тооцооны байгууллага нь дараах арга хэмжээг авч болно:

2.3.2.1.тооцооны гишүүнийг нэмэлт барьцаа байршуулахыг шаардах;

2.3.2.2.тооцооны гишүүн, эсхүл түүний харилцагчийн эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэгслийн позицитай дээд хязгаарлалтад өөрчлөлт оруулах;

2.3.2.3.үүсмэл санхүүгийн хэрэгслийн позицитай хаах.

2.3.3.төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор тооцооны гишүүн тус бүрээр барьцаа байршуулахыг шаардах;

2.3.4.зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн системийн эрсдэлийг урьдчилан тооцож, авч хэрэгжүүлэх арга хэмжээг санал дүгнэлтийн хамт Хороонд мэдэгдэх;

2.3.5.эрсдэлийг иж бүрэн удирдах эрсдэлийн удирдлагын тогтолцоотой байх бөгөөд тооцооны байгууллага болон тооцооны гишүүний позицитай өдөр бүр зах зээлийн үнээр дахин үнэлж, шинэчлэн тооцоолох, хянах, шаардлагатай тохиолдолд хязгаарлалт тавих;

2.3.6.тооцооны гишүүний байршуулсан барьцаа хөрөнгийг гишүүн тус бүрээр, өөрийн хөрөнгөөс тусдаа хадгалах бөгөөд зөвхөн тухайн тооцооны гишүүний төлбөрийн үүргийг баталгаажуулах, гүйцэтгэхэд ашиглах;

2.3.7.маржинг тооцоолох аргачлалд тогтмол хугацаанд хяналт тавьж, эрсдэлд суурилсан олон улсын аргачлалыг нэвтрүүлэх;

2.3.8.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд оролцогчдыг тооцооны байгууллагын үйлчилгээтэй холбоотой зардал, эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай мэдээллээр хангаж ажиллах;

2.3.9.үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг бүртгэж хөтлөх;

2.3.10.Хороо болон олон нийтэд дараах мэдээллийг хүргэх:

2.3.10.1.тооцооны байгууллагаас хийсэн бүх гэрээ, хэлцэл болон гүйлгээний төлбөр, тооцооны талаарх мэдээлэл;

2.3.10.2.тооцооны байгууллагын гишүүнээс авч буй тооцооны болон бусад шимтгэл, хураамжийн талаарх мэдээлэл;

2.3.10.3.маржинг тооцоолох аргачлал болон тооцооны байгууллагын төлбөрийн баталгааны сангийн хөрөнгийн хэмжээ болон бүрдэл;

2.3.10.4.тооцооны байгууллагаас хийсэн бүх гэрээ бүрийн өдрийн тооцооны үнэ, хэмжээ, нээлттэй позицитай талаар.

2.3.11.дараах үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталж, нийтэд мэдээлнэ:

2.3.11.1.үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагаа;

2.3.11.2.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны маржинг тооцоолох, маржин хэлбэрээр байршуулсан барьцаа хөрөнгийн төрөл зүйл, барьцаа хөрөнгийн найдвартай хадгалалт, хамгаалалт;

2.3.11.3.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны төлбөрийн баталгааны санг бүрдүүлэх, захиран зарцуулах;

2.3.11.4.тооцооны гишүүний төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд авах арга хэмжээ;

2.3.11.5.үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагаанд хяналт тавих;

2.3.11.6.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийн эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх, удирдах;

2.3.11.7.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх;

2.3.11.8.үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд оролцогчдын ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

2.3.11.9.онцгой нөхцөл байдалд авах арга хэмжээ;

2.3.11.10.системийн аюулгүй үйл ажиллагаа, найдвартай байдлыг хангах, давагдашгүй хүчин зүйлийн үед авах арга хэмжээ;

2.3.11.11.үүсмэл санхүүгийн хэрэгслийн тооцооны үйл ажиллагаа эрхлэх байгууллагын гишүүнд тавигдах шаардлага, шалгуур;

2.3.11.12.шаардлагатай бусад дүрэм, журам.

2.4.Брокер, дилер нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1.энэ журамд заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг урьдчилан Хороогоор хянуулсны үндсэн дээр үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцоно;

2.4.2.Брокер нь дараах мэдээллийг агуулсан бүртгэлийг хөтөлж, хадгална:

2.4.2.1.харилцагч тус бүрийн нэр, хаяг, ажил мэргэжлийн бүртгэл, түүнд орсон өөрчлөлт;

2.4.2.2.харилцагчийн захиалгатай холбоотой дэлгэрэнгүй бүртгэл, үүнд захиалгыг биелүүлэхээр шилжүүлсэн огноо, цаг, захиалга биелсэн огноо, цагийн бүртгэл;

2.4.2.3.харилцагч тус бүрийн санхүүгийн гүйлгээний мэдээллийг хөтлөх ба үүнд бүх арилжаа, орлого, зарлагын талаарх мэдээллийг тусгана.

2.4.3.үүсмэл санхүүгийн хэрэгсэлтэй холбоотой дараах үйл ажиллагааг зохицуулсан журмыг баталж, нийтэд мэдээлнэ:

2.4.3.1.брокер, дилерийн үйл ажиллагаа;

2.4.3.2.дотоод хяналтын үйл ажиллагаа;

2.4.3.3.харилцагчдыг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагааны тухай;

2.4.3.4.харилцагч, хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх тухай;

2.4.3.5.зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх тухай;

2.4.3.6.шаардлагатай бусад дүрэм, журам.

Гурав.Арилжаа эрхлэх байгууллага болон арилжаанд оролцогч зохицуулалттай этгээдэд тавигдах шаардлага

3.1.Арилжаа эрхлэх байгууллага нь дараах шаардлага, шалгуурыг хангасан байна:

3.1.1.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны программ хангамж, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;

3.1.2.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэхэд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчинтэй байх;

3.1.3.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаа эрхлэх нэгжтэй байх;

3.1.4.үүсмэл санхүүгийн хэрэгслийн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд гаргах боломжийг судлах, үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээний загварыг боловсруулах нэгжтэй байх;

3.1.5.үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг хянах нэгжтэй байх;

3.1.6.үүсмэл санхүүгийн арилжаа эрхлэхтэй холбоотойгоор Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний шаардлагыг хангасан байх;

3.1.7.үнийн санал болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаатай холбоотой мэдээллийг бүртгэх, түгээх, нийтэд ил тод мэдээлэх үр дүнтэй тогтолцоотой байх;

- 3.1.8. мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чадвартай байх;
- 3.1.9. системийн тасралтгүй ажиллагааны зохицуулалт буюу онцгой байдлын төлөвлөгөө, нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлтийг хангасан байх;
- 3.1.10. энэ журмын 2.2.14-т заасан журмыг боловсруулсан байх.
- 3.2. Тооцооны байгууллага нь дараах шаардлага, шалгуурыг хангасан байна:
 - 3.2.1. тооцооны үйл ажиллагааг тасралтгүй явуулах программ хангамж, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;
 - 3.2.2. тооцооны үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний шаардлагыг хангасан байх;
 - 3.2.3. тооцооны үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчний нөөцтэй байх;
 - 3.2.4. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааны төлбөрийн баталгааны санг бүрдүүлж ажиллах;
 - 3.2.5. үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлтэй холбоотой системийн эрсдэлийг тооцох, хэмжих, үнэлэх нэгжтэй байх;
 - 3.2.6. гишүүн байгууллагуудын санхүүгийн нөхцөл байдал ба үүсмэл санхүүгийн хэрэгслийн позицод хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоотой байх;
 - 3.2.7. тооцооны системээр дамжиж байгаа болон хадгалагдаж буй мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чадвартай байх;
 - 3.2.8. системийн тасралтгүй ажиллагааны зохицуулалт буюу онцгой байдлын төлөвлөгөө, нөөц төв, түүний техникийн зохистой үзүүлэлтийг хангасан байх;
 - 3.2.9. энэ журмын 2.3.11-т заасан журмыг боловсруулсан байх.
- 3.3. Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага дараах шаардлага, шалгуурыг хангасан байна:
 - 3.3.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг гүйцэтгэхэд шаардлагатай программ хангамж, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;
 - 3.3.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний шаардлагыг хангасан байх;
 - 3.3.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай мэргэшсэн боловсон хүчинтэй байх;
 - 3.3.4. арилжаа эрхлэх байгууллага болон тооцооны байгууллагын гишүүнчлэлийн журамд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байх;
 - 3.3.5. мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах чадвартай байх;
 - 3.3.6. Брокер нь харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлаж, харилцагч тус бүрд өөрийнхөө данснаас тусад нь данс нээж харилцагчийн хөрөнгийг хадгалдаг байх;
 - 3.3.7. Брокер нь аливаа өр төлбөрийг харилцагчийн хөрөнгөөр барагдуулахаас сэргийлэх дотоод хяналтын тогтолцоотой байх;
 - 3.3.8. Брокер нь дансны бүх гүйлгээ, төлбөр хураамж, орлогын талаарх мэдээллийг агуулсан дансны хуулгыг харилцагчид тухай бүр авах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
 - 3.3.9. Брокер нь харилцагчийн нэрийн өмнөөс хийсэн арилжааны бүх баталгаажуулалт, цэвэр ашиг болон алдагдлын талаарх мэдээллийг тухай бүр, цагийн хоцрогдолгүй харах нөхцөлийг бүрдүүлсэн байх;
 - 3.3.10. энэ журмын 2.4.3-т заасан журмыг боловсруулсан байх.

Дөрөв. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгүүлэх хүсэлт гаргах

- 4.1. Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хавсаргана:
 - 4.1.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгүүлэх өргөдөл;
 - 4.1.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээ;
 - 4.1.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт гэрээг бүртгүүлэх, түүнд өөрчлөлт оруулах талаар эрх бүхий этгээдээс гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

- 4.1.4.үүсмэл санхүүгийн хэрэгслийн танилцуулга болон түүний техник эдийн засгийн үндэслэл;
- 4.1.5.зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай төлбөрийн баримт;
- 4.1.6.энэ журамд заасан бусад нэмэлт баримт бичиг.
- 4.2.Арилжаа эрхлэх байгууллага нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгүүлэхээр Хороонд хүсэлт гаргасан бол танилцуулга болон техник эдийн засгийн үндэслэлдээ дараах мэдээллийг тусгана:
- 4.2.1.үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл, түүний дотор тухайн гэрээний стандарт нөхцөлүүдийг баталгаажуулж нотлох аливаа тоон өгөгдөл, мэдээ мэдээлэл;
- 4.2.2.суурь хэрэгслийн зах зээлийн бүрэн хэмжээний дэлгэрэнгүй судалгаа (энэхүү судалгаа нь суурь хэрэгслийн зах зээлтэй холбоотой олон нийтэд нээлттэй, баталгаат эх сурвалжаас гаргасан сүүлийн 3-аас доошгүй жилийн мэдээлэлд тулгуурласан байна. Судалгаанд ашигласан дээрх мэдээллийн эх сурвалжийг тодорхой зааж, баримтжуулсан байна);
- 4.2.3.үүсмэл санхүүгийн хэрэгслийн эрэлт, нийлүүлэлт, эдийн засагт үзүүлэх хувь нэмэр, эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийн удирдлага, суурь бүтээгдэхүүний үнийг ирээдүйд тогтоох боломжийн талаарх судалгаа;
- 4.2.4.арилжаа эрхлэх байгууллага нь гэрээний загварыг боловсруулах явцдаа тухайн зах зээлд оролцогчидтой зөвлөлдөж, тэдний санал бодлыг хэлэлцүүлэг өрнүүлэх замаар авах, мөн хэлэлцүүлэг, хурал зөвлөгөөний үйл явцыг баримтжуулж, тухайн хэлэлцүүлэг зөвлөгөөнөөр хэлэлцэгдсэн бүх асуудал, тэдгээрээс гарсан саналуудыг нэгтгэсэн тайланг баримт нотолгооны хамт.
- 4.3.Биетээр хүргэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг боловсруулахдаа дараах шаардлагыг хангана:
- 4.3.1.үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний нөхцөл нь суурь хэрэгслийн зах зээлийн нийтлэг үйл ажиллагаа, нөхцөл байдалд нийцсэн байх;
- 4.3.2.гэрээний хугацаа дуусах өдөр үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээ болон суурь хэрэгслийн зах зээлийн үнэ нь тэнцэж байх, суурь хэрэгслийн хүргэлтэд аливаа саатал учрахаас сэргийлсэн зохицуулалт тусгасан байх;
- 4.3.3.үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, тогтмол хэмжээнд барихаас сэргийлэхийн тулд суурь хэрэгслийн нийлүүлэлтийн хэмжээг хангалттай хэмжээнд байлгах талаар тооцоолсон байх.
- 4.4.Биет байдлаар хүргэх үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний загварт дараах зүйлсийг тусгана:
- 4.4.1.чанарын стандарт;
- 4.4.2.хүргэлтийн цэг, агуулах;
- 4.4.3.хүргэлтийн хугацаа, арилжааны сүүлчийн өдөр;
- 4.4.4.гэрээний хэмжээ (contract size), арилжих нэгж;
- 4.4.5.сав баглаа боодлын стандарт болон чанараас бусад стандарт;
- 4.4.6.хүргэлтийн баримт бичиг;
- 4.4.7.үзлэг, шалгалтын горим;
- 4.4.8.хүргэлтийн сар;
- 4.4.9.үнийн хамгийн бага хэлбэлзэл;
- 4.4.10.үнийн хамгийн их хэлбэлзэл;
- 4.4.11.позицид тавих хязгаарлалт;
- 4.4.12.Хороонд мэдээлэх позицийн хэмжээ;
- 4.4.13.арилжааны хуваарь;
- 4.4.14.арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон бусад.
- 4.5.Биет байдлаар хүргэдэггүй (cash settlement) үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний загварт дараах зүйлсийг тусгана:

- 4.5.1.суурь хэрэгслийн тодорхойлолт;
- 4.5.2.гэрээний хэмжээ (contract size), арилжих нэгж;
- 4.5.3.төлбөр тооцоо хийх горим;
- 4.5.4.суурь үнэ, үнийн хамгийн бага хэлбэлзэл;
- 4.5.5.үнийн хамгийн их хэлбэлзэл;
- 4.5.6.арилжааны сүүлчийн өдөр;
- 4.5.7.арилжааны сар;
- 4.5.8.позицид тавих хязгаарлалт;
- 4.5.9.Хороонд мэдээлэх позицийн хэмжээ;
- 4.5.10.арилжааны хугацаа;
- 4.5.11.арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон бусад.

4.6.Энэ журмын 4.5-д заасан гэрээг боловсруулахдаа үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, тогтмол хэмжээнд барихаас сэргийлж арилжаа эрхлэх байгууллага нь суурь хэрэгслийн зах зээлийн хэмжээ, хөрвөх чадварыг харгалзаж үзнэ.

4.7.Энэ журмын 4.5-д заасан гэрээний үнийг арилжаа эрхлэх байгууллага тогтоохдоо үнийг зохиомлоор өсгөх, бууруулахаас сэргийлж тооцоолох аргачлалыг нийтэд ил тод байлгана.

Тав. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэх

5.1.Хороо нь арилжаа эрхлэх байгууллагаас энэ журмын дагуу бүрэн гүйцэд ирүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 20 өдрийн дотор хянаж, хууль тогтоомж, журмын шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд гэрээг бүртгэсэн талаарх мэдэгдлийг арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

5.2.Хороо нь арилжаа эрхлэх байгууллагаас гэрээг бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичигтэй холбоотойгоор нэмэлт тайлбар, тодруулга, мэдээлэл авах эрхтэй.

5.3.Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэх тухай мэдэгдлийг арилжаа эрхлэх байгууллага болон тооцооны байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээнэ.

5.4.Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг ямар нэгэн нөхцөл болзолтойгоор бүртгэхгүй.

5.5.Арилжаа эрхлэх байгууллага нь Хороонд бүртгүүлсэн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээтэй холбоотой мэдээллийг нийтэд үнэ төлбөргүй хүргэх бөгөөд сонирхсон бүх этгээдийг танилцах боломжоор хангасан байна.

5.6.Аливаа этгээд Хорооны бүртгэлд бүртгэгдсэн үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд тусгагдсанаас өөр агуулгатай мэдээлэл, нэмэлт мэдээлэл олон нийтэд хүргэхгүй.

Зургаа. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах

6.1.Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд өөрчлөлт оруулах шийдвэрийг арилжаа эрхлэх байгууллагын эрх бүхий этгээд гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор дараах баримт бичгийн хамт Хороонд хүргүүлнэ:

6.1.1.үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд орох өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлт;

6.1.2.үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд өөрчлөлт оруулах тухай эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

6.1.3.үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд өөрчлөлт оруулах үндэслэл, тайлбар, судалгаа;

6.1.4.үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд өөрчлөлт орсноор гэрээний талуудад болон бусад аливаа үүсэж болзошгүй эрсдэл, эрсдэлийн удирдлагын талаар төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

6.1.5.зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

6.2.Хороо нь энэ журмын дагуу бүрэн гүйцэд ирүүлсэн баримт бичгийг ажлын 20 өдрийн дотор хянаж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөлтийг бүртгэхээс татгалзах үндэслэлгүй бол үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээнд орох өөрчлөлтийг бүртгэсэн талаар мэдэгдлийг арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

6.3. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хасуулах шийдвэрийг арилжаа эрхлэх байгууллагын эрх бүхий этгээд гаргаснаас хойш ажлын 5 өдрийн дотор дараах баримт бичгийн хамт Хороонд хүргүүлнэ:

6.3.1. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хасуулах тухай хүсэлт;

6.3.2. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хасуулах тухай эрх бүхий этгээдийн гаргасан шийдвэр, холбогдох нотлох баримт бичиг;

6.3.3. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг хасуулах үндэслэл, тайлбар, судалгаа;

6.3.4. үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг хассанаас үүсэх эрсдэл, гэрээний талуудад болон бусад аливаа үүсэж болзошгүй эрсдэл, эрсдэлийн удирдлагын талаар төлөвлөгөө, авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

6.3.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

6.4. Хороо нь энэ журмын дагуу бүрэн гүйцэд ирүүлсэн баримт бичгийг ажлын 20 өдрийн дотор хянаж, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу бүртгэлээс хасахад татгалзах үндэслэлгүй бол үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хассан талаар мэдэгдлийг арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

6.5. Хороо нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээг бүртгэлээс хассан тухай шийдвэрийг арилжаа эрхлэх болон тооцооны байгууллагад тус тус хүргүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

Долоо. Хороонд мэдээлэл хүргүүлэх

7.1. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцогчид нь Хорооноос баталсан “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам”-д зааснаас гадна дараах мэдээллийг Хороонд ирүүлнэ:

7.1.1. үйл ажиллагааны журам, харилцагчтай хийсэн гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш ажлын хоёр өдрийн дотор;

7.1.2. үйл ажиллагааны шимтгэл хураамжийн хувь, хэмжээнд өөрчлөлт орсон бол шийдвэр гарснаас хойш ажлын хоёр өдрийн дотор;

7.1.3. тооцооны байгууллага нь тооцооны гишүүн төлбөрийн чадваргүй болсны улмаас түүний төлбөл зохих төлбөрийг барагдуулсан тохиолдолд болон тухайн төлбөрийн чадваргүй болсон этгээдийн талаарх мэдээллийг тухай бүр;

7.1.4. стресс тестийн үр дүн, эрсдэлийн удирдлагын улирал бүрийн тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор;

7.1.5. зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээллийг ашиглан арилжаанд оролцсон тохиолдолд мэдээллийг тухай бүр;

7.1.6. шаардлагатай тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр хүргүүлэх.

Найм. Бусад

8.1. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцогчид нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн позицоос ашиг олох зорилгоор тухайн үүсмэл санхүүгийн хэрэгслийн суурь хэрэгслийн эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөх замаар үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэ ханшид нөлөөлөхгүй байх үүрэгтэй.

8.2. Аливаа этгээд нь олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан олон нийтийг төөрөгдөлд оруулсан, бодит бус хуурамч мэдээлэл цацах, амлалт өгөх замаар үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэ ханшид нөлөөлөхгүй байх үүрэгтэй.

8.3. Аливаа этгээд нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэ ханшийг урьдчилан тодорхойлсон судалгаа, шинжилгээг хийхдээ бодит бус, буруу ташаа мэдээлэл ашиглахгүй байх үүрэгтэй.

8.4. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцогч зохицуулалттай этгээд нь дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох, оролцохыг санал болгох, ятгах, бусдад дотоод мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын арван есдүгээр хавсралт

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АРИЛЖИХААР ГАРГАХ ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГЭХ, АРИЛЖИХ, ТАЙЛАГНАХ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификат /цаашид “хадгаламжийн сертификат” гэх/-ийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ны бүртгэлд бүртгэх, биржийн болон биржийн бус зах зээлд арилжихаар гаргах, тайлагнах, бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэлээс хасахтай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2. Биржийн болон биржийн бус зах зээлд арилжихаар гаргах хадгаламжийн сертификатыг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны үнэт цаасны бүртгэлд бүртгэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулахгүй.

1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.2.4-т заасан хадгаламжийн сертификатыг мөнгөний зах зээлд гаргах, арилжихтай холбоотой харилцаа энэ журмын зохицуулалтад хамаарахгүй.

ХОЁР. ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ ГАРГАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Банк нь хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахад дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1. Хороонд хүсэлт гаргахаас өмнөх сүүлийн хоёр жилд тогтвортой үйл ажиллагаа явуулсан байх;

2.1.2. Хороонд хүсэлт гаргах үед зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй байх;

2.1.3. Банкны тухай хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх;

2.1.4. Банкны тухай хууль тогтоомж болон Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг сүүлийн нэг жилийн хугацаанд бүрэн хангаж ажилласан байх;

2.1.5. Хорооноос баталсан компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байх.

2.2. Банк нь энэ журамд заасан шаардлагыг хангаагүй бол Хороо хадгаламжийн сертификатыг бүртгэхээс татгалзах ба татгалзсан шалтгаан, нөхцөлийг тодорхой тусган банкинд энэ тухай бичгээр мэдэгдэнэ.

ГУРАВ. ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БҮРТГҮҮЛЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ, ХҮСЭЛТИЙГ ХЯНАХ, БҮРТГЭХ, БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

3.1. Банк нь биржийн зах зээлд гаргаж буй хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлтийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллагад нэгэн зэрэг гаргаж болно.

3.2. Биржийн зах зээлд гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ:

3.2.1. хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт-1/;

3.2.2. Төв банк /Монголбанк/-ны санал, дүгнэлт;

3.2.3. хадгаламжийн сертификатыг үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргахтай холбоотой банкны эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.2.4. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэсэн тухай шийдвэр;

3.2.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн

тухай баримт.

3.3. Биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх хүсэлтийг Хороонд гаргахдаа дараах баримт бичгийг хүргүүлнэ:

3.3.1. хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл /Хавсралт 2/;

3.3.2. Төв банк /Монголбанк/-ны санал, дүгнэлт;

3.3.3. хадгаламжийн сертификат гаргагчийн хаалттай хүрээнд хадгаламжийн сертификат гаргахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;

3.3.4. биржийн бус зах зээлийн арилжаанд оруулахыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэсэн тухай Холбооны шийдвэр;

3.3.5. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн тухай төлбөрийн баримт.

3.4. Энэ журамд заасан баримт бичгийн бүрдэл дутуу, агуулгын хувьд зөрүүтэй, тодорхойгүй тохиолдолд Хороо нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга ирүүлэхийг банкнаас шаардана.

3.5. Энэ журмын 3.2, 3.3-т заасан хүсэлт гаргагчаас ирүүлсэн баримт бичгийг Хороо хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

3.6. Банк нь харилцагчийн хүсэлтээр хадгаламжийн сертификатыг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд арилжаа эрхлэх байгууллага, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус мэдэгдэж, Хороонд дараах баримт бичгийг ирүүлж, бүртгэлд өөрчлөлт оруулна:

3.6.1. хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт /Хавсралт-4/;

3.6.2. хадгаламжийн сертификатын гэрээ цуцалсан талаарх холбогдох баримт;

3.6.3. Хорооноос шаардсан бусад мэдээлэл.

3.7. Хороо нь энэ журмын 3.6-д заасан хүсэлтийг ажлын 3 өдөрт багтаан хянах ба тухайн хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах нь үндэслэлтэй гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага, арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд өөрчлөлт оруулах зөвшөөрлийг Хорооны даргын албан бичгээр хүргүүлнэ.

3.8. Хадгаламжийн сертификатыг дараах тохиолдолд Хорооны бүртгэлээс хасна.

3.8.1. хадгаламжийн сертификат гаргагч өөрөө хүсэлт гаргасан

3.8.2. хадгаламжийн сертификатын хугацаа дуусгавар болсон;

3.8.3. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хасагдсан;

3.8.4. шүүх болон эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрээр татан буулгах шийдвэр гаргасан.

3.9. Сертификат гаргагч нь хадгаламжийн сертификатыг бүртгэлээс хасуулахдаа дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

3.9.1. хадгаламжийн сертификатын бүртгэлээс хасуулах хүсэлт;

3.9.2. арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлээс хассан тухай шийдвэр;

3.9.3. зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн төлбөрийн баримт

3.10. Хороо хадгаламжийн сертификатыг бүртгэлээс хассан тохиолдолд бүртгэлээс хассан тухай шийдвэрийг сертификат гаргагч, арилжаа эрхлэх болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад тус тус хүргүүлж өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

ДӨРӨВ. ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ БИРЖИЙН БОЛОН БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛД ХУДАЛДАХ, АРИЛЖИХ

4.1. Банк нь энэ журмын 3.5-т заасан шийдвэрийг гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор хадгаламжийн сертификатыг олон нийтэд, эсхүл хаалттай хүрээнд мэргэжлийн хөрөнгө оруулагчдад худалдах ажиллагааг гүйцэтгэнэ.

4.2. Биржийн болон биржийн бус зах зээлд гаргах хадгаламжийн сертификатыг өөрийн үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх этгээд (цаашид “брокер” гэх)-ээр дамжуулан худалдан авах захиалга өгнө.

4.3. Банк, эсхүл түүний брокер нь энэ журмын 3.5-т заасан шийдвэр гарахаас өмнө

стратегийн болон мэргэжлийн хөрөнгө оруулагчдад хадгаламжийн сертификатын талаар танилцуулж, санал болгож болно.

4.4.Банк, эсхүл түүний брокер нь хадгаламжийн сертификатыг анхдагч зах зээлд санал болгож, захиалгыг эхлүүлэх тухай мэдэгдлийг ажлын таваас доошгүй өдрийн өмнө Хороонд мэдэгдэх бөгөөд мэдэгдэл нь дараах агуулгатай байна:

4.4.1.захиалга авч эхлэх огноо, үргэлжлэх хугацаа;

4.4.2. санал болгох хадгаламжийн сертификатын хэмжээ, үнэ;

4.4.3. санал болгох арга, хэлбэр.

4.5.Анхдагч зах зээлийн захиалга авах үйл ажиллагаа нь ажлын гурав өдрөөс илүүгүй хугацаатай байна.

4.6. Банк, эсхүл түүний брокер нь хадгаламжийн сертификатыг биржийн болон биржийн бус зах зээлд худалдсан тухай тайлан /Хавсралт 3/-г ажлын гурван өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

4.7. Хороо энэ журмын 4.6-д заасан тайланг хүлээн авч, хадгаламжийн сертификатыг амжилттай худалдсан гэж үзвэл үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэлийг баталгаажуулах мэдэгдлийг, арилжаа эрхлэх байгууллага болон Холбоонд хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг ажлын хоёр өдөрт багтаан Хорооны даргын албан бичгээр тус тус хүргүүлнэ.

4.8. Биржийн бус зах зээлд санал болгон гаргах хадгаламжийн сертификатыг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч этгээд өөрийн брокероор дамжуулан худалдан авч болно.

ТАВ. ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТ ГАРГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Хадгаламжийн сертификат гаргагч дараах эрх, үүрэгтэй:

5.1.1.Хорооны бүртгэлд бүртгүүлэхээр гаргасан хүсэлт нь хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаарх явцын мэдээ, мэдээллээр хангагдах;

5.1.2.Хорооноос хадгаламжийн сертификатын бүртгэлтэй холбоотой аливаа мэдээлэл хүргүүлэхийг шаардсан бол тодруулга, нэмэлт баримт бичгийг заасан хугацаанд Хороонд хүргүүлэх;

5.1.3.холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;

5.1.4.хадгаламжийн сертификатыг бүртгүүлэхтэй холбоотойгоор Хороонд хүргүүлсэн баримт бичиг, түүнд хавсаргасан холбогдох дүгнэлт зэрэг бусад баримт бичгийг хадгаламжийн сертификатын хугацаа дуусах хүртэлх хугацаанд хадгалах.

ЗУРГАА. МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛ

6.1.Хадгаламжийн сертификат гаргагч нь жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланг гаргах бөгөөд жилийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг дараа сарын 20-ны өдрийн дотор Хороо болон Монголбанкинд цаасан, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ.

6.2.Энэ журмын 6.1-т заасан жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайланд дараах мэдээллийг тусгана:

6.2.1. нийт хадгалуулагчийн тоо, тэдгээрийн хадгалагдаж буй сертификатын тоо;

6.2.2. хадгаламжийн сертификатын хүү, дуусах хугацаа;

6.2.4.үнэт цаасны зах зээлд арилжсан нийт сертификатын тоо, арилжааны дүн;

6.3. Монголбанкны зайны болон газар дээрх хяналт шалгалтаар банкны зохистой засаглал алдагдсан, төлбөрийн чадвар муудаж байгаа нь тогтоогдсон бол энэ талаар Хороонд мэдэгдэнэ.

6.4.Банк нь энэ журамд заасан мэдээллийг холбогдох журамдаа тусгаж, үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж ажиллана.

Хавсралт 1: Нийтэд санал болгон гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл

Хавсралт 2: Хаалттай хүрээнд гаргах хадгаламжийн сертификатыг бүртгүүлэх өргөдөл

Хавсралт 3: Хадгаламжийн сертификатын Рангдагч зах зээлд санал болгон худалдсан тухай тайлан

Хавсралт 4: Хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх,
арилжих, тайлагнах”-ын
I дүгээр хавсралт

**НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ
ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Огноо:/...../.....
	Он, сар, өдөр

Санхүүгийн зохицуулах хороонд

1.	Хадгаламжийн сертификат гаргагчийн мэдээлэл	
1.1.	Оноосон нэр:	Монгол:
		Англи:
1.2.	Хуулийн этгээдийн хэлбэр	Хувьцаат компани
		Хязгаарлагдмал хариуцлагатай компани
1.3.	Регистрийн дугаар:	
1.4.	Оришин байх албан ёсны хаяг /Монгол Улсад төлөөлөгчийн газартай бол түүний хаягийг мөн бичнэ/:	
1.5.	Цахим хуудас:	
1.6.	Цахим шуудангийн хаяг:	
1.7.	Холбоо барих утас:	
2.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл	
2.1.	Хадгаламжийн сертификатын нэр:	
2.2.	Хадгаламжийн сертификат гаргах арилжаа эрхлэх байгууллага:	
2.3.	Эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дугаар, огноо:	
2.4.	Хадгаламжийн сертификатын хугацаа:	

2.5.	Тоо ширхэг:	
2.6.	Нэрлэсэн үнэ:	
2.7.	Нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ:	
2.8.	Хадгаламжийн сертификатыг нийтэд санал болгон худалдахаар төлөвлөсөн хугацаа:	

Энэхүү өргөдөл, түүнд хавсарган хүргүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг өргөдөл гаргагч бид бүрэн хариуцах бөгөөд хөрөнгө оруулагчид тохиолдож болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулагчдад хүргэвэл зохих мэдээллийг үнэт цаасны танилцуулга, бусад баримт бичигт үнэн зөв, бүрэн тусгасан болно.

Өргөдөл гаргасан:

1. Овог, нэр:.....

2. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн ТУЗ-ийн дарга

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

3. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:.....

Тамга/тэмдэг)

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө/

Өргөдөл хүлээн авсан ажилтны овог нэр:	Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:	Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:
--	---	---

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх,
арилжих, тайлагнах”-ын
2 дугаар хавсралт

**ХААЛТТАЙ ХҮРЭЭНД ГАРГАХ
ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Огноо:/.../.... (0000,сс,өө)
Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификат гаргагчийн мэдээлэл	
1.1.	Нэр:	
1.2.	Хадгаламжийн сертификат гаргагчийн хэлбэр	Хувьцаат компани / ISIN код/ Хязгаарлагдмал хариуцлагатай компани Аймаг / нийслэл
1.3.	Хөрөнгө оруулалтын хэлбэр	Дотоодын хөрөнгө оруулалттай Гадаадын хөрөнгө оруулалттай
1.4.	Үүсгэн байгуулагдсан огноо:	
1.5.	Улсын бүртгэлийн дугаар:	
1.6.	Регистрийн дугаар:	
1.7.	Үйл ажиллагааны чиглэл: /чиглэл тус бүрийг бичнэ/	
1.8.	Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?	Тийм, үгүй Тийм бол товч мэдээлэл:
1.9.	Эзэмшдэг тусгай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийн дугаар, эзэмшсэн огноо, олгосон эрх бүхий байгууллага, хугацаа:	

Өргөдөл гаргасан:

2. Овог, нэр:.....

3. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн ТУЗ-ийн дарга

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

4. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....” ...К-ийн Ерөнхий нягтлан
бодогч

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Өргөдөл гаргасан огноо:.....

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан
ажиллах ажилтны овог нэр, албан тушаал,
холбоо барих утас:

--

ТУСГАЙ ТЭМДЭГЛЭЛ /зөвхөн Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан бөглөнө/

<p>Өргөдөл хүлээн авсан ажилтны овог нэр:</p>	<p>Өргөдөл хүлээн авсан огноо, цаг, минут:</p>	<p>Өргөдөл түүнд хавсаргасан баримтын тоо /нүүрээр/:</p>
---	--	--

**ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН
АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД САНАЛ БОЛГОН
ХУДАЛДСАН ТУХАЙ ТАЙЛАН**

Огноо:/.../.... (0000,сс,өө)
Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл	
1.1.	Хадгаламжийн сертификат гаргагчийн нэр:	
1.2.	Бүртгэлтэйарилжаа эрхлэх байгууллага:	
1.3.	Хадгаламжийн сертификатын нэр:	
1.4.	Бүртгэлтэй тоо, ширхэг:	
1.5.	Нийт үнийн дүн:	
2.	Санал болгосон тухай мэдээлэл	
2.1.	Захиалгаавчэхэлсэн огноо, үргэлжилсэн хугацаа:	
2.2.	Санал болгосон тоо ширхэг:	
2.3.	Санал болгосон хэлбэр:	Захиалгын бүртгэлийн арга, Тогтсон үнийн арга.
2.4.	Санал болгосон үнэ /захиалгын бүртгэлийн аргаар санал болгосон бол дээд, доод үнийг мөн бичнэ/:	
2.5.	Татантөвлөрүүлэхээртөлөвлөсөн мөнгөн хөрөнгийн хэмжээ:	
2.6.	Хүлээн авсан саналын үнийн дүн, хувь:	
2.7.	Анхдагч зах зээлд хүлээн авсан саналын мэдээлэл	
Агуулга	Хөрөнгө оруулагч	Харилцагч

	<i>Олон нийт</i>	<i>Мэргэжлийн хөрөнгө оруулагч</i>	<i>Бусад</i>
<i>Хөрөнгө оруулагчдын тоо</i>			
<i>Үнийн дүн</i>			
<i>Хувь</i>			

3.Арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлт

3.1. Арилжаа нь холбогдох журмын дагуу явагдсан эсэх:

3.2.Хорооны журмын дагуу явагдсан эсэх:

3.3.Захиалгын бүртгэлийг хийх явцад аливаа харилцагч, хөрөнгө оруулагчаас санал, гомдол гаргасан эсэх: /тийм бол тодорхой бичнэ үү/

Дээрх мэдээлэл үнэн зөв эсэх:

Баталгаажуулалт:

Брокер:

Хадгаламжийн сертификат гаргагч:

Тийм /авсан арга хэмжээний тухай мэдээллийг бичнэ үү/

Үгүй

Амжилттай

Амжилтгүй

“Үнэт цаасны зах зээлд арилжихаар гаргах
хадгаламжийн сертификатыг бүртгэх,
арилжих, тайлагнах”-ын
4 дүгээр хавсралт

**ХАДГАЛАМЖИЙН СЕРТИФИКАТЫН
БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХҮСЭЛТ**

Огноо:/.../.... (0000,сс,өө)
Дугаар:

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНД

1.	Хадгаламжийн сертификатын мэдээлэл			
1.1.	Хадгаламжийн сертификат гаргагчийн нэр:			
1.2.	Бүртгэлтэйарилжаа эрхлэх байгууллага:			
1.3.	Хадгаламжийн сертификатын нэр:			
1.4.	Бүртгэлтэй тоо, ширхэг:			
1.5.	Нийт үнийн дүн:			
2.	Хадгаламжийн сертификатын бүртгэлд өөрчлөлт оруулах болсон шалтгаан:			
2.1	Агуулга	Хадгаламжийн сертификатын мэдээлэл		
	<i>Харилцагчдын нэрс</i>	<i>Нэгжийн үнийн дүн</i>	<i>Тоо</i>	<i>Үнийн дүн</i>
	<i>Нийт</i>			

Өргөдөл гаргасан:

5. Овог, нэр:.....

Албан тушаал: Сертификат гаргагч
“.....”...К-ийн гүйцэтгэх захирал

Гарын үсэг:.....

(Тамга/тэмдэг)

Өргөдөл гаргасан огноо:.....

Өргөдөлтэй холбоотой асуудлыг хариуцан
ажиллах ажилтны овог нэр, албан тушаал,
холбоо барих утас:

--

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын хорьдугаар хавсралт

ХУВЬЦААНЫ ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ПРОГРАММ ХАНГАМЖИД ТАВИХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид "Хороо" гэх)-оос хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх этгээд (цаашид "үйлчилгээ үзүүлэгч" гэх)-ийг бүртгэх, бүртгэлээс хасах, түүний үйл ажиллагаа, програм хангамжид тавигдах нөхцөл шаардлагыг тогтоох, хувьцааны хамтын санхүүжилтаар татан төвлөрүүлэх хөрөнгийн дээд хэмжээ, иргэн хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын хязгаарыг тогтоохтой холбогдох харилцааг зохицуулна.

1.2.Гарааны компани биржийн бус зах зээл дээр олон нийтэд санал болгон хувьцаа гаргах замаар санхүүжилт татахтай холбоотой харилцааг Хорооноос баталсан Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

Хоёр.Үйлчилгээ үзүүлэгчид тавигдах ерөнхий шаардлага

2.1.Үйлчилгээ үзүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.энэ журамд заасан бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц болон бусад шаардлага;

2.1.2.хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ 1.0 тэрбум төгрөг байх бөгөөд зээлийн эх үүсвэрээс бусад мөнгөн хөрөнгөөс бүрдсэн байх;

2.1.3.эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлохтой холбогдох журамд заасан шаардлагыг хангасан байх;

Гурав.Үйлчилгээ үзүүлэгчийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн шаардлага

3.1.Үйлчилгээ үзүүлэгч нь гурав болон түүнээс дээш гишүүнтэй төлөөлөн удирдах зөвлөлтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна.

3.2.Энэ журмын 3.1-т заасан төлөөлөн удирдах зөвлөл нь дараах дүрэм, журам, бодлогын баримт бичгийг баталсан байна:

3.2.1.төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам;

3.2.2.компанийн гурван жилийн бизнес төлөвлөгөө;

3.2.3.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, удирдах талаар хэрэгжүүлэх төлөвлөгөө, дотоод хяналтын хөтөлбөр;

3.2.4.мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;

3.2.5.Кибер аюулгүй байдлын тухай хуульд нийцүүлсэн мэдээллийн технологийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам;

3.2.6.дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахаас сэргийлэх журам;

3.2.7.арилжааг урвуулан ашиглахаас сэргийлэх, хяналт тавих журам;

3.2.8.дампуурах, татан буугдах, кибер халдлага, түрэмгийлэлд өртөх зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед авах арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө;

3.2.9.хөрөнгө оруулагчдын гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам;

3.2.10.бусад шаардлагатай журам.

3.3.Үйлчилгээ үзүүлэгч нь дараах бүтэц, зохион байгуулалт, тухайн чиглэлээр мэргэшсэн хүний нөөцтэй байна:

3.3.1.мэдээллийн технологи, аюулгүй байдал хариуцсан нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.3.2.дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх нэгжтэй, эсхүл хариуцсан ажилтантай байх;

3.3.3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих болон комплайнсын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий хариуцсан нэгжтэй;

3.3.4.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой үйлчилгээ хариуцсан нэгжтэй байх.

3.4.Хуульд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэх удирдлага, мэргэжилтнүүд нь мэргэжлийн хариуцлагын даатгалд даатгуулсан байх.

Дөрөв.Үйлчилгээ үзүүлэгчийн програм хангамж, мэдээллийн технологид тавигдах шаардлага

4.1.Үйлчилгээ үзүүлэгч нь хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэхэд шуурхай, тасралтгүй, үйл ажиллагааны онцлогт тохирсон тусгай програм хангамжтай байх бөгөөд уг програм хангамж нь энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

4.1.1.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд холбогдолгүй гуравдагч этгээдээс нууцлах, системийн шифрлэлт нууцлал, аюулгүй байдлын стандартыг хангах;

4.1.2.зах зээлийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх боломжтой байх;

4.1.3.олон нийтэд мэдээлэл хүргэх нээлттэй самбартай байх;

4.1.4.оролцогчид өөр хоорондоо захидал харилцааны зурвас илгээх боломжоор хангагдах бөгөөд түүнийг хадгалж, түүх үүсгэх боломжтой байх;

4.1.5.бодит цагийн горимоор санхүүжилтийн үйл явц харагдах боломжтой байх бөгөөд хөрөнгө оруулагчдын эзэмшиж буй хувьцааны мэдээллийг арилжаанд оролцогчид авах боломжтой байх.

4.2.Энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан мэдээллийн технологийн стандартын хүчин төгөлдөр мөрдөж буй хувилбарыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах;

4.3.Энэхүү журмын нэгдүгээр хавсралтад заасан MNS ISO/IEC 27001 мэдээлэл технологийн стандартын сүүлийн хувилбарыг хангаж, хөндлөнгийн эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байна.

Тав.Үйл ажиллагааны зохицуулалт

5.1.Гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид дараах шаардлага тавигдана:

5.1.1.Гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь зөвхөн Монгол улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд байна.

5.1.2.Гарааны компани нь 500.0 сая төгрөг хүртэлх, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь 1.0 тэрбум төгрөг хүртэлх санхүүжилтийг нэг төслийн хувьд үйлчилгээ үзүүлэгчийн платформоор дамжуулантатан төвлөрүүлнэ.

5.1.3.Гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан 2 хүртэлх сарын хугацаанд санхүүжилт татан төвлөрүүлнэ.

5.2.Гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид нь дараах шаардлагыг хангасан эсэхээ үйлчилгээ үзүүлэгчид тодорхойлуулсны үндсэн дээр тус үйл ажиллагаанд оролцоно:

5.2.1.зээл, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй болохыг нотлох баримт бичиг;

5.2.2.татварын өр, төлбөргүй болохыг нотлох баримт бичиг;

5.2.3.санхүүжилт татан төвлөрүүлж буй хугацаанд өөр эх үүсвэрээс санхүүжилт татахгүй байх;

5.2.4.эдийн засгийн гэмт хэрэг үйлдэж байсан эсэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, банк санхүү, мэдээллийн нууцлалтай холбоотой хууль тогтоомжийн зөрчил сүүлийн 2 жилийн хугацаанд гаргаж байгаагүй байх;

5.2.5.Хорооноос шаардсан бусад.

5.3.Үйлчилгээ үзүүлэгч нь гарааны компани, жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчийн хамтын санхүүжилтийн платформоор дамжуулан гаргах төслийн танилцуулгатай танилцан шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд гаргахыг зөвшөөрнө.

5.4.Хамтын санхүүжилтийн үйл ажиллагаагаар татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийг зөвхөн үйлчилгээ үзүүлэгч, санхүүжилт татан төвлөрүүлэгчийн дундын тусгайлсан дансанд төвлөрүүлэх бөгөөд данс нь өөрийн үйл ажиллагаанаас тусгаарласан, системд нөлөө бүхий арилжааны банкны данс байна.

5.5.Тогтоосон хугацаанд татан төвлөрүүлэхээр зарласан хөрөнгийг бүрдүүлж чадсан тохиолдолд үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгө татан төвлөрүүлж буй гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчийн дансанд өмчлөх эрх шилжүүлснээс хойш ажлын 1 өдрийн дотор шилжүүлнэ.

5.6.Тогтоосон хугацаанд татан төвлөрүүлэхээр зарласан хөрөнгийг бүрдүүлж чадаагүй тохиолдолд татан төвлөрүүлсэн хөрөнгийг хөрөнгө оруулагчид ажлын 5 өдрийн дотор буцаан шилжүүлнэ.

5.7.Хамтын санхүүжилтийн үйл ажиллагаагаар дамжуулан санхүүжилт татсан гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч нь хувьцаагаа хоёрдогч зах зээлд гарган арилжаалах тохиолдолд хаалттай хувьцаат компани хэлбэрээр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад бүртгэгдэж, программ хангамжтай холбогдсон байна.

5.8.Энэ журмын 5.7-д заасан этгээдийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг санхүүжилт татсанаас хойш нэг жилийн хугацаанд нээхгүй.

5.9.Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад үйлчилгээ үзүүлэгч хяналт тавина.

5.10.Үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн хамтын санхүүжилтийн платформд дараах этгээдийг оролцуулахыг хориглоно:

5.10.1.Үйлчилгээ үзүүлэгчийн саналын эрхтэй энгийн хувьцааны 20 болон түүнээс дээш хувийг эзэмшигч;

5.10.2.үйлчилгээ үзүүлэгчийн удирдлага, ажилтан;

5.10.3. гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн холбогдох этгээд;

5.10.4.Тухайн санал болгох төсөл нь нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлнө гэж үзсэн тохиолдолд.

5.11.Үйлчилгээ үзүүлэгч нь хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд авах үйлчилгээний шимтгэлийн хэмжээгээ өөрсдөө дотооддоо тогтоох бөгөөд Хороонд уг шимтгэлийг тогтоосон тооцоо, судалгааг ирүүлж урьдчилж хянуулсны үндсэн дээр мөрдүүлнэ.

Зургаа. Хувьцааны хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэх гэрээ

6.1.Үйлчилгээ үзүүлэгч болон харилцагчийн хооронд байгуулсан гэрээ, хэлцэлд дараах нөхцөлийг заавал тусгаж, хүлээн зөвшөөрснийг баталгаажуулна:

6.1.1.хөрөнгө оруулагч нь хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулахдаа түүнээс үүдэн гарах эрсдэлээ өөрөө бүрэн даахаа илэрхийлсэн цахим баталгаа гаргах

6.1.2.үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд хүндрэл үүссэн тохиолдолд үйл ажиллагааг зогсоох төлөвлөгөө;

6.1.3.үйлчилгээ үзүүлэгч бүртгэлээс хасагдаж, үйл ажиллагаагаа зогсоосон тохиолдолд авах арга хэмжээ;

6.1.4.хөрөнгө нь хадгаламжийн даатгал, үнэт цаасны хөрөнгө оруулагчдыг хамгаалах аливаа даатгалд хамаардаггүй талаарх мэдээлэл;

6.1.5.үйлчилгээ үзүүлэгч, харилцагчийн эрх, үүрэг;

6.1.6.хөрөнгө оруулж буй компанийн хөрөнгийн талаарх үнэ цэнэ огцом өөрчлөгдөх эрсдэлийн талаарх мэдээлэл;

6.1.7.хөрөнгө оруулж буй компанийн хөрөнгийн үнэ цэнэ нь компанийн ашигт үйл ажиллагаанаас хамаарч тодорхойлогдох тул үнэ цэнийн хэлбэлзлээс хамаарч алдагдал хүлээх эрсдэлийн талаарх мэдээлэл.

6.2.Бусад гэрээний нөхцөлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн талууд гэрээнд тусгаж болно.

Долоо.Хөрөнгө оруулалт хийх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага

7.1.Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-т заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдээс гадна иргэн, хуулийн этгээд, олон улсын санхүүгийн байгууллагууд үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан санхүүжилт татаж байгаа компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийж болно.

7.2.Энэ журмын 7.2.1, 7.2.2-т заасан шаардлагыг хангасан Монгол улсын иргэн, хуулийн этгээд нь гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулахад дараах хязгаарлалт тавигдах бөгөөд үүнд үйлчилгээ үзүүлэгч хяналт тавина:

7.2.1.энэ журмын 7.2.1-т заасан Монгол улсын иргэний хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулах дээд хэмжээ нэг төслийн хувьд 5.0 сая төгрөг байх бөгөөд 1 жилд 10 хүртэлх төсөлд хөрөнгө оруулна;

7.2.2.энэ журмын 7.2.2-т заасан Монгол улсын хуулийн этгээд нь хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд хөрөнгө оруулах дээд хэмжээ нэг төслийн хувьд 50.0 сая төгрөг байх бөгөөд 1 жилд 20 хүртэлх төсөлд хөрөнгө оруулж болно.

Найм.Хороо болон үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг

8.1.Хороо хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

8.1.1.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд хяналт тавих, зах зээлийг урвуулан ашиглахаас сэргийлэх;

8.1.2.үйлчилгээ үзүүлэгчид хууль ёсны шаардлага тавих, хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулах;

8.1.3.үйлчилгээ үзүүлэгчээс тайлан, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд, эсхүл шаардлагатай гэж үзсэн үед ирүүлэхийг шаардах;

8.1.4.энэ журмын 8.1.3-д заасан тайлан, мэдээ, мэдээлэлтэй холбоотойгоор нэмэлт тайлбар, тодруулга авах;

8.1.5.эрсдэлийг бууруулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид хүлээлгэсэн хариуцлагын талаарх мэдээллийг ил тод мэдээлэх;

8.1.6.шаардлагатай гэж үзсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалтыг гүйцэтгэх;

8.1.7.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны үнэт цаасны хадгаламжийн үйл ажиллагааг хэвийн явуулахад холбогдох байгууллагатай хамтран ажиллах.

8.2.Үйлчилгээ үзүүлэгч нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

8.2.1.энэ журамд заасан шаардлага, шалгуурыг хангаж байгаа эсэхийг Хороогоор урьдчилан хянуулж, бүртгүүлсний үндсэн дээр хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа эрхлэх;

8.2.2.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд тасралтгүй, ил тод, алдаагүй, шударгаар зохион байгуулах;

8.2.3.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай ажлын байр, хүний нөөц, программ хангамж болон техник, тоног төхөөрөмжийг бүрдүүлэх;

8.2.4.хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг урвуулан ашиглах, санхүүжилт татах программ хангамжид доголдол үүсэхээс сэргийлэх зорилгоор бодит цагийн хяналт тавих, тандалт судалгаа хийх;

8.2.5.төвлөрсөн санхүүжилтийн зарцуулалтад хяналт тавих;

8.2.6.Хороо болон олон нийтийг мэдээ, мэдээллээр хангах;

8.2.7.ашиг сонирхлын зөрчил үүссэн, зах зээлийг урвуулан ашигласан талаар нотлох баримт гаргах чиглэлээр төвлөрсөн санхүүжилтийн бүхий л мэдээллийг аюулгүй хадгалах, бүртгэл хөтлөх;

8.2.8.хөрөнгө оруулагчдын мэдээллийг тухай бүр шинэчлэх;

8.2.9.хөрөнгө оруулагчдаас гомдол гаргасан тохиолдолд уг асуудалтай холбоотой нэмэлт тайлбар, шаардлагатай бүхий л баримт материалыг Хороонд хүргүүлэх.

8.2.10.зах зээлийн нөхцөл байдалтай холбоотойгоор Хорооноос шаардсан мэдээллийг тухай бүр ирүүлнэ.

Ес.Бүртгэх, бүртгэхээс татгалзах, бүртгэлээс хасах

9.1.Хүсэлт гаргагч нь энэхүү журмын гуравдугаар хавсралтад заасан баримт бичгийг нотлох баримтын хамт Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

9.2.Хороо бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй бол хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэж, нэмэлт баримт бичгийг шаардаж болно.

9.3.Хороо шаардлагатай тохиолдолд хүсэлт гаргагчаас ирүүлсэн баримт бичгийн талаар холбогдох этгээдээс тодруулах, дүгнэлт гаргуулах, лавлагаа авч болно.

9.4.Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа явуулах ажлын байр тоног төхөөрөмж, программ хангамж нь энэ журмаар тогтоосон шаардлагыг хангасан эсэхийг Хорооны холбогдох албан тушаалтан газар дээр нь шалгаж, танилцаж болно.

9.5.Хороо дараах үндэслэлээр үйлчилгээ үзүүлэгчийг бүртгэхээс татгалзана:

9.5.1.бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн;

9.5.2.бүртгэлээс хасуулах хүсэлтээ албан бичгээр гаргасан;

9.5.3.бүртгүүлснээс хойш 6 сарын хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй;

9.5.4.үйлчилгээ үзүүлэгчид тавигдах шаардлагыг хангахгүй болсон;

9.5.5.эрх бүхий албан тушаалтан болон холбогдох этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шаардлагыг хангаагүй;

9.5.6.Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон энэ журамд заасан бусад шаардлагыг хангаагүй.

9.6.Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү журамд тусгагдсан аль нэг холбогдох шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон тохиолдолд хугацаатай үүрэг даалгавар өгч, үйл ажиллагааг түр түдгэлзүүлэх арга хэмжээ авах бөгөөд үүрэг даалгаврын хугацаанд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахгүй хэвээр байх нь Хорооны бүртгэлээс хасах үндэслэл болно.

9.7.Үйлчилгээ үзүүлэгч болон гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч хоёрын харилцаа ямагт ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмаар явагдах бөгөөд ашиг сонирхлын зөрчил илэрсэн нь тогтоогдвол Хорооны бүртгэлээс хасах хүртэл арга хэмжээ авна.

Арав.Хороонд мэдээлэл хүргүүлэх

10.1.Үйлчилгээ үзүүлэгч нь жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн аудитлагдсан тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд цахимаар ирүүлнэ.

10.2.Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгийн хадгалалт, бүртгэлтэй холбоотой мэдээллийг цахим хэлбэрээр Хороонд сар бүр ирүүлнэ.

10.3.Үйлчилгээ үзүүлэгч нь гарааны компани, жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчийн татан төвлөрүүлсэн санхүүжилтийн зарцуулалтын тайланг цахим хэлбэрээр Хороонд улирал бүр ирүүлнэ.

“Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн үйл ажиллагаа, түүний программ хангамжид тавих нөхцөл, шаардлага”-ын нэгдүгээр хавсралт

ХУВЬЦААНЫ ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА МӨРДӨХ МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СТАНДАРТЫН ЖАГСААЛТ

№	Стандартын нэр	
1	MNS 5969	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга техник-Мэдээллийн аюулгүй байдлын эрсдлийн удирдлага
2	MNS 6248	Программ хангамжийн боловсруулалт-Программ хахгамжийн бүтээгдэхүүний чанарын шаардлага болон үнэлгээ (Square)-чанарын шаардлага
3	MNS 6197	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга-Мэдээллийн технологийн сүлжээний аюулгүй байдал-1-р хэсэг: Сүлжээний аюулгүй байдлын архитектур
4	MNS 6242-2	Мэдээллийн технологи-Аюулгүй байдлын арга-Мэдээллийн технологийн сүлжээний аюулгүй байдал-2-р хэсэг: Сүлжээний аюулгүй байдлын архитектур
5	MNS ISO 12207	Программ хангамж боловсруулах үйл ажиллагааны циклүүд
6	MNS ISO 19011	Менежментийн тогтолцооны аудитын заавар
7	MNS ISO/IEC 27001	Мэдээллийн технологи: Аюулгүй байдлын арга техник – Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-Шаардлага
8	MNS ISO/IEC 13335-1	Мэдээллийн технологи: Аюулгүй байдлын арга техник – Мэдээллийн аюулгүй байдлын удирдлага-1-р хэсэг: Мэдээлэл холбооны технологийн аюулгүй байдлын үндсэн ойлголтууд болон загварууд
9	IEEE 829	Программ хангамж турших болон баримт бичигжүүлэлтийн стандарт
10	MNS 6498	Харилцаа холбооны тоног төхөөрөмжид тавих аюулгүй байдлын шаардлага
11	MNS 6528	Дата төвийн цахилгаан холбооны дэд бүтэц

“Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн үйл ажиллагаа, түүний программ хангамжид тавих нөхцөл, шаардлага”-ын хоёрдугаар хавсралт

ХУВЬЦААНЫ ХАМТЫН САНХҮҮЖИЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭХЭЭР ҮҮСГЭН БАЙГУУЛАХ БАРИМТ БИЧГИЙГ БҮРТГҮҮЛЭХ ТУХАЙ ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч компанийн нэр	Монгол					
	Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ)					
Улсын бүртгэлийн дугаар						
Иргэний бүртгэлийн дугаар						
Хэсэг 1. Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл						
Хувь нийлүүлсэн хөрөнгө (төгрөгөөр)						
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай					
Хаяг байршил	Аймаг/хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж, байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим шуудангийн хаяг						
Цахим хуудас						
Удирдлага, мэргэшсэн хүний нөөцтэй холбоотой мэдээлэл:						
Нийт ажилтан, албан хаагчдын тоо						
Албан тушаал	Овог, нэр	Харьяалал	Иргэний бүртгэлийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ТУЗ-ийн дарга						
ТУЗ-ийн гишүүд						
Гүйцэтгэх удирдлага						
Мэргэшсэн нягтлан бодогч (байгаа бол)						

Мэдээллийн технологийн хариуцсан албан хаагч					
Бусад					
Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх мэдээлэл					
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ (төгрөгөөр)
Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Тоо ширхэг	Үнэ (төгрөгөөр)

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Бид үйл ажиллагаандаа Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн хангаж, биелүүлж ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд (тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ.):

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Иргэний бүртгэлийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:
Хуулийн этгээдийн
Тэмдэг

_____ / _____ /

(гарын үсэг)

(гарын үсгийн тайлал)

“Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагааг эрхлэх этгээдийн үйл ажиллагаа, түүний программ хангамжид тавих нөхцөл, шаардлага”-ын гуравдугаар хавсралт

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Энэхүү журмын хоёрдугаар хавсралт дахь өргөдөл	
2	Улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрмийн эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар, хувьцааны хамтын санхүүжилтийн үйлчилгээ үзүүлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр	
3	Хувьцааны хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн танилцуулга, мэдээлэл, технологийн дэд бүтцийн тасралтгүй, найдвартай ажиллагаа, нууцлал, аюулгүй байдлыг хангасан талаарх мэдээлэл, мэдээлэл хадгалах системийн талаар танилцуулга	
4	Тухайн үйл ажиллагааны гурван жилийн бизнес төлөвлөгөө	
5	Компанийн дотоод бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтнууд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан болохыг нотлох баримт бичиг	
6	Хүсэлт гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт, гарал үүслийн талаарх тодорхойлолт	
7	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах тогтолцоо, автомат хяналтын системийн талаарх танилцуулга	
8	Журмын 3.2-т заасан журмууд, төлөвлөгөө	
9	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр	
10	Үүсгэн байгуулах ажиллагааны нийт төсөв, зардал, уг зардлыг санхүүжүүлэх чадавх, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, гарал үүслийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;	
11	Улсын тэмдэгтийн хураамж, Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт	
12	Харилцагчдаас авах үйлчилгээний хураамжийн хувь хэмжээ, харилцагчтай байгуулах гэрээний төсөл	
13	Компанийн ажлын байрны тодорхойлолт, ажлын байр нь компанийн өөрийн өмчлөлийн байр бол үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувь, эсхүл нотариатаар баталгаажуулсан хуулбар, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбар	

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны ...
дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах
зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн
багц журам”-ын хорин нэгдүгээр хавсралт

ҮНЭТ ЦААС ЗЭЭЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад хамаарах үнэт цаасыг зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг эрхлэхэд тавих шаардлагыг тогтоох, зээлэх, зээлдүүлэх ажиллагаанд оролцогчдын эрх үүргийг тодорхойлох, эрсдэлийн удирдлага, мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтэд Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэ журмаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн зохицуулалтад хамаарахгүй мөнгөний зах зээлийн хэрэгслийг зээлэх, зээлдүүлэх, үнэт цаасыг барьцаалсан тохиолдолд барьцааны цахим мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахгүй.

Хоёр. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагаа

2.1. Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх үнэт цаасны компани, хөрөнгө оруулалтын сан (цаашид “зээлдүүлэгч” гэх) нь үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээг эрхлэн гүйцэтгэнэ.

2.2. Үнэт цаас зээлдүүлэгч болон зээлдэгчийн хооронд үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээг зуучлах, барьцаа хөрөнгийг бүртгэж, хадгалах, тооцооллыг хийх зэрэг эрх үүргийг үнэт цаас зээлдүүлэх ажиллагаанд үнэт цаасны компани, эсхүл кастодиан (цаашид “зуучлагч” гэх) хэрэгжүүлнэ.

2.3. Хамтын нээлттэй, хаалттай болон хувийн хөрөнгө оруулалтын сан (цаашид “ХОС” гэх)-ийн хувьд хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодианаар дамжуулан сангийн актив хөрөнгөд бүртгэлтэй байгаа үнэт цаасыг зээлдүүлнэ.

2.4. Үнэт цаасны компани шууд буюу зуучлагчгүйгээр үнэт цаасны өмчлөх эрхэд бүртгэлтэй өөрийн нэр дээрх болон номиналь эзэмшигчийн үнэт цаасыг түүний зөвшөөрөлтэйгөөр үнэт цаас зээлдэгчид зээлдүүлэх бөгөөд энэ тохиолдолд Хорооноос үнэт цаасны номиналь данс эзэмших зөвшөөрөл авсан байна.

2.5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.1.19-д заасан этгээд (цаашид “зээлдэгч” гэх) үнэт цаас зээлдүүлэх ажиллагаанд оролцож, энэ журмаар зөвшөөрсөн үнэт цаасыг зээлдэн авч болно.

2.6. Зээлдүүлэгч нь Засгийн газар, аймаг, нийслэлийн үнэт цаас, Монгол Улсын хөгжлийн банк, олон улсын байгууллагаас гаргасан өрийн хэрэгсэл, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын I ангилалд бүртгэлтэй компанийн хувьцаа, нээлттэй арилжаалагддаг компанийн бонд, үнэт цаасны зах зээлд гаргасан хадгаламжийн сертификатаас бусад үнэт цаасыг зээлдүүлэхгүй буюу үнэт цаас зээлдүүлэгчид учирч болзошгүй эрсдэл, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан түргэн хөрвөх чадвартай, санхүүгийн эрсдэл багатай үнэт цаасыг зээлдүүлэх зарчмыг үйл ажиллагаандаа баримтална.

2.7. Зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь зээлдэгчийг таньж мэдэх, түүний санхүүгийн чадамж, барьцаа хөрөнгө, хөрөнгө оруулалтын туршлага зэрэг хүчин зүйлсийг хянаж үзэж, энэ талаарх мэдээллийг хүлээн авсны дараа тухайн зээлдүүлэгч нь үнэт цаасаа зээлдүүлэх эсэх шийдвэрийг гаргана.

2.8. Үнэт цаас зээлдүүлэх ажиллагаанд оролцож буй талууд “Үнэт цаас зээлдүүлэх гэрээ” (цаашид “гэрээ” гэх)-г Олон улсын үнэт цаас зээлдүүлэх холбоо (ISLA)-ны зарчмуудад тулгуурлан байгуулах бөгөөд уг гэрээнд дараах зүйлсийг тусгана:

2.8.1. Үнэт цаас зээлдүүлэх ажиллагаанд оролцож буй талуудын хууль ёсны нэр, хаяг, хуулийн этгээдийн бүртгэлийн дугаар болон бусад мэдээлэл;

2.8.2. Зээлдүүлэх үнэт цаасны төрөл, тоо хэмжээ, тус бүрийн болон нийт үнийн дүн;

- 2.8.3. Зээлийн хүүгийн хувь хэмжээ;
- 2.8.4. Зээлийн хугацаа;
- 2.8.5. Зээлийн барьцаа;
- 2.8.6. Зээлийн барьцааны үнэлгээ;
- 2.8.7. Үйлчилгээний хураамж, шимтгэлийн хэмжээ;
- 2.8.8. Талуудын эрх үүрэг, хариуцлага;
- 2.8.9. Гэрээний зөрчил үүссэн тохиолдолд талуудын авах арга хэмжээ;
- 2.8.10. Шаардлагатай бусад мэдээлэл

2.9. Зээлдэгч нь зээлдэж авсан үнэт цаасны үнэ цэнэ дээр үндэслэн үнэт цаасыг эргэн төлөх баталгаа болгон барьцаа хөрөнгө байршуулах бөгөөд барьцаа хөрөнгө нь бэлэн мөнгө, болон энэ журмын 2.6-т заасан түргэн хөрвөх чадвартай, санхүүгийн эрсдэл багатай санхүүгийн хэрэгслээс бүрдэнэ.

2.10. Энэхүү журмын 2.9-д заасан бэлэн мөнгөний барьцаа хөрөнгөтэй холбоотой дараах үйл ажиллагааг зээлдүүлэгч, эсхүл зуучлагч хэрэгжүүлж болно:

2.10.1. Зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь гэрээнд заасан бол зээлдэгч зээлээр авсан үнэт цаасаа буцаан олгох хүртэл барьцаанд байгаа бэлэн мөнгийг богино хугацааны мөнгөн хадгаламжид хадгалуулах;

2.10.2. Энэхүү журмын 2.10.1-т заасан барьцаа хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд зээлдүүлэгч нь олсон хүүгийн орлогоос тодорхой хэмжээг зээлдэгчид төлөх бөгөөд хүүгийн хэмжээ, төлбөрийн нөхцөлийг талууд тохиролцсоны үндсэн дээр гэрээнд тодорхой заана;

2.11. Зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь зээлдэгчийн барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ буурсан тохиолдолд зээлдүүлэгчийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлдэгчээс нэмж байршуулах нэмэлт хөрөнгийг шаардана.

2.12. Зээлдэгч нь барьцаа хөрөнгө байршуулсан тохиолдолд зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь үнэт цаасыг зээлдэгчид шилжүүлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

2.13. Үнэт цаас зээлдүүлэх гэрээний хугацаа дуусах үед зээлдэгч нь зээлсэн үнэт цаасыг нэр төрөл, тоо ширхгээр зуучлагчийн, эсхүл зээлдүүлэгчид буцаан шилжүүлж, зээлийн хүүг зуучлагчийн, эсхүл зээлдүүлэгчийн дансанд байршуулах үүрэгтэй.

2.14. Үнэт цаасыг болон зээлийн хүү болон бусад төлбөрийг гэрээнд заагдсан хугацаанд Зуучлагчид, эсхүл зээлдүүлэгчид төлснөөр, зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь зээлдэгчид барьцаа хөрөнгийг буцаан олгоно.

2.15. Зээлдүүлсэн үнэт цаасны ногдол ашиг, үнэт цаасны хүү зэрэг үнэт цаасны эзэмшилтэй холбоотой бүх төрлийн өгөөж хүртэх эрх зээлдүүлэгчид хадгалагдах ба зээлдэгч нь тухайн төлбөрийг хүлээн авсан даруй зуучлагчаар дамжуулан, эсхүл зээлдүүлэгчид шилжүүлнэ.

2.16. Зээлдүүлэгч нь зээлдүүлсэн үнэт цаасаа эргүүлэн дуудахтай холбоотой зохицуулалтыг энэ журмын 2.8- д заасан гэрээнд тусгаж болно.

Гурав. Эрсдэлийн удирдлага

3.1. Зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь санхүүгийн болон төлбөрийн чадвартай байхаас гадна холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан журам, заавар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ханган, сүүлийн 3 жилийн хугацаанд үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцсон этгээд байна.

3.2. Зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь харилцагчийн барьцаа, дэнчин (маржин) -ийн хэмжээг тооцоолох, төлбөрийн чадваргүй болсноос учрах эрсдэлийн түвшинг өдөр тутмын давтамжтайгаар тооцоолох чиг үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна.

3.3. Энэхүү журмын 3.2-т заасан эрсдэлийн нэгж эсхүл ажилтан нь үйл ажиллагаандаа мөрдөх эрсдэлийн удирдлагын бодлоготой байх бөгөөд уг бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан журмыг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөнө.

3.4. Зуучлагч нь зээлдүүлэгчийн үүргийг гүйцэтгэн өөрийн хөрөнгөөр үнэт цаас зээлдүүлэх үйл ажиллагаанд оролцон зээлээр хувьцаа авах тохиолдолд энэхүү журмын

3.3-т заасан эрсдэлийн алба эсхүл ажилтнаас гадна тусдаа хөрөнгө оруулалтын нэгж байгуулах ба уг нэгж нь тухайн компанийн зээлээр хувьцаа аван арилжаанд оролцох ажиллагааг удирдан, харилцагчдад үзүүлэх үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагаанаас тусад нь зохион байгуулна.

3.5. Үнэт цаас зээлдүүлэх үйлчилгээг эрхлэн гүйцэтгэх этгээдэд 20 хувийн активын хязгаарлалт тавина.

3.6. Зээлдэгч нь зээлдүүлсэн үнэт цаасны үнэ цэнэ дээр үндэслэн зээлдүүлэгчид маржин байршуулна.

3.6.1. Маржины хэмжээ болон нөхцөлийг талууд гэрээнд тодорхой заана.

3.6.2. Зах зээлийн нөхцөлөөс хамааран маржины хэмжээг шинэчлэн тогтоож болно.

3.7. Зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь зээлдүүлсэн үнэт цаас болон барьцааны үнэт цаасны ханшнаас хамааруулан барьцааны үнэлгээг арилжааны өдөр бүр шинэчлэн гаргана.

3.8. Барьцааны үнэлгээ тогтоосон хэмжээнээс буурсан тохиолдолд зуучлагч, эсхүл зээлдүүлэгч барьцаа хөрөнгийг тухайн өдөрт багтаан нэмэгдүүлэхийг зээлдэгчээс шаардана.

3.9. Барьцаа хөрөнгө нэмэгдүүлэх тухай зуучлагч, эсхүл зээлдүүлэгчийн гаргасан шаардлагыг Үнэт цаас зээлдэгч хугацаанд нь хэрэгжүүлээгүй тохиолдолд зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь Үнэт цаас зээлдүүлэх гэрээнд заасан арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.10. Үнэт цаас зээлдүүлэх болон зээлдэж авах хүсэлт гаргасан этгээдтэй гэрээ байгуулахаас өмнө зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь үнэт цаас зээлэх болон зээлдүүлэхтэй холбогдон үүсэж болзошгүй эрсдэлийн тухай мэдээллийг холбогдох талуудад танилцуулсан байна.

3.11. Зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь барьцааны хөрөнгийг өөрийн нэрийн дансанд шилжүүлэн бүртгэх, хянах, хадгалах болон зээлдэгч болон зээлдүүлэгч талуудад тогтмол тайлагнана. Барьцааны төрлөөс хамаарч барьцааны нийт хэмжээ дараах байдлаар тогтоогдоно:

3.11.1. Мөнгөн хөрөнгө бол зээлдүүлсэн үнэт цаасны нийт үнийн дүнгийн 115 хувь;

3.11.2. Үнэт цаас бол зээлдүүлсэн үнэт цаасны нийт үнийн дүнгийн 115-130 хувь байна;

3.12. Зах зээлд үүссэн онцгой нөхцөл байдлын улмаас үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагааг тодорхой хугацаагаар зогсоох арга хэмжээг Хороо хэрэгжүүлнэ.

Дөрөв. Оролцогч талуудын үүрэг, хариуцлага

4.1. Хорооны үүрэг, хариуцлага

4.1.1. Хороо нь зуучлагч, эсхүл зээлдүүлэгч үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ энэ журам болон холбогдох хууль тогтоомжид заасан шаардлага, нөхцөлийг баримталж байгаа эсэх, үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбоотойгоор харилцагч болон компанид учрах эрсдэлийг бууруулахын тулд эрсдэлийн алба эсхүл ажилтан ажиллуулан барьцаа хөрөнгө, маржинг өдөр бүр тооцоолж буй эсэхэд зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох хуульд заасан хариуцлага ногдуулна.

4.1.2. Хороо нь үнэт цаас зээлэх, зээлдүүлэх, мэдээллийн ил тод байдалтай холбоотой үйл ажиллагаанд энэ журам болон бусад хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Зуучлагчийн үүрэг, хариуцлага

4.2.1. Зээлдүүлэгч болон зээлдэгч талуудыг холбож, зуучлагчийн үүрэг гүйцэтгэх, гэрээ байгуулахад мэргэжлийн зөвлөгөө өгөх, гэрээний нөхцөлийг тохируулахад тусална.

4.2.2. Харилцагчид өөрийн дансаараа дамжуулан үнэт цаас зээлэх, зээлдүүлэх боломжийг олгох цахим платформоор хангаж, гүйлгээний мэдээллийг хянаж, талуудыг мэдээллээр хангана.

4.2.3. Зээлдүүлэгч болон зээлдэгч талуудын хооронд үнэт цаасыг найдвартай

шилжүүлэх, баталгаажуулах болон тайлагнах үүргийг хариуцна.

4.2.4. Үнэт цаасны бүртгэлийг хөтлөх, зээлийн үйл явцыг хянах, мөн ногдол ашиг болон хүүгийн хуваарилалтыг зохицуулж, эдгээрт хяналт тавина.

Тав. Мэдээллийн ил тод байдал

5.1. Үнэт цаасны зохицуулалттай зах зээлд үнэт цаас зээлэх, зээлдүүлэхтэй холбогдон үүсэх нарийвчилсан харилцааг энэ журмын хүрээнд мэргэжлийн байгууллагаас баталсан дүрэм журам эсвэл оролцогч талуудын хооронд байгуулах гэрээгээр зохицуулна.

5.2. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйлчилгээг гүйцэтгэх зуучлагч, эсхүл зээлдүүлэгч нь дараах мэдээллийг цахимаар Хороонд хүргүүлнэ. Үүнд:

5.2.1. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн хэлцлийн сар бүрийн мэдээллийг дараа сарын 5-ны дотор;

5.2.2. Үнэт цаас зээлэх, зээлдүүлэх үйл ажиллагаатай холбоотой зуучлалын үйлчилгээний хөлс өөрчлөгдсөн тохиолдолд тухай бүр;

5.2.3. Зээлдэгч төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр;

5.2.4. Үнэт цаас зээлдүүлэх гэрээтэй холбоотой маргаан шүүх, хяналтын байгууллагад шилжсэн тохиолдолд тухай бүр;

5.3. Хороо нь тодорхой нөхцөлд зах зээлд оролцогчдоос нэмэлт тайлан, мэдээлэл гаргахыг шаардаж болно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны зах зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээний бүртгэлийн багц журам”-ын хорин хоёрдугаар хавсралт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРМИЙН ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. “.....” компани нь нээлттэй хувьцаат компани /цаашид “компани” гэх/ мөн.

1.2. Монгол улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна.

1.3. Компанийн оноосон албан ёсны нэрийг
-монголоор: “.....” ХК компани

-англиар: Joint stock Company гэнэ.

1.4. Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол улс, хот/аймаг/

1.5. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд нээлттэй ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

1.6. Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.7. Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй бйх бөгөөд түүний загварыг Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ баталж, Оюуны өмчийн газар бүртгүүлсэн байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг зөвхөн “. ” ХК эдэлнэ.

1.8. Компани нь үйл ажиллагаандаа нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ болон компанийн засаглалын шилдэг жишгийг удирдлага болгоно.

1.9. Компани нь хязгааргүй хугацаагаар үйл ажиллагаа явуулна¹

1.10. Компанийг энэхүү дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөх болон өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.

ХОЁР. КОМПАНИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

2.1. Компани нь үүсгэн байгуулагдсан үеэсээ хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

2.2. Компани нь өөрийн тусгаарласан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ. Компани нь бие даасан баланс, өөрийн нэр бүхий тэмдэг, компанийн логотой байх ба Компани нь банкинд төгрөгийн, гадаад валютийн болон бусад данстай байна. Компани нь шүүх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.

2.3. Компани нь өөрийн материаллаг болон мөнгөн хөрөнгөтэй байх ба тэдгээрийг ашиглах, захиран зарцуулах болон бусад эрхийг эдэлнэ.

2.4. Хувьцаа эзэмшигчид Компанийн хариуцлагыг хүлээхгүй ба Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй болно.

2.5. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна².

2.6. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.

ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

3.1. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.

¹Компанийн тухай хуулийн 8.5-д компанийн үйл ажиллагаа явуулах хугацааг компанийн дүрэмд тухайлан зааж болохоор байгаа тул тухайн компанийн онцлогоос хамааран хугацааг зааж болно.

- 3.2. Компанийн эрхэм зорилго нь:³.
- 3.3. Компани нь хуулиар хориглоогүй дараах төрлийн үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ⁴:
- 3.3.1. ...
- 3.3.2. ...
- 3.3.3. хууль тогтоомжоор хориглоогүй бусад төрлийн үйл ажиллагаа;
- 3.4. Компани нь энэ дүрмийн 3.3-т заасан үндсэн үйл ажиллагаанаас гадна дараах төрлийн үйл ажиллагааг эрхлэж болно. Үүнд:
- 3.4.1.
- 3.4.2.
- 3.5. Монгол улсын хууль тогтоомжоор тусгай зөвшөөрөл авахаар тусгайлан заасан үйл ажиллагааг эрхлэхдээ холбогдох тусгай зөвшөөрөл авч тухайн төрлийн үйл ажиллагааг эрхлэнэ.
- 3.6. Үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор нээлттэй зах зээл дээр үйл ажиллагаа явуулна.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН БОЛОН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

- 4.1. Компанийн зарласан хувьцаа нь нэг бүрийн ... төгрөгийн нэрлэсэн үнэтэй ... ширхэг энгийн хувьцаа, нэг бүрийн ... төгрөгийн нэрлэсэн үнэтэй ... ширхэг давуу эрхийн хувьцаанаас бүрдэнэ⁵.
- 4.2. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн ... төгрөгийн нэрлэсэн үнэтэй ... ширхэг энгийн хувьцаа байна.
- 4.3. Компани гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авсан бол эдгээр хувьцааг халаасны хувьцаа гэж үзэх бөгөөд балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэгт нэрлэсэн үнээр нь хасах тэмдэгтэйгээр харуулна.
- 4.4. Компанийн нийт хөрөнгөнөөс өр төлбөрийг хассан дүнг өөрийн хөрөнгө гэх бөгөөд өөрийн хөрөнгийн дүн нь санхүүгийн тайлан баланс гарах бүрт өөрчлөгдөнө.
- 4.5. Жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс бага болсон тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь ийнхүү бага болсон шалтгааныг судлан, дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах /хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар/ тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлнэ. Хэрвээ ийнхүү бага болсон нь алдагдалтай ажилласанаас шалтгаалсан бөгөөд дахин хөрөнгөжүүлэх, хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар шийдвэрлэх боломжгүй бол компанийг татан буулгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

² Компанийн тухайн хуулийн 7.4-д “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай шийдвэрийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ гаргана” гэж заасан бөгөөд компанийн өөр эрх бүхий этгээд уг шийдвэрийг гаргах боломжтой байхаар компанийн дүрэмд өөрөөр зааж болно.

³ Компанийн эрхэм зорилго нь компани бүрт өөр өөр байх бөгөөд компанийн үйл ажиллагаандаа баримтлах үндсэн зарчмыг тодорхойлдог юм. Бизнесийн байгууллага нь эрхэм зорилгодоо 3 асуудлыг тусгасан байх шаардлагатай гэж үздэг. Зорилтот зах зээл /гол худалдан авагч, үйлчлүүлэгчид/ Нийлүүлэх бараа, үйлчилгээ /худалдан авагч, үйлчлүүлэгчиддээ чухам ямар бараа, үйлчилгээ нийлүүлэх вэ

⁴ Компани болгон өөр өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэх бөгөөд энэ хэсэгт үйл ажиллагааны төрлөө жагсааж зааж өгнө.

⁵ Компанийн тухай хуулийн 32.3-т зааснаар компани нь энгийн хувьцааг заавал гаргах үүрэг хүлээдэг бөгөөд харин давуу эрхийн хувьцаа гаргах эсэхээ компани өөрөө шийдвэрлэх боломжтой.

4.6. Шинээр хувьцаа гаргаж хөрөнгө оруулбал тэр хэмжээгээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны тоо нэмэгдэнэ.

4.7. Цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаад үлдсэн ашгийн хэмжээгээр компанийн өөрийн хөрөнгө нэмэгдэх бөгөөд хувьцааны тоо өөрчлөгдөхгүй.

4.8. Алдагдал гарсан, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг устгасан, найдваргүй авлагыг данснаас хассан зэрэг тохиолдолд тэр хэмжээгээр компанийн хуримтлагдсан ашиг болон өөрийн хөрөнгө буурна. Хувьцааны тоо болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй.

4.9. Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө ба хувьцааны балансын үнэ нэмэгдэж, хорогдоно.

4.10. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж хорогдуулж болно:

4.10.1. хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;

4.10.2. хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөлгүйгээр хувьцааг хуваах эсхүл нэгтгэх;

4.10.3. хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох.

ТАВ. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Компанийн энгийн болон давуу эрхийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.

5.2. Энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

5.2.1. хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;

5.2.2. ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед давуу эрхийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилсны дараа эзэмшиж буй хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хувиарлаагүй бол алданги төлөхийг шаардах;

5.2.3. компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;

5.2.4. нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх⁶;

5.2.5. хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах;

5.2.5.1. нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;

5.2.5.2. хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;

5.2.5.3. хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

⁶ Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд зааснаар Нэмж гаргаж буй хувьцааг тодорхой хөрөнгө оруулагчдад тодорхой гэрээний дагуу эзэмшүүлэхээр гаргаж байгаа тохиолдолд хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэсэн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хуралд оролцож буй саналын эрхийн дийлэнх олонхийг эзэмшигчдийн саналаар шийдвэрлэж болно

5.2.5.4. нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон, эсхүл компанийн төрийн мэдлийн багц хувьцааг худалдсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй;

5.2.6. энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;

5.2.7. компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөртэй хуулбарлан авах;

5.2.8. энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;

5.2.9. энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх, ТУЗ энэ саналыг үндэслэлгүйгээр хүлээн аваагүй тохиолдолд өөрөө зарлан хуралдуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал зарлагдсан үед хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг шаардан гаргуулах;

5.2.10. компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль болон энэ дүрмийн 8.2-т заасан үүргээ биелүүлээгүй, зөрчсөнөөс компанид хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;

5.2.11. хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.

5.3. Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй:

5.3.1. хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;

5.3.2. нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;

5.3.3. нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх;

5.4. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.

5.5. Компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль болон давуу эрхийн хувьцаа гаргах тухай шийдвэрт заасан нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцоно. Давуу эрхийн хувьцааны тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, тухайн төрлийн хувьцаа эзэмшигчдэд олгох давуу эрх, тэдний хувь нийлүүлэгчдийн хуралд саналын эрхтэй оролцох нөхцөл зэргийг давуу эрхийн хувьцаа гаргах тухай асуудлыг шийдвэрлэсэн хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрт заасан байна

ЗУРГАА.КОМПАНИЙН ҮНЭТ ЦААСЫГ ГАРГАХ ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

6.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг гаргаж болно⁷.

6.2. Энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахаар, энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.

⁷Компанийн тухай хуулийн 4.3-т зааснаар үнэт цаас гаргах эсэх талаар компанийн дүрэмд зааж болно. Мөн гаргахгүйгээр заасан ч болох юм.

6.3. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй үнийн дүн бүхий өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ⁸. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.

6.4. Компанийн тодорхой тооны энгийн болон давуу эрхийн хувьцааг тогтоосон үнээр, заасан хугацаанд худалдан авах, худалдах эрхийг баталгаажуулсан опцион гаргаж болно⁹.

6.5. Хувьцаа бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу Компанийн ТУЗ тогтооно.

6.6. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг мөнгө, үнэт цаас, эд хөрөнгийн хэлбэрээр хийж болох бөгөөд мөнгөн бус хэлбэрээр гүйцэтгэх тохиолдолд үнэлгээг тогтоохдоо ТУЗ нь мэргэжлийн үнэлгээний байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно.

6.7. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу брокерт захиалга өгөх замаар худалдан авч болно.

6.8. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна¹⁰.

6.9. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

6.10. Гаргасан үнэт цаасыг худалдан авч байгаа этгээд нь төлбөрөө мөнгө, үнэт цаас, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн аль ч хэлбэрээр хийж болно¹¹.

6.11. Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно¹².

ДОЛОО. КОМПАНИЙН УДИРДЛАГА

Хувьцаа эзэмшигчдийн хурал

7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлдэх, хурлын зар мэдээг хүргэх, хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэр болон хурлын тэмдэглэлийг баталгаажуулах, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх журам” болон Компанийн ТУЗ-өөс баталсан “Хувьцаа эзэмшигчдийн хулыг зарлан хуралдуулах журам¹³”-аар зохицуулна.

⁸ Компанийн тухай хуулийн 33.3-т заасны дагуу дээрхи шийдвэрийг ТУЗ эсвэл дүрмээр ХЭХ-аас тогтоохоор зааж болно.

⁹ Энэхүү заалтыг дүрэмд зааж мөн заахгүй болно / Компанийн тухай хуулийн 40.1/. Хэрвээ дүрэмд заасан тохиолдолд опционоор худалдаж авч болох энгийн хувьцаа нь гүйлгээнд байгаа нийт хувьцааны 25 хувиас бага бол опцион гаргах тухай шийдвэрийг ТУЗ, түүнээс их бол хувь нийлүүлэгчдийн хурал гаргана. Шийдвэрт гаргах опционы тоо, нэгж опцион эзэмшигчдийн худалдан авч болох хувьцааны тоо, хувьцаа худалдаж авах үнэ, опционы хүчинтэй байх хугацаа, опционыг санал болгох үнэ зэргийг заасан байна.

¹⁰ Компанийн тухай хуулийн 33.8-д заасны дагуу компани нь эргүүлэн худалдан авсан хувьцааг дахин гаргахаар дүрэмд зааж болно.

¹¹ Компанийн тухай хуулийн 44.1-т заасны дагуу компанийн дүрмээр гаргасан үнэт цаасыг худалдаж авах хэлбэрийг тухайлан зааж болно. Мөн Компанийн тухай хуулийн 44.4-т үнэт цаасны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийж болох тохиолдлуудыг зааж өгсөн. Харин компани дүрэмдээ тусгахгүй байсан ч болно.

¹² Дээрхи заалтыг зөвхөн мөнгөн хөрөнгөөр хийх эсвэл тусгайлан төлбөр хийх хэлбэрийг компанийн дүрмээр зааж болно.

7.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.

7.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу 5 дугаар сарын 01-ны дотор ТУЗ зарлан хуралдуулна.

7.4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 50 болон түүнээс дээш хувь нь оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно¹⁴.

7.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдан явуулна. ТУЗ-ийн дарга хуралд оролцох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай асуудлыг шийдвэрлэсэн ТУЗ-ийн хурлаас томилогдсон этгээд хурлыг удирдана. Хурал удирдахаар томилогдсон этгээд хуралд хүрэлцэн ирэх боломжгүй нь хурал хуралдах үед илэрхий болсон бол хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар хурал даргалагчийг сонгоно.

7.6. Шаардлагатай үед ТУЗ, эсхүл ТУЗ-ийн 2-оос доошгүй хараат бус гишүүн, саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн санаачилгаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-өөс зарлан хуралдуулах, ТУЗ энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй бол тухайн этгээд өөрөө зарлан хуралдуулах эрхтэй.

7.7. Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ¹⁵:

7.7.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;

7.7.2. нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

7.7.3. компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;

7.7.4. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

7.7.5. хувьцааг хуваах буюу нэгтгэх;

7.8. Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ¹⁶:

7.8.1. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;

7.8.2. компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх;

7.8.3. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх;

7.8.4. компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхиор шийдвэрлэх;

7.8.5. компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

¹³ Хувьцаа эзэмшигчдийн хурлаар энэхүү журмыг баталхаар дүрэмд зааж болно.

¹⁴ Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг дүрмээр үүнээс өндөр хувь тогтоож болно. Хэрэв дүрмээр өндөр хувь тогтоож өгсөн бол тэрхүү хувьд хүрсэн тохиолдолд хурал хүчин төгөлдөр болно.

¹⁵ Компанийн тухай хуулийн 63.8-д заасны дагуу компанийн дүрэмд энэхүү дүрмийн 7.6.1-7.6.6-д заасан асуудлуудыг хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд компанийн дүрэмд дийлэнх олонхоос өндөр хувиар шийдвэрлэхээр тогтоож өгч болно.

¹⁶ Компанийн дүрмээр үүнээс өндөр хувь тогтоож өгч болох бөгөөд харин доогуур тогтоож болохгүй.

7.8.6. компанийн өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх;

7.8.7. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

7.8.8. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

7.9. Компанийн нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.

7.10. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ¹⁷. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж хүмүүсийн нэрсийг тус тусад нь жагсаана. Хувьцаа эзэмшигч нь ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй хүмүүст тус тусад нь саналаа өгөх бөгөөд ТУЗ нь 9 гишүүнтэй байхаар дүрэмдээ засан бол энгийн гишүүнд нэр дэвшиж буй 1-6 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 2/3-ийг, хараат бус гишүүнд нэр дэвшиж буй 1-3 хүртэл тооны хүнд нийт саналынхаа 1/3-ийг өгсөн байна. Энэ хуваарийг зөрчиж санал өгсөн бол саналын хуудсыг хүчингүйд тооцно.

7.11. Хувьцаа эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.

7.12. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.

7.13. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ.

7.14. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл бүртгэнэ. Бүртгэлийг тооллогын комиссын дарга эсхүл түүний томилсон этгээд гүйцэтгэнэ.

7.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 74-р зүйлд заасан журмын дагуу хөтөлж, хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор холбогдох эрх бүхий этгээдээр баталгаажуулна. Хурлын тэмдэглэлийн тус бүр нэг хувийг гарсан шийдвэрийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад баталгаажсанаас хойш ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.

7.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.

7.17. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.

7.18. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.

7.19. Саналын хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал хураасан дүн, санал хураалтын тайланг тооллогын комисс гаргаж, ТУЗ-д хүргэнэ.

7.20. ТУЗ нь энэхүү дүрмийн 7.18-д заасан тайланд үндэслэн шийдвэр гаргаж, шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд гарсан шийдвэрийн тухай мэдээллийг хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хүргэнэ.

¹⁷ ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэж сонгох нь хувьцаа эзэмшигчдийн тэгш төлөөллийг ТУЗ-д гаргаж ирэх нийтлэг хэлбэр юм. Энэ аргыг хэрэглэх журмыг Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 367 дугаар тогтоолоор баталсан “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх” тухай журамаар зохицуулна.

Төлөөлөн удирдах зөвлөл

7.21. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, тэдний үйл ажиллагааны болон үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх, нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.

7.22. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 нь ердийн, 3 нь энэ дүрмийн 7.25-д заасан шалгуурыг хангасан хараат бус гишүүн байна¹⁸.

7.23. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь ... жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжлэнэ¹⁹.

7.24. ТУЗ-ийн гишүүн мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан компанийн эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохино.

7.25. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шалгуурыг хангасан этгээд байна:

7.25.1. дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;

7.25.2. өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа нэгдлийн бусад оролцогч компанид эрх бүхий албан тушаал хашдаггүй;

7.25.3. төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй;

7.25.4. өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн өнгөрсөн жилийн нийт борлуулалтын 1 хувиас дээш хэмжээний үнийн дүн бүхий хэлцлийг компанитай хийж байгаагүй²⁰;

7.25.5. компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшдэг этгээд, эсхүл компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш;

7.25.6. компани болон түүний хараат, охин компани, компанид нэгдэлд хамаарах компанийн нэгдэлд сүүлийн ... жилийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан болон бусад албан тушаалд ажиллаж байгаагүй;

7.25.7. компанийн өрсөлдөгч аж ахуйн нэгж болон түүнд харьяалагддаг компанийн нэгдлийн аливаа оролцогч компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд биш.

¹⁸ Компанийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээнээс хамааран ТУЗ-ийн гишүүдийн тоог 9-өөс илүү байхаар дүрэмдээ зааж болно. Гэхдээ нийт гишүүдийн 1/3-ээс доошгүй нь заавал хараат бус гишүүдээс бүрдсэн байх ёстой. 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байх нь хуулиар тогтоосон доод хэмжээ бөгөөд үүнээс дээгүүр хувийг компанийн дүрмээр тогтоож өгч болно.

¹⁹ ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг компанийн дүрмээр тогтооно. Гэхдээ ТУЗ-ийн гишүүдийн хариуцлагыг, ялангуяа хараат бус гишүүдийн хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг дараагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл тогтоох нь илүү үр дүнтэй байдаг. Жил бүр ТУЗ-ийн гишүүдийг сонгодог байхаар тогтоовол жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын өмнө ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх болно. ТУЗ-ийн гишүүд санаачлагатай, хариуцлагатай ажиллах нь компанийн сайн засаглалыг хэвшүүлэх хамгийн чухал хүчин зүйл юм.

²⁰ энэ дүрмийн 7.25.1-7.25.4-т заасан шалгуурууд нь Компанийн тухай хуульд заасан шалгуур юм. Компанийн хувьд хараат бус гишүүн нь өндөр эрх мэдэлтэй, компанийн үйл ажиллагааны талаарх их хэмжээний /үүний дотор компанийн бизнесийн нууцад хамаарч болох мэдээлэл авах, олон чухал асуудлаар ТУЗ-өөс гаргах шийдвэрийн талаар санал боловсруулж оруулах эрхтэй этгээд байх учраас компанийн өрсөлдөгч этгээдийн ашиг сонирхлыг төлөөлөх магадлалтай этгээд байхаас сэргийлэх асуудлыг дүрэмдээ тусгах зайлшгүй шаардлагатай байх бөгөөд 7.25.5-7.25.7-т заасан болон бусад нэмэлт шалгуурыг тогтоох компанийн дүрмээг тогтоох ихээхэн ач холбогдолтой байдаг.

7.26. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо энэ дүрмийн 7.25-т заасан шалгуурыг хангасан этгээдийн нэрийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлнэ. Хараат бус гишүүнд нэрийг нь дэвшүүлж буй этгээд нь өөрөө зөвшөөрлөө бичгээр өгсөн байх бөгөөд энэ дүрмийн 7.25-т заасан шалгуурыг хангаж байгаа гэдгээ албан ёсоор баталгаажуулсан байна. Энэхүү баталгааг хуурамчаар гаргасан нь тогтоогдвол ТУЗ-ийн дарга энэ талаар хувьцаа эзэмшигч болон Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

7.27. Компанийн ТУЗ- гишүүнд нэр дэвшигч нь ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо болон хувьцаа эзэмшигчдийн хуралд дараахь мэдээллийг үнэн зөвөөр тайлагнах үүрэгтэй:

7.27.1. нэр дэвшүүлсэн этгээдийг нэр;

7.27.2. нэр дэвшигчийн нас, боловсролын байдал, ажилласан туршлага болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл;

7.27.3. нэр дэвшигчийн сүүлийн 5 (тав) жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаал;

7.27.4. нэр дэвшүүлэх үед түүний эрхэлж байгаа ажил, ажил тушаал, сонгуульт ажлууд;

7.27.5. нэр дэвшигч нь компанийн хоорондын харилцан хамаарал байгаа эсэх;

7.27.6. нэр дэвшигч нь компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ямар нэг хамааралтай эсэх;

7.27.7. компанийн томоохон бизнесийн түншүүдтэй ямар нэг хамааралтай эсэх;

7.27.8. нэр дэвшигчийн орлогын эх үүсвэр, болон түүний ТУЗ-ийн гишүүний ажил үүрэгт нөлөөлөхүйц бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл²¹.

7.28. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалны хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ:

7.28.1. компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;

7.28.2. ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;

7.28.3. ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх;

7.28.4. хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон компанийн засаглалын жишгийн талаар цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг бүрэн хангах;

7.28.5. өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх.

7.29. ТУЗ-ийн гишүүн нь үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно²².

7.30. ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар ТУЗ-ийн даргыг сонгоно.

7.31. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, ТУЗ-ийн зөвшөөрснөөр тодорхой асуудлаар тушаал, шийдвэр гаргах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

²¹ 2012 онд хуралдах хувьцаа эзэмшигчдийн хурлаар анхны хараат бус гишүүдийг сонгох шаардлагатай болно. Гэтэл нэр дэвшүүлэх хороотой ТУЗ байхгүй учраас анхны хараат бус гишүүдийг сонгохдоо Компанийн тухай хуулийн 79.2-т төрийн өмчийн болон төрийн өмч давамгайлсан компанийн хувьд хараат бус гишүүнд компанийн сайн засаглалыг дэмжих зорилготой төрийн бус байгууллагаас нэр дэвшүүлж болно гэсэн заалтыг хэрэглэж болох юм. Ингэснээр нэр дэвшүүлсэн төрийн бус байгууллага нь нэр дэвшүүлсэн этгээдийнхээ өмнөөс хариуцлага хүлээдэг байх эрүүл тогтолцоог бүрдүүлэх боломжтой. Гэхдээ хуульд зааснаар энэ нь ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хорооны бүрэн эрх учраас ТУЗ-ийн одоогийн бүрэлдэхүүнд хараат бус гишүүний шаардлага хангасан этгээд байгаа тохиолдолд бүрэлдэхүүндээ нэр дэвшүүлэх хороо байгуулах замаар асуудлыг шийдвэрлэх боломжтой.

7.32. ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.32.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратеги, энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;

7.32.2. компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах;

7.32.3. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах;

7.32.4. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;

7.32.5. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах,

7.32.6. компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;

7.32.7. компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;

7.32.8. компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;

7.32.9. компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох;

7.32.10. ногдол ашгийн хэмжээ болон түүнийг төлөх журмыг тодорхойлох²³;

7.32.11. ТУЗ-ийн үйл ажиллагааны болон компанийн сайн засаглалын зарчмуудыг хэвшүүлэхтэй холбоотой “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан бусад дотоод журмуудыг батлах;

7.32.12. зарласан хувьцааны тоо, төрөлд багтаан хувьцааг гүйлгээнд гаргах шийдвэр гаргах²⁴;

7.32.13. өөрийн гаргасан хувьцаа болон бусад үнэт цаасыг эргүүлэн авах эсхүл худалдан авах шийдвэр гаргах;

7.32.14. компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн дарга, захирлыг томилох²⁵;

7.32.15. компанийг өөрчлөн байгуулах талаар хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;

7.32.16. компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

7.32.17. компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

7.32.18. эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

7.32.19. гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хувь нийлүүлэн хөрөнгө оруулах, компанийн хөрөнгөөр баталгаа гаргах;

7.32.20. компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлыг шийдвэрлэх;

7.32.21. хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

²³ Компанийн тухай хуулийн 46.1-т заасны дагуу ногдол ашиг хувиарлах тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурал гаргахаар зааж болно.

²⁴ Компанийн тухай хуулийн 33.3-д зааснаар энэ асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэхээр компанийн дүрэмд зааж болно.

²⁵ Компанийн тухай хуулийн 7.4-т компанийн салбар төлөөлөгчийн газар байгуулах эрхийг ТУЗ эсвэл хувьцаа эзэмшигчдийн хурал хэрэгжүүлэхээр заасан бөгөөд хэрэв дүрэмд заасан бол хувьцаа эзэмшигчдийн хурал энэ эрхийг эдэлнэ. Мөн Компанийн тухай хуулийн 7.11-т салбар төлөөлөгчийн газрын гүйцэтгэх захирлыг толгой компанийн ТУЗ эсвэл компанийн дүрэмд гүйцэтгэх захирал томилохоор мөн зааж болно.

7.33. ТУЗ-ийн хурлыг сард нэг²⁶ удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.

7.34. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байж болно.

7.35. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон дотоод хяналтын алба, хараат бус аудитийн байгууллагын санаачилга, шаардлагаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

7.36. ТУЗ-ийн хурлын зохион байгуулалтыг нарийн бичгийн дарга хариуцаж, тэмдэглэл хөтөлнө. Мөн хурлын тухай зар, хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичиг, гарах шийдвэрийн төслийг ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байх бөгөөд хурал хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан гишүүдэд хүргэнэ.

7.37. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн хурлыг удирдана. ТУЗ-ийн дарга аливаа этгээдийг томилоогүй бол хуралд оролцож байгаа хамгийн ахмад гишүүн хурлыг удирдана. ТУЗ-өөс тодорхой асуудлыг шийдвэрлэх эрхийг ТУЗ-ийн дэргэдэх аль нэг Хороонд олгож болно.

7.38. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно²⁷. Компанийн тухай хуульд тусгайлан заасан зарим асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй гаргана.

7.39. Тухайн шийдвэрлэж буй асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд Компанийн тухай хуульд заасны дагуу санал өгөх эрхгүй бол шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.

7.40. ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Гишүүн нь эсрэг саналтай байвал түүнийгээ протоколд тэмдэглүүлэх эрхтэй.

7.41. ТУЗ-ийн гишүүн нь саналын эрхээ бусад гишүүд болон гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

7.42. ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, нас барсан тохиолдолд орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо түр томилно. Түр томилогдсон гишүүн нь энэ дүрмийн 7.25-т заасан шаардлагыг хангасан байна. Хараат бус гишүүнд нэр дэвшсэн боловч сонгогдож чадаагүй гишүүдийн дотроос нөхөн сонгох асуудлыг тэргүүн ээлжинд дэвшүүлж болно.

7.43. ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд компани нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.

7.44. ТУЗ-ийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.44.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлж хяналт тавих, үнэн зөвийг хариуцах;

7.44.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

²⁶ Компанийн тухай хуулийн 80.1-д дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулна гэж заасан бөгөөд энэ нь үйл ажиллагааны онцлог, цар хүрээнээс шалтгаалан зарим компанийнхувьд ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулах нь ач холбогдол багатай байдаг бөгөөд үүнийг Компани өөрийн онцлогт тохируулан 2 сард нэг удаа, улиралд нэг удаа эсхүл сард 2 удаа хуралдуулна гэх зэргээр компанийн дүрэмд өөрөөр тусгаж болно.

²⁷ ТУЗ-ийн шийдвэрийг дийлэнх олонхоос өндөр хувийн саналаар хүчин төгөлдөр болохоор компанийн дүрэмд зааж өгч болно. Харин хурлын ирцийг хуульд зааснаар зөвхөн дийлэнх олонх нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд үүнийг өөрөөр тогтоож болохгүй.

7.44.3. хувьцаа эзэмшигчдийн жил бүрийн ээлжит хурлын бэлтгэлийг энэ дүрэмд заасны дагуу хангаж байгаа эсэхэд хяналт тавих, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг гаргасан байх асуудлыг ТУЗ-ийн дарга биечлэн хариуцах ёстой;

7.44.4. ТУЗ-өөс олгосон бусад эрх хэмжээ.

26 Компанийн тухай хуулийн 80.1-д дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулна гэж заасан бөгөөд энэ нь үйл ажиллагааны онцлог, цар хүрээнээс шалтгаалан зарим компанийнхувьд ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулах нь ач холбогдол багатай байдаг бөгөөд үүнийг Компани өөрийн онцлогт тохируулан 2 сард нэг удаа, улиралд нэг удаа эсхүл сард 2 удаа хуралдуулна гэх зэргээр компанийн дүрэмд өөрөөр тусгаж болно.

7.45. ТУЗ-ийн гишүүд нь зохих хэмжээний урамшуулал авах бөгөөд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.

7.46. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Нэр дэвшүүлэх, Аудитийн болон Цалин урамшууллын хороотой²⁸ байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна.

Аудитын хороо

7.47. ТУЗ-ийн аудитийн хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд санхүү, бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна²⁹.

7.48. ТУЗ-ийн аудитийн хороо нь дараах чиг үүрэгтэй байна:

7.48.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

7.48.2. компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээлийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;

7.48.3. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллын талаарх гүйцэтгэх удирдлагын саналыг хянах, ТУЗ-д танилцуулах;

7.48.4. хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, Хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитийн байгууллагад чиглэл өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитийн байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/;

²⁸ Компанийн тухай хуулийн 81.2-т зааснаар Хувьцаат компани нь Аудит, Цалин урамшуулал, Нэр дэвшүүлэх гэсэн 3 хороотой байх бөгөөд өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон өөр бусад хороог /хөрөнгө оруулалтын, хууль эрх зүй, эрсдэлийн компанийн засаглалын гэх мэт/ дүрэмд тусгах замаар байгуулан ажиллаж болно.

²⁹ Компанийн тухай хуульд зааснаар Аудитийн хороо нь маш хариуцлагатай үүрэг гүйцэтгэх ёстой бөгөөд энэ чиг

үүргийг хэрэгжүүлэх нь ихээхэн цаг хугацаа, санхүү нягтлан бодох бүртгэл, эрсдэлийн удирдлагын талаар өндөр мэдлэг мэргэшилтэй байхыг шаардахаар байгаа юм. Хараат бус гишүүд ТУЗ-ийн Аудитийн хорооны дийлэнх олонхийг бүрдүүлэх ёстой. Ийм учраас Аудитийн хороо нь хараат бус, хөндлөнгийн аудитийн байгууллагад чиглэл өгөх, тэдний гаргасан дүгнэлтийг ханах, холбогдох арга хэмжээ авах замаар чиг үүргээ хэрэгжүүлэх нь хамгийн оновчтой шийдэл байх учраас дүрмийн 6.39.4-т холбогдох заалтыг тусгасан болно.

ТУЗ-ийн Аудитийн хороо нь ТУЗ-ийн зүгээс гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй бол дотоод хяналтыг алба нь гүйцэтгэх удирдлагын зүгээс компанийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байх ёстой учраас энэ асуудлаар санал боловсруулах, шийдвэр гаргахад гүйцэтгэх удирдлага шийдвэрлэх саналтай байх нь чухал. Ийм учраас энэ асуудлыг ТУЗ шийдвэрлэх бус танилцдаг байх ёстой гэж үзээд 6.39.3 дах заалтыг томъёолсон болно.

7.48.5. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;

7.48.6. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

Нэр дэвшүүлэх хороо

7.49. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо нь дараах чиг үүрэгтэй:

7.49.1. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

7.49.2. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд энэ дүрмийн 7.25-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

7.49.3. ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/;

7.49.4 ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

7.49.5. гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох;

7.49.6. ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

7.49.7. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

7.50. ТУЗ-д нэр дэвшсэн аливаа этгээдийн нэрийг саналын хуудсанд оруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэхдээ тухайн этгээд нь дараах нөхцөл байдлыг хянах үүрэгтэй:

7.50.1. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаарх шаардлагыг хангаж байгаа эсэх;

7.50.2. жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулаагүй, эсхүл зохих журмын дагуу хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон ТУЗ-д ажиллаж байсан эсэх³⁰;

7.50.3. өмнө компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан этгээдийн нэрийг дахин дэвшүүлж байгаа бол ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэх;

7.50.4. компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх;

7.51. Дор дурдсан этгээд ТУЗ-ийн гишүүн байхыг хориглоно:

7.51.1. эрх зүйн чадамжгүй;

7.51.2. урьд нь эдийн засаг, аж ахуйн нэгжийн эсрэг гэмт хэрэгт шийтгэгдсэн бөгөөд ялтай байх хугацаа нь дуусагүй байгаа;

7.51.3. өмнө нь дампуурсан хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалд ажиллаж байсан;

7.51.4. Компанийн тухай хуулийн 81.5.7-д заасан хугацаа өнгөрөөгүй байгаа;

7.51.5. Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас 2 болон түүнээс дээш удаа захиргааны хариуцлага хүлээж байсан³¹.

³⁰ Компанийн тухай хуулийн 59.5-д зааснаар санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа зарлан хуралдуулаагүй бол ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулахаас бусад бүрэн эрх нь дуусгавар болохоор заасан бөгөөд мөн хуулийн 81.5.7-д энэ шалтгаанаар бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд тухайн ТУЗ-ийн гишүүн байсан этгээдийн нэрийг аливаа хувьцаат компанийн ТУЗ-д нэр дэвшүүлэхээс татгалзахыг нэр дэвшүүлэх хороонд үүрэг болгосон байгаа.

³¹ Компани нь өөрийн онцлогоос шалтгаалан үүнээс өөр шаардлагуудыг компанийн дүрмээр тогтоож өгч болно.

Цалин урамшууллын хороо

7.52. Цалин урамшууллын хороо нь дараах чиг үүрэгтэй:

7.52.1. эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

7.52.2. эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах;

7.52.3. компанийн цалин урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

7.52.4. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

7.53. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн даргын санал болгосон этгээдийг ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын асуудлаар сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна. Нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

7.54. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд түүнийг сонгох, үйл ажиллагааг нь зохицуулах хянахтай холбоотой нарийвчилсан асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно:

7.54.1. компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;

7.54.2. бүрэн эрхийнхээ хүрээнд компанийн ажилтнууд компанийн засаглалын бодлогыг дагаж мөрдөх, компанид сайн засаглалын практикийг хэвшүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэх арга хэмжээ авах;

7.54.3. Хувьцаа эзэмшигчдын хурал, Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний хороодын хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах арга хэмжээг зохион байгуулах;

7.54.4. компанийн ТУЗ нь гүйцэтгэх албаны хэлтэс газрууд үр дүнтэй мэдээлэл солилцох тогтолцоог хариуцах;

7.54.5. мэдээлэлийг нийтэд хүргэх арга хэмжээ авах замаар компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;

7.54.6. хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас ТУЗ-д ирүүлсэн аливаа санал, гомдол хүсэлтийг шийдвэрлэхэд оролцох, компани доторхи маргааныг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах;

7.54.7. хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий сонирхогч этгээд Компанийн тухай хууль болон энэ дүрмээр тогтоосон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх боломж олгох;

7.54.8. компанийн сайн засаглалын талаар олон улсын болон бусад компанийн туршлага, төрийн болон төрийн бус байгууллагаас энэ талаар дэвшүүлж буй санал санаачлагыг судлах замаар өөрийн компанийн засаглалыг цаашид сайжруулах санал боловсруулах;

ТУЗ-ийн хараат бус гишүүн

7.55. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь бусад гишүүдтэй адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.55.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь хууль тогтоомж, компанийн дүрэм болон холбогдох дотоод журмуудад нийцэж байгаа эсэх, компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавих, ийм зөрчилтэй шийдвэр гаргахаас сэргийлэх, гаргасан бол зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг ТУЗ-д тавьж хэлэлцүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахыг шаардах, хуралдуулаагүй тохиолдолд 2-оос доошгүй хараат бус гишүүн хамтран хурал зарлан хуралдуулах;

7.55.2. компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;

7.55.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах;

7.55.4. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

7.56. Төрийн болон орон нутгийн өмчит болон давамгайлсан /50-аас дээш хувийн оролцоотой/ компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн энэ дүрмийн 7.55-д зааснаас гадна дараах нэмэлт эрх үүрэгтэй байна:

7.56.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу бараа ажил үйлчилгээг худалдан авч байх талаар санал боловсруулах;

7.56.2. бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг дээр хуулиар тогтоосон зарчим, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн боловсруулсан саналын дагуу худалдан авч байгаа эсэхэд хяналт тавих;

Гүйцэтгэх удирдлага

7.57. Компанийн гүйцэтгэх удирдлага /цаашид “гүйцэтгэх захирал” гэх/ нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

7.58. Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах журам, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэргийг ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээгээр зохицуулна³².

7.59. Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлнэ³³.

7.60. ТУЗ компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд ТУЗ-ийн төлөөлөн дарга гарын үсэг зурна.

7.61. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно. Харин ТУЗ-ийн дарга байх эсхүл өөр компанийн гүйцэтгэх захирлаар ажиллахыг хориглоно³⁴.

7.62. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө. Үүнд:

7.62.1. компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна;

7.62.2. хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулан, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн ба үр дүнгийн гэрээ байгуулна;

7.62.3. компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна;

7.62.4. компанийн дотоод журмыг батална;

7.62.5. өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана;

7.62.6. компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулна;

7.62.7. компанийг төлөөлөх итгэмжлэл олгоно;

³² ТУЗ нь гүйцэтгэх захиралтай ямар төрлийн гэрээ /хөлсөөр ажиллах гэрээ, контракт гэрээ, хөдөлмөрийн гэрээ г.м./ байгуулахаа өөрөө тодорхойлно.

³³ Компанийн тухай хуулийн 83.2-т зааснаар гүйцэтгэх удирдлагыг хувь хүн эсвэл гүйцэтгэх удирдлагын багаар хэрэгжүүлж болно. Өөрөөр хэлбэл нэг хүнтэй биш, мэргэжлийн багтай гэрээ байгуулан компанийг удирдуулж болно. Компани нь хэрэв гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэглэхээр шийдвэрлэсэн бол энэ талаар Компанийн дүрэмд зааж болно. Энэ тохиолдолд багийн ахлагчтай гэрээ байгуулах бөгөөд багийн ахлагч нь гүйцэтгэх захирал байх бөгөөд баг нь гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх боловч хариуцлагыг багийн ахлагч хүлээдэг байхаар дүрэмдээ тусгах нь зүйтэй.

³⁴ Гүйцэтгэх захирал нь өөр аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллаж болох эсэхийг ТУЗ хэлэлцэн дүрэмдээ тусгах нь зүйтэй. Энэ нь компанийн онцлогоос шалтгаалах бөгөөд гүйцэтгэх захирал нь маш их ачаалалтай ажиллах шаардлагатай том компанийн хувьд өөр аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллах боломжгүй байж болно. Харин ачаалал багатай ажиллах, эсхүл хангалттай тооны дэд захирлуудтай бол ажиллаж болохоор зааж болно. Гүйцэтгэх захирлаар ажиллахыг нь хориглоод, ТУЗ-д давхар ажиллах боломжтой байдлаар зохицуулж болно

7.62.8. компанийн ажиллагсдын хөдөлмөрийн сахилга бат, хөдөлмөр хамгаалалтын дэг журмын хэрэгжилт, технологийн горимын хэрэгжилт болон аж ахуй санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалтад хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

7.62.9. Монгол улсын хууль, тогтоомж болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна.

7.62.10. компанийн түүний бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж, ТУЗ-өөр батлуулан, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдын баг бүрдүүлэх;

7.62.11. компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна;

7.62.12. хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангана;

7.62.13. компанийн улирал, жилийн үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн хуралд тайлан тавьж хэлэлцүүлнэ. Энэхүү тайланд тухайн хугацаад хийсэн гэрээ, хэлцлийн дотор компанийн аль нэг эрх бүхий албан тушаалтны хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх, байсан бол тухайн хэлцлийг Компанийн тухай хуулин 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай асуудлыг тусгасан байна.

7.63. Компанийн ТУЗ нь гүйцэтгэх захирлыг албан тушаалаас нь хэдийд ч чөлөөлөх эрхтэй. Түүнийг чөлөөлсөн тохиолдолд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

7.64. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно. Энэхүү саналыг гаргахдаа хэлэлцүүлэх асуудлын талаарх танилцуулга, гарах шийдвэрийн төсөл зэргийг хүргүүлнэ.

НАЙМ. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ТЭДГЭЭРИЙН ХАРИУЦЛАГА

8.1. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэнгүүд, хараат болон охин компаниудын захирлуудыг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно³⁵.

8.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

8.2.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;

8.2.2. ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдахь этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;

8.2.3. шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаад оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;

8.2.4. шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

8.2.5. өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;

8.2.6. эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарсанаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

³⁵ Компани бүрийн хувьд тодорхой албан тушаалын нэр өөр өөр байж болох учраас дүрэмдээ эрх бүхий албан тушаалтанд хамаарах хүмүүсийн албан тушаалын нэрийг зааж жагсаалт гаргах нь зүйтэй. Жагсаалт гаргахдаа эрх бүхий албан тушаалтан гэдэгт компанийн удирдлагын шийдвэрийг гаргахад оролцох эрх бүхий этгээд хамаардаг гэдгийг удирдлага болгоно.

8.3. Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 8.2.2-т заасан үүргийг хүлээнэ.

8.4. Албан тушаалтан энэ дүрмийн 8.2 болон 8.3-т заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурьдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

8.4.1. компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;

8.4.2. хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн;

8.4.3. эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;

8.4.4. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;

8.4.5. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгсөнөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

8.5. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН

Компанийн нягтлан бодох бүртгэл, тайлан

9.1. Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

9.2. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

9.3. Компани нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээлийн үнэн зөвийг ерөнхий нягтлан бодогч гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна.

9.4. Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтлөх бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалсан байх нь гүйцэтгэх захирлын хариуцах асуудал болно³⁶:

9.4.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг, эзэмшиж буй үнэт цаасн төрөл, тоо зэрэг мэдээллийг тусгана. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн байгууллагатай гэрээ байгуулан хөтлүүлнэ;

9.4.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон хурлын шийдвэр, хуралд зориулан хувьцаа эзэмшигчдэд тараасан материал, хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлын талаар ирүүлсэн саналын бүртгэл. Хурал, хурлын шийдвэрийн бүртгэлд хурал хийсэн байр, он,сар,өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр;

9.4.3. ТУЗ-ийн хурал, хурлын шийдвэрийн бүртгэл;

9.4.4. компанийн дүрэм, түүнд орсон өөрчлөлтийн бүртгэл.

³⁶ Аль нэг дэд захирлын хариуцах асуудлын хүрээд байхаар дүрмэндээ зааж болно. Ямар ч гэсэн бүртгэл хөтлөх, бичиг баримтыг хадгалах асуудлын төлөө хэн хариуцлага хүлээх вэ гэдгийг дүрэмдээ заавал тусгах нь зүйтэй.

- 9.4.5. компанийн болон эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл;
- 9.4.6. компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээдийн бүртгэл;
- 9.4.7. төрийн эрх бүхий хяналт, зохицуулалтын байгууллагад хүргүүлсэн мэдээ, тайлангийн бүртгэл;
- 9.4.8. хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас баталсан компанийн засаглалын, хөдөлмөрийн, цалин урамшууллын, хөдөлмөр хамгааллын гэх мэт дотоод журам, зааврын бүртгэл;
- 9.4.9. компанийн санхүүгийн тайланд болон ТУЗ, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий бусад этгээдийн хүсэлтээр хийсэн аудитийн шалтгалтын тайлангийн бүртгэл;
- 9.4.10. компанийн бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийн бүртгэл;
- 9.4.11. ТУЗ болон гүйцэтгэх захирлын шийдвэрээр тогтоосон бусад бүртгэл;
- 9.5. Энэхүү дүрмийн 9.4-т заасан бүртгэлтэй холбогдох үндсэн бичиг баримт болон дор заасан бичиг баримтыг хадгална:
- 9.5.1. компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлүүд, лицензи;
- 9.5.2. компанийн өмчлөл болон эзэмшилд байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт;
- 9.5.3. анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт;
- 9.5.4. салбар төлөөлөгчийн газрын дүрэм;
- 9.5.5 гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр;
- 9.5.6. ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт;
- 9.6. Энэ дүрмийн 9.4 болон 9.5-д заасан бичиг баримтыг 5 жил хадгалаад архивт шилжүүлнэ. Харин компанийн дүрэм, хүчин төгөлдөр гэрээ, тусгай зөвшөөрөл зэргийг байнга хадгална.
- 9.7. Компани нягтлан бодох бүртгэлийн хуульд заасан журмын анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтөлж, улирал, жилийн санхүүгийн тайлан гаргана.
- 9.8. Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд заавал орсон байна.
- 9.8.1. баланс;
- 9.8.2. орлогын, үр дүнгийн тайлан;
- 9.8.3. мөнгөн гүйлгээний тайлан;
- 9.8.4. хуримтлагдсан ашгийн тайлан;
- 9.8.5. нэмэлт, тайлбар, тодруулга;
- 9.8.6. тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт;
- 9.8.7. эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин урамшууллын дүн, албан тушаалтан бүрээр нэрээр;
- 9.8.8. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга.
- 9.9. Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.
- 9.10. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторийг томилон ажиллуулна.
- 9.11. Санхүүгийн тайланг компанийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитийн байгууллагаар хянуулах бөгөөд ТУЗ санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хэлэлцүүлнэ.
- 9.12. Компани Монгол улсын аль нэгэн болон хэд хэдэн банкинд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын

бүртгэлийн албанд бүртгүүлж байна. Компани нь гадаадын банкинд валютын данс нээх бол энэ тухайгаа Монголбанк болон Татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.

9.13. Компанийн ТУЗ нь санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт тайлбар тодруулга, тайлангийн талаарх аудитийн болон ТУЗ-ийн дүгнэлтээс гадна дараах мэдээллийг тусгасан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичнэ:

9.13.1. компанийн бүтэц зохион байгуулалт түүнд гарсан өөрчлөлт;

9.13.2. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үйл ажиллагаа тус бүрийн талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, үр дүн;

9.13.3. компанийн өмчлөл, эзэмшилд байгаа эдийн болон эдийн бус хөрөнгө, тусгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээлэл, эдгээрт гарсан өөрчлөлт.

9.14. Компанийн гүйцэтгэх захирал нь энэ дүрмийн 9.13-т заасан мэдээлэлтэй танилцах боломжоор хувьцаа эзэмшигчдийг хангана.

АРАВ. НОГДОЛ АШИГ

10.1. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.

10.2. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

10.3. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:

10.3.1. ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;

10.3.2. ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;

10.3.3. компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

10.4. Ногдол ашиг хуваарилсны дараа компанийн өөрийн хөрөнгө нь хуваарилсны өмнөх хэмжээнээс 25-аас дээш хувиар багассан тохиолдолд ногдол ашгийг шилжүүлснээс хойш ажлын 15 хоногийн дотор зээлдүүлэгчиддээ өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ. Энэ үүргийг гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

10.5. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

10.6. Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх ашгаас нийгэм, соёлын арга хэмжээний санг ТУЗ-ийн шийдвэрээр байгуулж болох бөгөөд уг санг байгуулах, түүний хөрөнгийг зарцуулах журмын төслийг гүйцэтгэх захирал боловсруулж ТУЗ-ийн хурлаар батлуулж мөрдөнө³⁷.

10.7. Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүй бол хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал хариуцна.

10.8. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөнө. Ногдол ашгийг хувьцаа эзэмшигч бүрийн арилжааны банкин дах дансанд шилжүүлэх бодлого баримтална.

³⁷ Нийгэм соёлын арга хэмжээний тусгай санг хуваарилагдаагүй ашгаас байгуулдаг байх нь ажиллагсдын нийгмийн асуудал, компанийн нийгмийн хариуцлагатай холбоотой асуудлыг шийдвэрлэх зэрэгт гүйцэтгэх удирдлагаас зарцуулж болох хөрөнгийн хэмжээг тогтоож, тусгаарлах, мөн хөрөнгийг хэрхэн зарцуулах журмыг тогтоож өгөх ач холбогдолтой.

10.9. Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед ногдол ашгийн хуваарилалтын тайланг гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

АРВАН НЭГ. КОМПАНИЙН САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ

Дотоод хяналт

11.1. Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитийн хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

11.2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.

11.3. Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-тэй зөвшилцөн гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

11.4. Дотоод хяналтын албаны ажилтнууд нь компанийн ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.

11.5. Дор дурдсан этгээдийг дотоод хяналтын албанд ажиллуулахыг хориглоно:

11.5.1. эрх зүйн чадамжгүй;

11.5.2. урьд нь дампуурсан компанийн удирдлагад ажиллаж байсан;

11.5.3. компанийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд эсвэл ямар нэг шалтгаанаар тэдний нөлөөнд автах боломжтой/ найз нөхрийн болон өмнө хамт ажиллаж байсан зэргээр холбоо харилцаатай/;

11.5.4. толгой компани болон хараат буюу салбар компанид ажилладаг;

11.5.5. өмнө нь авилгын хэрэгт шийтгэгдэж байсан.

11.6. Дотоод хяналтын албанаас хийх шалгалт нь ээлжит болон тусгай гэсэн хэлбэртэй байна. Ээлжит шалгалтын хуваарийг өмнөх жилийн 12 дугаар сард албаны дарга боловсруулан гүйцэтгэх захирлаар батлуулж ажиллана. Харин ТУЗ болон гүйцэтгэх захирлын даалгавараар, тэдний баталсан удирдамжийн дагуу тодорхой асуудлаар хийх шалгалтыг тусгай шалгалт гэнэ.

11.7. Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралдаанаар дотоод хяналтын албаны мэдээлэл, шалгалтын дүнг улирал бүр хэлэлцэн, холбогдох арга хэмжээ авч байна³⁸.

³⁸ Дотоод хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх нь компани бүрийн хувьд онцлогтой байна. Томоохон ХК, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд дотоод хяналтын тусгай албатай эсхүл ажилтантай байх нь зүйтэй. Дотоод хяналтыг зөвхөн хөрөнгө, мөнгөний зарцуулалт бүрэн бүтэн байдалд тавих хяналт гэсэн ойлголт өргөн тархсан байдаг. Гэтэл дотоод хяналт нь компанийн бүхий л үйл ажиллагаанд үүний дотор, хөдөлмөрийн болон технологийн сахилга бат, хөдөлмөр зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, техник ашиглалт, материал, түүхий эдийн оновчтой зарцуулалт, хөрөнгө мөнгөний зарцуулалт, бүрэн бүтэн байдал зэрэг маш олон асуудлыг хамрах бөгөөд бүх шатны менежерүүд дотоод хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байдаг. Ийм учраас бүх шатны менежерүүдийн “Ажлын байрны тодорхойлолт”-д тогтмол хэрэгжүүлэх хяналтыг нарийвчлан тусгах нь зүйтэй. Гүйцэтгэх удирдлагын зүгээс компанийн үйл ажиллагааны бүхий л хэсэгт тогтмол хэрэгжүүлэх дотоод хяналтыг маш нарийн бодож боловсруулсан горимын дагуу хэрэгжүүлэх ёстой. “Дотоод хяналтын журам”-ыг үйл ажиллагааны хэсэг бүрээр /цех, тасаг, хэлтэс, газар/ боловсруулж, хэн хариуцаж, хэзээ ямар журмаар хяналт тавих, яаж тайлагнах, байнгын хяналт хэр зэрэг үр дүнтэй байгааг яаж дүгнэх, түүний мөрөөр ямар арга хэмжээ авах талаар хэн санал боловсруулах, хэрхэн шийдвэрлэх зэрэг бүх асуудлыг тусгасан байх ёстой. Үүнийг боловсруулах нь гүйцэтгэх удирдлагын үүрэг, хянаж чиглэл өгөх нь ТУЗ-ийн бүрэн эрх байх ёстой. Дүрмийн энэ хэсгийг компани бүр өөрийн онцлогт тохируулан боловсруулах нь зүйтэй.

Аудиторын /хөндлөнгийн/ хяналт

11.8. Аудитын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулж, ажиллуулна.

11.9. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитийн шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

11.10. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.

11.11. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, түүний аудитийн хорооны шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх захирлын саналаар хэдийд ч хийж болно.

11.12. Компанийн ТУЗ-ийн аудитийн хороо аудитийн байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудитийн байгууллагын эрх үүрэг, хариуцлага, аудитийн үйлчилгээний хөлсний хэмжээг заана. Аудитийн дүгнэлтийн шинж чанараас хамааруулан аудитийн хөлсний хэмжээг тогтоохыг хориглоно.

11.13. Аудитийн ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж, гэрээ байгуулж хийлгэсэн хувьцаа эзэмшигч хариуцаж төлнө. Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.

11.14. Компанийн эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

11.15. Эрх бүхий албан тушаалтан энэ дүрмийн 9.17-д заасан үүргээ хэрэгжүүлээгүйгээс аудиторын ажил зогссон хоногт оногдох ажлын хөлсийг буруутай албан тушаалтан хариуцан төлнө. Энэ тухай шийдвэрийг аудитийн компаниас ирүүлсэн албан ёсны хүсэлтийг үндэслэн ТУЗ гаргана. Харин дээрх шалтгаанаар аудиторын ажил зогссон тухайд аудитийн компани ТУЗ-ийн аудитийн хорооны даргад албан ёсоор мэдэгдсэн байна.

11.16. Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд гаргасан дүгнэлийнхээ талаар тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.

11.17. Дараах этгээдийг компанийн аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно:

11.17.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;

11.17.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хувьцаа эзэмшигч, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;

11.17.3. компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол.

11.18. Аудитор нь дүгнэлтээ зөвхөн бичгээр гаргах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлыг заавал тусгасан байна:

11.18.1. компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;

11.18.2. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрсэн бол зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлсон;

11.18.3. шалгалтын хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, эдгээр хэлцлийг КТХ-д заасан журмын дагуу хийсэн эсэх тухай дүгнэлт;

11.18.4. Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлэл;

11.18.5. ТУЗ-ин аудитийн хорооны саналаар аудитийн үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад асуудлын талаарх мэдээлэл, дүгнэлт;

АРВАН ХОЁР. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ЗОХИЦУУЛАХ

12.1. Компанийн үйл ажиллагаанд гарч болох компани түүний бизнесийн түншүүд /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч г.м/, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид зэргийн хооронд гарсан аливаа зөрчил маргаан, сонирхлын зөрчлийг хэлэлцэн тохирох замаар зохицуулах нь ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын анхаарлын төвд байх асуудал болно.

12.2. Аливаа зөрчил, маргаан үүссэн үед компанийн эрх зүйн хэлтэс /хуулийн зөвлөх/ шалтгааныг судалж, хэрхэн шийдвэрлэж болох тухай саналаа холбогдох дээд шатны удирдлагад танилцуулна.

12.3. Энэ дүрмийн 12.2-т заасан саналыг холбогдох удирдлага судалж үзээд зохих арга хэмжээ авах замаар зөрчлийг зохицуулах үүрэгтэй.

12.4. Зөрчил маргаан нь эрх бүхий албан тушаалтнуудын хооронд гарсан, эрх бүхий албан тушаалтан болон бусад оролцогч талуудын хооронд гарсан /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид г.м/ бол зөрчил маргааныг шийдвэрлэхэд тухайн сонирхлын зөрчилтэй эрх бүхий албан тушаалтан оролцохгүй.

12.5. Компани нь Компанийн тухай хуулийн арванхоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ дараах журмыг баримтална:

12.5.1. компанитай болон охин компанитай хийж буй аливаа хэлцэлд тухайн хэлцлийг хийх талаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх бүхий аль нэг албан тушаалтан оролцож байгаа /өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэлд зуучлагч төлөөлөгч болж байгаа, эсхүл хэлцэлээс шууд болон шууд бусаар орлого хүртэж байгаа бол оролцож байгаа гэж үзнэ/ бол тухайн албан тушаалтан энэ тухайгаа хэлцэл хийх шийдвэр гаргах үед гүйцэтгэх захиралд болон аудитийн хорооны даргад мэдэгдэнэ. Гүйцэтгэх захирал өөрөө хэлцэлд оролцогч этгээд бол ТУЗ-ийн даргад мэдэгдэнэ;

12.5.2. хэлцэл хийх шийдвэр гаргах болон хэлцэлтэй холбогдох үнэ тогтооход хэлцэлд оролцож буй эрх бүхий албан тушаалтан оролцож, санал өгөхгүй;

12.5.3. хэлцэл хийхэд оролцох этгээд гэдгээ мэдээгүй, сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компанид хохирол учруулсан бол эрх бүхий албан тушаалтан уг хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

12.5.4. Компанийн тухай хуулийн 92.3-т заасан тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

АРВАН ГУРАВ. КОМПАНИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

13.1. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

13.2. Компанийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгана.

13.2.1. компанийн үйл ажиллагаа алдагдалтай байгаагаас цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

13.2.2. хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийг татан буулгахаар шийдвэрлэсэн;

13.2.3. Компанийн тухай хуульд заасан бусад үндэслэлээр;

АРВАНДӨРӨВ. ДҮРЭМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

14.1. Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхиор баталж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн албанд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

14.2. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан

журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 14.1-т заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.